

Стефэн ЖОН



Мэрвин КЕРЛИНС

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ПОКЕРЧИД



Дэлхийн шилдэг Покерчид
Зохиолч: С.Жон, М.Керлинс
Орчуулсан: Н.Баатар

ISBN: 978-99929-1-950-7

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Өмнөтгөл



Жэк МакКлелланд

Покерын тэмцээн бол миний амьдрал, түүнчлэн миний мэргэжил юм. 1980-аад оны эхээр би Лас Вегаст хэдэн зуун жижиг тэмцээнд оролцсон. Би тэмцээн маруухан зохиогдсон талаар эхнэр Алмадаа байнга гомдоллоно. Алма маш хурц зантай эмэгтэй. Заримдаа түүний үг хэл нь ч маш хурц. Тэрээр нэгэн удаа надад хандан "Хэрвээ чи тийм мундаг юм бол тэр тэмцээнүүдээ яагаад өөрөө зохиодоггүй юм бэ" гэж хэлж байсан удаатай.

Тэр бүх тэмцээний явцад маш олон шилдэг тоглогчидтой таарч байсан. Жонни Моссын ширүүн харц, ширээн дээрх бүх хасааг хураан авч өөрийнхөө урд өрснийхөө дараа Дэвид "Хасаа" Рийсын нүүр дүүрэн инээмсэглэл зэргийг би хэзээ ч мартдаггүй. Мөн Стю Унгарын гэрлийн хурдаар хурдан гарч ирснээ унаж, дахин гарч ирснийг ч яахин мартаж билээ.

Хорин зургаан жилийн хугацаанд мянга гаруй тэмцээнд оролцсоныхоо дараа эргээд харахад би өөрийн энэ ажилдаа маш дуртай.

Энэ номын эхний уншигчийн хувьд шилдэг тоглогчдын тухай уншиж байхад гайхал төрүүлсэн нэг зүйл бол тэд бүгд покерыг эрж хайн, их замыг туулж ирсэн юм. Энэ номд багтсан ихэнх хүмүүсийн хувьд покер нь өрөөнөөсөө компьютерээр тоглох одоогийнх шиг боломжтой байгаагүй харин покер дөнгөж эхэлж байх үед далдаас нууцгайхан эхэлсэн анхдагчид билээ. Тэдний үед тоглоомыг олж очно гэдэг урт аялал болдог, маш их адал явдалтай замыг туулдаг, заримдаа шударга бус, аюултай хүмүүстэй тулгардаг байлаа. Өнөөдөр тоглоом чамайг өрөөнөөс чинь олдог болжээ. Хэдэн жилийн өмнө бол дэлхийгээр хэрэн хэсч, покерын тоглоомын газар хайж явдаг байсан.

Жонни Чан өөрийн дурсамждаа 1970-аад оны сүүлчээр буюу 16 насандаа Хьюстоноос Лас Вегас хүртэл аялдаг байснаа дурссан байдаг. Фил Хелмут Висконсин мужаар хэрэн хэсч, томоохон тэмцээн хайж байснаа, мөн Лас Вегас руу 10 удаа аялахдаа ганцхан удаа л хожиж байснаа дурдсан байдаг. Ховард Ледерер гэхэд Нью Йоркт нэгэн шатрын клубын өрөөний буланд унтаж, тэндхийн покерын өрөөг цэвэрлэн, тэнд тоглохоор очсон хүмүүст сэндвич зөөж, анх тоглох мөнгөө олж авч байснаа өгүүлсэн нь бий.

Тэр бүх аялал болгон тэдний гэр бүлийнхний хувьд маш том асуудал, дарамт болдог байсан нь мэдээж. Мөрийтэй тоглоом гэсэн утгаараа бусад хүмүүст хүнд тусдаг. Нийгмийн зүгээс бидний нарийн тооцоотой, энэ сайхан тоглоом покерыг маань шүүмжлэлтэй авч үздэг байсан.

Покерын тоглолтын явц дахь мөнгөний удирдлага, сонирхолтой өрсөлдөөнтэй нөхцөл байдал зэрэг нь олон тоглогчдыг мэргэжлийн болоход нөлөөлсөн. Эдгээр асуудлуудын тухайд бараг бүгд шахам ижилхэн ханддаг болохыг би харсан. Жишээ нь, Эрик Сайдел, Фил Айви, Крис Фергюсон нар бооцооны хэмжээгээ бууруулж, буцаж хэмжээндээ очихын тулд томоор тоглохоо түр азнах чадвартай байсан. Мөн тэд ийм их чадвар шаардсан тоглоомноосоо рулет зэрэг чадвар шаардахгүй бусад тоглоом руу хазайгаагүй билээ.

Эрчүүдийн энэ тоглоомын ертөнцөөр аялсан Анние, Женнифер нарын бүсгүйчүүлийн сонирхолтой тоглолт, вьетнам тоглогч Скотти Нгуен, Чау Гианг нарын тухай сэтгэл хөдлөм дурсамжийг энд дурдахгүй өнгөрөхийн аргагүй. Америкт тэд халаасандаа сохор зоосгүй ирцгээсэн ч, зүрхэндээ тээсэн аугаа хүсэл, оюуны маш их чадварын хүчинд гайхамшигтай амжилтад хүрцгээсэн.

Миний хувийн бодлоор, 1989 оны Покерын дэлхийн цуврал тэмцээн хамгийн ер бусын болсон. 1988 оны долоон хөзрийн стадын* (покерийн нэр томъёоны талаарх тайлбарыг үзнэ үү.) дэлхийн аваргын тэмцээнд би шувтаргын тоглолтод шалгарсан тэр жил покерын дэлхийн цуврал тэмцээний Main Event-д шинээр орж ирсэн Эрик Сайделийг Жонни Чан хоёр дахин чек хийн урхидаж хожсон билээ. Тэгэхэд Чаны тэрхүү тоглолтын бичлэгийг миний эхнэр Алма хэд дахин эргүүлэн үзэж байсныг би санаж байна.

1989 оны эхээр Покерын дэлхийн цувралын эмэгтэйчүүдийн тэмцээнд миний эхнэр Алма долоон хөзрийн стад тоглоомоор тоглож байхдаа шувтаргын тоглолтод өрсөлдөгч нь тийм ч

сайн модгүй байхад нэлээн хэмжээний хасаагаа надаас болж алдсан юм. Би тэгэхэд тэр тэмцээний зохион байгуулагчаар ажиллаж байсан билээ.

Тэмцээний завсарлагаар бид хамтдаа хооллох үед тийм ч таатай байгаагүй.

Хэдэн цагийн дараа Алма гартаа гурван хатантай байхад түүний өрсөлдөгч Адрианна Зояа дөрөв дэх хөзөр боол гарахад бооцоогоо нэмж эхлэв. Хөзөр эргэх болгонд Адрианна илүү сайжирч байсан. Би тэр тоглолтын хувилбаруудыг толгойдоо тооцоолж Алмаг хүнд байдалд орлоо хэмээн бодож байлаа. Сүүлийн хөзөр эргэхэд Алма хоёр дахин чек хийж, бооцоогоо даруухан өсгөхөд Адрианна бүгдийг түлхэв. Тэр үед Алма дөрвөн хатан гаргаж, Покерын дэлхийн цувралын аваргын алтан бугуйвчаа хүртсэн юм. Тэрээр над руу харснаа "Би яг Жонни Чаны хийснийг хийсэн" гэв. Алма өрөөнд тоглож байсан Жак Бинион руу хандан "Хөөе, Жак, чи надад алтан бугуйвчны өртэй боллоо" шүү хэмээн хашгирч билээ. Энэ нь миний амьдралдаа харсан хамгийн бахархалтай мөч байлаа.

Сүүлийн найман жилийн хугацаанд өөрийн хамтрагч, покерын үйл ажиллагааны захирал Дог Далтонтой хамт Беллажиод ажиллаж байгаадаа би маш их баярладаг. Бид хамтдаа Покерын дэлхийн аялан тоглолтыг 2002 онд анх санаачилсан юм. Энэ нь дэлхий даяар хамгийн шилдэг, нэр хүндтэй тэмцээн болж чадсан билээ. Телевизийн тоглолтыг ч эхлүүлж, энэ нь Лайл Берман, Стив Липскомб нарын мөрөөдөж байснаар дэлхийгээр шуурга мэт тархав.

Тоглогчдын гар дахь модыг харах боломжийг үзэгчдэд олгож, интернетээр покер тоглох боломжийг нээж, бас мөнгө хүүлэгч Крис шиг 40 доллараар саяыг хожих боломжийг дэлхий нийтэд харуулсан нь покерыг сонирхох явдлыг улам бүр нэмэгдүүлсэн юм. Түүнчлэн Дойл Брансоны үргэлжилсэн хожлууд, шинэ одод болох Даниел Нигрэану, Эрик Линдгрэн, Фил Айви, Аллен Каннинхам нар түрэн орж ирсэн зэргээс улбаалж нэг л мэдэхэд покер тоглох нь хамгийн "эрхэм нэр төрийн хэрэг" болон хувирсан юм. Супер од Карлос Мортенсен, Скотти Нгуен, Жой Хачем нар Покерын дэлхийн цуврал тэмцээн болон Покерын дэлхийн аялан тоглолтод зэрэг зэрэг түрүүлэн алдраа цуурайтуулахын сацуу покерын тэмцээний бооцоо сая саяараа гол шиг урсаж, покерын төлөөх хэнээрхэл үргэлжлэн өссөөр байна.

Энэхүү номонд шилдэг тоглогчид өөрсдийн намтар түүх, покер тоглоомд анх хэрхэн яаж татагдсан, өөрсдийн авьяас чадвартаа хөтлөгдөн шинэ шинэ сорилтуудтай хэрхэн тулгарч байсан тухайгаа өгүүлнэ. Тэд бүгд өөрсдийн өсч төрсөн, амьдарч байсан хотын тэмцээнүүдээс хэрхэн шалгаран тодорч, өөр хүчтэй өрсөлдөгчидтэй том хотыг үргэлж хайж эрж явсан тухайгаа ч дурссан байгаа. Эдгээр шилдэг тоглогчид гагцхүү Покерын дэлхийн цуврал болон Покерын дэлхийн аялан тоглолтын аваргын ширээнд тоглосноор тэрхүү хүсэл нь дарагддаг билээ. Тэдгээр авьяаслаг хүмүүсийн тухай, тэд хэрхэн дэлхийн шилдэг тоглогчид болсон тухай энэ номонд өгүүлэх болно.

Би амьдралынхаа туршид Бурхнаас заяасан ерөөлтэй бас маш их азтай хүн. Гайхамшигт эхнэр Элизабетийн дундаршгүй хайр, дэмжлэгийн хүчээр энэ тоглоомд дахин хэсэг хугацаанд ч гэсэн байх болов уу гэж найдаж байна.

Энэхүү номын өмнөтгөл үгийг бичсэндээ маш их талархаж байна.


Хөзрөө холь, тэгээд унш.

Жэк Мак Клелланд

Покерын тэмцээний захирал.

Беллажио казино. Лас Вегас хот, Невада муж.

Их гарын тоглогчид



Доул Брансон

Нэг одтой мужид бүх зүйл супер хэмжээстэй байдаг. Харин покерын ертөнцийн хувьд домогт "Техасын хүүхэлдэй" Брансоноос илүү аварга хүн үгүй. Тэрбээр покерын ертөнцийн загалмайлан эцэг юм. Покерын ертөнцийн гол төвд 40 гаруй жил ноёрхсон Д.Брансон хаана ямар л томоохон тэмцээн, их мөнгөний тоглолт болно тэр бүгдэд хождог байсан. Энэ үедээ тэр покерын тухай "Супер систем" хэмээх ном бичсэн нь өнөөг хүртэл хамгийн их уншигчидтай ном хэвээр байна.

Покерын дэлхийн цуврал тэмцээн болон Покерын дэлхийн аялан тоглолтод хоёуланд нь түрүүлж байсан түүнийг покерын хамгийн аугаа тоглогчдын нэг төдийгүй өнөөг хүртэл амьд

байгаа шилдэг тоглогчоор өргөмжилсөн билээ.

Покерын дэлхийн цуврал тэмцээнд дараалан хоёр удаа түрүүлсэн тэрбээр цуцашигүй тэмцэгч, аугаа дээд хүндлэлийг хүлээсэн, өөрийн гэр бүлийг дээдэлсэн, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн гэдгээрээ шилдэг покер тоглогчдын тэргүүн эгнээнд бичигддэг юм.

Түүний зорилго бол өөрийгөө тэр "покер тоглох маш дуртай нэгэн төдийгүй покерыг хөгжүүлэхэд бүхий л боломжоо бүгдийг зориулсан" хэмээн покерын түүхэнд дурсагдахыг хүсдэг юм. Тэр өөрийнхөө амьдралын туршид энэ бүхнийг нэр хүндтэйгээр биелүүлсэн, энэ зорилгодоо ч хүрсэн. Түүний үлдээсэн аугаа өв уламжлал нь ирээдүйн үе үеийн тоглогчдын урам зоригийг бадрааж, үлгэр жишээ нь болсоор байгаа билээ. Эдүгээ хаана хэзэр холигдон, покер тоглогдож байна, тэнд хүртэл түүний өв уламжлал, туршлага "амьсгалагдсаар" байгаа гэсэн үг.

Би зуу гаруй хүнтэй жижиг хотод өссөн. Манай гэр бүлийнхэн дөлгөөхөн агаад бурханд итгэдэг хүмүүс байв. Аав минь даавууны өт үржүүлдэг фермер байлаа. Тэрбээр покер тоглодог байсан ч түүний эргэн тойронд юу болж байсан тухай би юу ч мэдэхгүй. Миний үеийн хүүхэд цөөхөн байсан ч тэднээс хоёр нь миний сайн найзууд байлаа. Бид бүгдээрээ мэргэжлийн тамирчид, бүр од болохыг хүсдэг байв. Бид ядуу фермерийн жижигхэн хотынхон байсан. Тиймээс энэ байдлаас гарах цорын ганц арга нь тамирчны тэтгэлгээр коллежид орох явдал гэдгийг мэдэж байлаа. Үүний тулд бид маш их хичээсэн. Хэрэв амжилтад хүрэхгүй бол бидэнд фермер болох л зам үлдэж байсан болохоор биднээс хэн нь ч ийм байдалдаа үлдэхийг хүсээгүй. Иймд сагсан бөмбөг, гүйлтийн талаарх бодол хамаг анхаарлын төвд байв. Покер үнэндээ толгойд орох зайгүй байсан.

Гэвч ахлах сургуулийн төгсөх ангид байхдаа ганц хоёр удаа покер тоглож үзэв. Надад сайхан санагдсан. Коллежид орсон эхний жилдээ покерт үнэн голоосоо дурлаж эхлэв. Нэгэн явдлыг би ер мартдаггүй юм. Орой үдэшлэг тараад оюутны байрандаа иртэл тэнд покер тоглож байв. Бид шөнөжингөө тоглоод маргааш өглөө нь шууд хичээлдээ явцгаав. Өдөр нь гүйлтийн тэмцээнтэй байлаа. Би нэлээн сайн гүйгч байв. Гэвч шөнөжингөө тоглосон учир маш их ядарч, гүйх ямарч тэнхэлгүй байсан болохоор дасгалжуулагч руугаа утасдан "Би өнөөдөр өвчтэй байна, гүйж чадахгүй нээ" гэж хэлсэн.

Тэрбээр "Юу болсон бэ" гэхэд нь "Би ханиад юм уу өөр ямар нэг өвчтэй байх шиг байна" гэлээ. Дасгалжуулагч "Окей" гэв. Би ч гэсэн ингээд асуудлаа шийдчихлээ хэмээн бодсоор өрөөндөө очиж, орондоо орж дөнгөж унтах гэж байтал хаалга хүчтэйхэн тогшив. Энэ бол дасгалжуулагч байлаа. Тэр "Хөөе, эмчид очицгооё" гэв. Тэгэхэд нь би "Үгүй, өвдөөгүй ээ, зүгээр байна" гэхэд, "Үгүй ээ, би чамайг эмчид аваачмаар байна" хэмээн зүтгэсэн.

Түүнийг харахад урд шөнө юу болсныг гадарласан шинжтэй байлаа. Хариуд нь "За, би гүйнээ" гэхэд дасгалжуулагч маань "Би ч тэгж бодоод, чиний өмсгөлийг аваад ирсэн" хэмээн хэлж билээ.

Хувцсаа өмсч, талбай дээр ирээд жаахан сунгалт хийгээд ширээн доогуур орж унтах боломж хайж байлаа. Гэтэл нэг хүүхэд ирж, чамайг дасгалжуулагч дуудаж байна гэв. Тэгэхээр нь дасгалжуулагч дээр очтол "Талбай дээр гар, хагас бээрийн зайд уралд" гэхэд нь "Энэ чинь

миний зай биш байна, би уралдахгүй" гэлээ. Тэрбээр бодлоо өөрчлөлгүйгээр цааш нь "Өнөөдөр чи хагас бээрийн зайд уралдах болно" хэмээн шаардав. Яах ч аргагүй байдалд орж талбайд гараад өнөөх өвчтэй байсан хүн уралдаж түрүүлсэнд бүгд маш их гайхсан шүү. Би өөрөө ч үүндээ бараг итгэхгүй байлаа. Энэ бол миний хамгийн шилдэг хагас бээрийн зай дахь уралдаан байв.

Ингээд л "За, тэмцээн дууслаа" хэмээн бодож хэсэг хөөрцөглөн баярласны дараа дуг хийхээр ус түгээдэг хэсгийн хавьцаа хэвтэж, дөнгөж унтаж эхэлтэл нөгөө хүүхэд дахин ирж "Дасгалжуулагч чамайг нэг бээрийн зайд уралд гэж байна" хэмээн хэлдэг байгаа.

Гэвч ахлах сургуулийн төгсөх ангид байхдаа ганц хоёр удаа покер тоглов. Надад сайхан санагдсан. Коллежид орсон эхний жилээ би покерт үнэн голоосоо дурлаж эхэлсэн.

Тэгээд дахин дасгалжуулагч дээрээ очоод "Би дөнгөж сая уралдаж ирчихээд байна шүү дээ, хөл нэлээн өвдөж байна" гэхэд "Зүгээрээ, талбайд гар, уралд" гэж билээ. Энэ удаад нэлээн өрсөлдөөнтэй уралдаан болов. Гайхалтай нь, би бас л түрүүлсэн. Түүний дараа үнэхээр ядарч, ямар ч тэнхээгүй болсон мэт санагдан сандал дээр сунаж унан хэвтэхэд, нөгөө хүүхэд гурав дахь удаагаа ирж, "Буухиа тэмцээнд оролц гэж байна" хэмээн хэлэв. Энэ үед хамаг бие хөндүүлэн өвдөж, бөөлжмөөр санагдаж байсан ч яаж ч чадалгүй уралдсан. Даанч тэр уралдаанд түрүүлж чадаагүй.

Энэ бүхнээс маш үнэ цэнэтэй сургамж авсан даа. "Дасгалжуулагчтайгаа хэзээ ч бүү зөрж бай" гэдгийг хатуухан ойлгосон юм. Хэдий тийм боловч энэ тохиолдол нь миний спортод хандах хандлагад нөлөөгүй ээ. Урд орой нь тоглосон покер тоглоом ч гэсэн маш их сонирхол татсан хэвээр үлдэв. Би өрсөлдөөнд маш их дуртай. Спорт болон покер хоёулаа миний тэр орон зайг маань нөхдөг байсан.

Би Техасын Абилэн дахь Хардин Симмонс их сургуульд спортын тэтгэлгээр суралцав. Миний хувьд мэргэжлийн сагсан бөмбөгчин болно гэж мөрөөддөг байлаа. Тоглох хугацаа маань дуусахаар төрсөн хотдоо очиж, багш эсвэл дасгалжуулагч хийнэ гэж боддог байв. Хоёрдугаар курст байхад Миннесота Лейкерсийнхэн миний тоглолтыг ажиглаад намайг ирэх жилээс багтаа авах талаар яригдав. Тэр үед 185 см өндөртэй хамгаалагч коллежийн хэмжээнд байгаагүй юм. Тэр жилдээ би хамгийн үнэ цэнэтэй тоглогч болов. Лейкерсийнхэн намайг сургууль төгссөний дараа багтаа авахаар төлөвлөж байгаагаа дасгалжуулагчид хэлжээ. Амьдрал энэ үед үнэхээр сайхан байлаа.

Миний хувьд мэргэжлийн сагсан бөмбөгчин болно гэж мөрөөддөг байлаа. Тоглох хугацаа маань дуусахаар төрсөн хотдоо ирж, багш эсвэл дасгалжуулагч хийнэ гэж боддог байв.

Сагсан бөмбөг миний хүсч байгаа бүх мөрөөдлийг биелүүлнэ хэмээн бодож байсан ч энэ бодол маань тун удалгүй замхарч билээ. Хоёрдугаар курсийнхээ зуны амралтаар нэлээн хүнд зуны ажил хийж байгаад хөл дээрээ шохойн хавтан унагаж, хүндхэн гэмтэл авав. Яг л мөчир хугарч байгаа юм шиг хөл минь хугарч, яг түүн шиг мэргэжлийн сагсан бөмбөгчин болох хүсэл мөрөөдөл, зорилго маань талаар болсон доо.

Азаар сургууль маань дараа жилийн тамирчны тэтгэлэгт хамруулж, үргэлжлүүлэн

суралцуулав. Гэвч тамирчин болох зам маань цааш үргэлжлэх боломжгүй болж, ирээдүйд ямар мэргэжил эзэмших талаар бодож эхлэв. Ингээд цаашид магистрын зэрэг хамгаалж, багш болно гэсэн зорилт урдаа тавилаа. Гэсэн ч бэрхшээлтэй асуудал олон гарч ирэв. Надад тэтгэлэг, сургалтын төлбөр төлөх мөнгө байхгүй бас дээр нь би ажилгүй байв. Юу байсан бэ гэвэл боломжийн сайн покер тоглох чадвар л байлаа. Сургуулийнхаа эргэн тойрон покер тоглон сургалтын төлбөрөө олно. Их сургуулийн дотуур байрны орчимд хангалттай тоглолтууд явагдана, покер тоглоход дутагдах зүйл гэж үгүй. Тоглож эхэлсэн эхний үеэс л би ихэнх тоглогчдоосоо илүү гэдэг нь ойлгомжтой байв. Тамирчин байсан болохоор Техасын бусад сургуулиудад ч бас олон найзтай. Долоо хоногийн сүүлчээр муж дамжин бусад сургуулиуд дээр очиж, покер тоглодог болов. Мастерын зэрэг автал покерын хожил маань хамтдаа үргэлжилсэн юм.

Ингээд мастерын зэрэгтэй болж сургуулиа төгссөний дараа хамгийн эхний зорилго бол ажилтай болох явдал байв. Энэ үед покерыг мэргэжил болгоно гэж огтхон бодоогүй. Надад таалагдахаар багшийн ажил олдоогүй ч покерын тухай бодоогүй хэвээрээ байв. Ажил хайсны эцэст бүртгэлийн машин үйлдвэрлэдэг Бурроу корпорацид борлуулалтын ажилтнаар орсон. Энэ нь миний амьдралдаа хийсэн цор ганц "бодит" ажил байлаа. Хэдэн сарын турш сургалтад хамрагдаж, хүлээсний эцэст Техасын Форт Ворт хотын хойд хэсэгт орших борлуулалтын албанд оров. Эхлээд маш их утсаар ярьж, борлуулалтаа хийдэг байлаа. Зарим худалдан авагч газруудаар очиж уулзах үеэр тэд арын өрөөнүүддээ покер тоглодог болохыг олж мэдсэн юм.

Үүнийг ажигласны дараа би өөртөө "Хэрэв би тэд нартай покер тоглож, ойртон нөхөрлөж чадвал магадгүй борлуулалтаа улам ч нэмэх боломжтой юм байна" хэмээн бодож тэрхүү тоглолтуудад оролцож эхэлсэн билээ.

Покер тоглож, тэдгээр ажилчдаас хожсон мөнгө маань миний бүтээгдэхүүн зарж олдог орлогоос хавьгүй илүү болов. Тиймээс би ажлаасаа гарч, бүтэн цагаар покер тоглож эхэлсэн юм.

Гэтэл байдал эсрэгээрээ эргэж, шийдвэр гаргадаг хүнийг покероор хожвол бүтээгдэхүүнээ зарах боломж тэр хирээр багасдаг болов. Покер тоглож, тэдгээр ажилчдаас хожсон мөнгө маань миний бүтээгдэхүүн зарж олдог орлогоос хавьгүй илүү болохыг би олж харсан юм. Чухам энэ үед л покер тоглох сонирхол маань нэмэгдэж, борлуулагчийн ажлаасаа залхаж гүйцэв. Өөрчлөлт хийх цаг нь болсон байсныг ойлгоход сансрын шинжлэх ухааны мэдлэг шаардагдахгүй нь ойлгомжтой байлаа. Ингээд ажлаасаа гарч, покерыг үндсэн ажлаа болгон тоглож эхэлсэн юм.

Форт Вортын хойд хэсэг бол нэлээн хүнд гарын оршин суугчидтай байлаа. Танхай хүмүүс маш ихээр амьдарна. Иймд тэр хавиар гэмт хэрэгтнүүд, хулгайч луйварчид, зальтнууд, ер нь юу ч хийхээс буцахгүй этгээдүүд гээд олон янзын дүр төрх холилдон байдаг учраас түүнийгээ дагаад мөнгөний тоглоом нэлээн хөгжсөн байлаа. Ийм газар сайн покер тоглогч байна гэдэг зөвхөн тоглоомондоо хожихоос илүү их олон зүйлд анхаарах хэрэгтэй болдог. Заримдаа тоглоомын үеэр луйвардуулна. Луйвардуулахгүйн тулд зальтай хүмүүстэй тоглохдоо маш их анхаарал хандуулж тэднийг ажиглах хэрэгтэй болно. Тэгээд арай зальдуулчихалгүй тоглоомоо дуусгалаа гэхэд хууль бус тоглоомыг байнга хориглож, шалгалт хийдэг цагдаа

нараас зугтах аргаа бас олох хэрэгтэй. Мөн мөнгө хожоод, цагдаагаас бултаад гарлаа гэхэд хожсон мөнгөө цуглуулж авна гэдэг том асуудал үүснэ. Тэр хавиар ямар ч мөнгөгүй ядуу луйварчид их. Танхай этгээдүүд тэнд байгаа тоглогчдын амьдралын зүгээр нэг өчүүхэн хэсэг нь юм. Хожсон мөнгөө хулгайд алдалгүй, дээрэмдүүлж, буудуулалгүй гарна гэдэг тэр чигээрээ адал явдал гэсэн үг.

Цаг оройхон покер тоглон сууж байтал тэр залуу орж ирээд, миний хажууд сууж байсан хүний толгойд буугаа тулган буудаж, түүний тархийг эсрэг талын ханаар нэг цацаж орхисон юм.

Тэнд тоглож байх хугацаандаа нийтдээ таван хүн янз бүрийн шалтгаанаас болж бусдад алагдахыг би харсан. Нэг удаа яг миний хажууд суугаад покер тоглож байсан хүнд ийм явдал тохиолдсон юм. Танхимын захад хоёр тоглоом явагдаж байлаа. Нэгэн дээр нь би тоглож байв. Би покер тоглож байх үедээ мах савладаг үйлдвэрт ажилладаг нэг залууг мэдэх болсон юм. Бид тийм ч сайн найзууд биш ч, ямар ч байсан бие биенээ танина. Оройхон покер тоглон сууж байтал тэр залуу орж ирээд, миний хажууд сууж байсан хүний толгойд буугаа тулган буудаж, түүний тархийг эсрэг талын ханаар нэг цацаж орхисон юм.

Хоёрхон секундын өмнө инээлдэн, хөгжилдөн байсан хүн яг миний хажууд үхдэл болсон байлаа. Иймэрхүү тохиолдол хэнийг ч юм бодоход хүргэнэ. Сүүлд нь сонсоход тэр хоёр хоорондоо хүүхний асуудалтай байсан юм билээ. Яг тухайн тохиолдолд дахин сум исгэрэн ульж эхлэхээс өмнө тэндээс аль болох хурдан гарахыг зорьцгоож байлаа. Бид бүгдээрээ арын хаалгаар чихцэлдэн гарахаар дайрцгаав. Энэ тухай тэнд байсан хүмүүсээс хэн ч цагдаад хэлэхийг хүсээгүй.

Форт Вортын хойд хэсэгт би хоёр жил гаруй амьдарсан. Дараа нь хотын төвд арай гайгүй хүмүүстэй тоглож эхэлсэн юм. Тэр үеэс би Техас даяар бас ойр хавийн мужуудаар явж тоглодог болов. Мэдээж зарим газарт уригдаж тоглоно. Тэр үед хэрэв тоглож чаддаг л бол тун амархан алдаршиж олонд танигддаг үе байлаа. Тэгж яваад Сейлор Робертс, Амарилло Слим нартай баг болж, хамт явж тоглодог болсон юм. Бид бие биендээ ч харилцан тусладаг байлаа.

Тэр үед маш аюултай байсан хэдий ч би хичнээн удаа дээрэмдүүлснээ одоо хирнээ санадаггүй юм.

Тэр дээрэмчдийн нэг нь буугаа давхар цэнэглэн, миний цохон дээр тулгаж "За, чамаас сүүлчийн удаа асууя, энэ тоглоомыг хэн явуулдаг вэ?" гэж маш зэвүүн өнгөөр асуув.

Бас нэгэн тохиолдлыг сайн санаж байна. Аустинд нэг залуугийн хувийн байшинд томоохон тоглолт хийдэг байлаа. Тэнд хэд хэдэн ширээн дээр зэрэг тоглоно. Гэтэл гэнэт пис пас хийх чанга дуу чимээ гарч, нүүрээ халхалж баг өмссөн хэсэг залуус буу барьсаар цонх хагалан орж ирсэн юм. Тэд биднийг хана дагуу нэг эгнээ болгон зогсоогоод бүгдийнх нь өмдийг хөлийн шагай хүртэл нь шувтлуулав. Тэдний нэг нь бидэнд хандан "Бид та нарт байгаа бүх мөнгийг авах болно, гэхдээ бүгдийг чинь нэгжих хугацаа алга, иймд та нарын дундаас заримыг чинь сонгож нэгжинэ. Хэрвээ мөнгөө нуусан хүн гар Ван түүний хөлийг хуга буудна" гэв. Дөнгөж хэлж дуусангуут л миний хажууханд зогсч байсан нэг залуу тэдэнд хандан "Залуусаа, миний халаасанд 400 доллар байгаа" гэтэл, бас нэгэн тоглогч "Миний цамцны халаасанд 600 доллар

байгаа түүнийг авахдаа битгий мартаарай" хэмээн бувтнав.

Тэгтэл шувууны буу шиг хоёр хошуу бүхий буутай дээрэмдэгчдийн нэг нь надруу ойртон ирж "Энэ тоглоомыг хэн явуулдаг вэ?" хэмээн асуусан юм. Түүний хариуд би олон юм бодолгүй шууд л "Би мэдэхгүй ээ" гэхэд, тэрбээр миний хариултад дурамжхан байсан тул миний гэдэс руу буугаараа хүчтэй цохиж, асуултаа давтан "Энэ покер тоглоомыг хэн явуулдаг вэ?" хэмээн дахин асуулаа. Сурсан зан ч юм уу, аль эсвэл зарчим маань болсон байсан уу, би дахиад л "Би мэдэхгүй ээ" хэмээн хариултал тэр маш ихээр уурлан буугаа авч толгой руу цохин, "За, одоо энэ тоглоомыг хэн явуулдаг болохыг мэднэ биз дээ?" хэмээн заналтайгаар асуухад, "Би мэдэхгүй ээ" хэмээн хэлтэл, тэрбээр буугаа давхар цэнэглэн цохон дээр тулгаж "За, чамаас сүүлчийн удаа асууя, энэ тоглоомыг хэн явуулдаг вэ?" гэхэд би хариуд нь "Тэр залуу, тэнд зогсч байна" гэж билээ.

Тэгэхэд зоригтой ч мөн тэнэг байж дээ.

Заримдаа би өнөөгийн тансаг казинод тухтай, тааваараа суун покер тоглож байгаа залуу тоглогчдыг хараад, покер тоглохын тулд бидний туулж өнгөрүүлсэн тэр хүнд үеийг зайлшгүй дайрч гарахаас өөр аргагүй байсан гэдгийг тэд одоо төсөөлдөг болов уу хэмээн хааяахан боддог юм. Үнэндээ одоогийн залуучууд бид хаанаас яаж ирснийг хүндлэх ёстой. Хэрэв бид тийм нөхцлийг даван туулж гарч ирж чадаагүй бол покер нь өнөөгийн түвшинд хүртэл хөгжихгүй байсан болов уу. Тийм ч учраас Лас Вегас ингэтлээ хөгжсөн байгаа биз ээ.

Хорт хавдар хүндэрсэн байна гэхэд надад хийж чадах нэг ч зүйл байхгүй байсан. Тэд надад амьд явах гурван сарын л хугацаа байна гэв.

Хэдэн жил покер тоглосны дараа би амьдралын маш хүнд үетэй нүүр тулсан юм. Намайг хорт хавдартай хэмээн онош гарав. Таван эмч дараалан шалгасны дараа хорт хавдар толгойноос бие рүү тархсан нь оношоор тогтоогдов. Түүний дараа юу хийх, яахаа огт мэдэхгүй сонин байдалд орлоо. Тэгэхэд би дөнгөж 28 настай байлаа. Үе тэнгийн залуучуудын адил миний амьдрал урд минь байгаа хэмээн би боддог байв. Ямар ч байсан хагалгаа хийж үзье, нээж харснаар арай илүү ойлголттой болж магадгүй гэж эмч нар шийдээд мэс засал ч товлогдлоо. Тэд нээж хараад л буцаагаад оёсон. Эмч нар "Бид юу ч хийж чадахгүй, хавдар хүндэрсэн байна. Чамд гурван сарын амьд явах хугацаа байна" гэж надад хэлсэн. Ойлгомжтой, би шууд л нурж унан, хүнд байдалд орсон.

Гурван долоо хоногийн дараа Хьюстонд байдаг хамгийн шилдэг хавдар судлалын эмнэлэгт очин дахин шалгуулж үзүүлэхээр шийдэв. Түүндээ их өөдрөг байгаагүй. Хавдартай тэмцэх талаар надад ямар ч бодол байгаагүй. Зүгээр л боломжит бүх хувилбаруудыг оролдож үзэхийг хүссэн сүүлийн сонголт нь тэр байлаа. Хьюстоны эмч нар ч хавдрыг нээж харахыг хүсэв. Тэд юу харсан бэ гэвэл итгэмээргүй зүйлийг олж мэдсэн. Хавдар тэр чигээрээ байхгүй болсон, ерөөсөө би зүв зүгээр эрүүл болсон байжээ.

Үүний дараа би эхний эмч нар буруу оношилжээ гэж бодсон. Тэд байхгүй зүйлийг байгаа мэтээр хэлсэн гэдэгт би итгэлтэй байгаагаа Хьюстоны эмч нарт хэлэхэд тэд "Үгүй ээ, чиний онош зөв гарсан, чиний радиограф нэлээн хүнд хэлбэрийн хавдрыг харуулж байна" гэв. "Иймэрхүү тохиолдол маш ховор байдаг, хавдар ингэж ор мөргүй алга болох нь бурханы

уучлал байх" хэмээн эмч нар тайлбарлав. Энэ бол 47 жилийн өмнөх явдал юм.

Үнэндээ Техаст покер тоглож байхад покер зөвхөн хууль бус төдийгүй дээрэмчин, хулигаан, үл бүтэх этгээд болон бусад бохир заваан үйлдэлтэй адил ойлгогддог байлаа.

Тэр үеийн миний өвчний түүх, эмнэлгийн оношийн дэвтрүүд хаа нэгтээ одоо болтол байгаа л байх. Тэр бол гайхамшиг байсан, үүнээс өөр үг огт олдоогүй дээ. Тэр үед миний амьдралд Бурхан гэж байгаагүй. Харин Бурхан миний амьдрал дундуур орж ирсэн гэдэгт би итгэдэг. Энэ бол Бурханы анагаах хүчний үйлчлэл байсан нь гарцаагүй.

Эмнэлгээс гарч явж байхдаа урьд өмнө нь хэзээ ч анзаарч байгаагүй зүйлээ харж эхэлснээ би санадаг. Тэнгэр яасан хөх юм бэ, цэцэгс ямар гоё юм бэ гээд их олон зүйлийг өөрөөр хардаг болов. Энэ бүхний эцэст би амьдралын үнэ цэнийг ойлгож түүнд талархан ханддаг болсон юм. Энэ үеэс эхлэн би амьдралынхаа үлдсэн хэсэгт юу хүссэн дуртай зүйлээ хийж, түүнээсээ сэтгэлийн ханамж, таашаал авч амьдрахын чухлыг ойлгож мэдэрсэн. Тэр бол покер тоглох явдал байлаа.

Покер миний оюун ухаанд байсан. Ганц хүндрэл нь би ер нь покер тоглох уу аль эсвэл ажил хийж амьдрах уу гэдгээ ялгагдаггүй байлаа.

Хавдрын тухай асуудал гэнэт орж ирээгүй бол би бараг л буцаж ажиллах хүчний эгнээнд орж, ажил хайх байсан. Эхнэр маань хүртэл нэг боломжийн ажил хий хэмээн байнга сануулдаг байв. Түүнд би ажил хийнэ гэж амладаг байсан.

Өвчний дараахнаас покерыг мэргэжил болгох хүслийг маань эхнэр зөвшөөрч бид гэр бүлээрээ Лас Вегаст нүүн ирж, тэндээ амьдарцгаах болов. Тун удалгүй эхнэр маань покерын ширээний араас олж ирж байгаа мөнгийг хараад миний гаргасан шийдвэрт тааламжтай хандах болсон гэдэгт би итгэдэг. Тэгээд ч покер тоглон гэр бүлээ тэжээх нь боломжтой гэдгийг ухаарсан юм.

Покерыг ажлаа болгоно гэдэг нь хүн бүрт тохирохгүй, энэ нь яг л мэргэжил шиг, үүнд зөв хандлага, чадвар хэрэгтэй. Түүнгүйгээр амжилтад хүрэхгүй.

Үхлийн ирмэг дээр ирснийхээ дараа би покерыг мэргэжил болгохоор шийдэв. Үүнийгээ олон нийтэд зарлахыг тэр үед хүсээгүй. Өнөөдөр бол мэргэжлийн покер тоглогч гэдэг нэр хүндтэй мэргэжил. Харин тэр үед бол байдал шал өөр байлаа. Үнэндээ Техаст покер тоглож байхад покер зөвхөн хууль бус төдийгүй дээрэмчин, хулигаан, үл бүтэх этгээд болон бусад бохир заваан үйлдэлтэй адил ойлгогддог байсан.

Олон нийтийн дунд, нийгэмд покер тоглодог хүмүүсийг ихэд тааруухнаар үнэлж, бараг ад үзэх нь холгүй байлаа. Тэр ч бүү хэлпокерчдыг "хоёрдугаар зэрэглэлийн хүмүүс" шиг ялгаварлан гадуурхаж ханддаг үе байлаа. Коллежид хамт сурч, нэг өрөөнд амьдардаг байсан найз маань гудамжинд тааралдаад "Сайн уу" гэж хэлэхээс цэрвэн, хажуугаар зөрж өнгөрсөн нь ердөө л миний покер тоглож түүгээрээ амьдардагтай холбоотой байв.

Түүний энэ хандлага надад их зүйлийг бодогдуулсан. Тэр цагаас хойш өөрийнхөө сонгосон

покерын мэргэжлийн талаар гэр бүлийн хүрээнийхнээсээ өөр хэнд ч ярихаа болив. Үүнийгээ хөршөөсөө хүртэл нуусан. Учир нь миний сонгосон сонголтоос болоод эхнэр хүүхдүүд минь янз бүрийн гутаан доромжлолд өртөх, санаа зовоосон элдэв асуудал үүсэхээс сэрэмжилсэн юм.

Тэр ч байтугай Хардин Симмонс их сургууль хүртэл намайг спортын алдартнуудынхаа жагсаалтад оруулалгүй 30 жил болсон нь бас л миний сонгосон покерын мэргэжлээс болсон биз ээ. Энэ нь тэд покерыг ёс суртахуунгүй зүйл гэж үздэг байсантай холбоотой. Бүр сүүлд тэд намайг алдартан болгосон гэдгээ мэдэгдэж захиа ирүүлсэн юм.

Харин өнөөдөр бол намайг зүгээр босоод ариун цэврийн өрөө орох замд хүмүүс миний гарын үсгийг гуйж, зургаа хамт авахуулахыг байнга хүсдэг. Нийгмийн сэтгэл зүй үнэхээр маш их өөрчлөгдсөн. Мэдээж ийм түвшинд хүрэхэд урт хугацаа шаардагдсан.

Намайг покероор амьдардаг гэдгийг хүмүүс хүлээн зөвшөөрөх хүртэлх үеийн хамгийн сүүлд болсон нэг тохиолдлыг би сайн санаж байна. 1970-аад оны эхээр би Покерын дэлхийн цуврал тэмцээнд оролцов. Шувтаргын тоглолтод Пагги Пийрсон, Амарилло Слим бид гурав үлдлээ. Тэр үеэр гэнэт сэтгүүлчид, телевизийн сурвалжлагч нар гарч ирсэн нь урьд өмнө хэзээ ч болж байгаагүй үзэгдэл байсан. Би сурвалжлагчдаас түр азнахыг хүсээд, хамт тоглож байсан залуустаа хандан хэвлэл мэдээллээр олон нийтэд ил гарах сонирхолгүй байгаагаа хэлэв. Хэвлэл мэдээллээр нийтэд ил гарсны дараа Техаст байгаа гэр бүлийнхэнд маань ямар нэг муу зүйл тохиолдохоос болгоомжилж санаа зовсон юм. Тэднийгээ надаас болж зовох вий гэсэндээ л ингэсэн хэрэг л дээ. Үнэндээ би ТЭДНИЙГЭЭ зовоохыг хүсээгүй. Пагги надтай мөн адил олны өмнө гарахыг хүсээгүй юм. Харин Слим "Би зөвшөөрч байна" гэсэн. Тэгээд бид тэмцээний зохион байгуулагч Жак Мак Клеландтай уулзаж зөвлөлдөн энэ байдлаа хэлэхэд тэрбээр зөвшөөрөв. Би өвчтэй гэдэг шалтгаанаар тэмцээнээс гарах болж, өөрийн цуглуулсан 40 мянган доллараа авч тэмцээнийг орхисон. Эцэст нь Слим энэ тэмцээний аваргаар тодорч, энэ нь түүнийг покерын нэр хүндтэй төлөөлөгч, бэлэг тэмдэг нь болгосон билээ. Учир нь тэрбээр тэмцээний дараа бүх ярилцлага, уулзалтад оролцсон хэрэг. Хэрэв би тэмцээнээ үргэлжлүүлэн тоглосон бол тэр бүгдийг хийж чадах байсан.

Хамгийн сонирхолтой нь гэртээ ирээд энэ болсон явдлаа гэрийнхэндээ ярьж, та нарыгаа эвгүй байдалд оруулах байх гэж бодоод тэмцээнийг орхисноо хэлэхэд, тэд "Өө, юунд тэгээ вэ, тийм шийдвэр гаргах хэрэггүй байсан юм, хэрэв түрүүлсэн бол бид бахархах байсан юм, та олон нийтийн өмнө гарах ёстой байсан" гэж хэлцгээсэн. Манай гэр бүлийнхэн миний мэргэжлийн покерч гэдгийг хүлээн зөвшөөрч байгааг ингэж л ойлгосон доо. Тэгээд би тэдэнд дараачийн удаа боломж гарвал заавал түрүүлнэ, тэгээд бүх ярилцлага, уулзалтад орно гэж амласан.

Покер бол тэнгэрт хөвөх үүлс мэт эргэн тойрондоо чөлөөтэй эргэлдээд л яг үүн шиг эрх чөлөөт байдлыг надад авчирдаг.

Покероор хэр зэрэг хол явахыг хэлэхэд үнэхээр хэцүү. Жирийн тоглогчоос од болно гэдэг тийм ч амаргүй. Энэ өөрчлөлтийг би хүндэтгэдэг. Тэгээд ч би өөрийгөө од биш зүгээр л покер тоглогч гэж үздэг. Маш олон залуу тоглогчид өөрсдийгөө одод хэмээн боддог. Энэ нь покерын үндсэн зарчимаас хамаагүй хол хөндийрч байгаа хэрэг гэж би боддог. Чухамдаа яг

покерын тухайд бол зөвхөн өрсөлдөөний тухай л ярихаас хүмүүсийг зугацуулж цэнгүүлэх, телевизээр нийтэд ил гарах тухай огт боддоггүй.

Зарим хүмүүс надаас "Та өөрийнхөө амьдралаа эргэн хараад покерыг мэргэжил болгосондоо харамсдаг уу?" гэж асуудаг. Түүнд нь би "Үгүй" гэж хариулдаг. Би покерын өрсөлдөх байдалд үргэлж дуртай байдаг. Спортоос ялгаатай нь покер бол маш багахан хугацаанд хамгийн дээд түвшиний өрсөлдөөнд оролцох боломжийг хүмүүст олгодог. Хэрэв хүмүүс покерын ширээний ард сууж байх л юм бол өрсөлдөх боломжтой, тэр байдлаа хэр удаан үргэлжлүүлэхийг тэдний хүсэл зориг л мэднэ. Ийм ч учраас покер нь миний өрсөлдөх дур хүслийг минь гүйцэлдүүлэх хэрэгсэл болж өгсөн.

Покер бас маш агуу чөлөөт байдлыг надад бий болгож өгсөн. Покерт чи өөрөө өөртөө эзэн, чи хэзээ тогломоор санагдана, хэзээ хүснэ тэр үедээ тоглох боломжтой. Үлгэрлэвэл, тэнгэрт хөвөх үүлс адил эрх дураараа эргэлдэнэ, яг үүн шиг би эрх чөлөөтэй.

Түүнээс гадна покер тоглоод олж байгаа мөнгийг мартаж болохгүй. Өнөөдөр тэмцээнд оролцоод юм уу эсвэл бэлэн мөнгөний тоглолт хийгээд маш их хэмжээний мөнгө олох боломжтой. Ширээн дээр байгаа мөнгөнөөс илүү ихийг ч олох боломжтой. Шилдэг тоглогчид өөрдөө том сурталчилгаа болж өгдөг төдийгүй бас их хэмжээний мөнгөөр покертой холбоотой бизнес, сурталчилгааны ажлууд явагддаг.

Покер бас миний амьдралын чухал дотоод ертөнцийг нээж өгсөн. Покер надад юу хүсч байгаагаараа бус, зөвхөн өөрт байгаа гарын модоороо өөрийнхөө ур чадвар, оюун ухааныг ашиглан хамгийн сайн үр дүнд хүрэхийн төлөө тоглож сурах хэрэгтэйг зааж өгсөн.

Энэ олон жилийн туршид покерын ширээний араас өөрт ашигтай, хэрэгтэй олон зүйлд суралцсан. Үүгээрээ би покерын мэргэжил ямар ч асуудалгүй гэж хэлэх гээгүй шүү. Хамгийн гол зөрчил бол хүн дотроо өөрөө өөртэйгээ зөрчилддөг. Сайн, шилдэг тоглогчид маш их цаг, хүч энергээ покер тоглоход зориулдаг. Тэр хэрээр гэр бүл найз нөхөддөө зарцуулах цаг зав багасч, тэднийгээ зөнд нь орхидог.

Бас дээр нь покерчдын амьдралын хэвшлийг авч үзэх хэрэгтэй. Покер тоглогчид улам алдартай болохын хэрээр хүсэл шунал, тачаал байнга нэмэгддэг. Хар тамхи, хүүхэн, мөрийтэй тоглох зэрэгт донтох нь их. Тэр эргүүлгэн дунд амьдралаа алдчихалгүй аваад үлдэх чадвар хэрэгтэй. Олон сайн нөхөд маань хар тамхинд орж, амьдралаа алдахыг би харсан. Энэ бол маш том эрсдэл.


Түүнчлэн ширээн дээр алдсан алдагдал, хожигдлоо хэрхэн яаж хүлээж авах вэ? гэдэг чухал асуудал юм. Шилдэг тоглогчид хүртэл хараал урсган минчийтлээ уурлаж, бүр дампуурах нь ч бий.

Покерыг мэргэжлээ болгох нь хүн болгонд байж болох зүйл мөн үү? Үгүй, яг л бусад мэргэжил шиг покерт амжилт олоход зөв хандлага, чадвар хэрэгтэй. Покерын зөв хандлага гэдэгт покер тоглоход үнэхээр дурлах, хүсэх, өрсөлдөх тэмүүлэл, хожих зорилго бүгд орно. Надад байгалиас заяасан өрсөлдөх хүсэл маань покерт амжилт олоход үнэхээр түлхэц болсныг би мэднэ. Харин чадварын хувьд хэлэхэд маш сайн ой санамжтай байх хэрэгтэй.

Бүх сайн тоглогчид чадвар муутай тоглогчдыг бодвол тоглолт дууссаны дараа олсон бүх явцыг сэргээн санах чадвартай байдаг. Миний хувьд бол 40, 50 жилийн өмнө тоглож байсан хөзрийн хослолуудаа ч мартаагүй. Тэгэхэд юу болсон, яагаад тийм болсон зэргийг бүгдийг санадаг болохоор дахин тийм тохиолдолтой таарахад яах ёстойгоо төвөггүй мэддэг. Үүн дээр нэмж хэлэхэд, тэмцээний ачааллыг дааж, давж гарч чадах чадвар маш чухал. Мэргэжлийн бусад тамирчид шиг хүнд хэцүү, дарамттай үед түүнд төөрөгдөлгүй ухаалгаар бодож, сэтгэж, тухайн нөхцөл байдалд зөв дүгнэлт өгч сурах хэрэгтэй. Үүгээрээ л аварга хүн эхлэн суралцагчаас ялгаатай. Миний хувьд бусад хүмүүсийг бодвол хүнд байдлыг даван туулахдаа тэднээс хавьгүй илүү байдаг. Бас тийм чадвараараа надаас ч илүү олон сайн тоглогчидтой хүртэл өрсөлдөж байсан.

Хэрэв өрсөлдөх чадвар маань хэвээр байх юм бол аль болох удаан хугацаагаар покер тоглохыг би хичээж байгаа. Одоогоор бараг 50 жил тоглолоо. Энэ бүх хугацаанд покер надад дотно байсны адил би ч гэсэн цаашид покерт дуртай хэвээр байхыг хүсч байгаа. Эцэст нь хэлэхэд би покерт үнэхээр дуртай хүн байсан гэдгээрээ түүхэнд үлдэхийг хүсдэг. Бас дээр нь бусад шилдэг тоглогчдыг бодвол дээд түвшинд хамгийн удаан тоглосон тоглогч, түүнчлэн ширээний ард өөрөө өөрийгөө хамгийн шударгаар, нэр төртэй, итгэлтэйгээр удирдаж байсан тоглогч гэдгээр онцлон тэмдэглэгдэхийг хүсч байна. Эцэст нь покерыг бодитойгоор хөгжүүлэн, сурталчлан дэлгэрүүлэхийн төлөө бүхнээ зориулсан гэдгээрээ дурсагдахыг хүсч байна.

Хэрэв та Дойл Брансонтой покер тоглохыг хүсвэл Дойлын интернетийн doylesroom.net гэсэн хаягаар орж тоглож болно. Тэрээр хавдрыг бууруулах, урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг Америкийн Хавдар Судлалын Нийгэмлэгийг (www.cancer.org) санхүүжүүлдэг. Энэ байгууллага нь үндэсний хэмжээний, олон нийтийн үүсгэл санаачлагын сайн дурын эрүүл мэндийн байгууллага юм.



Жонни Чан

Жонни Чан бол покерын ертөнцөд үнэхээр домогт хүн. Тэр маш содон өвөрмөц, гоц чадвараа покерын түүхэнд харуулсан. Ж.Чан олон жилийн туршид хамгийн шилдэг гэдгээ харуулсан хэдий ч ирээдүйд түүний өмнө их урт зам бий.

Хэзээ ч хүчтэй өрсөлдөгч байдаг тэрээр 1987, 1988 онд Покерын дэлхийн цуврал тэмцээний аваргыг дараалан авсан юм. Ер нь бол гучин жилийн хугацаанд Покерын дэлхийн цуврал тэмцээний 10 бугуйвчийг авсан алдартан. Тэрбээр домогт тоглогч болохоо олон удаа харуулсан. Покерын ертөнцийн хамгийн ширүүн тэмцээнд төдийгүй маш их мөнгөний бооцоотой тоглолтуудад тэрбээр тогтмол дээгүүр байр эзэлж, хождог байлаа. Тэр хэзээ ч хаана ч ширээн дээрх уур амьсгалыг бүрэн удирдаж чаддаг.

Жоннигийн чадварыг покерын тухай Холливудын кинонд хуртэл гаргасан. "Rounders" кинонд

1988 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний үеэр Эрик Сайделыг урхинд оруулан хожсон тухай тод томруун харуулсан. Түүний покерын хөгжилд оруулсан их хувь нэмрийг үнэлэн 2002 онд Покерын шилдгүүдийн жагсаалт (Poker Hall of Fame)-д оруулсан билээ.

Лас Вегасын "World" казиногийн (одоогийн Стратосфейр) эзэн Боб Стюпак Америкийн цом гэдэг тэмцээнийг явуулдаг байлаа. Тэр тэмцээний сүүлийн шатанд би бусад есөн тоглогчийн хамт үлдэв. Тэднийг хоёр цагийн дотор л буулгаж авсан. Тэмцээний дараа Боб над дээр ирж "Жонни, чи тэднийг тэнд огт байгаагүй юм шиг л дайраад гарлаа шүү, чи яг л "Дорнын буухиа" шиг байлаа" гэв. Тэр цагаас хойш энэ нэр миний хоч болон үлдсэн юм. Энэ хоч маань миний арга барил болсон. Намайг дэлхийн хамгийн шилдэг тоглогч болоход энэ бүгд их тус болов.

Магадгүй, миний сурсан хамгийн чухал зүйл бол мөнгөний үнэ цэнийг ойлгосон явдал. Мөнгийг олох, хадгалах, хамгаалах талаар ч их зүйлийг суралцсан. Мөнгийг олох хэцүү харин үрэх маш амархан. Харин алдсан тохиолдолд эргүүлж олж авна гэдэг бүр ч хэцүү.

Би покероор маш өндөр амжилтанд хүрч чадсан. Дөнгөж покер тоглож эхэлсэн үеэ хэзээ ч мартдаггүй. Манай гэр бүл Хонконгоос АНУ-д 1968 онд намайг 11 настай байхад ирж Финикс, Аризонад суурьшсан юм. Манайхан тэнд хувийн зоогийн газартай байлаа. Гэтэл бидний хэн нь ч англи хэл мэддэггүй байв. Би англиар зөвхөн "тийм" эсвэл "үгүй" гэдэг хоёрхон л үг мэднэ. Ямар ч асуулт асуусан тэр хоёр үгээрээ л хариулах бөгөөд огт хамааралгүй асуулт байсан ч хариулт нь яг ижилхэн. Жишээ нь, хэн нэгэн "Жонни, Хонконгт өсч томроход хир байсан вэ?" гэж асуухад "Тийм ээ" л гэж хариулна.

Манай сургуулийн мянга гаруй хүүхдүүдээс би ганцаараа хятад байсан учир яах ч аргагүй бусдаасаа ялгарна. Эхэн үедээ англи хэл сурна гэдэг маш хэцүү байлаа. Хүүхдүүд намайг гайхан харцгаан, миний аялгаар шоолж ярьцгааж, бөөн инээд наргиан болно. Намайг гадуурхаж, дээрэлхэх явдал их гаргадаг ч би тэдэнд огт гомдоллодоггүй байсан. Энэ хэрсүүжилт маань намайг хатуужуулж өгсөн юм. Хэдийгээр надад хэлний бэрхшээл байсан ч хичээлдээ би сайн байсан. Миний хамгийн дуртай хичээл маань математик байлаа. Математик бол ер нь хэнд ч ойлгомжтой байдаг шүү дээ. Үнэн шүү. Тоо бодоход англи хэлийг төгс мэдэх шаардлагагүй шүү дээ.

Гэр бүл маань 1973 онд Хьюстон руу нүүлээ. Хьюстон ч хөгжихийн хэрээр тэндхийн ази хороолол улам томорсоор байлаа. Тэнд манайх Хой Сай Гай гэдэг том зоогийн газар нээв. Англиар "Аугаа эргүүлэг" гэсэн үг л дээ. Ази заншлаар хүүхдүүд нь гэр бүлийнхээ бизнест туслалцдаг уламжлалаас би ч бас гажаагүй. Олон цагаар ажиллаж, хийх ёстой бүхнийг нь хийдэг байлаа. Шал угаана, жорлон цэвэрлэнэ, ширээ цэвэрлэнэ, заримдаа хоол хүртэл хийдэг байв. Манай гэрийнхэн бүгдээрээ л байдгаараа зүтгэцгээсэн дээ. Тэр үед л би энэ бол миний хийх ажил биш юм байна, үүнийг насан туршдаа хийхгүй гэдгээ ойлгож авсан юм. Гэхдээ ингэж хүнд ажилд нухлагдсанаар маш олон зүйлд суралцсан. Тиймээс ч тэр бүх чанарууд намайг өдий хүртэл авч яваа билээ. Тэр бүхнээс миний сурсан хамгийн чухал зүйл бол мөнгөний үнэ цэнийг ойлгосон явдал. Мөнгийг олох, хэмнэх, хадгалах, хамгаалах талаар ч их зүйлд суралцсан даа. Мөнгийг олох хэцүү харин үрэх амархан. Харин алдсан тохиолдолд эргүүлж олж авна гэдэг бүр ч хэцүү.

Ахлах сургуульд суралцаж байх үед гэр бүлийнхээ зоогийн газарт байнга л ажиллаж байлаа. Дараа нь Хьюстоны Их Сургуульд орсон үедээ хүртэл ажилласан юм. Коллежид зочид буудлын удирдлагын чиглэлээр суралцсан ч энэ мэргэжлээрээ амьдралынхаа туршид явахгүй гэдгээ ойлгож билээ.

Тэрхүү зоогийн газарт ажиллаж байхдаа би анх удаагаа покер тоглож үзэв. Өнөөгийн маш олон залуус онлайн-аар покер тоглож сурсан байдаг. Намайг анх покер тоглож сурч эхэлж байхад онлайн гэдэг юмны сураг ч байгаагүй. Амралтын өдрүүдэд ажлын цаг дууссаны дараа зоогийн газраа хааж байгаад анх тоглоцгоож билээ. Дилерийн сонголтоор 50 доллараас нэг долларын дүнгээр Др.Пеппер, бэйсбол, Мексикийн дөрвөлжин, Холдем, Омаха гээд олон тоглоом тоглодог байв. Би эхнээсээ л олон төрлийн тоглоомыг зэрэг сурсан нь өдгөө янз бүрийн тоглоомын олон төрлийн тэмцээнд ямар нэгэн хүндрэл бэрхшээлгүй тоглох гол үндэс суурь минь болсон юм.

Тоглоомд ихэвчлэн манай зоогийн газрын ажилчид, үйлчлүүлэгчид, найз нар тоглоно. Зарим сайн тоглосон үедээ 20 доллар хожно. Энэ нь арван хэдхэн настай хүүхдэд бол их мөнгө байсан. Тоглолт шөнөжингөө үргэлжилнэ. Үүр цайнгуут тоглоомоо дуусган хажуугийн Дэннис кафед орж, өглөөний цайгаа ууцгаана. Хожсон нь бүх хүний хоолны төлбөрийг даадаг байлаа. Энэ нь маш аз жаргалтай сэтгэгдэл төрүүлэх төдийгүй төлбөрийн тооцоог авна гэдэг нэг ёсны бахархал байж билээ.

Тун удалгүй тоглоом зөвхөн зоогийн газрын хүрээнээс гарч, Хьюстоны эргэн тойронд тоглоомын газрууд дэлгэрэв. Хувийн байшингууд дахь тоглолтууд ч бий болов. Тэр бүхэнд би байнга оролцдог байсан төдийгүй тоглоомдоо ч бас нухацтай ханддаг болсон. Эхэндээ задгай мөнгөний төлөө тоглодог байснаа богинохон хугацааны дараа нэлээд их хэмжээний мөнгөний төлөө тоглодог болсон юм.

Би үнэхээр байнга хождог болсноор хуримтлал цуглуулж эхлэв. Ингээд л "Пөөх, би үнэхээр покер тоглоод мөнгө олж байна гэж үү?" хэмээн бодох болсон юм. Хаанаас ч олж мэдсэнийг бүү мэд, ямартаа ч тэндхийн аяллын нэг компани Лас Вегасын Лэндмарк зочид буудал руу үнэгүй аялал зохион байгуулдаг болохыг мэдэв. Тэднийх Лас Вегас руу тусгай аяллыг хүмүүст санал болгохдоо тэнд очоод заавал мөрийтэй тоглоно гэсэн болзолтойгоор уг аялалд хамруулдаг байлаа. Дөнгөж 16 настай хүүхдэд онгоцоор нисч, тансаг өндөр зэрэглэлийн зочид буудалд бууж, бусад хүмүүст "VIP" буюу "онцгой хүн" хэмээн хүндлүүлэх нь үнэхээр итгэмээргүй байсан. Энэ аялалд оролцохын тулд 2500 долларын урьдчилгаа төлж, гурван шөнө, дөрвөн өдөр аялах эрхтэй болох байлаа. Үүнд ирж, очих онгоцны тийз, өрөө, хоол унд бүгд багтана. Покер тоглож олсон мөнгөөрөө аяллынхаа төлбөрийг төлөөд хэсэг нөхдийн хамт явлаа.

Лэндмаркт ирсний дараа нэрийг маань бичсэн энгэрийн зүүлт өгөв. Түүнийг зүүхэд үнэхээр "онцгой хүн" шиг л санагдаж байлаа. Зүүлтийг нь цамцандаа хадаад казинод орж, шууд явсаар блэккекийн ширээнд очив. Ширээний менежер над руу харж, нэрийн хуудсыг минь гүйлгэж уншаад нас болон бичиг баримт асуулгүйгээр "Ноён Ч. танд хэдий хэмжээний мөнгө хэрэгтэй вэ?" хэмээн асууж билээ. Тэр үед казиногийнхон хэдэн настай эсэхийг асуух ямар ч сонирхолгүй байсан юм.

Тэд зөвхөн бооцооны хэмжээг л сонирхож, хэдий хэмжээний мөнгөөр тоглох гэж ирснийг л асууна. Би энд 1970-аад оны Лас Вегасын тухай ярьж байна. Тэр үед тэндхийнхэн "Та мөнгөтэй хэдий ч үнэмлэхгүй байж болно. Энэ бол асуудал биш. Та ийшээ явна уу" хэмээн урьж оруулдаг байсан.

"Танд хэдий хэмжээний мөнгө хэрэгтэй вэ?" гэж түүнийг үргэлжлүүлэн асуухад нь би "За, бүгдийг нь авъя" гэснээр миний урьдчилгаанд өгсөн 2500 доллараа тэдэнд тушаасан хэрэг байлаа.

Орой долоон цагийн үед блэкжекийн ширээнд суув. Тэнд тийм ч сайнгүй байсан болохоор 15 минутын дараа шооны ширээн дээр очиж тоглоход мөн адил амжилт олсонгүй. Тэгсээр байгаад долоо хагасын үед надад байсан бүх мөнгө болох 2500 доллараа бүгдийг нь алдсан юм. Юу ч үгүй болж, хүнд байдалд оров.

Ингээд Лас Вегаст дампуурч эхэлсэн дээ. Санхүүгийн хувьд төдийгүй сэтгэл санааны уналтад оров. Би маш их уурлан бухимдаж, гонсойн гутарч, ичгүүртэй байдалд орж, яахаа мэдэхээ болив. Та төсөөл дөө. Хэрэв мөнгөгүй л бол таны тэр "онцгой хүн"-ий нэр хүнд болоод бусад бүх зүйл цөм утга учиргүй болно. Хамаг зүйл баларч, дээрээс нь бүхэл бүтэн чилийсэн гурван өдөр үлдсэн байлаа. Бүх зүйл төлөвлөснөөр болоогүй тул би гадагш гарч алхахаар шийдэв. Тэр л миний хийж чадах цорын ганц зүйл байлаа. Буудлаасаа гарч хотын төв рүү чиглэв. Зуны Лас Вегасын агаарын халуун ямар гэж санана. Гэвч тэр үед би түүнийг огт анзааралгүй, мэдрэх ямар ч сөхөөгүй явсаар л байлаа. Хэрэв тэр үед цас орсон бол мөн адил мэдрэхгүй л байхсан болов уу.

Би явахаар бэлдэж эхлэв. Гэтэл казиногийн удирдлага өөр төлөвлөгөөтэй байсныг жаахан хүүхэд би яахин ойлгох билээ. Тэгээд ч Лас Вегасын казинонууд их хэмжээний мөнгө хожсон хүнийг зүгээр нэг явуулчихна гэдэг байж боломгүй зүйл.

Эцэст нь би Голден Наггетад тулж очоод дотогшоо орж хартал нүдэндээ ч итгээгүй юм. Тэнд покер тоглож байв. Би казинод покер тоглодог гэдгийг ерөөсөө мэдээгүй. Тэнд уламжлал болсон блэкжек, шоо, рулет зэргийг л тоглодог гэж бодож байлаа. Хэрэв покер тоглодог гэдгийг мэдсэн бол Лэндмаркт хамаг мөнгөө алдахгүй байсан даа хэмээн бодсоор, тэнд тоглож байгаа хүмүүсийг хэсэг хугацаанд ажиглаж зогсов. Тэд нэг их сайн тоглодоггүй болох нь мэдрэгдэв. Би ч тоглохыг үнэхээр үхэн хатан хүсч байлаа. Та миний бяцхан асуудлыг төсөөлж байгаа биз дээ. Надад даанч мөнгө байгаагүй. Цөхрөнгөө барахдаа, яаж мөнгө олох вэ? хэмээн хэсэг бодсоны эцэст гэнэт 200 долларын хязгаартай Мастер зээлийн карттай болохоо гэнэт санаж билээ. Гэвч урьд өмнө нь хэзээ ч зээлийн карт ашиглан мөнгө авч байгаагүй учир мөнгө сольдог цонхон дээрх хүнтэй тун найрсгаар харьцаж, эвийг нь олж, эвтэйхэн асуух хэрэгтэй хэмээн бодсоор очсон юм. Би түүнтэй ямар ч тохиролцоо хийхэд бэлэн байдалтай дөхөж очив.

"Уучлаарай, хатагтай. Надад энэ зээлийн карт байна. Тэгээд..." хэмээн асууж эхэлтэл тэрээр миний яриаг таслан "Та тэгээд бүгдийг нь авах уу" гэв. Энэ нь маш амархан бүтэв.

Зээлийн картын компани зээлийн хүү 19 хувь хэмээн мэдэгдэж, бас дээр нь ийм ч юмны шимтгэл, бас өөр хураамж гэх мэтээр баахан юм ярихыг нь би бараг сонсоогүй. Ер нь 100

хувийн хүүтэй байсан ч огт хамаагүй би авах л байсан.

•••

Үнэхээрийн ялагч болохын тулд хамгийн түрүүнд мөнгөө алдсан хүн ямар байдгийг сайтар ойлгох хэрэгтэй гэдэгт би хатуу итгэдэг болсон. Хожсондоо сэтгэл ханамжтай байхыг мэдрэхээсээ өмнө эхлээд бүх мөнгөө алдсаны дараа ямар байдгийг мэдрэх нь хамгийн чухал гэдгийг би ойлгосон.

•••

Би 200 доллараа барин шууд покерын ширээн дээр очсон. Тэнд 10-20 долларын хязгаартай Холдем тоглоомд хоёр багц улаан (5 ам.долларын) хасаа аван сууж тоглож эхэлсэн. Тэгээд бараг гурван өдөр зогсолтгүй покер тоглоод 30 мянган доллартай болсон. Арван хэдхэн настай хүүхэд 1970-аад оны үед халаасандаа 30 мянган доллартай байна гээд төсөөлөөд үз дээ. Би дотроо машин, үнэт эдлэл, өөр бусад олон зүйлс авна хэмээн бодож эхэлсэн. Хурдхан гэртээ харьж энэ тухайгаа гэрийнхэндээ болон найзууддаа хэлэхийг яарч байлаа.

Би явахаар бэлдэж эхэлсэн. Тэгтэл казиногийн удирдлага өөр төлөвлөгөөтэй байсныг хүүхэд би яахин ойлгох билээ. Тэгээд ч Лас Вегасын казинонууд их хэмжээний мөнгө хожсон хүнийг зүгээр л явуулчихна гэдэг байж боломгүй зүйл.

Тиймдээ ч тэд намайг зүгээр хаалгаараа алхаад гаргуулчихалгүй хэсэг хугацаанд үлдэж, ахиад тоглохыг санал болгосон.

Казиногийн босс нь надад "Ноён Чан, бид танд том өрөө, хоол, лимузин, Лас Вегаст болох ямар ч тоглолтыг үнэгүй үзэх эрх олгож байна" гэхэд "VIP" буюу "онцгой" зэрэглэл, хүндлэл бүхэн намайг эзэмдэн тэр саналыг хүлээн авсан юм. Би хожиж болсон юм чинь дахин давтан хожих нь тийм ч их хэцүү асуудал биш. Зөв биз дээ? Буруу.

Хэсэг хугацаанд сайхан байсан. Мэдээж хэрэг, тэнэг жаахан хүүхэд мөнгөний үнэ цэнийг яаж ойлгох билээ. Олсон хамаг мөнгөө бүгдийг алдсан. Тэгээд гэртээ хоосон, урам хугарсан байдалтай ирсэн. Покерын ширээний ард би бусдаас илүү байдгаа мэддэг боловч олсноо бүгдийг нь алдсандаа өөртөө маш их уурлаж байсан. Хамгийн гол дутагдал нь би алдаанаасаа суралцаагүйд байсан юм. Өөрийгөө хянаж чаддаггүй энэ том алдаагаа ойлгох хүртлээ нэлээн хэдэн казиногийн аялалд явж багагүй мөнгөө алдсаны дараа л ухаарсан. Үнэхээрийн ялагч болохын тулд хамгийн түрүүнд мөнгөө алдсан хүн ямар байдгийг сайтар ойлгох хэрэгтэй гэдэгт би хатуу итгэдэг болсон. Хожсондоо сэтгэл ханамжтай байхыг мэдрэхээсээ өмнө эхлээд бүх мөнгөө алдсаны дараа ямар байдгыг мэдрэх нь хамгийн чухал гэдгийг би ойлгосон.

Лас Вегаст өнгөрүүлсэн аялал дуусч, Хьюстонд эргэн очиж сургуульдаа суралцаж, зоогийн газартаа ажиллаж эхлэв. Мэдээж хажуугаар нь хотын эргэн тойронд покер тоглож байлаа. Гэвч бүх зүйл ондоо, тэс өөр болсон байв. Миний их мөнгө хожсон туршлага амьдралын тухай бодох бодлыг минь тэр чигээр нь өөрчилсөн. Лас Вегаст их хэмжээний мөнгөө алдсан ч гэсэн тэнд маш их хэмжээний мөнгө хийх боломжтой, бас хожих ч болно гэдгээ би мэдэж

байсан. Гол нь хэзээ яаж вэ? гэдэг зөвхөн цаг хугацааны л асуудал байлаа.

Манай гэрийнхэн намайг Хьюстоны Их сургуулийн зочид буудлын менежментийн ангид оруулж өгсөн боловч тэнд би нэг их удаагүй. Учир нь аль хэдийнэ их хэмжээний мөнгөний амтанд орчихсон байсан юм. Сургуульд сурна гэдэг миний оюун бодлоос хол, хамгийн мухарт байлаа. Суралцаж байх хугацаандаа зочид буудлын удирдлагын чиглэлээр ажиллавал жилд ердөө 30 мянгыг л хийх боломжтойг тооцоолов. Гэтэл би Наггетад ердөө долоо хоног хүрэхгүй хугацаанд л түүнийг хийж байсан шүү дээ хэмээн бодсон.

21 нас хүрүүтээ сургуулиасаа гарч, хэзээ ч унтдаггүй хотод очиж, мэргэжлийн покерчин болохоор шийдэв. Би амьдрапынхаа туршид зоогийн газар ажиллахыг хүсээгүй. Би зөвхөн өөрөө өөртөө эзэн байхыг хүссэн. Мэдээж би үүнийхээ хажуугаар хэзээ ч зогсохгүй адал явдал, бас хамгийн чухал нь хорхой хүргэм мөнгөний амтанд хэдийнэ орчихсон байсан юм. Энэ тухайгаа гэрийнхэндээ хэлтэл тэд маш их уурлаж, бужигнажицгааж билээ. "Жонни, Лас Вегас бол нүгэл хилэнцэт бузрын хот" гэж тэд хэлээд "Чи юу бодож байгаа чинь энэ вэ?" гэж намайг мөрийтэй тоглохыг эсэргүүцсэн юм. Тэд надад хайртай учир миний төлөө санаа зовнин ингэж хэлсэн хэрэг. Тэр үед надад эд нар намайг хянахыг оролдож байна гэсэн бодол төрөв. Лас Вегасын мөрийтэй тоглоомчдоос маш цөөхөн хүн л үлддэг гэдгийг тэд мэдэж байсан. Тэр ч бүү хэл, аав маань "Хэрэв чи явах л юм бол дахиж хэзээ ч битгий ирээрэй" гэж хэлснийг санаж байна. Энэ үгс үнэхээр сэтгэлийг минь их зовоосон. Намайг л муу зүйлээс хамгаалахын тулд түүнийг ингэж хэлснийг нь би мэдэж байсан ч энэ бүхэн гэр бүлийнхнийгээ гомдоосон, үргэлжийн сэтгэл зовоосон асуудал байсныг би ойлгосон юм. Тэдний зөв ч байж мэднэ гэж би бодов. Лас Вегас хот олон хүний амьдралаар тоглосныг ч бас мэднэ. Жилд хичнээн хүн Лас Вегаст очиж, нүд ирмэхийн зуур баян болно гэсэн мөрөөдөлтэй яваад буцаж ирэхдээ толгойгоо гудайлган, сүүлээ хавчин мөлхөж ирдэг билээ дээ. Ийм хүмүүсийн тоо хэдэн мянгаар тоологдоно. Би бүсээ дахин нэг шатаар чангалахыг хүсч байна уу? гэж өөрөө өөрөөсөө асуусан. Тэгээд оролдоод үзэж болох юм гэж бодсон. Би оролдоод үзэхээр шийдсэн байлаа. Энэ бол миний амьдралын хувьд хонх цохиж байна гэдэгт би итгэлтэй байсан.

•••

Тэр ч бүү хэл, аав маань "Хэрэв чи явах л юм бол дахиж хэзээ ч битгий ирээрэй" гэж хэлснийг би санаж байна. Энэ үгс үнэхээр сэтгэлийг минь их зовоосон доо. Намайг муу зүйлээс хамгаалахын тулд түүнийг ингэж хэлснийг нь би мэдэж байсан ч энэ бүхэн гэр бүлийнхнийгээ гомдоосон, үргэлжийн сэтгэл зовоосон асуудал байсныг би ойлгосон.

•••

Гэрийнхнийгээ ингэж хэлсэн тэр мөчид надад эргэж буцах ямар ч зам байхгүй болсон юм. "Аав, та ингэж хэлсэндээ гэмших болно шүү" гэж аавдаа хэлээд "Би нэг л өдөр дэлхийн аварга болно, бас их мөнгөтэй баян болно. Би үүнийг хийж чадна. Тэгээд ч би санасандаа хүрэхийг хүсч байна" гэв.

Хувийн хэрэглэлүүдээ машиндаа ачиж аваад Лас Вегас руу явахаар хөдлөв. Хуучин "Камаро" машин маань л харин очих ёстой газраа хүрч чадах болов уу гэдгээс ихэд айж байлаа.

Би огтхон ч эргэж харалгүйгээр гэрийнхээ үүднээс хөдлөв.

Лас Вегаст ирсний дараа эхэндээ нэлээд хүндрэлтэй байлаа. Тэр бүхэн нь миний муу зуршлын гай байсан юм. Покер тоглон мөнгө хожиж байсан ч олсон мөнгөө блэкжек, шоо, спортын тэмцээнд бооцоо тавьж алдана. Эсвэл хэтэрхий удаан тоглосноос тэвчээр барагдаж, буруу шийдвэр гаргана.

Сэтгэлийн хөдөлгөөн бол покерын туршлагатай тоглогчдын өмнө чамайг маш хурдан сүйрүүлэх гол шалтгаан нь болдог. Би бүрэн ялалт байгуулахын тулд эхлээд өөрийнхөө зан авираа хянаж сурах хэрэгтэй гэдгийг сайтар мэдэж байлаа. Гэвч ингэж хэлэхэд амархан боловч хэрэгжүүлэхэд гол учир бий. Сэтгэл хөдлөлөө хянаж сурахаас минь өмнө сэтгэл хөдлөл намайг эзэмдэж байсан болохоор олон тохиолдолд би алдаж байсан. Хэд хэдэн удаа дампуурч, хүнд байдалд орсон учир мөнгө олохоор цагийн ажил хүртэл хийв. Хотын төвд байх "Фрэмонт" казинод тогоочоор ажиллаж эхлэв. Зууш хийгээд шигшиж байхад покерын ширээний ард хасаа хурааж байгаа мэт санагддаг байлаа. Ажлаа дуусангуут гал тогооноос шуудхан покерын өрөө рүү очдог болов. Эхлээд бага мөнгөөр гурваас зургаан долларын хязгаартай Холдем тоглоно. Мөнгө багатай байсан учир гурваас зургаан долларын тоглоом хуримтлал цуглуулах зөв зам байлаа. Миний зорилго бол нэг тоглолтоос 50-100 доллар хожиж, хангалттай мөнгө цуглуулаад дараагийн өндөр бооцоот тэмцээнд тоглох явдал байлаа.

Энэ нь надад сэтгэл хөдлөлөө барих, тоглолтоо хяналтдаа байлгах боломжийг олгов. Ингэж сэтгэл хөдлөлөө дарж, хяналтдаа байлгахын тулд нэлээд хугацаа зарцуулав. Маш их туршлага хуримтлуулсны дараа би Лас Вегаст мэргэжлийн тоглогч болж үлдсэн юм. Тоглохоос өмнө сэтгэл зүйгээ зөв чиглүүлж өгөх хэрэгтэй. Хамгийн гол нь сэтгэл хөдлөлөө ил гаргахгүй байх, дараалан алдсан тохиолдолд сэтгэл санаагаа зөв удирдах, бас хожсон үедээ хэтэрхий сэтгэл хөөрөхгүй байх зэргийг сурав. Ажиглаад байхад даруухан, өөрийгөө хянаж чадсан хүн л голдуу хождог болохыг анзаарч билээ.

Нэг өдөр би ерөөсөө алдаагүй, гэхдээ яг хэзээ вэ гэдгээ тодорхой санахгүй байна. Тэр өдрөөс эхлэн хожиж эхэлсэн дээ. Маргааш нь бас хожсон, түүний дараачийн өдөр гэх мэтээр хожсоор байлаа.

Дорнын буухиа галт тэрэг нэгэнт хөдөлснийг би мэдэж байсан. Бүр хамаг хурдаараа урагшилж байлаа. 1985 онд 300-400 хүнийг хожиж, анхны алтан бугуйвчаа хүртэв. Шагналд нь 185 мянган доллар авч байлаа. Яг тэр мөчид би хийж чадсанаа мэдсэн.

Энэ бүх амжилт маань нүд ирмэхийн зуур болоогүй. Туулж өнгөрүүлсэн энэ бүх цаг хугацааны дараа манай гэр бүлийнхэн бодлоо өөрчлөн намайг хүлээн зөвшөөрч бүр дэмждэг болсон юм. 1987 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний Main Event-д түрүүлсний дараа Хьюстоны сонинд миний тухай нийтлэл гарах үед манай гэрийнхэн "Энэ бол манай хүү!" хэмээн хүмүүст хэлцгээж байлаа. Түүний дараа намайг амралтаараа Хьюстонд очих болгонд тэд хамаатан садан, найз нөхөд рүүгээ утасдаж "Жонни ирсэн, хүрээд ирцгээ, хамтдаа хооллоё" хэмээн дууддаг болсон юм.

Покерын тэмцээнд зөвхөн хожсоноор Лас Вегас дахь бүх юм дуусаагүй. Энэ бол хангалттай зүйл биш. Үүнээс гадна хожсон мөнгөө би хадгалж сурсан юм. Бусад муу зуршлаар даган

алдахгүй байхыг сурах хэрэгтэй байлаа. Намайг бусдад зөвлөгөө өг гэвэл би өөрийн туулсан сургамжаас үндэслэж, хэрэв мөнгөтэй болсон бол түүнийгээ хамгаалж сур гэж л хэлнэ. Лас Вегаст байгаа залуу тоглогчдод анхааруулж хэлэхэд, тэр хавиар дүүрэн шунал бий. Хэрэв чи өөрийгөө сайтар хянахгүй бол хэдхэн хормын дотор дампуурна. Энэ бол зөвхөн казиногийн тоглоомд ч биш. Ер нь шийдэх ёстой ганц асуудал чинь юм гэдгийг санаж яв.

Лас Вегас бол мөрийтэй тоглоомын эх орон. Мөрий тавигсад кино театр, уушийн газар, зоогийн газар, дэлгүүр гээд ер нь хаа сайгүй бий. Жишээ нь, зоогийн газарт хоол идээд сууж байхад хамт хооллож байгаа хүн чинь зурагтаар гарч байгаа тэмцээнийг хараад шууд л "Энэ тамирчин талбайгаа давуулан цохино гэдэгт 100 доллараар мөрийцөх үү" гэнэ. Эсвэл хаа нэгтээгээс сонгон авсан зүйлээ хэлж мөрийцөх санал тавина. Ийм маягаар ямар ч авцалдаагүй гэнэтийн зүйлсээр хэдэн арав, зуун мянган доллараар мөрий тавьцгаадаг юм. Энэ жил болон ирэх жилд хэдэн бугуйвч авах вэ гэдгээрээ хүмүүс сая доллараар мөрийцөж байхыг би харсан. Энэ бол тийм сайхан санаа биш. Би покер тоглохдоо хамаг анхаарлаа төвлөрүүлэхийг л чухалчилдаг. Харин морь, шоо, болон элдвийн мөрийнөөс аль болох хол байхыг боддог. Юунд сайн түүнийгээ хий, дэмий сул зүйлстэй битгий орооцолд.

Лас Вегаст мэргэжлийн покерчин байхдаа сурсан бас нэг зүйл бол биеийн эрүүл мэндээ анхаарч сурсан явдал юм. Анх Невадад ирэхэд биеийн эрүүл мэнддээ нэг их анхаардаггүй байсан. Эрүүл мэндээ анхаарах нь покерт их чухал гэдгийг ойлгохын тулд нэлээн хэдэн жил зарцуулсан. Биеийн байдал муу үед сайн тоглоно гэдэг огт бүтэхгүй зүйл байсан. Покер тоглоход удаан цагаар суух хэрэгтэй болдог. Удаан хугацаанд гүнзгий төвлөрнө. Үүнийг миний бие даахгүй болж эхлэв. 1970-аад онд бараг л хүн бүр тамхи татна, согтууруулах ундаа хэрэглэнэ, эрүүл бус хооллоно, тэр тусмаа биеийн тамираар хичээллэнэ гэж огт боддоггүй үе байлаа. Би ч мөн адилхан. Хэдэн жил ингэж явсаар ядарч, бие муудаж эхлэв. Тамхи, буруу хооллолт, хөдөлгөөний дутагдал зэрэг нь удаан хугацааны тэмцээний явцад миний тоглолтод тодорхой хэмжээгээр нөлөөлөв. Ингээд амьдралын хэв маягаа өөрчлөхөөр шийдэж, өдөрт дөрвөн хайрцаг тамхи татдагаа зогсоож, архи уухаа больж, эрүүл хооллож, дасгал хийж эхэлснээр олон тэмцээнд амжилттай оролцох боломжийг бүрдүүлсэн билээ. Ингэснээр эрүүл, гоолиг, аз жаргалтай Жонни Чан дээд түвшинд хүрэх алхмаа хийж эхэлсэн юм. Байнгын дасгал хөдөлгөөн, зөв хооллолт, хангалттай сайн унтаж амрах зэрэгтээ ихэд анхаарах болов. Үүний үр дүнд эрүүл амьдралын давуу талыг олж мэдсэнээр "Хүч чадлын ус" гэсэн нэртэй хийжүүлсэн ундаа үйлдвэрлэх бизнесээ эхлэв. Энэ ундаа одоо ч бүхэл бүтэн 14 цагийн турш хязгааргүй Холдемийн тэмцээнд оролцож байгаа покерчдод хүнд хэцүү үед нь цовоо сэргэлэн байдлаа хадгалахад тусалдаг юм.

Өнгөрсөн хэдэн жилийн туршид надтай уулзсан бараг бүх хүн "Роундерс" киноны тухай асуудаг. Покер олон жилийн туршид том мөнгөний тоглоом байсаар ирсэн. Гэвч маш олон хүн "Роундерс" киног үзсэний дараа хязгааргүй Техас Холдемийг үндэстний хэмжээнд авч үзэх болсон юм. "Роундерс" киноноос өмнө Жонни Чан миний бие покерчдын хүрээнд л танил бөгөөд зөвхөн тэдэндээ л хүндлэгддэг байлаа.

Харин Сиэтл, Питсбургт очиход хэн ч намайг мэддэггүй байв. Харин мэдлээ гэхэд магадгүй ганц нэг амжилтын тухай сониуч мэдээллээр бага зэрэг халыг мулыг мэддэг байх. "Роундерс"-ыг гарсны дараа дэлхий даяар покер тоглодог, тоглодоггүй хүн бүр Жонни Чаныг таньдаг

болсон юм. Хэзээ ч покер тоглож байгаагүй хүн хүртэл над дээр хүрч ирээд "Та чинь Техас Холдел тоглодог залуу мөн үү?" хэмээн асуудаг.

"Роундерс" кино миний амьдралыг үндсээр нь өөрчилсөн юм. Би нэг шөнийн дотор л од болж хувирсан. Түүний дараа хандив, хүлээн авалт, нээлт зэрэг олон ажиллагааны үүд хаалга нээгдэв. Эрик Сайделыг ялсан миний ялалтын дараа тэд кино зураг авахаар над руу ойртож ирээд асуухад нь, би баярлаж талархсанаа илэрхийлээд нэг бяцхан болзол тавьсан юм. Кинонд зөвхөн би л тоглоно гэв. Кинонд намайг уялдуулахын тулд тэд Магг Дамоны дүртэй миний дүрийг холбох зорилгоор покерын ширээн дээр надтай тэмцэлдэж байгаа миний жижигхэн зураглалыг киноны төгсгөлийн нэмж хэсэгт оруулсан юм.

•••

"Роундерс" кино миний амьдралыг үндсээр нь өөрчилсөн. Би нэг шөнийн дотор од болов.. Түүний дараа хандив, хүлээн авалт, нээлт зэрэг олон ажиллагааны үүд хаалга нээгдсэн.

Эрик Сайделыг ялсан миний ялалтын дараа тэд кино зураг авахаар над руу ойртож ирээд асуухад нь, би баярлаж талархсанаа илэрхийлээд нэг жижигхэн нөхцөл тавьсан.

•••

Би зургаан хүүхэдтэй. Миний сайн аав гэдэг нэр хүнд маань покерчин гэдэг нэр алдраас хамаагүй илүү. Манай хүүхдүүдээс нэг нь ч мэргэжлийн покерчин болоогүй. Тэд онлайн тоглодог. Бид заримдаа гэр бүлээрээ зөвхөн зугаагаа гаргах маягаар хамт тоглоно. Би тэдэнд хэзээ ч покер тоглож болно, эсвэл болохгүй гэж хэлдэггүй. Энэ асуудлыг би тэдэнд нээлтэй үлдээсэн. Харин тэдэнд сайн боловсрол олж авахыг зөвлөдөг. Хамгийн том хүү минь үл хөдлөх хөрөнгийн брокер, хүч чадлын ундааны бизнесийг маань авч явдаг. Хэрэв тэр өөрөө шийдвэр гаргаж, би мэргэжлийн покерчин болно гэж шийдвэл, мэдээж би түүнд покер яаж тоглодгыг зааж өгнө. Гэвч тэрээр одоо хүртэл өөрийнхөө сонирхлыг илэрхийлээгүй л байна. Би ч түүнийг өөрийнхөө амьдралаа өөрчил гэж хэзээ ч зөвлөхгүй. Тэр маань одоогийн амьдралдаа ханамжтай байгаа.

Цаг хугацааны сорилтыг давж туулж дээд амжилтуудын эзэн болсон тоглогч гэдгээрээ би түүхэнд дуурсагдана гэдэгтээ итгэдэг. Гуч гаруй жилийн хугацаанд 10 бугуйвч авснаас гадна миний нэр покерын ертөнцийн түүхэнд хамгийн их олонд алдаршсан юм. Цаг хугацааны туршид ингэж тэсэн үлдэнэ гэдэг тийм амар зүйл биш. Хэрэв надад итгэхгүй бол Мөнгө хүүлэгч хочит Крис, Жимми Голд нараас асууж болно. Тэр хоёр хоёулаа покер ертөнцийн хамгийн дээд түвшинд хүрсэн төдийгүй покерын үндсэн тэмцээнүүдэд ялсан тоглогчид юм. Дээд түвшинд гарна гэдэг ямар хэцүү болохыг тэд мэднэ. Харин тэр орой дээрээ тэсч үлдэнэ гэдэг түүнээс бүр ч хүнд хэцүү гэдгийг тэд бас хэлж чадна.

Дойл Брансон, Фил Хэлмут бид нар цаг хугацааны шалгарлаар шалгарч үлдсэн покерчид юм. Даниел Нигрэану, Аллен Каннинхам, Фил Айви нар бол залуу тоглогчдын төлөөлөл. Тэд нэг их ухаан гаргалгүйгээр покерын алдартнуудын эгнээнд орцгоосон юм. Тэд анхаарлаа сайн төвлөрүүлж, түүнийгээ хадгалж, сэтгэл хөдлөлөө барьж, мөнгөө зөв удирдан тоглож чаддаг юм.

Гучин жил мэргэжлийн покерчин явсан хугацаагаа эргэн харахад, покер надад үргэлж ивээлээ хайрлаж байжээ. Мэргэжлийн покер надад хувийн эрх чөлөө, өөрөө өөртөө эзэн болох боломжийг олгосон юм. Амьдралын бүхий л замаар намайг хөтлөн авч явсан. Би аялах, дэлгүүр хэсэх, тансаг зоогийн газарт хооллох, усанд сэлэх, дасгал хийх дуртай. Би покер тоглох дуртай. Цаашид ч дуртай хэвээр байх болно. Гэвч тэр миний улиг болсон бодол биш. Би долоо хоногт заавал долоо, зургаа, тав, эсвэл дөрвөн өдөр ажиллана хэмээн өөртөө зорилго тавиагүй. Би одоо тоглох тэмцээнээ сонгохдоо нэлээд няхуур ханддаг болсон. Хэрэв тогломоор санагдвал оролцоно, тоглох сэтгэл төрөхгүй бол түүнийг алгасна. Заримдаа покерчид над дээр ирж, яаж илүү сайн тоглох вэ хэмээн асуудаг. Тэдэнд би "Өөрийнхөө хожиж чадах тэмцээндээ оролц. Ширээн дээр суугаад тоглож байгаа үедээ хүндрэл саадыг өөрөө төсөөл, өөрийгөө хяна. Хожих боломжтой байна уу, эсвэл ялагдахаар байна уу гэдгээ тодорхойл. Дараа нь өөрөөсөө асуух хэрэгтэй. Хэрвээ хожигдохоор байвал яагаад тоглож байгаагаа, харин хожих боломжтой санагдвал яагаад түүнээс алгасах ёстой гэж..." хэмээн зөвлөдөг.

Жоннитой JohnnyChan.com гэсэн сайтаар зочлон уулзаж болно. Бас AllinEnergy.com сайтаар орж зочилж болно. Жонни Чан АНУ-ын залууст олон нийтийн боловсролыг олгоход тусалдаг Андре Агассигийн Сан (www.AgassiFoundation.org)-г санхүүжүүлэн дэмждэг юм.



Женнифер Харман

Женнифер Харман бол өндөр бооцоот тэмцээний дэлхийн хамгийн шилдэг тоглогчдын нэг. Арваад жилийн турш Беллажио казиногийн 2000-4000 долларын "Том тоглолт"-д тогтмол оролцож, сая сая доллар хожсон тэрээр Техас Холдемийн дэлхийн хамгийн шилдгүүдийн нэгээр тодорсон юм. Тэрээр покерын тэмцээнээс илүүтэй бэлэн мөнгөний тоглолтыг голлон тоглодог.

Покерын дэлхийн цуврал тэмцээнд хоёр удаа түрүүлсэн цорын ганц эмэгтэй. Тэрээр тэмцээнүүдээс нийтдээ хоёр сая доллар хожсон аж. Анхны алтан бугуйвчаа 2000 оны Покерын дэлхийн цуврал тэмцээнээс авахдаа хэзрийн туг долоогоос бага гэсэн тоглолтоор авч байжээ. Ж.Харман урьд өмнө хэзээ ч энэ тоглоомоор тоглож байгаагүй ч тэмцээний өмнө ердөө таван минутад Ховард Ледерерээр заалгаж тоглоод түрүүлсэн гэдэг.

Покерын тухай тайлбарласан бүрэн хэмжээний ном болох Доил Брансоны "Супер систем-2" номын хязгаартай Техас Холдем бүлэгт Ж.Харман шалгарч орсон байдаг. Ж.Харман өөрийн нөхөр, покерын хамтрагч Марко Траниеллотой 2000 онд гэрлэсэн ажээ. Тэд 2007 оны 11 дүгээр сард төрсөн ихэр хөвгүүдтэйгээ хамт амьдардаг.

Би бараг л покер тоглож өссөн дөө. Гэвч надад хамгийн тод үлдсэн дурсамж бол би оролцон тоглохоосоо илүү хажуунаас нь ажиглан хардаг байлаа. Нэг удаа аав, ээж хоёр найзуудтайгаа хамт аяллын гурван машинтай Невада мужаар аялсан юм. Бид шөнө Тонопа хавьцаа буудаллаж амарцгаав. Томчуул гал тогооны ширээн дээр покер тоглохыг жаахан охин би давхар орон дээрээс анхааралтай ажиглаж байлаа. Тэр үед би зургаан настай байлаа. Тэдний покер тоглохыг ажиглаж байхад итгэмээргүй сонин мэдрэмж төрж байсныг тодорхой санаж байна. Олон өнгийн хасаа, тэдгээрийн ер бусын чимээ, задгай мөнгө болон долларын дэвсгэртүүд ширээн дээгүүр ийш тийш гүйлдэхийг хараад толгой эргэмээр байлаа. Хэдий балчир байсан ч мөнгө гэдгийг мэддэг учир тэр их мөнгийг ширээн дээр тэгтлээ ихээр овоолсон байсан нь миний анхаарлыг өөрийн эрхгүй татсан юм. Тэр бүх ажиглалт маань надад маш гүнзгий сэтгэгдэл төрүүлэв. Миний бүх анхаарал түүнд хүчтэй татагдсан байлаа. Урьд өмнө би покер тоглож үзээгүй байсан ч покер тоглоомын ерөнхий төрх, овоолоостой өнгөт хасаа, тэдгээрийн шажигнах чимээ, бас мөнгө надад хэзээ ч мартагдашгүй дурсамжийг үлдээсэн юм.

Найман настай байхдаа хамаатныхаа хүүхдүүдтэй хамт тав зургуулаа нийлж ойр ойрхон тоглодог байв. Дүрмийн дагуу зөв тоглуулах үүднээс ээж голдуу дилер хийнэ. Бид нэгээс хоёр цаг л тоглоно. Ихэвчлэн тав, эсвэл долоон хэзрийн стад тоглоцгооно. Нэгтийн центээр тоглоход төвөг болдоггүй байлаа. Ээж ч үүнийг том асуудал хэмээн үзээгүй. Тэгээд ч зугаа болгон тоглоно. Тиймээс тоглож байгаа хэн ч мөнгөний талаар санаа зовдоггүй байв. Арван нас хүрэх үед тоглоом маань өргөжиж, манай найз охид бас тэдгээрийн ах нар нэмэгдэн ирж тоглох болов. Голдуу л зугаа хэлбэрээр мөнгөний төлөө гэхээсээ хожлын төлөө л онгирцгоож тоглоно.

Дунд сургуульд байхдаа байнга тоглоогүй ээ. Хааяа л аав болон түүний найз нартай хамт тоглох тоглоомонд оролцдог байлаа. Арван гурван настай байхдаа аавтай хамт хөрш найзынх нь гэрт тоглох тоглоомонд очсоноо санаж байна. Тоглоом эхлээд цаг гаруй хугацаа өнгөрсний дараа аав ихэнх хасаагаа алдав. Тэгээд надаас өөрийнхөө оронд суух уу гэж асуулаа. Дөнгөж арван хэдхэн настай охин ширээ дүүрэн хөгшин эрчүүдийн өмнөөс тоглохоор зэрэгцэн сууж, аавын алдсан хасаануудыг эргүүлж авахаар тоглож эхлэв. Намайг ширээнд суусны дараа аав хамгийн эхлээд "Газарт страйт гарвал орж болохгүй шүү" хэмээн миний чихэнд шивнэсэн. Хариуд нь би уцаарлангуйгаар "Мэдэж байна, би яаж тоглохоо мэднэ" гэв. Мэдээж тоглох аргаа мэдэж байсан болохоор тэр шөнө бид явахынхаа өмнө аавын алдсан хасааг эргүүлэн авч алдагдалгүй ч ашиг ч үгүй тэнцүү болсон доо.

Урьд өмнө би покер тоглож үзээгүй байсан хэдий ч покер тоглоомын ерөнхий төрх байдал, овоолоостой өнгөт хасаа, тэдгээрийн шажигнах чимээ, бас мөнгө надад хэзээ ч мартагдашгүй дурсамж үлдээсэн.

Аавын бас нэг сайн найз нь үргэлж өөрийгөө покерт мундаг яг л мэргэжлийн тоглогч шиг гэж надад хэлж байсан. Арван таван настай байхад тэр манайд ирж, надтай хамт түүний

тоглох дуртай Долоон хэзрийн стад тоглосон юм. Бид гал тогооны өрөөний ширээн дээр өөд өөдөөсөө харан хоёулхнаа мөнгөгүйгээр зүгээр тоглоход тэрбээр надад покер яаж тоглохыг зааж байгаадаа баяртай байсан. Тоглож байхад тэр өөрийн эзэмшсэн олон чадвараа харуулж, тайлбарлан өгч байлаа. Бас казинод нэгээс гурван долларын стад тоглон нэлээн их мөнгө хожиж байснаа ч ярьж өгөв.

Арван зургаан нас хүрснийхээ дараа би түүнийг хэр зэрэг мундаг тоглодог болохыг өөрийн нүдээр харахыг хүслээ. Би яагаад ингэтлээ сониучирхаад байгаадаа өөрөө ч гайхаж байв. Надад хуурамч үнэмлэх байсан учир түүгээрээ казинод амархан орчихов. Покерын өрөөнд оруут түүний тоглохыг араас нь харж суув. Ингэж харж суухдаа "Энэ тоглоомыг би тоглож чадах юм байна" хэмээн өөртөө хэлж билээ. Тэгээд л үүнийгээ ч хийхээр шийдсэн хэрэг.

Маргааш нь сургуульдаа явахдаа хорин доллар авч явав. Хичээлээ таруут казинод очиж покер тоглоно хэмээн төлөвлөв. Бас нэг асуудал гарсан нь тэр өдөр нүдний эмчид очихоор цаг авсан байлаа. Учир нь шинжилгээгээр нүдний хүүхэн хараа тэлж бараг хараагүй болно гэсэн онош гарсан юм. Хагас хараагүй байж казинод очиж покер тоглоно гэдэг тийм ч сайхан санаа биш гэдгийг мэдэж байсан. Гэвч покер тоглоно гэхээс тэсч ядаж байсан учир тэр бодлоо өөрчлөн казино явж покер тоглолоо. Нэгээс гурван долларын стад тоглоомын ширээн дээр суун тоглож эхлүүт ийм байдалтай покер тоглохоор ирсэн нь маш буруу байжээ гэдгээ шууд л ойлгов. Нүд томрон харанхуйлж хөзрөө сайн харахгүй байсан учир тоглолтыг орхихоос өөр аргагүй байдалд оров. Тэгээд удалгүй босон явж байхдаа булан дахь их том ширээн дээр тоглож байгаа тоглоомыг ихэд шохоорхон, яаж тоглодог юм бол хэмээн гайхсан. Тэр ширээнд ойртон очиж, тоглож байгаа нэг хүнээс энэ ямар тоглоом болох талаар асуухад, тэрбээр Техас Холдем тоглож байна хэмээн хариулав. Энэ нэрийг би урьд хэзээ ч сонсч байгаагүй юм. Дилер надад тоглоомын дүрмийн талаар товч тайлбарлахад миний толгойд энэ тоглоомоор тоглох сонирхлын оч харваж билээ. Миний тоглох тоглоом энэ гэдгийг би мэдэж байлаа.

•••

Би хүүхэд байлаа. Харин ээж намайг казинод тоглодог болсон талаар юу ч мэддэггүй байв. Хэдэн цагаар үргэлжлүүлэн тоглож, бага зэрэг мөнгө алдсан боловч энэ шинэ тоглоомыг тоглох сонирхол маань огтхон ч буураагүй юм.

•••

Маргааш нь 40 доллартай казинод очиж, гурваас зургаан долларын ширээн дээр тоглохоор суув. Тэр бол миний анхны тоглосон Техас Холдем байсан бөгөөд түүнийг би хэзээ ч мартдаггүй. Надад цэцгийн тамга, ноён ирсэн байлаа. Миний нэг өрсөлдөгчид маань харин хоёр хатан ирсэн аж. Газарт хөзөр эргэхэд гурван цэцэг, түүн дотор хатантай байв. Тэгээд би флаш болсон. Түүний гурван хатны хослолоос илүү давуу байсан хэрэг. Мэдээж би түүнийг хатантай гэдгийг мэдээгүй ч түүнээс илүү гэдэгтээ итгэлтэй байлаа. Дараагийн хөзөр эргэхэд дахин хатан, тэрээр ингээд дөрвөн хатантай болов. Би түүнээс илүү давамгай хэвээр байсан болохоор бооцоог зургаан доллараар өсгөв. Тэрээр намайг бүрэн цөлмөж болохоор байсан ч надад өршөөнгүй хандаж, миний гараас барьж "Бооцоог бүү өсгө!" хэмээн дөрвөн хатнаа харуулав. Бусад тоглогчид бөөн инээдэм болов. Тэр залуу намайг зогсоосонд би баярлаж байлаа. Учир нь би мөнгөө алдах боломжоос мултарсан юм. Үүний дараа түүнд би

гарт байсан флашаа харуулаад "За, энэ тийм сайн болж чадах уу" хэмээн хөзрөө ширээнд дэлгэж билээ. Түүний дараа үдээс хойш яаж өнгөрснийг сайн санадаггүй юм.

Би хүүхэд байлаа. Харин ээж намайг казинод тоглодог болсон талаар юу ч мэддэггүй байв. Би бүр хэдэн цагаар үргэлжлүүлэн тоглож, бага зэрэг мөнгө алдсан боловч энэ шинэ тоглоомд татагдсан сонирхол маань огт буураагүй. Энэ тоглоомыг тоглоно гэдгээ ч мэдэж байсан.

Казинод анх Холдем тоглосны дараа долоо хоногтоо хоёроос гурав удаа байнга очиж тоглодог болов. Гурваас зургаан долларын ширээн дээр голдуу тоглодог байсан. Тэр үед 17 настай байлаа. Тогтмол шахуу казинод очдог байсан болохоор тэндхийн байнгын үйлчлүүлэгчидтэй танилцаж, бие биенээ мэддэг болж эхлэв. Фрэдди Дийб бас их тоглодог байсан учир бид хоёр танилцаж найзууд болцгоов. Дийб бол маш сайн покерчин, тэрбээр олон өнгөтэй алаг цамц өмсдөгөөрөө алдартай. Тэрбээр 2007 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний 50 мянган долларын HORSE тоглолтод түрүүлж, 2.276.832 долларыг бэлнээр авч байсан юм. Нэгэн амралтын өдөр 3-6 долларын тоглолт тоглож байтал миний эсрэг талд Фрэдди тоглож байлаа. Тэрбээр над руу тонгойж "Би чамайг 5-10 долларын ширээнд тоглуулъя, мөнгийг би нь гаргая, чи тогло" гэв. Би бүр хөдөлгөөнгүй хөшчихөв. Тэр санал надад таалагдсан хэдий ч би тоглоогүй. Тэгээд түүнд "Үгүй ээ, уучлаарай, би чадахгүй, энэ хэтэрхий томдсон асуудал байна" гэв. Тэгээд ч 5-10 долларын тоглолт надад хэтэрхий ахадмаар санагдсан юм.

•••

Покер тоглох явдал эрүүл мэндийн асуудлаас сэтгэл санааг минь бүрэн салгаж чадав. Донор бөөр хүлээж хоног тоолон суух маш хүнд цаг хугацааг туулахад минь ихэд тусалсан даа.

•••

Арван долоогоос арван найман насны хооронд бөөрний дутагдалаас болж би маш хүнд байдалд орсон. Би өөрөө ийм байдалд орно гэдгээ мэдэж байсан. Учир нь удам дамжсан өвчин байсан. Ээж маань ч энэ өвчнөөр нас барсан. Надад бөөр шилжүүлэн суулгах шаардлагатай болсон учир донорын бөөр хүлээн диализийн эмчилгээнд дөрвөн сар гаруй болсон. Үүний дараахан эмч надад хэрэв донор бөөр ирэхгүй бол надад амьд явах сарын хугацаа байгааг хэлсэн.

Диализын эмчилгээгүй өдрөө казинод очин покер тоглодог байсан. Покер эрүүл мэндийн асуудлаас сэтгэл санааг минь бүрэн салгаж чадсан. Донор бөөр хүлээн хоног тоолон суух маш хүнд цаг хугацааг туулахад их тусалсан. Бодоод үз л дээ, бөөр хүлээн цаг хугацааг тоолон сууна гэдэг хичнээн дарамттай байсан гэж бодно. Дэйри Кюин, Мэйсид ажиллаж хуримтлуулсан мөнгөөрөө долоо хоногт дөрвөөс зургаан өдөр казинод очиж тоглодог байлаа. Тэр үед олохоосоо алдах нь их байсан. Байнга бэлэн мөнгөний машин руу явдаг байснаа санаж байна. Эцэст нь бөөр шилжүүлэн суулгуулсаны дараа Невадагийн их сургуулийн Рено дахь коллежид орж покероос хэсэг хугацаанд холдсон. Бараг гурван жил покерын ширээнд ойртоогүй. Тэр хугацаанд биеэ тэнхэрүүлж, бас дээр нь хичээлдээ чармайн суралцсан.

Хорин нэгэн нас хүрэнгүүтээ Рено дахь Харрах казинод коктейлийн үйлчлэгчийн ажил хийсэн юм. Миний үүрэг бол түр завсарлага авсан зөөгчдийн оронд ажлыг нь тасралтгүй

гүйцээж үйлчлэх явдал байлаа. Казиногийн олон хэсэгт, үүн дотор покерын өрөөнд хүртэл үйлчилдэг байсан. Би олон жил покер тоглосон болохоор покер тоглож буй хүмүүсээс олныг танина. Тэд ч надад сайн цайны мөнгө өгдөг байлаа. Ингэж нэлээд мөнгө цуглуулсан. Сарын дараачаас ажлаа дуусгангуут дөнгөж саяхан л шар айраг зөөж өгч байсан хүмүүстэйгээ хамт ширээнд сууж, покер тоглох болсон. Төдөлгүй тэднийг хожиж эхэлсэн дээ. Өөртөө нэлээд итгэлтэй болж, тоглоомныхоо хэмжээг дээшлүүлж таваас арван доллар, удалгүй 10-20 долларын ширээнд тоглон мөнгө хуримтлуулж эхлэв. Үүний дүнд хуримтлал маань боломжийн хэмжээнд хүрсэн. Тоглож байхдаа юунаас ч айдаггүй тоглодог байлаа. Учир нь хэн нэгний мөнгөөр тоглоогүй, өөрийнхөө мөнгөөр байсан болохоор өөртөө илүү итгэлтэй бас зоригтой тоглох болсон.

•••

Дугуйн клубыг олж мэдсэнээс долоо хоногийн дараа би өөртөө "Би байх газраа оллоо, энэ нь миний хүсч мөрөөдөж байсан газар мөн байна" хэмээн хэлснээ санаж байна.

•••

Өндөр бооцоотой тоглон их мөнгө хожиж байсан ч алдах үед илрэх өвчнийг арилгаж чадаагүй. Нэг удаа 200 доллар алдаад маш их уур хүрсэн. Урьд өмнө хэзээ ч ийм их мөнгө алдаж байгаагүй болохоор хэцүү санагдсан. Тэгээд дахин 200 доллар гарган блэкжекийн ширээн дээр очиж бүгдийг нь тавив. Үүндээ сэтгэл түгшин чичирч байлаа. Гэвч би хожсон. Мөнгөө аваад шууд гарснаар тэр оройдоо алдагдалгүй, тэнцүү болж гарав. Түүнээс хойш блэкжек бараг тоглоогүй. Хааяа зөвхөн зугаагаа гаргах маягаар тоглодог болсон.

Лос Анжелес руу нүүхээр шийдэхээсээ өмнө Ренод коктейлийн зөөгч, покер тоглогч гэсэн хоёр ажлаа давхар хийсээр л байлаа. Надад орчноо солих шаардлага гарав. Өөрийнхөө амьдралыг цэгнэх цаг хугацаа хэрэгтэй болсон юм. Урьд өмнө нь эмч болохыг мөрөөддөг байсан ч өвчтэй байсныхаа дараа эмнэлгийн бүхий л зүйлстэй дахиж харьцах ямар ч сонирхолгүй болсноор тэрхүү бодлоо хаясан даа. Хамгийн гол асуудал бол би юу хийхийг хүсч байгаагаа шийдэх хэрэгтэй байсан юм.

Лос Анжелест ирсэнийхээ дараа Калифорнид покер тоглох нь хуулиар зөвшөөрөгдсөн байдгийг хараад ихэд гайхсан. Ренод покер тоглож байхдаа танилцсан нэгэн танил маань Белл Гардений ойролцоо Дугуйн клуб гэдэг газар бий, тэнд очоорой гэж надад хэлэв. Намайг тэнд үнэхээр тун дажгүй тоглоно гэж тэр бодсон байх. Эхлээд би түүний зөвлөгөөг нэг их тоогоогүй. Сар гаруй хугацаа өнгөрсний дараа тэр танил маань над руу залган "Чи Дугуйн клубт очихгүй юм уу, тэндхийн тоглолтууд тун дажгүй шүү" хэмээн хэлсэн. Түүний зөвлөснөөр клубт очиж 5-10 долларын Холдем тоглож эхлэв. Тун удалгүй долоо хоногтоо таваас зургаан өдөр, нэг тоглохдоо наймаас арван цагаар тоглодог болов. Марина Дэл Рэйд байдаг гэрээсээ клуб руу очиход гучин минут орчим явдаг байлаа. Би ихэвчлэн өдрийн хоёр цагаас эхэлж тоглоно. Зургаан долоо хоногийн дотор 5-10 долларын ширээнээс 30-60 долларын ширээ рүү шилжив. Ашиг ч олж эхэлсэн. Мэдээж, үүнийхээ хажуугаар бас алдах үе ч байлаа. Энэ нь надад их саад болсон. Харин нэг тохиолдлыг ерөөсөө мартдаггүй юм. Тэр өдөр 30-60 долларын ширээнд тоглож байгаад алдагдал хүлээв. Алдагдалтай үедээ тоглоомыг зогсоохыг би хүсээгүй. Ингээд үргэлжлүүлэн тоглосоор зогсолтгүй гучин цаг тоглов. Энэ бол

миний хувьд хамгийн удаан тоглосон тоглолт байлаа.

Тэнд байсан надаас бусад хүмүүс цагийг аятайхан өнгөрүүлсэн нь мэдээж. Тэр үед миний жин ердөө 98 паунд байсан бол бусад тоглогчид барагцаалбал 300 гаруй паунд жинтэй лагс хүмүүс байв. Тэд намайг тал талаас шахаж, би хөзрөө авах гэж тэдний дундуур мушгиралдан чихцэлдэж зүтгэн ордог байлаа. Тэд бүгд хоол унд идэцгээн хөгжилдөж байхад харин би амьсгалахад ч хэцүү бүгчимдэж, сайн мод ч ирэхгүй хүндхэн байдалд ордог байв. Энэ бүхний эцэст алдагдлаар дуусч, нийтдээ 2000 доллар алдсан даа. Ийм их хэмжээний мөнгийг анх удаа ингэж алдсан юм. Энэ байдлыг маань аав харсан бол намайг гайхах байсан даа гэж тэр үед бодсон.

Намайг покер тоглож амьдардаг гэдгийг аав огт мэдэлгүй нэлээд хугацаа өнгөрсөн. Ер нь бид хоёр тийм ч дотно харилцаатай байгаагүй. Эцэст нь намайг мэргэжлийн покер тоглодог болсон гэдэг мэдээг сонсоод бидний харилцаа улам бүр муудсан. Бүр өмнөхөөсөө ч дордов. Мэдсэнийхээ дараа тэрбээр ихэд уурлаж байсныг нь би сүүлд мэдсэн. Тэр үед би дөнгөж хорь гаруй настай байлаа. Чамд хоёрхон сонголт байна, аль нэгийг нь сонго, эхнийх нь покер тоглож амьдрахаа боль, хоёр дахь нь үгүй гэвэл чамаас би харилцаагаа бүрмөсөн тасална гэж надад тэр хэлэв. Энэхүү сонголт надад маш хүнд байсан. Би покерт дуртай, яаж тоглохыг мэднэ, тэгээд ч түүндээ сайн байсан болохоор аавын тулгасан том шахалтыг сөрж, покероо үргэлжлүүлэн тоглохоор шийдсэн юм. Хэдэн жилийн дараачаас би амжилттай сайн тоглож, түүндээ ч их урамтай байлаа. Аав бид хоёрын харилцаа ч гэсэн эргэж сэргэв. Түүний амьдралын сүүлийн жилүүдэд ч бидний харилцаа сайн байсан. Аав маань хэдэн жилийн өмнө нас барсан юм.

•••

Аав надад, чамд хоёр сонголт байна, аль нэгийг нь сонго, эхнийх нь покер тоглож амьдрахаа боль, хоёр дахь нь үгүй гэвэл чамаас би харилцаагаа тасаллаа гэсэн.

•••

Калифорнид би бараг дөрвөн жил тоглосон доо. Долоо хоногийн таван өдөр, дунджаар 40-50 цаг тоглох нь ердийн үзэгдэл болов. Ингэж тоглож байхдаа өөрийнхөө амьдрал ахуйн хэрэгцээг бүрэн хангаж байлаа. Олон цагаар тоглохдоо өөрийгөө мэргэжлийн покерчин гэж хэзээ ч бодож байгаагүй ээ. Харин покерыг мэргэжил болгохын төлөө тоглож байна гэж бодож байлаа. Бас энэ бүхэн надад маш их зугаатай байсан. Дугуйн клубыг олж мэдсэнээс долоо хоногийн дараа "Би байх газраа оллоо, энэ миний хүсч мөрөөдөж байсан газар мөн байна" хэмээн хэлсэнэ санаж байна.

Энэ бүхнийг би покер миний амьдралын зорилго гэсэндээ хэлээгүй, харин покерыг би тоглох дуртай түүнийгээ амьдралынхаа үлдсэн хугацаанд тоглоно гэсэн утгаар хэлсэн юм.

26 настайдаа би покер тоглож байгаад Зүүн эргээс ирсэн нэгэн тоглогчтой танилцаж, бид биендээ дурлацгааж улмаар гэр бүл болцгоов. Тэр Мерилэндаас ирсэн юм. Нөхөр маань тэнд амьдрахыг хүсч, бид Зүүн эрэгт нүүж очиж, шинэ амьдрал эхлэв. Бид ажилгүй байсан ч покер тоглож олсон мөнгөөрөө ачааны машин худалдан авч нүүрс зөөж эхлэв. Би тэр үед 60 мянган

доллар хожсон байсан юм. Энэ бизнес тийм ч ашигтай байгаагүй. Жил гаруй бизнесээ үргэлжлүүлсний эцэст бид бараг дампуурлын байдалд оров. Хажуугаар нь өөр бусад бэрхшээлүүд ч их гарч байлаа. Нэг удаа явж байгаад буга мөргөн, машиныхаа салхины шилийг хагалав. Түүнийгээ солих мөнгө ч бидэнд байгаагүй. Байдал улам хүндэрч, хадам ээж маань бидэнд хоол зөөдөг байлаа. Үнэндээ тэгэхэд бидэнд хүнсээ ч авах мөнгө байгаагүй. Өөрсдийн амьдралаа буцаан хэвэнд нь оруулахад маш бага сонголт үлдсэнийг бид мэдэж байлаа. Тэр бол покер байсан юм. Санхүүгийн хувьд амьдралаа хөл дээр нь босгохын тулд бид Лос Анжелес юм уу Лас Вегас руу буцахаар шийдэцгээв. Тэгээд бид Лас Вегаст очихоор шийдсэн ч дахин покероо тоглож эхлэх мөнгө хэрэгтэй байлаа.

Би ааваасаа мөнгө зээлэхийг оролдсон ч Лас Вегаст очин покер тоглохыг тэрбээр огт зөвшөөрөхгүй байлаа. Харин эмээ 20 мянган доллар зээлүүлснээр бидний амьдралын шинэ хуудас эхэлсэн юм.

Лас Вегаст нүүж ирсний дараа бид хоёулаа чөлөө завгүй покер тоглож эхлэв. Хэдхэн сарын дотор эмээгээсээ зээлсэн мөнгөө эргүүлэн төлж, өрнөөсөө салав. Удалгүй бид хаус худалдаж авав. Тэр үеэс хойш одоог хүртэл би Лас Вегаст покер тоглосоор ирсэн билээ. Энэ бол сонирхолтой зам. Би хэзээ ч мэргэжлийн покерчин болно гэж сонголт хийгээгүй бас тоглоомоор амьдарна гэж хэзээ ч бодож байгаагүй юм. Үргэлж л ямар нэгэн ажил хийнэ дээ гэж боддог байсан. Гэвч Мерилэндын сургамж болон Лас Вегаст байсан хугацаа энэ бүх бодлыг минь үндсээр нь өөрчлөв. Ямар ч ажил надад покерын ширээнээс илүү санхүүгийн үр ашиг болон аз жаргал, сэтгэлийн таашаал авчрахгүй юм байна гэдгийг тэр үед л ойлгож билээ.

Миний эхний гэрлэлт бүтэлгүй болж салсны дараа би дахин дампуурав. Тухайн үед сэтгэл санаа минь хүнд хэцүү байсан ч тэр бүхэнд ердөө ч харамсаагүй. Ямартаа ч эргээд хөл дээрээ бүрэн зогсч чадав. Тэгээд л покерын ширээнээс мөнгө хожиж эхэлсэн дээ. Тэр бид хоёр өнөөг хүртэл сайн андууд хэвээр байгаа.

Покер нь энэ бүх хугацаанд санхүүгийн олон боломжийг олгож байсан шиг сайн сайн хүмүүстэй уулзах бусад боломжийг ч мөн адил олгож билээ. Нэгэн хүнтэй би олон жилийн туршид маш сайхан нөхөрлөж байна. Бидний анхны уулзалт ер бусын сонин байлаа.

Би домогт покерчин Дойл Брансоны хүү Тод Брансонтой 1990-ээд оны сүүлчээс болзож эхэлсэн юм. Тэрбээр үнэхээр сайн тоглогч. Тод 2005 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний Омаха Их бага тоглолтын аварга болж бугуйвч авч байлаа. 1998 онд покерын талбарт нэг их олонд танигдаагүй нэгэн шинэ дажгүй тоглогч байв. Тэр залуу тоглогч Тод хоёр 1998 онд "Horseshoe" казинод болсон 2000 долларын дундын сангийн хязгаартай Холдемын тэмцээнд сателайт (satellite) тоглолтод өрсөлдсөн юм. Энэ тэмцээнд тэр хоёр тунаж үлдэв. Тэмцээнд ороход 1500 доллар төлсөн байлаа. Тэд сүүлийн тоглолтод тоглохоор суухдаа "хадгаламж" хийхээр шийдэцгээв. Тэр нь 500 доллар байлаа. Энэ нь нийт мөнгөний гуравны нэг гэсэн үг. Шинэ залуу Тодыг хожиж шагналыг хүртэв.

Тэгээд тэр шинэ залуу тоглогч Тод дээр ирж, түүнд өгөх ёстой гуравны нэг хувийнхаа мөнгийг өгөх гэтэл Тод 500 доллараа авахаа түр азнан дараачийн тэмцээний чинь хожлын 33 хувийг авья гэв. Тэр үед шинэ залууд тэмцээнд орохын тулд мөнгө хэрэгтэй байсан учир

Тодын саналыг зөвшөөрч дараачийнхаа тэмцээнд орохоор явсан юм.

Тэр орой Тод гэртээ ирээд тэр шинэ залууг бараг мэдэхгүй мөртлөө "Женнифер, чи "Horseshoe" казинод очиж Даниел Ниагра гэдэг залууг хараарай, би түүний хожлын мөнгөнөөс хуваалцах ёстой, чи миний өмнөөс уулзчихаарай" гэв. Үүний дараа би "Horseshoe"-д очиж зарим бэлэн мөнгөний ширээн дээр тоглож байхдаа түүнийг ажигласан юм. Түүний нэрийг Ниагра биш Даниел Нигрэану гэдгийг мэдэж авав.

Тэр оройдоо түүнийг тэмцээнд хожихыг харж байлаа. Тэмцээний дараа түүн дээр очоод өөрийгөө танилцуулаад, том хожилд нь баяр хүргэв. Тэгээд Тодын хүсэлтийг биелүүпж, түүний өмнөөс яваа гэдгээ ч уламжлав. Дараа нь уушийн газарт очиж, түүний ялалтыг тэмдэглэн бүхэл шөнийн туршид ярилцаж суув. Түүнээс хойш бид хамгийн сайн найзууд болсон доо. Бараг л ах, дүү шиг болцгоосон гэхэд хилсдэхгүй болов уу.

Би алдах дургүй. Ер нь алдахад дуртай хэн байх билээ. Гэвч би алдахад суралцах нь хожиход суралцахтай адил чухал гэдгийг ойлгосон.

Хэдэн жилийн турш бид хувийн амьдрал, покер зэрэг олон асуудлаар санаа бодлоо хуваалцдаг байлаа. Бидний яриа голдуу хэдэн цагаар, түүнээс ч илүү хугацаагаар үргэлжилнэ. Харин ширээний ард бие биенийхээ эсрэг тоглох үедээ би түүнийг хожихын төлөө хамаг байдгаа зориулдаг байсан. Хэрэв би мөнгөө алдахаар болвол Даниелд түүнийгээ алдахад арай л сэтгэл өег байдаг.

Даниел намайг хэтэрхий сайн мэднэ. Нэг удаа "Хөзөр тоглогч" сэтгүүлд миний тухай нийтлэл бичихээр болж надаас ярилцлага авсан юм. Үнэн хэрэгтээ тэр бүгдийг бичсэн агаад миний хариултыг хүртэл надаас асуулгүйгээр бичсэн байлаа. Түүнийгээ засварлуулахаар надад ирүүлэхэд нь нэмж засах зүйл бараг гараагүй дээ.

Покер бас намайг амьдралын минь үнэнч дурлалтай учруулсан. Гэхдээ шууд бус замаар шүү. Маркотойгоо би Беллажиогийн доод давхрын машины зогсоолд анх үүрийн гурван цагийн үед танилцсан юм. Тэр өдөр үнэхээр хүнд өдөр байлаа. Учир нь тэр өдрийн тэмцээнд оролцохыг үнэхээр хүсч, яаран очиход эрт эхэлсэн учир хаачихсан байв. Тэгээд би цаг гаруй хүлээж байгаад хоёр дахь тоглолт эхлэхэд оролцсон юм. Тэгээд тэр тоглолтод орж 50 мянган доллар алдав. Өнөөдөр ер бүтэхгүй нь хэмээн бодсоор, гэртээ харихаар шийдэн гарч машиндаа суух үедээ Маркотой таарав. Машинаа бид хоёр зэрэгцээ зогсоолд тавьсан байлаа. Машин дээрээ ч бараг нэгэн зэрэг очсон байх. Тэр эхэлж яриа өрнүүлж, Лас Вегаст амралтаараа ирсэн гэдгээ хэлэв. Тэгээд хамт явж бүжиглэх үү гэж асуусан. Би түүнд үгүй гэж хэлсэн. Дөнгөж саяхан покер тоглоод 50 мянган доллараа алдсанаа хүлээн зөвшөөрч, бас бүжгэнд очих нь надад маш хэцүү байгаагаа яагаад түүнд хэлснээ ч мэдэхгүй. Тэрбээр маш сэтгэл татам бас тун тэвчээртэй байгалиас заяасан өвөрмөц хүн байсан болохоор нэг л мэдэхэд сүүлдээ бид казиногийн хажуу дахь шөнийн клубт тэрхүү шөнийг бүжиглэж өнгөрөөв. Түүнээс хойш долоо хоногийн турш хамтдаа зугаалан түүний амралтыг өнгөрүүлэв. Дараа нь Марко Итали руу гурван долоо хоног яваад эргэж ирсэн. Бид харилцан дурлалцаж, хэдхэн долоо хоногийн дараа гэрлэсэн юм. Энэ бүхэн маш хурдан болж өнгөрсөн дөө. Бид хоёр гэрлэлтийн гэрчилгээгээ орон нутгийн шүүхийн танхимаас авч, нэлээд орой болсон хойно худалдааны гудамж дахь сүмд очиж шөнийн 23 цаг болж байхад жинс, богино

цамцтай хуримаа хийсэн түүхтэй юм.

2004 онд би покер тоглолгүй өнжив. Учир нь би хоёр дахь удаагаа бөөр шилжүүлэн суулгах хагалгаа хийлгэх шаардлагатай болсон юм. Энэ удаагийн мэс засал эхнийхийг бодвол илүү хүнд байлаа. Нэгд, би нас ахисан, хоёрт, өмнөхөөсөө улам илүү өвчтэй болсон байв. Зарим нэг шалтгаанаас болж, бөөр бараг ажиллахгүй болж, цусны даралт ихэсч, долоо хоногийн туршид маш өндөр түвшинд байлаа. Энэ бүхний улмаас би маш их айсан төдийгүй хүндхэн цохилтод оров. Тиймээс гэрийнхэн рүүгээ утасдаж, хэрэв байдал муугаар эргэсэн тохиолдолд яах талаар зөвлөгөө хүртэл өгч байснаа санаж байна. Би үнэхээр төхөөрөмжийн тусламжтайгаар амьд байх хүсэлгүй байлаа. Биеийн байдал улам муудсаар хагалгаа хийх өдөр болоход жингээ 35 паунд алдав. Бөөрний ажиллагаа бараг зогссон тул биенээс ус болон хорт бодис ялгарч гарах боломжгүй байв.

Хоёр дахь удаагийн бөөр шилжүүлэн суулгах хагалгаагаар эрхтний донорын ачаар эсэн мэнд үлдснийхээ дараа би Үндэсний бөөрний холбооны хүмүүнлэгийн болон буяны үйл ажиллагаанд оролцох болсон юм. Тэр байгууллага нь бөөрний өвчтэй хүмүүс ба тэдний гэр бүлийнхэнд туслах, мөн судалгаа шинжилгээний ажилд зориулсан сан байгуулах үндсэн зорилготой. Эгч бид хоёр бөөрний дутагдалд орж ирээдүй улам бүрхэг болж байлаа

Намайг мэргэжлийн түвшинд покер тоглож байгааг ээж минь хараагүй нь тун харамсалтай. Хэрэв намайг ингэж тоглож байхыг харсан бол лав их баярлах байсан даа. Тэрээр янз бүрийн тохиолдолд гэрийнхээ арын өрөөнд мөнгөөр пинокль тоглодог байсныг санаж байна. Ээж маань маш их шартай өрсөлдөөнч хүн байлаа. Миний тоглоно гэснийг мэдсэн бол тэр тэсэн ядан хүлээж сэтгэл нь хөөрөх байсан даа.

Өнөөдөр надаас маш олон хүн яагаад мэргэжлийн тоглогч болсон талаар асуудаг. Би тэдэнд покерт дуртай болохоороо л тоглодог хэмээн хариулдаг. Хэдий удаан хугацаанд тоглоно төдий чинээ сэтгэлийн баяр баясгалан, аз жаргал хамт ирнэ. Миний хувьд покер хэзээ ч дуусахгүй сорилтыг надад бий болгож, хүсэл сонирхлыг минь татаж байдаг. Покер тоглож байхад оюун ухаан маань сэргэж, байнга их зүйлд суралцаж байдаг билээ. Түүнээс гадна покер нийгмийн үзэл баримтлалд минь олон талаар тусалсан юм. Үүний үр дүнд олон сайхан хүмүүстэй танилцаж, заримтай нь одоог хүртэл маш дотно харилцаатай байна. Покер миний амьдралыг улам амжилттай болгоход тусалсан. Жишээ нь хүмүүсийг унших чадварыг би покероос олж авсан. Үүний дүнд ширээний ард ямар ч хүмүүстэй хамт суусан, ямар ч нөхцөл байдал үүссэн, түүнтэй хамгийн оновчтойгоор зохицох, эсвэл өөртөө ашигтайгаар эргүүлэх чадварт суралцсан билээ.


Харин покерын гол дутагдалтай тал гэвэл мэдээж алдагдал. Заримдаа дараалан алдах тохиолдол ч байдаг. Энэ бол тоглогч бүрт, тэр байтугай хамгийн чадварлаг тоглогчдод хүртэл тохиолдоно. Миний хувьд, тодруулбал Лас Вегаст 1000-2000 долларын Холдем тоглож байгаад 100 мянган доллар алдаж бараг л сүйрсэн дээ. Үүнийгээ ер мартдаггүй юм. Покерын гайхамшигтай, алдарт мэргэжлийн тоглогч Тэд Форест над руу дөхөж ирснээ, юу болоо вэ хэмээн асуухад, 100 мянган доллар алдчихаад байна гэв. Тэгэхэд тэр мөрөө хавчин "Хөөе, битгий бухимд, иймэрхүү зүйлс сая удаа дараа тохиолддог юм" гэж билээ. За яахав ийм л юм болоо биз.

Гэхдээ л би алдах дургүй. Ер нь алдахад дуртай хэн байх билээ. Гэвч би алдахад суралцах нь хожиход суралцахтай адил чухал гэдгийг ойлгосон. Тэгээд ч покер тоглогчид урт удаан хугацаанд өөрсдийгөө болон мөнгөө удирдахад суралцдаг. Хэцүү үед хуримтлуулсан туршлага, зан төлөв хэвшин тогтсоор улам хүчирхэгжин бэхжиж, хожим нь хэрэг болдог. Би одоогоор өөрийн зан төлөвийг арай тогтоогүй байгаа гэж боддог. Удахгүй хэдэн жилийн дотор тогтох байх хэмээн найдаж байна.

Ж.Харманы тухай мэдээллийг eip^eгНагтап.com сайтаас авч болно. Харин Женнифертэй хамт покер тоглох бол [Full Tilt Poker \(www.fulltiltpoker.net\)](http://www.fulltiltpoker.net) сайт руу орж тоглох боломжтой.

Тэрээр Үндэсний бөөрний холбоо (www.kidney.org) гэдэг ашгийн бус сайн дурын байгууллагыг санхүүгийн хувьд дэмждэг аж. Уг байгууллага нь бөөрний өвчнөөр өвдсөн хувь хүмүүс болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн хэвийн нөхцлийг хангахад болон донор эрхтнүүдийг олж өгч туслах зорилготой.

Түүнчлэн Женнифер Невадагийн Амьтдыг хэрцгий халдлагаас хамгаалах нийгэмлэгийг (www.nevadascpa.org) санхүүжүүлдэг байна. Амьтдын эсрэг гэмт хэргийг зогсоох, тэднийг хамгаалах зорилготой ашгийн бус энэхүү байгууллага нь амьтдыг хөнөөхгүй байхыг сурталчлах, хүмүүнлэгийн талаар мэдээлэл өгөх, хүмүүсийн дотны андыг халамжлах, хямд үнэтэй шүршигч вакцин зэргийг нийлүүлэхэд голчлон тусалдаг ажээ.



Ховард Ледерер

Ховард Ледерер нь мэргэжлийн покерчдын дундаас хамгийн авъяаслаг, хамгийн хүндтэй хүмүүсийн нэг юм. Покерын дэлхийн цуврал тэмцээн болон Покерын дэлхийн аялан тоглолтын аварга тэрбээр "Профессор" тэмцээнд ялалт байгуулж таван сая доллар хожсон. Покерын ширээн дээр амжилт гаргахаас гадна Ховард покерын бизнесмэн, сургагч багш төдийгүй покер тоглогчдын ур чадварыг дээшлүүлэхэд туслах зорилгоор видео сургалт болон хувийн семинар зөвлөгөө өгдөг байна.

Ховард мэргэжлийн покерын замналаа ахлах сургуулийн сурагчаас эхэлж олон улсад танигдсан мэргэжлийн тоглогч хүртлээ алдаршсан юм. Тэрбээр Нью Йорк хотын шатрын клубт бага хэмжээний бооцоотой покер анх тоглож эхэлсэн юм. Шатрын клуб цэвэрлэж, тэнд тоглогчдод сэндвич, ундаа зөөж, покер тоглох анхны мөнгөө олж, эгэл даруухнаар тоглож эхэлсэн Ховард хүү хожмоо хамгийн аугаа бас алдарт Фул тилт покер веб сайтын

үндсэн санааг сэтгэгчдийн нэг болсон юм.

Сүүлийн үед Ховард Ледерер билэг ухаан, аугаа хүчээ ашиглан өөрийгөө Зэн шиг дийлдэшгүй хүчирхэг болгож чадсанаар дэлхий дахины томоохон тэмцээн, мөнгөний тоглолтуудад хамгийн сүрдмээр бас халишрмаар өрсөлдөгчдийн нэг болсон юм. Тэрбээр бас покерын ертөнцөд өндөр хүндэтгэлийг хүлээсэн бизнесмэн, хамтран тоглогч, жинхэнэ эр хүн юм.

Зочдын өрөөний шалнаас л миний покерын мэргэжил эхэлсэн гэж хэлж болно. Намайг хүүхэд байхад гэр бүлийнхэн маань тэнд олон цагаар хөзрийн тоглоом тоглон суудаг байв. Аавд хуучны хэдэн ширхэг шавар хасаа байлаа. Бид тэр хасаанаас хэн нь олныг цуглуулахаа үзэлцэн тэмцэлдэнэ. Ингэж тоглож байх үедээ өрсөлдөхийг хүсдэг болов. Бас өрсөлдөөнд суралцаж эхлэв. Энэ нь маш сайхан төдийгүй нэр төрийн хэрэг байлаа. Ширүүхэн тоглож, өрсөлдөгчөө хайр найргүй буулган авна. Тэмцэл дууссаны дараа найзууд хэвээрээ үлдэнэ. Өрсөлдөх чадварыг би ааваасаа сурсан юм. Тэрбээр хурц ширүүн өрсөлдөгч байлаа. Намайг долоон настай байхад аав надад шатар зааж өгөв. Есөн жилийн туршид тэр надад хэзээ ч бууж өгч, хожигдож байгаагүй. Арван зургаатайдаа шатарт нэлээд сайжирч сүрхий тоглодог болов. Тэр үед аавыгаа хоёр удаа дараалан хожиж билээ. Түүнээс хойш тэрбээр надтай дахиж тоглоогүй. Үүнийхээ оронд хотод байдаг өөрөөсөө илүү сайн хүмүүсийг зааж өгч, тэдэнтэй арай өндөр түвшинд өрсөлдүүлэхээр явуулна.

Арван хэдтэй байхдаа би хувийн сургуульд явдаг байлаа. Ахлах ангид ороход нэг улирал бие даан суралцах боломжтой болсон. Ингээд би Нью Йорк явж хоёр сарын турш олон улсын шатрын мастеруудтай тоглож, тэднээс суралцахаар шийдэв. Тэр үед дөнгөж 18 нас хүрээд байв. Сургалтын төлөвлөгөө ёсоор долоо хоногт нэг удаа мастерын хичээлд сууна. Шатрын тухай материал судлах гэрийн даалгавар маш их өгдөг байлаа. Амралтын өдрүүдэд Нью Йоркийн шатрын төвд тэмцээнд оролцоно. Тэр клубт очсоныхоо дараа тэнд шатраас өөр тоглоом тоглодог болохыг би мэдсэн юм. Клубын арын өрөөнд 0.25-1 долларын хязгаартай покер тоглодог байв. Тэр үед би бүхэлдээ шатарт татагдсан байсан болохоор эхэндээ покерын тоглоом миний сонирхлыг ер татаагүй. Би тэдэнтэй цөөн удаа хамт сууж тоглосноо санаж байна. Өрсөлдөөнд дуртай бас тоглогчидтой найзалсан учир би гол төлөв тоглодог байлаа. Гэвч тэр хугацаанд би покерыг гайхамшигтай тоглоом гэдгийг олж мэдэж чадаагүй юм. Покерыг боломжид тулгуурласан тоглоом, харин чадвар сорьдоггүй юм байна гэж л ойлгосон.

Ахлах анги төгсөх жилээ Колумбын их сургуульд суралцах эрхтэй болов. Гэвч би сургуулийн асуудлыг нэг жил хойшлуулж, бие даасан сургалтаа үргэлжлүүлэхээр шийдсэн юм. Миний зорилго бол мэргэжлийн шатарчин болох явдал байлаа. Тиймээс би зочид буудлын нэг өрөө хөлсөлж, түр зуурын ажил хийнэ гэсэн төлөвлөгөөтэйгээр Нью Йоркт зургаан сарын дундуур халаасандаа 2000 доллартай очив. Тэгээд шатрын төвд буцаж ирээд өөрийгөө шатраас илүү покерт дуртай болсныг мэдрэв. Тэгээд арын өрөөний байнгын үндсэн тоглолтод оролцож эхэлсэн. Хоёр долоо хоногийн дотор бүх мөнгөө алдсан. Түүндээ би маш их гутарсан ч биеэ хэт тоосон байснаас сүүлээ гуяандаа хавчаад гэртээ буцаж очихыг хүсээгүй юм. Надад нэгэн мэргэн санаа төрөв. Долоодугаар сарын дөрөвний амралтын өдөр ойртож, шатрын клуб хаагдах үе байлаа. Хүмүүс Пенсильванид болох Шатрын дэлхийн аваргын нээлттэй тэмцээнд явахаар зэхэж байх зуур би шатрын төвийн эрхлэгчид дөхөж очоод өөрийнхөө саналыг хэлэв.

Хэрэв та намайг ирэх амралтын өдрүүдэд энд үлдэхийг зөвшөөрвөл хаалттай байх хугацаанд би бүгдийг нь цэвэрлэж, таныг ирэхэд цэв цэмцгэр болгосон байж чадна гэв. Тэр зөвшөөрөв. Ингээд хэд хоногийн дараа түүнийг ирэхэд үнэхээр шатрын төв ямар ч тос шороогүй цэвэрхэн болсон байв. Тэрбээр ихэд талархаж намайг тэнд амьдрахыг зөвшөөрсөн. Ингээд миний ажил покерын өрөөг цэвэрлээд шөнө бүхэн тоглоход бэлэн бэлэн болгоход оршдог байв. Покер тоглох өрөөг цэвэрлэхийн зэрэгцээ би тоглогчдын захиалгаар гудамжны эсрэг талд байдаг жижигхэн түргэн хоолны газраас хоол, сэндвич, ундаа авчирч өгдөг ажил бас хийх болов. Үүнээс би боломжийн хэмжээний цайны мөнгө олдог байв. Тэр мөнгөө амралтын өдрүүдэд болдог шатрын тэмцээнд оролцох бас шөнө бүрийн покерын тоглоомд зарцуулдаг байлаа. Шатрын төвд би бараг хагас жил гаруй амьдарсан даа.

Өөрийгөө би шатраас илүү покерт дуртай болсноо мэдэрсэн. Тэгээд арын өрөөний байнгын үндсэн тоглолтод оролцож эхэлсэн юм. Гэтэл хоёр долоо хоногийн дотор бүх мөнгөө алдчихав.

Миний амьдрал нэгэн хэмнэлд оров. Покер оройн долоон цагаас эхэлнэ. Шөнийн 12 цаг гэхэд кофе, сэндвич зэргийг түргэн хоолны газраас зөөнө. Олсон цайны мөнгөө цуглуулж покер тоглох боломжийн мөнгөтэй болдог байв. Тэр үед 0.50-1 долларын тоглолтод 15 доллар цуглуулан орж покер тоглосон юм. Би суусан болоод л 15 доллараа алдчихав. Дараа нь хоёр доллар зээлж түүгээрээ тамхи, сэндвич авч маргааш өдөр хүртэл голоо зогоолоо. Дахин ажиллаад зээлээ дарж, илүү гарсныг нь буцаагаад тоглоомд өгнө. Нэг иймэрхүү тойрогт орсон доо.

Хожиж эхэлтлээ би бараг зуун удаа дампууралд орж байлаа. Тухайн үед байдал маш ондоо байсан. Би Лас Вегасын тухай мэддэг байвч Покерын дэлхийн цуврал тэмцээний талаар ер мэддэггүй байлаа. Түүнд мэргэжлийн тоглогчид оролцож, өндөр бооцоотой тоглодог байсныг ч бас мэдээгүй юм. Невадад болдог покерын тэмцээнд амжилт гаргахын тулд аугаа тоглогчид авьяас чадвараа гарган тоглодогийг ч ойлгоогүй байлаа. Тоглоом бүхэлдээ ур чадвар гэдгийг би бүрэн ойлгоогүй байв. Би бол тоглох дуртай тааруухан л нэг тоглогч байсан. Сайжрах хэрэгтэй гэдгээ мэддэг байсан ч голдуу зугаа хэлбэрээр тоглосоор ирсэн юм.

Тоглоом бүхэлдээ ур чадвар гэдгийг би бүрэн ойлгоогүй байв. Би бол тоглох дуртай тааруухан л нэг тоглогч байсан.

Ширээн дээр тууштай ялагч болохын тулд тоглоомыг хэрхэн тоглох талаар хангалттай мэдлэгтэй болох хүртэл өнгөрүүлсэн жил хагасын үе надад маш их хэрэг болсон юм. Тэгээд ч би боломжийн мөнгө хадгалж чадсан учир шатрын төвөөс гадуур амьдрахаар болов. Нэг залуу сард 150 доллараар байр хөлсөлдгийг мэдээд түүн дээр очиж өрөө хөлсөлж сууснаар эрх чөлөөтэй тусгаар байдлыг мэдрэв. Ингэснээр илүү их тоглох цаг завтай ч болсон түүний дараахнаас өндөр бооцоотой 2-6 долларын ширээнд 100 доллар төлж ордог тоглоом руу очсон юм. Тэр тоглолтууд баасан гарагийн орой эхэлж ням гараг хүртэл тасралтгүй ахин дахин үргэлжилдэг байсан. Эхэндээ тэр тоглолтод эхнээс нь дуустал марафон маягаар тоглодог байснаа больж баасан гарагийн орой боломжтой үедээ тоглоомыг орхин сайхан амарч, бямба гарагийн үдийн хавьд ирэхэд урд шөнийн тоглогчид бүгд л яг хэвээрээ үргэлжлүүлэн тоглоцгоож байдаг байлаа. Тэд бүхэл шөнөжингөө тоглон эцэж ядарцгаасан

хирнээ үргэлжлүүлэн тоглоцгооно. Ийм үед ширээнд суугаад тоглоход надад маш их давуу талтай. Учир нь би сайхан амарчихсан, толгой сэргэг бараг гучин цаг түүнээс ч илүү хугацаагаар унтаагүй тэдгээр тоглогчидтой өрсөлдөнө. Цагийн энэхүү зохицуулалт маань покерт үзүүлэх амжилтад маш ихээр нөлөөлсөн. Ийм үнэ цэнэтэй хичээлийг би хэзээ ч мартдаггүй юм.

Нью Йоркт жил гаруй болсныхоо дараа шатраас бараг л татгалзаж харин покертоо илүү их төвлөрөв. Түүнээс гадна надад маш хэрэгтэй хоёр ном уншив. Энэ номнууд миний цаашдын амьдралд ихээр нөлөөлсөн. Эхнийх нь Амарилло Слимийн бичсэн покерчдын тухай сонин хачин түүхийг өгүүлсэн ном байлаа. Энэ номоо тэрээр Пагги Пийрсон, Сайлор Робертс, "Техасын хүүхэлдэй" Брансон нарын бодит туршлагад үндэслэн бичсэн байв. Тэр номноос би Покерын дэлхийн цуврал болон Техасын том тоглоомын тухай олж мэдэж билээ. Эдгээр нь Покерын мэргэжлийн тухай миний анхны мэдлэг болсон юм. Тэр цагаас хойш Покерын дэлхийн цуврал тэмцээнийг мөрөөдөх болов. Миний чадвар, мөнгөний хэмжээ тэр үед тэмцээнд ороход үнэхээр жулдаж байсныг би мэдэж байсан. Гэвч тэмцээнд орох хүртэл хугацаа байгааг ойлгосон. Гэвч А.Слимын ном покер тоглон амьдарч болох юм байна гэдэг ойлголтыг надад төрүүлсэн юм. Хоёрдахь нь Дэвид Скланскийн Холдем покерын тухай ном байлаа. Тэр ном үнэндээ покерын талаарх миний үзэл бодлыг өөрчилж билээ. Тийм ч том биш, жижигхэн нимгэн, сүртэй гоё биш ном хэдий ч покер бол маш их стратеги, чадвар шаардсан тоглоом гэдгийг ойлгуулав. Тэр номд нэгэн нүд бүлтийлгэм санаа бичсэн байсныг би тодхон санаж байна. Энэ нь хязгаартай покер тоглож байхад газарт флаш гарвал мөрийгөө өсгө, хэрэв түүнийг хийж чадвал их мөнгө хожно, хийж чадахгүй бол гудамжинд хоосон хөзөр бариад явж байгаатай ижилхэн болно хэмээн өгүүлсэн санаа байв. Энэ нь өөр өөр стратеги ашиглан өрсөлдөгчөөсөө илүү мөнгө хэрхэн гаргуулах талаар надад зааж өгсөн төдийгүй покерын талаар илүү нухацтай сайн бодоход хүргэсэн юм.

Би томоохон тэмцээнүүдэд тоглох хэрээр чадвар маань ч нэмэгдсээр байлаа. 57 дугаар гудамжинд болдог долоо хоног тутмын 6-10 долларын тоглолтод би байнга оролцдог болов. Нэг удаа миний мөнгө 8000 доллар болтлоо өсөв. Тэр үед би "тэд Мэйфейр клубт покер тоглож эхэлсэн..." гэж нэгэн тоглогчоос сонссон нь дэлхийд алдартай бэкгаммон, гүүр тоглодог клуб байлаа. Би тэнд тоглож үзэхээр шийдэв. Ер нь Нью Йоркт би бараг хоёр жил хагас тоглосон доо. Энэ нь надад сорилт болж байсныг би мэдэрсэн.

Тэнд 50-100 долларын тоглоомд орохын тулд 1000-2000 доллар төлдөг байлаа. Хэдийгээр би 8000 доллартай байсан ч тэр мөнгө надад харьцангуй өндөр санагдсан. Би мөнгөнийхөө дийлэнх хэсгээр эрсдэл хийхээр байсан нь эрүүл ухаанаар надад мэдрэгдэж байсан учир тоглох хэрэггүй байлаа. Гэвч тэр үед тоглож, 21 хоногийн дотор бүх мөнгөө алдав. Энэ нь миний анхны алдагдал биш байсан ч ийм их хэмжээний мөнгө алдсан эхний тохиолдол байлаа. Урьд нь би 15 доллар алддаг байсан бол энэ удаа бүр мянгаар нь тавиад туучихав. Азаар, надад мөнгөтэй найз нөхөд байсны хүчинд тэд намайг дэмжиж, дараачийн тэмцээнд орох боломж олгосон юм. Шинэ эрч хүч, туйлын их төвлөрөлттэй тоглосноор би тэрхүү тэмцээнд түрүүлэв. Түүнээс хойш тийшээ эргэж харахаа ч больсон доо. Мэйфейр клубээс ойлгосон зүйл гэвэл "дампуурал" ба "покерын дампуурал" хоёрын ялгааг ойлгосонд оршино. Хэрэв чи өөрийгөө нэр хүндтэй сайн тоглогч, шударга үнэнч итгэлтэй гэж бодож байгаа бол чи үргэлж олны анхаарлын дунд байна, тэнд чамайг дэмжигч хэн нэгэн заавал байдаг. Хэрэв

чиний чадвар муу, покерын тойрогт үнэлэмж багатай бол чи үнэхээр дампуурсан ч хэн ч чамайг үл тооно.

Мэйфейр клубт олж авсан чадвар маань өнөөдрийн миний покер тоглох үндэс суурь болж өгсөн юм. Үнэндээ тэндээс л жинхэнэ мэргэжлийн покер тоглогч болох гараагаа би эхэлсэн. Энэ нь миний покерын ертөнцөд орж ирсэн үе байлаа. Анх суралцсан орчин маш чухал. Мэйфейр клуб бол гүүр, бэкгаммон тоглодог дэлхийн шилдгүүдийн цуглардаг газар төдийгүй надаас өгсүүлээд бусад бүх покерчдын анхлан суралцсан газар юм.

Тэрхүү ном нэгэн нүд бүлтийлгэм санаа бичсэн байсныг би тодхон санаж байна. Тэр нь хязгаартай покер тоглож байхад газарт флаш гарвал мөрийгөө өсгө, хэрэв түүнийг хийж чадвал их мөнгө хожно, хэрэв хийж чадахгүй бол гудамжинд хоосон хөзөр бариад явж байгаатай ижил болно гэж өгүүлсэн байсан. Энэ нь өөр өөр стратеги ашиглан өрсөлдөгчөөсөө хэрхэн илүү мөнгө гаргуулах талаар надад зааж өгсөн төдийгүй покерын талаар илүү нухацтай сайн бодоход хүргэсэн билээ.

- Би томоохон тэмцээнүүдэд тоглох хэрээр чадвар маань ч нэмэгдсээр байсан. 57 дугаар гудамжинд болдог долоо хоног тутмын 5-10 долларын тоглолтод тогтмол оролцдог болов. Нэг удаа миний мөнгө 8000 доллар болтол өсөв. Тэр үед би "тэд Мэйфейр клубт покер тоглож эхэлсэн.." гэж нэгэн тоглогчоос сонссон нь дэлхийн алдартай бэкгаммон, гүүр тоглодог клуб байлаа. Тэнд би тоглож үзэхээр шийдэв. Ер нь Нью Йоркт би бараг хоёр жил хагас тоглосон доо. Энэ нь надад сорилт болж байсныг би мэдэрсэн.

Тэнд 50-100 долларын тоглоомд орохын тулд 1000-2000 доллар төлдөг байсан. Хэдийгээр би 8000 доллартай ч тэр мөнгө надад харьцангуй өндөр санагдсан. Би мөнгөнийхөө дийлэнх хэсгээр эрсдэл хийх байсан нь эрүүл ухаанаар надад мэдрэгдэж байсан учир тоглох хэрэггүй байлаа. Гэвч тэр үед тоглож, 21 хоногийн дотор бүх мөнгөө алдсан юм. Энэ нь миний анхны алдагдал биш байсан хэдий ч ийм их хэмжээний мөнгө алдсан эхний тохиолдол байлаа. Урьд нь 15 доллар алддаг байсан бол энэ удаа бүр мянгаар нь алдав. Азаар надад мөнгөтэй найз нөхөд байсны хүчинд тэд намайг дэмжиж, дараачийн тэмцээнд орох боломжтой болов. Шинэ эрч хүч, туйлын их төвлөрөлттэй тоглосноор тэр тэмцээнд түрүүлэв. Түүнээс хойш тийшээ эргэж харахаа ч больсон.

Мэйфейр клубээс ойлгосон зүйл гэвэл "дампуурал" ба "покерын дампуурал" хоёрын ялгааг ойлгосонд оршино. Үнэхээр нэр хүндтэй, шударга үнэнч итгэлтэй тоглогчид үргэлж олны анхаарлын төвд байдаг. Тэднийг дэмжигчид хаа ч байдаг.

Хэрвээ чадвар муутай, покерын ертөнцөд үнэлэмж багатай бол дампуурсан үед хэн ч тоохгүй. Мэйфейр клубт олж авсан чадвар маань өнөөдрийн миний покер тоглох үндэс суурь болж өгсөн юм. Үнэндээ тэндээс л жинхэнэ мэргэжлийн покерчин болох гараагаа эхэлсэн хэрэг. Энэ нь миний покерын ертөнцөд ирсэн үе байлаа. Анх суралцсан орчин маш чухал. Мэйфейр клуб бол гүүр, бэкгаммоны тоглодог дэлхийн шилдгүүдийн цуглардаг газар төдийгүй надаас өгсүүлээд бусад бүх покерчдын хувьд эхлэн суралцдаг учир бүхий газар юм.

Энэ бүх хүмүүс өөр өөрсдийн тоглоомоороо дэлхийн хэмжээний чадварлаг тоглогчид байсан. Бас тэд тоглоом бүртээ өөр өөрсдийн хурц ухаан, мэдлэг, сэтгэлгээ, зарчмуудыг

шинээр нээж байлаа. Хүн бүр л ямар нэг өвөрмөц арга сэдэж, түүнийгээ ширээн дээр гаргахад түүнд хариулах хариултууд ч тэр дороо гарч ирдэг байсан. Тийм учраас аль ч тоглоомын тактик хэзээ ч байгаагүйгээр задарч, тэр хирээр өрсөлдөөний амжилтуудад нөлөөлсөн юм. Хамгийн чухал зүйл нь бүх тоглогчид тоглоомын тухай өөрсдийн санаа, хувилбаруудыг хоорондоо ярилцан зөвлөлдөж хамгийн сайн сонголтыг олдог байлаа.

Хэрвээ чадвар муутай, покерын ертөнцөд үнэлэмж багатай бол дамнуурсан үед хэн ч тоохгүй.

Мэйфейр клуб бол покерт суралцах хамгийн аугаа ертөнц юм. Түүнийг покерчдын ур чадвараа дээшлүүлж, покерыг төгс эзэмших дээд түвшний амьд сургалт ч гэж хэлж болно. Үнэхээр өдөр бүр "хичээл" явагдана. Тоглолт үдээс хойш дөрвөн цагт хөрөнгийн бирж хаагдах цагтай яг зэрэгцэн эхэлдэг байлаа. Учир нь Wall Street-ын хөрөнгийн биржийнхэн ихэвчлэн тоглодог байсан болохоор тэд ажлаа дуусгаад ирнэ. Тоглолт үдэш болтол үргэлжилнэ. Дараа нь хэдүүлээ үлдээд ойролцоох уушийн газарт орж жаал юм уунгаа тэр оройныхоо тоглолтын тухай хэдэн цагаар ч хамаагүй ярилцана. Тэр үед маш олон асуулт бидний дунд өрнөдөг байв. Тухайлбал, "Тэр үед чи ямар модтой байсан бэ?", "Би бол ингэж тоглох байсан", "Чи яагаад тэгж тогловоо, түүний оронд тэгэхгүй яасан юм" гэхчилэн өөр өөрсдийн санаагаа хоорондоо солилцдог байлаа. Тэнд зөвхөн покер тоглох хүсэлдээ автсан хүмүүс л цугларна. Бидний яриа бүгдэд нь покерт суралцах маш сайхан боломжийг олгодог байлаа. Таваас зургаан нөхөд бүгдээрээ л тэр мэтгэлцээнээсээ маш их зүйлийг харилцан суралцсан билээ. Бид ширээний ард өрсөлддөг ч тоглоомынхоо дараа тухайн тоглолтын үед төрсөн санаагаа хоорондоо зөвлөлдснөөр улам илүү сайн тоглогчид болцгоосон. Үнэндээ бид яг л завь өргөдөг далайн давалгаа шиг бүгдээрээ тэр давалгаатай хамт дээшилж байсан гэж хэлж болно. Мэдээж клубт тоглодог бүх хүмүүс тоглоомын дараах энэ "шинжилгээ"-нд оролцдоггүй байсан. Гучин хэдэн хүнээс тав зургаан нөхөд л энэ дүн шинжилгээний бүлгийн гол цөм нь байлаа.

Гэхдээ манай энэ бүлгийхэн бүгдээрээ тохиолдлоор амжилттай сайн тоглогчид болчихоогүй юм. Тэдний дунд Жэй Хэймовиц, Микки Эппелман, Дэн Харрингтон, Эрик Сайдел, Жэйсон Лестер, Стив Золотов, Ноли Франциско нар байлаа.

Зарим хүмүүс Мэйфейр клубт хамгийн шилдэг покерын тоглолтууд болж байсан гэдэг. Энэ бол үнэхээр үнэн. Мэйфейр клубт ирээгүй бол би мэргэжлийн покерчны түвшинд хүрнэ гэдэг үнэндээ бүтэхгүй зүйл байв. Дор хаяхад өндөр бооцоотой тоглолтуудад оролцож чадахгүй байх байсан. Ер нь нэгээс гурав эсвэл хоёроос дөрвөн долларын тоглолтод ихэвчлэн цагийг зугаатай өнгөрөөх гэсэн хөгжилтэй хүмүүс л тоглодог. Харин Мэйфейрын залуус бол тэднээс тэс ондоо. Энэ номыг уншигчдад зөвлөхөд, хэрэв та покерт үнэхээр амжилт гаргахыг хүсч байвал покерын төлөө бүхнээ зориулдаг, покерт үнэхээр дур сонирхолтой тийм л хүмүүсийг олж нөхөрлөх хэрэгтэй. Тийм хүмүүс покерын тухай асуудлыг маш нухацтай авч үздэг. Тэд яг бид нар шиг тоглоомын дараах яриа хөөрөө, хэлэлцүүлэгт ч дуртай байдаг юм. Хэрэв ингэж чадвал энэ оролдлогын үр дүнд сайн тоглогч болж чадна.

Би 1990-ээд оны эхээр Нью Йоркт байхдаа покерын ертөнцөд шинэ орон зайг эрэлхийлж эхлэв. Миний дараачийн шат Лас Вегас руу явах байсан.

Мэйфейр клубт би арваад жил тоглосон. Хэдхэдэн удаа Невада явсныг эс тооцвол миний хувьд покерын цөм ертөнц маань энэ клуб байсан. 1990-ээд оны эхээр Нью Йоркт байхдаа покерын ертөнцөд шинэ орон зайг эрэлхийлж эхлэв. Хамгийн том тоглолт нь 150-300 долларын тоглолтууд байлаа. Өөрийнхөө тоглолтыг би дараачийн шатанд гаргахын тулд Лас Вегас руу явах хэрэгтэй байв. Лас Вегаст хамгийн шилдэг тоглогчдын, хамгийн өрсөлдөөнтэй тоглолтууд явагдана. 1993 онд манайх Лас Вегас руу нүүв. Ийнхүү миний хувьд Мэйфейрийн покерын сургалтын дараах покерын цоо шинэ орон зай нээгдсэн юм. Үнэндээ энэ орчин, хүрээлэл нь миний хувьд покерт суралцах маш аугаа боломжийг олгов. Хасаа хочит Рийс, Дойл Брансон нартай тоглосноор би илүү чадвартай тоглогч болсон билээ. Дахин сануулахад, ширээний ард сайн тоглогч болохыг хүсвэл өөрөөсөө илүү сайн чадвартай хүмүүстэй тогло. Би ихэнхдээ чадварын хувьд тааруухан хүмүүстэй тоглож тэднээс цуглуулсан мөнгөө өөрөөсөө илүү чадвартай тоглогчидтой тоглохдоо "сургалтынхаа төлбөр" болгон хураалгадаг байлаа.

Дахин сануулахад, ширээний ард сайн тоглогч болохыг хүсвэл өөрөөсөө илүү сайн чадвартай хүмүүстэй тогло.

Энэхүү номыг бичиж байх үеийг хүртэл би нийтдээ 25 жил покер тогложээ. Зарим хүмүүс надаас "Энэ бүх хугацаанд таны хувьд, мэргэжлийн сайн тоглогч болохын тулд үүнийг хийх ёстой гэдгээ мэдрэх үе байсан уу?" гэж асуудаг. Үүнд нь би "Тийм ээ" гэж хариулдаг. 1987 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний сүүлийн шатанд тийм үе тохиож байлаа. Тэр үед дэлхийн хамгийн шилдэг тоглогч Жонни Чаны эсрэг тоглож байсан юм. Тэрбээр үнэхээр "хасааны эзэн" байсан. Надад хос дадар ирсэн байлаа. Тэрбээр дуудлаа, би ч мөн адил дуудсан тэгтэл газарт боол, ес, туг эргэв. Тэрбээр чек хийхэд би дагаж чек хийсэн. Гэтэл дөрөв эргэхэд Чан бооцоогоо нэмдэг юм байна. Надад сайн хөзөр байгаа гэдэгтээ итгэлтэй байлаа. Тав дахь мод эргэхэд бүгдийг оруулах шаардлага гарч магадгүй гэж бодсон. Ширээг нэлээн удаан, бараг минут гаруй харж байгаад даруухан дуудлаа. Сүүлчийн хөзөр бас дөрөв байсан. Газарт хос модтой болж, миний хувьд байдал эергээр эргэв. Гэвч Жоннид дөрөв байсан бол тэр намайг ялах байсан. Тэгээд би "миний мод дөрөв дэх гудамжинд илүү байсан юм чинь сүүлийн хэсэгт бас илүү байх ёстой" гэж бодов. Эндээс Жонни намайг бүгдийг оруулахад хүргэсэн. Би тэгэхэд ялж, хасаагаа хоёр дахин нэмсэн. Ширээнд таван хүн тоглож байлаа. Тэгж хожсоны дараа хүртэл би тавдугаарт нь байсан. Үнэндээ тэр тоглолт мөнгөний хувьд тийм их амжилт авчраагүй ч би хэнтэй ч тоглож чадах юм байна гэсэн итгэлийг надад төрүүлж өгсөн юм.

Мэдээж, ганцхан удаагийн хослол покерын амжилтыг төлөөлж чадахгүй. Хэрэв сайн хослол ирсэн гэдэгтээ итгэлтэй байвал "Хөөе. Надад хамгийн шилдэг тоглогчид ирдэг мод надад ирсэн байна" хэмээн хэлдэг байлаа. Тэрхүү тоглолт зөвхөн Жонни Чаны эсрэг тоглолт байгаагүй юм. Тэр бол тэмцээний сүүлчийн шатанд болсон шувгаргын тоглолт байлаа. Хэрэв би буруу тооцоолсон бол өөрийгөө муу гэдгээ бусдад сайн дураараа харуулах ёстой байв. Тэр үед өөрийнхөө зөв гэдэгт би бат итгэлтэй байсан. Түүн дээрээ туйлбартай зогсч, хөгжөөн дэмжигчид болон тухайн нөхцөл байдлын нөлөөллөөс өөрийгөө бүрэн тусгаарлаж чадсан юм.

Өөрийнхөө амьдралыг эргээд харж байхад покерыг мэргэжлээ болгон сонгосондоо би огтхон

ч харамсдаггүй. Покер надад сайхан амьдралыг өгсөн. Амьдралын тухай маш аугаа хичээлийг надад заасан билээ. Маш үнэтэй сургамжуудыг ч бас өгсөн. Покерын чадварлаг тоглогч бол өөртөө чин үнэнч, бодитой ханддаг байх ёстойг би олж мэдэв. Чадварлаг тоглогч болохын тулд өөрийнхөө сул талыг зайлшгүй мэдэх шаардлагатай. Түүнийгээ засах талаар маш их хичээл зүтгэл гаргах хэрэгтэй. Ингэснээр өөрөө өөртэйгээ маш дотно харилцааг бий болгодог. Покерын ширээн дээр ялалт байгуулахыг хүсч байгаа бол өөрөө өөрөөсөө суралц гэдэгт би итгэдэг. Хэрэв ингэж чадахгүй бол ширээний ард эсрэг тэсрэг тогтворгүй байдалтай тоглож, өөрийгөө зовоож бас нураадаг. Мөнгөтэй харьцах харилцаагаа хөгжүүлэх хэрэгтэй. Энэ нь тийм ч амар биш. Маш олон хүн мөнгөтэй харьцаж чаддаггүйгээс аливаа асуудалд ордог. Би хар багаасаа л их мөнгө, баялагтай харьцаж байгаагүй. Хэрэв мэргэжлийн покерчин болохыг үнэхээр хүсч байгаа бол мөнгөтэй харьцах харилцааг зайлшгүй сурах хэрэгтэй. Энэ нь сайн тоглогч болох хүсэл мөрөөдлөөс тэс ондоо зүйл. Гэвч энэ харилцаа чамайг үнэндээ хэн бэ? гэдгийг чинь тодорхойлох болно. Хүн болж төлөвших замыг чинь зааж өгнө. Түүнээс гадна оюун санаагаа сайтар төвлөрүүлж, аливаа асуудлыг дээрээс нь томоор харж сурахад өөрийгөө сургах хэрэгтэй. Мэдээж хүн бүр өдөр болгон покерын ширээн дээр хожихгүй. Өгсөж уруудах давааг давж гарч чадах сэтгэл зүйн бэлтгэлтэй болох хэрэгтэй.

Покерчны хувьд миний талаар ямар дурсамж үлдэх бол? Хүмүүс намайг ширүүн өрсөлдөгч, тоглож байхдаа жинхэнэ эр хүн, покер тоглох дуртай нэгэн, тоглоомын байнгын "сурагч" гэж хэлнэ гэдэгт найдаж байна. Покерын зөвлөх, олон хүнд покер сайн тоглож сурахад нь тусалсан гэж үнэлэлэгдэнэ гэдэгтээ бас итгэлтэй байна.

Нэмж хэлэхэд, домог болохоор хэд хэдэн ялалт надад бий. Үүнд, Покерын дэлхийн цуврал тэмцээн, Покерын дэлхийн аялан тоглолт, түүнчлэн мөнгөний томоохон тэмцээнүүд орно. Эцэст нь хэлэхэд, би олны хүндэтгэлийг хүлээсэн, итгэлтэй тоглогч байсан гэж дурсагдахыг хүсч байна. Покерыг мэргэжлээ болгохыг хүсч байгаа хүмүүст хэлэхэд, сонголтоо маш оновчтой зөв хийгээрэй, үнэхээр хүсэл сонирхол байвал мэргэжлийн тоглогч болж болно гэж хэлэх байна. Хэрэв тэр зорилгодоо хүрч чадвал өөрөө өөрөөрөө бахархах болно. Түүнчлэн итгэлтэй сайн найзууд, талархдаг дэмжигчидтэй ч болж чадна. Бас нэг зүйлийг хэлэхэд, шаардлагатай үед санхүүгийн дэмжлэг үзүүлдэг нөхдүүдтэй байх хэрэгтэй. Хэрэв хэн нэгэн бизнес хийж байгаад дампуурвал өөр нэрээр бизнесээ дахин эхэлж болдог. Харин покерт тухайн хүний нэр гэдэг бол өөрт нь байгаа ганцхан өмч. Хэрэв покерын ертөнцөд нэрээ л алдах юм бол түүнийхээ горыг насан туршдаа амсах болно гэдгийг байнга санаж яв.

Түүний тухай мэдээллийг HowardLederer.com сайтаас авч болно. Мөн www.fulltiltpoker.com - оор орж түүнтэй хамт покер тоглож болно. Ховард ба түүний эхнэр Сюзи нар Лас Вегасын "Хөвгүүд ба охид" клуб (www.bgclv.org) гэсэн байгууллагыг санхүүгийн хувьд дэмждэг. Энэ байгууллага нь өөртөө итгэлтэй, хүсэл эрмэлзэлтэй, өөдрөг, аливаа зүйлийг хийх чин эрмэлзэлтэй хүүхдийг дэмжих зорилготой.



Фил Хэлмут /бага/

Хэрвээ Покерын дэлхийн цуврал тэмцээнийг бэйсболтой харьцуулвал бүх оддын тоглолтын гарааны тоглогчоор Фил Хэлмут яах аргагүй тодорно. Фил Хэлмут покерын ертөнцөд хамгийн дээд амжилтыг үзүүлсэн юм. Покерын дэлхийн цувралын 11 удаагийн алтан бугуйвчтай, 2007 онд покерын ертөнцийн бүх үеийн шилдгүүдийн жагсаалтад бичигдсэн тэрбээр Покерын дэлхийн цуврал тэмцээнд цахиур хагалж байснаас гадна 10 сая орчим доллар бэлнээр авч байсан түүхтэй. Дэлхийн олон газар олон тэмцээнд түрүүлсний дотор 2005 оны Үндэсний шилгүүдийн аварга шалгаруулах тэмцээнд мөн аваргалжээ.

Покерын ширээн дээрх амжилтаас гадна "Покерыг мэргэжлийн түвшинд тоглоцгооё" гэдэг ном бичсэн. Энэ ном нь Нью Йорк таймс сониноос шалгаруулсан хамгийн шилдэг номын нэг болсон юм. Тэрбээр зурагтын хэд хэдэн шоуг найруулж, заримд нь өөрөө оролцжээ. Сүүлийн

хэдэн жил арилжааны чиглэлийн томоохон олон ажлыг эрхлэхийн сацуу тэрбээр "Poker Brat" гэсэн хувцасны бизнес хийж, түүнийгээ сурталчилдаг. Түүний зураг гэхэд 12 сая ширхэг хувиар "Milwaukee's Best" шар айрагны шошгон дээр сурталчлагдсан байна. Тэрбээр покерын ертөнцийн билэг тэмдэг болсон юм. Ф.Хэлмутын покерын ертөнц дахь нэр хүнд нь яг л гольфийн ертөнцийн нүүр царай болсон Тайгер Вүүдсийнхтай адил.

Заримдаа тэр покерын ширээний ард хамгийн содон хүмүүсийн нэг боловч маш их гэр бүлсэг нэгэн. Эхнэр, хоёр хүүдээ маш хайртай. Филээс хамгийн их хүндэлдэг одууд чинь хэн бэ гэж асуухад тэр "Тэр бүлээ нэгдүгээрт авч үздэг, ямар ч одыг би хүндэлдэг" хэмээн хариулжээ.

Би өөдрөг бодлын хүч чадалд баттай итгэдэг нэгэн. Өгүүллэгийг үндсээр нь өөрчилсөн Германы зохиолч Йохан Гёте нэгэн удаа шинэ зүйл хийхээр төлөвлөж байгаа хүний талаар өгүүлэхдээ "хэрэв эхний алхмаа хийсэн л бол аугаа их хүчин зүйлүүд чиний зам дээр аль хэдийнээ бууж ирсэн, тэгэхээр одоо гагцхүү тэр зам дээр гарч хурдаа нэм" гэж бичжээ. Үнэн үг тэр болгон хэлэгддэггүй ч энэ үг үнэн болохыг би өөрийн амьдралаараа мэдэрсэн юм. Хэрэв би өмнө тавьсан зорилгоо амьдралынхаа үндсэн зарчим болгон бүх эрч хүч чадвараа түүнд төвлөрүүлж зүтгэх юм бол надад аугаа зүйлс тохиолдох нь гарцаагүй. Хүн ирээдүй өөд бүхнээ чиглүүлэн тэмүүлж явахын чухлыг манай гэр бүлийнхэн надад зааж сургасан билээ.

Намайг бага байхад ээж хэд хэдэн үгийг цаасан дээр бичээд угаалгын өрөөний толин дээр наадаг байлаа. Тиймээс би "Чи юу бодож сэтгэж байгаагаараа тодорхойлогдоно", "Чи бодож байгаа шигээ болох болно", "Юу бодож байгаа зүйлс чинь бодит болно" хэмээх урам өгсөн үгсийг өглөө болгон шүдээ угааж байхдаа хардаг байсан.

Би Висконсин дахь Мэдисон гэдэг сургуулийн хотод төрсөн юм. Энэ хот Невадагийн казиногоос 1700 бээрийн зайтай газар юм. Манай гэрийнхэн намайг хэзээ ч мэргэжлийн покерчин болно гэж төсөөлж байгаагүй. Яагаад гэвэл ээж маань уран барималч, аав Висконсины их сургуулийн декан байлаа. Ийм нэр хүндтэй өндөр хүндэтгэлийг хүлээсэн хүмүүст мөрийтэй тоглоом гэдэг маш бүдүүлэг төдийгүй санаанд багтамгүй зүйл байсан биз ээ. Таван хүүхдийн хамгийн ахмад нь би учир нэг эрэгтэй дүү, гурван охин дүүдээ үлгэр дууриал үзүүлэх хэрэгтэй байсан юм. Гэрийнхэн маань намайг сургуульд орж, эрдмийн зэрэгтэй болж боловсролын чиглэлээр юм уу мэргэжлийнхээ ажил хийнэ гэж төсөөлдөг байв. Хуулийн юм уу, анагаахын чиглэлээр явах болов уу гэж бодож байсан. Сүүлд нь миний хийсэн сонголтыг сонсоод "хөзрөөс гадуур байсанд" ихэд гутарсан гэдэг.

Би 12 настай байхдаа анх покер тоглосон юм. Манай найзууд, хөршийн хэдэн хүүхэд нийлэн тоглодог болов. Бид улаан, цагаан, цэнхэр өнгийн хасаануудыг тэндхийн дэлгүүрээс худалдан авч түүгээрээ тоглоно. Зуныхаа амралтаар Висконсины хойд хэсэгт орших өвөөгийн дөө очно. Тэнд ч бас тэр хавийн хүүхдүүдтэй нийлэн покер тоглодог байлаа. Заримдаа насанд хүрсэн хүмүүс ч тоглоомд оролцдог байсан ч голдуу хүүхдүүд хэдхэн доллараар хөзөр тоглон зугаацаж, цаг нөгцөөхөөс цааш хэтэрдэггүй байв.

Гэвч тэдгээр зугаатай мөчүүд ирээдүйн тухай төсөөллүүдийг надад бий болгосон төдийгүй алсын мөрөөдөл, амжилтын эх үндсийг тавьсан билээ. 15 бил үү, 16 настайдаа нэгэн удаа покер тоглож байлаа. Баасан гарагийн тэр нэг орой жирийн л тоглолт явагдаж байсан юм. Яг

тэр үед Ийглзын дуулсан "Хязгаарт нь хүртэл явуул" хэмээх дуу эгшиглэв. Би түр саатан түүнийг сонсох үед надад нэгэн мэдрэмж төрөв. Тэгээд "Тийм ээ, би хязгаарт нь тултал мөрийцөж болно шүү дээ" хэмээн бодсоноо санадаг.

•••

Түүний нэрийг Роус Гнаден гэдэг. Энэ эмэгтэй зурхайч гэдгээрээ олонд алдаршсан байв. Тэр надтай хамт байсан хүмүүсийн гарын алгыг харуут уншиж эхэлсэн юм. Тэрээр тэдэнд гэгээрүүлэн сэнхрүүлэх зүйл огт хэлээгүй. Миний ээлж болоход тэр гарыг минь барьсныхаа дараа гэнэт царай нь хөхрөв. Энэ нь надад жаахан түгшүүр төрүүлэх мэт санагдав..

•••

Миний амьдрал Висконсины их сургуульд орсны дараа өөрчлөгдөж эхлэв. Би сурлагадаа тийм их анхаараагүй, харин покер байнга тоглодог байв. Хэдэн улирал сургуульд суралцсаны дараа таван долларын Техас Холдемийг байнга тоглох болов. Гол төлөв 1968 оны Вьетнамын дайны дурсгалд зориулсан оюутнуудын цугларалтын газар болох Дурсгалын Холбоонд ихэвчлэн тоглоно. Тэндхийн тоглоом олон хүний анхаарлыг татсан юм. Таксины жолооч, оюутнуудаас эхлээд эмч, эрдэмтэд гээд маш олон янзын хүмүүс тоглоно.

Их сургуулиас мөрийтэй тоглохыг сургуулийн талбай дээр хориглосон учир бид Австрийн зоосоор тоглодог байлаа. Энэ нь биднийг жинхэнэ мөнгөөр мөрийтэй тоглож байгаагаа далдлах сайхан боломж байв. Ямар нэг асуудал болоход гадаадын мөнгөн дэвсгэртээ харуулж бид мөнгөөр мөрийтэй тоглоогүй ээ, зүгээр зугаа болгон тоглож байна гэдэг байлаа. Харин дараа нь түүнийгээ бэлэн мөнгөөр солиулахад л жаахан асуудал гарна.

Би тэр тоглолтод алдаг оног амжилттай тоглож байсан. Арав дахь долоо хоног дээрээ ялагч болж гэртээ 300 доллартай харив. Энэ мөчийг хүртэл надад тийм их хэмжээний мөнгө хэзээ ч байгаагүй. Манай гэр бүл тийм баян байгаагүй. Мэдээж таван хүүхдийн хоол хүнс, гутал хувцас дээрээс нь миний сургалтын төлбөр, байр хоолны зардал гээд зарлага ихтэй л дээ. Гэрийнхэн маань надад ажил олж өгөв. Тэр нь сургуулийн туршилтын лабораторийн туслах ажилтан байв. Өглөө долоогоос өдөр арван нэг хүртэл ажиллана. Сармагчингуудын тор цэвэрлэдэг үнэхээрийн дарамттай ажил байлаа.

Тэр сармагчингууд тэвчихийн аргагүй авиртай, наад зах нь баасаа бие биендээ нялах жишээтэй. Миний ажлын нэг хэсэг бол тэр сармагчингуудын урьд орой нь хана руу шидсэн хатсан баасыг өндөр даралттай усаар шүршин угааж цэвэрлэх үүрэгтэй байв. 300 доллар хожсоноосоо хойш дахин мөрийцмөөр санагдав. Ажил дээрээ ирээд сармагчны баасаар дүүрсэн хана болон шинэхэн хожсон мөнгөө хараад дараачийн шийдвэрийг их амархан гаргасан. Лабораторийн туслахын ажлаасаа гарч покероо хөөхөөр болов. Би покер тоглох дуртай, тоглож суухад хүртэл хорхой хүрэм, мөнгө нь илүү, мэдээж бас агаар нь ч хамаагүй цэвэр.

•••

Сэтгэл зүйч надаас чамд цаашид ямар төлөвлөгөө байна хэмээн асуусан юм. Би өөрийнхөө

цаашдын амьдралд гайхамшигтай зүйл олныг бүтээх болно гэж итгэлтэйгээр түүнд хэлсэн. Харин түүний хариулт миний бодож байснаас тэс өөр байлаа. Тэр хариу нь миний эгдүүг хүргэсэн төдийгүй харин ч бүр ээжийг уурлуулж орхив.

•••

Би тэр үед Тули Харомитай анх уулзсан юм. Тэр маш ухаантай бас Лас Вегас дахь Невадагийн их сургуулийг биохимийн чиглэлээр докторын зэрэгтэй төгссөн байлаа. Тэрээр 18 настай байхдаа цагт 25 доллараар цалинжиж сургуулийн компьютер сүлжээг засварлах ажил хийдэг байв. Үнэндээ 25 доллар гэдэг тухайн үедээ маш их мөнгө байлаа. Биднийг танилцах үед Тули 32 настай амьдралын маш их туршлагатай болсон байв. Харин би дөнгөж их сургуулийн нэгдүгээр курст хуруу хумсаа хугалан суралцана. Бидний нас, амьдралын туршлага асар их зөрөөтэй байсан ч бид сайн найзууд болов. Нэг үгээр хэлбэл биднийг покер холбож өгсөн. Тэрээр покерыг тооны ухаан, сэтгэлгээний урлаг гэдэг талаас нь авч үздэг байсан төдийгүй өөрийнхөө хэмжээнд сайн тоглогч байлаа. Покерын тухай маш олон зүйлийг надад зааж өгсөн дөө.

Тули мөнгөний маш сайн менежер төдийгүй илүү дутуу зүйлгүй чанга хатуу бизнесмэн. Би хамгийн эхлээд түүний бизнес чанараас суралцсан. Сармагчны үүрийг цэвэрлэх ажпаасаа гарснаас хойш хэсэг хугацааны дараа би бүх мөнгөө алдав. Тэр үед Тули надад 100 доллар зээлдүүлсэн юм. Ингэхдээ барьцаа болгон миний жолооны үнэмлэхийг авсан юм. Энэ бол хувийн харьцааны асуудал биш цэвэр бизнесийн асуудал. Энэ бүх үнэ цэнэтэй хичээлийг хэцүүхэн замыг туулж байж ойлгосон доо. Тэр үе бол миний хувьд покерын мөнгөө төлж чадахгүй болсон анхны бөгөөд сүүлчийн тохиолдол байлаа.

Надад покер тоглох хангалттай мөнгө байсангүй. Бүр оюутны байрны мөнгөө төлж чадахгүй халаас хоосон үе ч олон бий. Жолооны үнэмлэх маш их хэрэгтэй байсан учраас сургуулиасаа гарч, тэндхийн фермд ажилд оров. Фермийн ажил маш хүнд байлаа. Нуруу байнга өвдөнө. Өглөө долоон цагт хөлдөж үхмээр хүйтэнд мотоциклиэр явж, өдөрт наймаас есөн цаг эрдэнэ шишийн талбайд ажилладаг байлаа. Ингээд гурван сар гаруйн дараа өрөө дарж, бас дээрээс нь тоглох мөнгөтэй болж, покерын ширээндээ эргэж ирсэн.

Гэвч покер тоглох миний сонголт манай гэр бүлийнхний дунд маш хүнд асуудал үүсгэсэн юм. Ялангуяа аав бид хоёрын дунд эцэс төгсгөлгүй маргаан дэгдэж эхлэв. Аав маань намайг покер тоглохоор болсонд тун дургүй байсан. Тэр үеэс эхлэн бид хоёр өөр өөрсдийн байр сууриа баттай хамгаалцгааж, эсрэг тэсрэг туйлд сөргөлдөн зогсох болсон юм. Бид хоорондоо үргэлжид маргалдан зөрөлддөг байв. Заримдаа маргаан хурцдаж, бүр ч ширүүснэ. Хэн нь ч бууж өгөхгүй нэг хэсэгтээ л үзэлцэнэ. Оройн хоолоо хамт идэхдээ ширээний ард олон удаа зөрөлдснөөс ээж тавагтай хоолоо авч ширээг орхиж, нөгөө өрөөндөө ороход хүрдэг байсан. Нэгэн удаа манай гэрийнхэн сэтгэл зүйчид хандаж, асуудлуудаа ил гаргаж шийдвэл харилцаа маань сайжрах байх хэмээн бодсоор бид бүгд очсон юм. Би бодохдоо энэ бүхэн надад л хэрэгтэй зүйл хэмээн бодов.

Манай гэр бүлийнхэн тойрог болон сууцгааж бие биендээ хандан, өөр өөрсдийн бодол санаагаа шуудхан хэлцгээж байлаа. Гэтэл сэтгэл зүйч над руу хандаж, яг энэ үед чиний амьдралын цаашдын төлөвлөгөө юу вэ хэмээн асууж билээ. Би цаашдын амьдралдаа

гайхамшигтай зүйлсийг бүтээх болно гэж итгэлтэйгээр түүнд хэлэв.

Харин түүний хариулт миний хүлээж байснаас тэс өөр байлаа. Тэрбээр "Чиний хэлж ярьж байгааг харахад чамд хүсэл эрмэлзлэл рүүгээ тэмүүлж байгаа гэх ганц ч зүйл алга. Бүгд чамд огт хэрэггүй өөрийг чинь доош нь хийх бодолд авгжээ" хэмээн хэлэхэд нь би дотроо нэлээд эгдүүцсэн ч ээжийн маань бүр их хүрсэн байлаа.

Ээж суудлаасаа үсрэн босч тэр сэтгэл зүйчид хандан "Чи ер нь өөрийгөө хэн гэж бодоо вэ? Чи миний хүүг ямар ч онцгой зүйл хийж чадахгүй гэж бүү хэл" хэмээн уурлаж билээ.

Бидний сэтгэл зүйчид хандсан явдал үүгээр төгсөв. Гүйцээ.

•••

"Илжиг гэдэг бол нуруун дээрээ мөнгөө ачиж Лас Вегаст хүрч ирээд, бидний урд найрсгаар буулгаж тавьдаг амьтад."

Хэдийгээр Лас Вегаст очиж тоглох боломжтой болсон үедээ би сэтгэлээр хөөрч байсан ч энэ бүх хугацаанд зүгээр л нэг "хөгийн тэнэг гар" байхыг хүсээгүй юм.

•••

Гэр бүлийнхнийхээ шахалтаас болж би сургуульдаа эргэж оров. Гэхдээ покер тоглохоо ч больсонгүй. Оюутны холбооны тоглолтод тоглодог сэтгэл мэдрэлийн эмч мэргэжилтэй нэг тоглогч надад лхагва гараг бүрийн орой 100 долларын бооцоотой покер тэдний гэрт тоглодгийг хэлэв. Тэрхүү "эмч нарын покер" миний хувьд шинэ орчин байсан хэдий ч тэнд очингуутаа би маш их хэмжээний мөнгөөр тоглодог болохыг мэдэв. Миний урьдын туршлага, амжилт маань намайг хөөрөгдөж байлаа. Тэр тоглолтууд миний өөрөө өөртөө итгэх итгэлийг улам сэргээж өгсөн. Тэнд тоглогчдоос зөвхөн би л ганцаараа нэрнийхээ урд магистр, доктор гэсэн тодотголгүй байсан ч тэднийг ээлж дараалан хожсоор байлаа. Энэ нь тэд нарыг доромжилж байгаа хэрэг огтхон ч биш. Бас докторын зэрэггүй байлаа гээд хүнийг унших чадвар муу, тоглоомын онолын мэдлэг дутуу гэсэн үг огт биш ээ. Хамгийн багадаа 100 доллараар тоглолтод орно. Зарим нь бүр 500,1000 долларын хасаа аван тоглодог байсан. Нэг орой гэхэд зарим хүн хэдэн зуугаар нь алдаж байсан. Сайн тоглосон нэг орой би 2700 доллартай болов. Тэр бол ийм их хэмжээний мөнгө хожсон анхны тоглолт байсан.

Покерын ширээн дээр гаргасан өөрийнхөө амжилтад урамшин дөрөвдүгээр курст байхдаа сургуулиасаа гарав. Энэ үеэс эхлэн покерыг үндсэн ажлаа болгон тоглох болов. Лхагва гарагийн оройн тоглолтдоо үндэслэн Тули бид хоёр өөрсдийн тоглоомыг үүсгэн байгуулсан юм. Удалгүй би 20 мянган доллартай болж, бас 21 нас ч хүрлээ. Тэр үеэс Лас Вегаст очиж покер тоглох ур чадвараа шилдгүүдийн эсрэг туршиж үзэхийг үнэнээсээ хүсч эхэлсэн юм. Ер нь би хэр зэрэг тоглогч вэ? гэдгээ мэдэхийг л хүссэн хэрэг. Би хотынхоо бүх тоглогчдыг хожиж энэ хотын аварга болсон. Ийм хүн Лас Вегасын мэргэжлийнхнийг хожих болов уу?

Лас Вегас бол над шиг залуусын мөрөөдлийн орон юм. Тиймдээ биднийг "илжиг" гэдэг. Навчин тамхи татдагаараа алдаршсан покерын ертөнцийн нэгэн өвөрмөц тоглогч Пагги

Пийрсон бидэн шиг залуусыг тодорхойлсон шинэ хэллэг гаргасан нь бий. "Илжиг гэдэг бол нуруун дээрээ мөнгөө ачиж Лас Вегаст хүрч ирээд, бидний урд найрсгаар буулгаж тавьдаг амьтад" гэж тэр хэлсэн байдаг. Хэдийгээр Лас Вегаст тоглох боломжтой болсон үед би сэтгэлээр хөөрч байсан хэдий ч энэ бүх хугацаанд зүгээр л нэг "хөгийн тэнэг гар" байхыг хүсээгүй юм.

Миний Лас Вегас руу хийсэн анхны аялал дурсамж дүүрэн байв. 1985 оны шинэ жилийн орой Дюнес хэмээх покерын өрөөнд орж, 20-40 долларын найм ба түүнээс дээшхи стад тоглосон юм. Эхний тоглолтоо хийхээр ширээнд очиход Тэли Саваласын хажуу дахь хоосон суудлыг зааж өгөв. Тэр үед би дотроо "Хачин юм, ийм сонин хувцас өмсөчихөөд хажууд сууж байна гэж үү" хэмээн бодов. Эхлээд их зантай мэт харагдсан боловч үнэндээ их дажгүй залуу байлаа. Хэсэг хугацаанд тоглосны дараа тэр над руу тонгойж харснаа "Хөөе хүүхдээ, чи бид хоёр энд загас шүү" хэмээн шивнэж билээ. Тийм ээ. Үнэхээр түүний зөв байв.

Тэлигийн магадлал үнэн болтол нэлээд хэсэг хугацаанд тоглосон. Би өөрт байсан бүх мөнгөө бас гурван мянган долларын аяллын тасалбараа бүгдийг нь алдав. Энэ сургамж надад гайхшрал, гутрал, доромжлол, гутамшиг, ухаарал гээд бүгдийг нэг дор ойлгуулсан юм. Мэдисонд би хэзээ ч тоглоомоо зогсоож байгаагүй. Би хүүхэд учир түүнээс өөр байх газар надад байгаагүй юм. Хэрэв шөнөжин үргэлжлэхээр бол хэн нэгэн л ширээг орхиж ажил руугаа, эсвэл гэр рүүгээ явдаг байлаа. Харин тэгэхэд би оронд нь тоглоод л үлддэг байв. Яагаад болохгүй гэж... Тэр үед өөр юу ч биш гагцхүү л покер миний амьдрал болсон байсан тул надад покерын ширээг орхих ямар ч шалтгаан байгаагүй юм.

Лас Вегаст покер тоглоом завсарлана гэж байхгүй. Шинэ тоглогчид байнга цаг үргэлж нөхөн ирдэг. Покерын тоглолтууд ар араасаа үргэлжилсээр би ч шимтэн тоглосоор байсан. Тэр үед нэг удаа 50 цаг тасралтгүйгээр тоглосон юм. Бараг хоёр өдөр нэг ч цурам хийлгүйгээр багахан хоол идээд хэдэн удаа ариун цэврийн өрөө рүү явсныг эс тооцвол зогсолтгүйгээр тоглов. Сүүлдээ ёстой нам цохиулсан даа. Хамаг мөнгөө алдаж, нэг ч зоосгүй, ичгүүртэй байдалд орж, эцэтлээ ядарсан би арайхийн хоёр хоног хоосон байсан өрөөндөө ирээд, орон дээрээ унаад өгсөн. Бараг л толгой дэрэнд хүрч амжаагүй байхад гүн нойронд дарагдаж нам унтаж билээ. Зургаа долоон цагийн дараа өрөөний хаалгыг маш хүчтэй балбахад би сэрэв. Тэд буудлын хамгаалалтынхан байлаа. Тэр үед би Тулитай хамт тэдний Лас Вегаст байдаг гэрт урьд өдрийн орой очно гэдгээ таг мартчихсан байв. Тэгээд тэрээр надтай утсаар холбоо барих гээд болохгүй байсан тул санаа нь буудлын хамгаалалтынханд хэлж тусламж гуйсан нь тэр байлаа. Хэрэв хаалгаа онгойлгож тохиолдолд эвдлээд ч хамаагүй орж намайг амьд байгааг шалгахыг хүссэн байлаа.

•••

Тэгэхэд би 50 цаг гаруй тоглов. Бараг хоёр өдөр нэг ч цурам хийлгүйгээр багахан хоол идээд хэдэн удаа ариун цэврийн өрөө рүү явсныг эс тооцвол зогсолтгүйгээр тоглосон юм.

Сүүлдээ ёстой нам цохиулсан даа. Хамаг мөнгөө алдаж, нэг ч зоосгүй, ичгүүртэй байдалд орж, эцэтлээ ядарсан би арайхийн хоёр хоног хоосон байсан өрөөндөө ирэв.

•••

Эргээд Мэдисондоо ирэхдээ хоосорсон байсан боловч тэгтлээ доош орчихоогүй байлаа. Удалгүй буцаж явлаа. Ингэж ирж буцсаар нийт есөн сарын хугацаанд есөн удаа Мэдисон, Лас Вегас хоёрын хооронд зорчсон байлаа. Үүнийхээ дүнд арайхийж олсон 20 мянган доллараа бүгдийг нь алдав. Энэ бүхэн мөрөөдөл биш хар дарсан зүүд болж хувирав. Лас Вегаст очин хамаг мөнгөө алдчихаад эргээд Мэдисондоо ирж дараачийн ээлжинд тоглох хэсэг мөнгө хийгээд буцаад явна. Ийм тойрогт орж удаан явсан. Энэ эргүүлэг дунд нэлээд хэмжээний мөнгө алдсан. Гэвч энэ бүхний эцэст би зорилготой болж эхэлсэн юм. Хэдийгээр би мөнгөө алдаж байсан ч гэсэн өөртөө улам итгэлтэй болж Лас Вегасын покерын ширээн дээр хожих итгэлээ улам бэхжүүлсээр байлаа. Мэргэжлийн тоглогчид ч гэсэн адилхан хүн, тэд ч гэсэн алдаа хийдэг гэдгийг би олж харав. Би тэр ойлголтыг өөртөө хэвшүүлж чадсанаар эцэстээ энэ бүхэн надад давуу талыг бий болгож байнгын тогтвортой ялагч болоход маань тусалж байсныг ойлгож байлаа. Гэхдээ би өөрийнхөө тоглолтыг дараачийн түвшинд гаргах хэрэгтэйг мэдэж байлаа. Гэвч түүнийгээ хийж хараахан чадаагүй л байлаа. Энэ үе миний амьдралын хамгийн шийдвэрлэх үе байв. Яг тэр үед хоёр зүйлийг ухаарсан. Тэр нь миний хувьд покерыг мэргэжил болгоно гэсэн үүрдийн мөрөөдлийг биелүүлэхэд хүчтэй нөлөөлсөн.

Эхнийх нь болж байгаа үйл явдал бүхэн дүрс үзэгдэл болон нүдэнд харагддаг болов. Одоогийн болон ирээдүйн байдал нүдэнд шууд ил харагдана. Тэр үед покерын ширээний ард суун эсрэг тоглогчдынхоо ихэнх хасааг хурааж, тэднийг бут ниргэж, миний урд хасаанууд цамхаг адил хасаа өрөөстэй харагдах болсон. Эхлээд энэ бүхэн юун тухай өгүүлээд байгааг мэдээгүй. Гэвч тэр бүхэн нь миний өөрөө өөрийнхөө чадварт итгэх итгэлийг бэхжүүлж өгөв.

Өнөөдрийн түвшингээс тэр үеийн нүдэнд харагддаг үзэгдлүүдийг бодоход нөмрөг ба малгай нь покерын ширээний ард өөрийгөө хянах, зарчмыг хөгжүүлэх хэрэгтэйг сануулсан анхааруулга гэдэгт итгэдэг. Төсөөлөөд үз дээ. Хувраг хүн хэрхэн сүсэг бишрэлдээ ханддаг шиг покерчин тоглоомдоо түүнтэй ижил хандах ёстой гэдгийг мэдэв. Зарчим ба өөрийгөө хянах чадвар нь хожиж буй тоглогчдын үндсэн хүчин зүйл бөгөөд өнөөг хүртэл би заримдаа тэр хүчин зүйлүүд дээр сандран алдсаар байгаа.

•••

Энэ бол мөрөөдөл биш дахин дахин учрах хар дарсан зүүд болов. Лас Вегаст очиж тоглоод хамаг мөнгөө алдчихаад эргээд Мэдисонд ирж дараагийн аялалд хүрэлцэхүйц мөнгө хийсний дараа дахин Лас Вегас явж бүгдийг алдана. Энэ тойрог үргэлжилсээр байлаа. Гэвч энэ үйл явц маань эцэстээ зорилготой болж эхэлсэн юм.

•••

Анхны удаа Лас Вегас явснаас хойш зургаан сарын дараа хоёр дахь явдал нь бодит амьдрал дээр тохиолдсон. Тэр үед нэлээд их хэмжээгээр алдсандаа сэтгэл санаагаар ихэд унав. Заримдаа би үнэхээр мэргэжлийн покерчин болох гээд байгаа минь зөв үү гэдэгтээ өөрөө ч гайхаж эхлэв. Мэдисонд ирснийхээ дараа хоёр найзтайгаа хамт покер тоглохоор явлаа. Бидний очсон тоглоом Лас Вегасын тоглоомыг бодвол түүний хажууд өчүүхэн мэт санагдсан ч тэнд тоглож мөнгөө өсгөх хэрэгтэй байлаа. Тэгээд өөртөө зэмлэнгүй хандаж, Лас Вегасын өндөр бооцоотой тоглоомын хажууд энэ өчүүхэн уйтгартай 3-6 долларын тоглолт хийх байх ч гэж дээ хэмээн өөртөө гутарч билээ. Тэгтэл нэг найз маань ерөөсөө гарья, харин хажуугийн

уушийн газарт орж биллiard тоглоё гэсэн санал гаргасан. Тэр үед өглөөний 11 цаг болж байлаа. Хаврын эхэн сар байсан болохоор цас гүйцэд хайлаагүй байсан. Тэгээд ч би тэр үед покерт тэгтлээ их татагдаагүй байсан болохоор тэднийг дагаж явахаар болов.

Уушийн газарт ортол гүн усанд шумбасан мэт харанхуйгаас гадна бохир нь ширээн дээр бөөгнөрсөн байлаа. Тэнд байсан хэсэг хүмүүс хямд шар айраг, виски, өөр бусад согтууруулах ундаандаа нэлээд хөлчүүрхсэн байдалтай байв. Манай найзууд булангийн хоосон ширээн дээр сууж, шар айраг захиалан тамхи баагуулцгааж, хэнд ч хэрэггүй өнгөрсөн баларсан түүх ярьцгааж, инээлдэн хөгжилдөцгөөлөө. Бас бооцоотойгоор биллiard тоглож эхэлсэн.

Би хэсэг зогсч байснаа гэнэт тэр уушийн газраас аль болох түргэн гармаар санагдав. Тэнд байхдаа "Би энд юу хийж байгаа юм бэ? Би тамхи татдаггүй, архи нэг их уудаггүй, уушийн газарт орох тийм ч дуртай биш байж өдрийн цагаар архи ууж энд сууж байх ч гэж дээ. Энэ бол надад зориулагдсан газар биш. Миний байх газар, явах зам биш байна" хэмээн өөрөө өөрөөсөө асууж байснаа санаж байна. Энэ нь надад нүүр руу минь хувин дүүрэн хүйтэн ус гэнэт цацах шиг санагдсан. Ингээд хойд хаалга руу алхаж очоод хаалгыг бүрэн нээтэл зайрмагтсан мөс болон хайлж буй цасан дээр нарны гэрэл маш хурцаар ойн тусч нүд гялбаад орчин тойрон огт харагдахгүй байлаа. Сүүлд бодоход энэ бүхэн бараг л үхлийн өмнөх байдал мэт сэтгэгдэл төрүүлэв. Тэр үед надад амьдрал үхлийн зааг дээр байгаа мэт мэдрэмж төрсөн билээ. Тэрхүү гэнэтийн хачин санаа бодлоос үүдээд тэндээс хурдхан шиг явмаар санагдсан. Би өөрөө машин барьж чадахгүй учир найзуудаасаа уучлал хүсч такси барьж харьсан.

Гэртээ ирүүтээ шууд ширээ рүүгээ очин дэвтэр гаргаж ирээд "ОК. Тэгэхээр чи үнэхээр покер тоглон амьдрах гэж байгаа бол чи хамгийн шилдэг нь болох ёстой" гээд үүний тулд амьдралдаа хэрэгжүүлэх зорилгоо тодорхойлон, дараалуулан жагсааж бичсэн юм.

1. Покерын дэлхийн цуврал тэмцээнд түрүүлэх.
2. Гайхамшигтай бүсгүйтэй танилцаж гэрлэх.
3. Нью Йорк таймсын шилдэг ном бичих.
4. Том сайхан байшинтай болох.
5. Тансаг машин авах.
6. Покерын томоохон тэмцээнүүдэд түрүүлэх гэсэн жагсаалтыг гаргаж билээ.

Тэр үед хэдийгээр жаахан хүүхэд байсан боловч тэр цагаас эхлэн өөрийн гэсэн зорилготой болж түүнийхээ төлөө зүтгэнэ гэдэгтээ итгэлтэй байсан. Хэдэн жил үргэлжилсэн ч хамаагүй, ямар ч байсан энэ зорилгоо биелүүлнэ хэмээн хатуу зорилго өөртөө тавьсан юм. Харин энэхүү галзуу гэмээр мөрөөдөлдөө хэзээ нэгэн цагт хүрнэ гэж бодож байсан боловч хэзээ гэдгийг нь мэдэхгүй байсан. Гэвч 25 насныхаа төрсөн өдрөөс өмнө энэ бүгдийг амжуулсан байлаа.

Арав дахь удаагаа Вегас руу явахдаа анх удаа "хожил" гэсэн баганад бичилт хийв. Тэр

хожилдоо баярлахынхаа оронд ихэд гайхсан юм. Урьд өмнө нь дандаа хожигддог байсан учир гэнэт хожиход надад энэ бүхэн цоо шинэ мэт санагдаж бас айж балмагдахад хүрэв. Тэгээд ээж рүүгээ утсаар ярьж "Та гэнэтийн цочролд орсон үедээ яадаг вэ?" хэмээн асуухад тэрээр "Энэ бол чиний ялалт. Ялалт амжилтыг хүлээн авна гэдэг бас тийм ч амаргүй" гэж хэлсэн. Би ч энэ тухай өмнө нь хэзээ ч бодож байгаагүй байсан. Ээж бид хоёр үргэлж дотоод сэтгэлээ хуваалцдаг байсан төдийгүй тэрээр миний билэг оюуныг үргэлж дэмжин тэтгэдэг байсан. Нэлээд олон удаа Вегаст хожсоны дараагаар арай тайвшрах хэмжээнд хүртлээ дансаа нэмэгдүүлсний эцэст тэндээс явсан юм.

•••

Нэлээн олон тохиолдолд покер тоглож олсон ашгаа казиногоос гарахаасаа өмнө алдаж байсан. Шоо бол надад маш аюултай байсан. Покер тоглогчдын дунд байдаг нэгэн хэллэг бол "гоожуулах" юм. Энэ нь покер тоглож олсон мөнгөө тэр тоглогч хожихгүй гэдгээ өөрөө мэдсээр байж өөр тоглоомд очиж бүгдийг нь алдахыг хэлнэ.

•••

Бас нэгэн асуудал нь покер тоглоод хожсон мөнгөө өөр бусад тоглоом ялангуяа шоонд алддаг байлаа. Нэлээд олон тохиолдолд Холдем покер тоглон олсон ашгаа казиногоос гарахаасаа өмнө "бакараг" болон "шоо"-нд алдаж байсан. Хөөе гэхийн завдалгүй л мөнгөө алдаж байсан даа. Шоо бол надад маш аюултай. Покер тоглогчдын дунд байдаг нэгэн хэллэг бол "гоожуулах" юм. Энэ нь покер тоглож олсон мөнгөө тэр тоглогч хожихгүй гэдгээ өөрөө мэдсээр байж өөр тоглоомд очиж бүгдийг нь алдахыг хэлнэ. "Тэнэгүүдийн" тоглодог шоо нь миний нэлээд зовж байж олсон мөнгийг мөн ч олон удаа гоожуулсан даа.

Би нэг удаа их мөнгө хожсон залуусын түгээмэл алдааны хохирогч болов. Тэд их мөнгө хожсоны дараа маш олон боломжоор оролдоно, хамаагүй тоглоно, огт хэрэггүй мөрий тавина, мөнгөний удирдлагаа алдана. Энэ бүхнийг ер хайхрахаа больдог юм. Энэ бүхнийг ухаарч, гоожуулахыг зогсоох талаар зөв арга хэмжээг авч чадсаны дүнд тэр аюулаас аврагдсан. Энэ бүхний эцэст шооны ширээ харуут бөөлжис хүрэм сэтгэгдэл төрдөг болсон доо. Би ямар ч амтгүй хожлын хойноос тэтгэлээ их хөөцөлдөхөө больсноор маш их өөрчлөлтийг хийж чадсан юм. Сүүлдээ иймэрхүү байдлыг бүрэн ухаарч казиногийн бусад тоглоомуудаас татгалзав. Бүр шооны ширээг харуутаа л бараг харшилтай мэт санагддаг болов. Энэ бүхнийг зогсоож чадсан нь үнэхээр сэтгэл хөдөлгөм зүйл болсныг өнөөдөр харахад харин бахархмаар.

Амжилттай сайн тоглогч болоход зөвхөн шоо л саад болоод байсан юм биш ээ. Оюунлаг хүрээлэлд хүндлэгдсэн аавын маань надтай харилцах харилцаа бас нэг томоохон асуудал байлаа. Аав маань намайг сургуулиа орхин мөрийтэй тоглож эхлэхэд ихэд дургүйцэн хүлээж авсан юм. Тэр үед тэрбээр үнэхээр урам нь хугарч гонсойсон байж билээ. Миний ирээдүйн бүх нөхцөл байдал огт тодорхойгүй болж байгааг надад тэр ойлгуулахыг хичээж байлаа. Боловсролыг чухалчилдаг тэрбээр намайг сургуульд сурч бага дүү нартаа үлгэр дууриал болох ёстой гэж хүсдэг байсан.

Энэ зөрөлдөөнөөс өөр үед бол аав минь тийм ч муу хүн биш, маш тайван амгалан хүн байв.

Миний сонгосон сонголтоос болж бид хоёрын хоорондын харилцаанд гарсан асар том зөрчилдөөн маань сүүлдээ манай гэр бүлийнхнийг бүхэлд нь хамарч бусад харилцаанд ч сөргөөр нөлөөлөв. Би тэрхүү үл ойлголцлыг хэрхэн даван туулах талаар суралцаж эхэлсэн дээ. Аль болохоор хамгийн нааштайгаар шийдэхийг зорих болов. Би тэр үед гэрийнхнээсээ тусдаа байранд амьдардаг байлаа. Үе үе оройн хоол хамтдаа идэхээр гэртээ цуглана. Тэр үед аав миний тухай яриа өрнүүлж, покер тоглох болсонд маань эмзэглэж байгаагаа илэрхийлж, эрүүний шөл уулгаж эхлүүт би гараад явчихдаг байлаа. Тэгж гарч явахдаа "За яахав. Би явлаа. Хэрэв та надтай покер тоглох болсон талаар маргах гэж байгаа бол би явлаа. Тэгээд сар ирэхгүй" гээд байнга гардаг. Сар гаруйн хугацаа өнгөрөөд дахин орж ирэхэд дахиад л ийм яриа өрнөнө. Ийм явдал байнга гардаг байлаа. Бараг хоёр жил гаруй үргэлжлэв. Ер Томоохон тэмцээнүүдэд оролцож их хэмжээний мөнгө хождог болох хүртэл үргэлжилсэн дээ.

1988 оны наймдугаар сард Лос Анжелест Дугуйн клуб казинод болсон тэмцээнд би маш сайн тоглосны дараа аав миний покерын мэргэжлийн тухай бодлоо арай зөөллөсөн юм. Намайг хэрхэн төвлөрч тоглож байгааг, бас өсч сайжирч мэргэжлийн тоглогч болж буйг тэрбээр харсан нь их чухал үйл явдал болов. Хамгийн гол нь тэр бүх боломжийг аав маань олж харж эхэлсэн юм. Түүний дараахан 1988 оны Диамонд Жим Брадийн тэмцээнд Эрик Сайделийн дараа хоёрдугаар байрт орж 68 мянган доллар хожиж билээ. Маргааш өдөр нь үндсэн тэмцээнд оролцож түрүүлэн, 145 мянган доллар хожив. Тэр тэмцээний шувтаргын ширээнд дэлхийн шилдэг гурван тоглогч болох Жонни Чан, Жак Кэллэр, Т.Ж.Клаутэр нарыг буулган авч түрүүлсэн дээ. Их хэмжээний мөнгө халаасалсан тул тэндээс туйлын баяр баясгалантайгаар гарсан даа.

•••

Би аавыг аяллаар авч явахыг хүсч түүнээс та хаашаа аялмаар байна хэмээн асуусан юм. Би дотроо бодохдоо Австрали, Шинэ Зеланд, эсвэл хаа нэгтээ урьд өмнө нь очно гэж мөрөөддөг байсан газар руугаа явах байх гэж бодсон. Гэтэл түүний хариулт маш гэнэтийн бүр гайхмаар бас бодол болохоор хариулт байлаа.

•••

Гэнэт мөнгөтэй болсон болохоор өөртөө эд зүйлс худалдан авах боломжтой болов. Юуны түрүүнд түүнийгээ гэр бүлийнхэнтэйгээ хуваалцахаар шийдэв. Үүний тулд ээжийн хэлснийг тод санаж байна. Тэрээр гүн ухаан судалдаг, маш их алсын хараатай, дэвшилтэт үзэлтэй хүн байлаа. Саглагар олон мөчиртэй, гүн үндэстэй, хүчирхэг том мод шиг гэж намайг харснаа ээж минь нэгэн удаа хэлж билээ. Модны салаа мөчир бүхэн нь гэр бүлийн гишүүддээ тусалж дэмжин, тэдэндээ нөмөр болж тэднийг хамгаална гэж тэр хэлэв. Би тэр бодлыг нь үнэхээр гайхсан төдийгүй тэрээр надад маш аугаа хариуцлагыг оногдуулсныг тэгэхэд л мэдэрсэн дээ.

Тэгээд нэг эрэгтэй дүү, бас нэг эмэгтэй дүү хоёртоо хоёуланд нь тус бүр 10 мянган долларыг хуулийн сургуулиа төгсөхөд нь зориулж өгсөн. Өөр нэг эмэгтэй дүүгээ коллежээ төгстөл нь санхүүгээр дэмжив. Хэдэн дүүгээ дагуулан амралт, зугаалгаар явав. Ээжийгээ дагуулан Флорида Кийс орж далайн гахайтай хамт сэлж, бас Бөө мөргөлийн талаар судлахад нь санхүүгийн талаар дэмжив. Би аавыг аяллаар авч явахыг хүсч түүнээс та хаашаа аялмаар байна вэ хэмээн асуусан. Би дотроо бодохдоо Австрали, Шинэ Зеланд, эсвэл хаа нэгтээ урьд

өмнө нь очно гэж мөрөөддөг газар руугаа явах байх гэж бодсон. Гэтэл түүний хариулт маш гэнэтийн харин ч эргэлзмээр хариулт байсан. Тэрбээр "Би чамайг 1989 оны Покерын дэлхийн цуврал тэмцээнд оролцохыг хармаар байна" гэж хэлсэн юм. Би тэр хариултад огт бэлтгэлгүй байсан учир юу гэж хэлэхээ мэдэхгүй хэсэг хугацаанд балмагдав. Ер нь би гэр бүлийнхнийгээ харж байхад нь сайн тоглоно гэж боддог байсан ч намайг тэгтлээ хориглож миний мэргэжлийг үгүйсгэж байсан хүн ийм санал гаргана хэмээн хэзээ ч бодож байсангүй. Тэгээд бараг минут гаруй хугацаанд "Аав юу гээд асуучихваа" хэмээн бодов. Мэдээж би аавыг тэнд байхыг хүссэн боловч эхлээд хэд хэдэн асуудлаар зөв ойлголттой болохыг хүсэв. Тэгээд түүнд "Хэрэв надтай хамт Покерын дэлхийн цуврал тэмцээнд очвол уйтгартай байна шүү дээ" гэж хэлэхэд тэр мөрөө хавчин "Хамаагүй ээ" гэв. "Тэмцээнд ороход маш олон цагаар тоглодог болохоор тантай хамт цагийг өнгөрөөх зав гарахгүй" гэхэд тэрбээр "Зүгээр ээ, хамт явна" гэж билээ. "Бүх л тэмцээний туршид та миний хараанаас бүр хол гадуур байх болно шүү дээ" гэхэд тэр надтай хамт явахыг хүссэн хэвээрээ байсан. Эцэст нь би түүнд хандаж "Та энэ тухай сайн бодож бай. Тэгээд эргээд хоёулаа ярилцъя" гэв.

Найман долоо хоногийн дараа тэрбээр өөрийнхөө санаагаа дэмжин эрхийгээ гозойлгосон хэвээр байв. Тэгэхээр нь Зул сарын баяраар ирнэ, тэр үед ярилцъя гэв. Тэрбээр явна гэсэн бодолтой хэвээрээ л байлаа. Би түүний хариултыг таамаглаж байсан. Бас түүнд өгөх хариултаа ч бэлдсэн байлаа. Тэгээд би түүнд "Хэрэв би хожвол танд шинэ машин худалдан авч өгнө" гэв. Мэдээж тэр тэмцээнд би түрүүлсэн. Гол нь аавынхаа дэргэд түрүүлсэндээ маш их бахархдаг.

Үнэндээ сүүлчийн тоглолтод хожсон тэр үе бол миний амьдралын хамгийн дурсамжтай мөчүүдийн нэг байсан. Гараа дээш өргөн баярлах тэр мөчдөө өрөөг тэр чигээр нь нилэнхүйд нь харж, аавыгаа хайлаа. Гэнэт түүнийг олж харахад тэрбээр бужигнасан олны хүмүүс дундаас над руу тэмүүлэн зүтгэж байлаа. Хамгаалалтын албаныхан түүнийг саатуулсан. Учир нь тэрхүү ширээн дээр сая доллар байсан юм. Нэлээд удсаны эцэст түүнийг даллан дуудсаар оруулж ирээд гараа алдлан тэвэрч авахад аав намайг үнэн зүрхнээсээ чанга тэвэрч билээ. Тэр нь яг л "Хүү минь би чиний тухай буруу бодож байжээ. Энэ покер гэдэг чинь их дажгүй юм байна. Бас чи ч үүндээ гарамгай сайн юм байна" гэж хэлэх шиг л санагдсан. Тэмцээний дараа би хэвлэлийнхэнд ярилцлага өгөхдөө "Миний аав бол үнэхээр бахархмаар хүн" гэж хэлэв. Аав ч бас олон ярилцлага өгсөн байх.



Чау Гианг

Тэр тэмцээнд түрүүлсний дараа бусад асуудалд арай тайван хандах болов. Өөрийнхөө амьдралын хэвшлийг тайван болгох талаар бодож эхлэв. Би ер нь тэр тэмцээнд орж түрүүлнэ гэсэн бодолдоо маш их төвлөрсөн байснаа сүүлд ойлгосон юм. Тэгээд дараа нь одоо амьдралынхаа асуудалд анхаарах цаг болжээ гэж бодоод өөртөө машин, байшин худалдан авсан юм.

Миний нэг гол зорилго бол шинэ Кадиллак авах явдал байлаа. Түүнийгээ ч авсан. Тэр үед Висконсины их сургуулийн оюутнуудын байранд амьдардаг хэвээр байсан юм. Тэр бол үнэхээр дажгүй, гайхамшигтай газар байсан ч миний хувьд тэр байшингийнхаа бараг нэг ч хүнийг таньдаггүй байлаа. Хэдэн долоо хоногийн дараа шөнөжингөө тоглож байгаад гэртээ харьж явтал нэгэн маш үзэсгэлэнтэй бүсгүй байшингийн буланд харагдав. Гайхамшигтай. Тэр

бүсгүйг хараад үнэхээр сонин байдалд оров. Тэрээр хувцасны хоосон сав гартаа барьж явлаа. Мэдээж тэрээр дөнгөж угаалгын өрөөнөөс гараад явж байжээ. Бид өөд өөдөөсөө алхсаар харц тулгарав. Би хажуугаар нь зөрөхдөө "Сайн уу" гэж хэлсэн нь миний хийж чадах зүйл байлаа. Тэрээр инээмсэглэн мэндлээд цааш явж одов.

Би түүнийг заавал эргэж ирж хувцсаа авна гэдгийг мэдэж байлаа. Манай байр угаалгын газрын яг эсрэг талд байх бөгөөд би өөрийнхөө байр руу гүйж ороод нүүр гараа бас шүдээ угааж, үсээ самналаа. Мөн бага зэрэг сүрчиг цацан тэр хавиар гүйж байхдаа өрөөндөө цоожпогдов. Тэгээд өөрийн дүү Молли руугаа утасдаж түүнд байгаа илүү түлхүүрээр намайг гаднаас онгойлго хэмээн гуйв. Би хүлээсээр, хүлээсээр байлаа. Моллиг ирэхэд нь би түүнд юу болсноо хэлэв. Тэгээд "Хэрэв би тэр охинтой гэрлэвэл бүр гайхамшигтай явдал болно" гэж нэмж өгүүлсэн юм.

Би ёстой хэдэн цаг хүлээх шиг болсон доо. Тэр хавиар сууж түүнийг хүлээж байлаа. Эцэст нь тэр ирлээ. Би их сандарч байсан ч түүнтэй яриа өрнүүлэхээр шийдэв. Харин тэр их найрсаг учир бид нэлээн хугацаанд ярилцсан юм. Түүний нэрийг Кэти гэдгийг мэдэв. Эцэст нь би тээнэгэлзэж байсан ч зориглон хамт гадагш гарах уу хэмээн асуулаа. Тэр өдөр мягмар гараг байлаа. Би түүнээс орой уулзахыг хүсэв. Тэрээр "Би завгүй" гэлээ. Тэгэхээр нь "Тэгвэл маргааш орой" гэтэл "Уучлаарай, бас л завгүй" гэсэн. "Пүрэв гарагт болох уу?" гээд би санаа зовж эхлэв. Тэрээр "Үгүй" гэхэд нь урам хугарч түүнийг сонирхолгүй байна хэмээн бодов. Долоо хоногийн дундуур орой болгон яахаараа завгүй байдаг байна аа? гэж бас бодов. Тэгээд танилцсандаа таатай байна гэж түүнд хэлээд ичгүүртэй байдлаас хурдхан салж, зугтахыг бодож эргэтэл "Би Баасан гарагт завгай" гэж хэлэхийг нь сонсч билээ.

•••

Өнөөдрийн өнцгөөс покероор явсан замналаа эргэн харж байхад шооны тоглоом бас аавтай харьцах харилцаа хоёр мэргэжлийн хувьд амжилт гаргахад маш том саад болж байлаа. Гэвч би тэр хоёрыг даван туулж шийдвэрлэж чадсан юм. Гэсэн хэдий ч бас нэг сүүлчийн "буг чөтгөрийг" эзлэн авах хэрэгтэй байсан байлаа.

•••

Бүх зүйлс эхнээсээ л бүтэлгүй болж магадгүй шинжтэй байв. Би Кэтиг хүлээж байгаад машиндаа суулган явахад тэрээр маш их гайхсан янзтай харж байлаа. Түүнийг би тэр дороо л гадарлав. Тэрээр намайг "24 настай, оюутны байранд амьдардаг мөртлөө ийм машин унадаг" гэж дотроо бодож байгааг нь би тааварлаж байв. Тэгээд түүнд өөрийгөө покер тоглогч, өдрийн цагаар тоглодог хэмээн хэлтэл тэрээр бараг бидний ойлголцол эхлэхээс өмнө харилцаагаа дуусгах дөхсөн юм. Тэгээд түүнийг харахад мөн л "Энэ залуу хар тамхи хэрэглэдэг байж магадгүй, өдөр болгон, шөнө болгон гардаг, тэгээд үд хүртэл унтдаг ..." зэрэг олон асуудлыг эргэцүүлэн бодож суугаа харагдав.

Гэвч бүх юм өөрөөр эргэж Кэти миний эхнэр болсноор би бас нэгэн зорилгоо биелүүлж чадсан юм. Бид одоог хүртэл жаргалтайгаар хамтдаа амьдарсан хэвээрээ байгаа.

Өнөөдрийн өнцгөөс покер тоглож явсан замналаа эргэн харж байхад шооны тоглоом бас

аавгай харьцах харилцаа хоёр мэргэжлийн хувьд амжилт гаргахад маш том саад болж байлаа. Гэвч би тэр хоёрыг даван туулж шийдвэрлэж чадсан юм. Гэсэн хэдий ч бас нэг сүүлчийн "бүт чөтгөрийг" эзлэн авах хэрэгтэй байлаа.

Тэр бол өөрийгөө хянах чадварын дутагдал.

Надад өөрийгөө хянах чадвар дутуу байдаг гэдгийг сонсоод та бүхэн гайхаж байж магадгүй. Бүх зүйл харагдаж байгаа шигээ байдаггүй. Та бүхэн намайг "Покер Брат" таних тэмдэгтэй, сэтгэл хөдлөлөө далдалсан, харьцангуй яриасаг, голдуу л хамаг зүйлийг хамаад явдаг хүн гэж боддог байх. Гэвч байдал эсрэгээрээ эргэвэл бас ч тийм байдаггүйг хүн болгон мэдэхгүй. Хэрэв хэн нэгэн миний эсрэг тоглохдоо гартаа муу модтой мөртлөө намайг хожих юм бол би түүнийг хувийн шинж чанартай нь холбож авч үздэг. Миний бодлоор муухан хожлоо гэж хүмүүс хэзээ ч боддоггүй харин би ялалт байгууллаа гэж бодоцгоодог. Өөрийн өрсөлдөөнт байдлаа хадгалах тусам үр дүн нь үргэлж сайнаар эргэдэггүйг би мэдэрсэн юм.

Яагаад өөрийгөө хянах чадвар муу гэж? Эргээд харахад маш олон хүчин зүйлс нөлөөлсөн байдаг. Оюутан байхдаа миний дүн үргэлж л тааруухан байдаг байсан учир сургуулийн декан аавын хувьд толгойгоо дээш өргөн явахад хүндхэн байсан болов уу. Харин манай дүү нар сайн сурлагатай хүүхдүүд байсан. Миний дүнд аав маш сэтгэл дурамжхан байдгийг би мэднэ. Тэгээд түүнээс болоод би ямар ч нэр хүндгүй юм байна гэсэн сэтгэгдэл төрдөг байв. Ахлах сургууль болон коллежид байхад олон найз нөхөд байгаагүй юм. Би ямар доогуур зэрэглэлтэй байсан гээч. Нүүрээрээ дүүрэн батгатай байсан болохоор байгаа дүрээрээ бүтэлгүй хүний төрхийг илтгэж байсан юм. Иймээс өөртөө итгэх итгэл арваад жил маш доогуур байсан. Тэгэхэд л миний сэтгэл хөдлөлийн тэсрэлт "Покер Брат" нэртэй покер тоглогчийг төрүүлэхэд хүргэсэн төдийгүй өөрийгөө батлан харуулах гэж оролдох болсон юм.

Би "Покер Брат" зан байдлаараа бахархан тоглохыг хүсдэггүй. Би өөрийн хувь хүний сүүдрийн дор байдаг. Сэтгэл хөдлөлийн тэсрэлтээ зурагтаар гарахад гоё байдаг ч тэр миний тоглолтыг сайжруулдаггүй бас хөгжөөн дэмжигчдийг надад татагдах шалтгаан ч болдоггүй. Би хүрэн орхимжтой лам хүний дүрийг төсөөлж өөрийгөө түүн шиг боллоо хэмээн боддог. Тэр мөчид сэтгэл хөдлөлийн тэсрэлтээ багасган хяналтдаа байлгах боломжтой болдог. Үнэндээ би "Покер Брат" покерын ширээнээс гадуур хаа ч ил үзэгддэггүй хүн. Найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ хамт байхад түүний тухай ер боддоггүй.

Одоо эргээд харахад покерчны амьдрал надад сайн нөлөө үзүүлж байсан. Миний эхлэн суралцагчаас мэргэжлийн түвшинд хүрсэн покер аялал богинохон хугацаанд болж өнгөрч би хувийн олон муу зуршлаасаа салж билээ. Ер нь би коллежид покер тоглож эхэлснээс хойш 1989 онд Покерын дэлхийн цуврал тэмцээний аварга болтлоо дөрвөн жил л зарцуулсан. Харин зарим шилдэг тоглогчдод одоог хүртэл тэр муу зуршлууд нь дагалдан явсаар байдаг. Өнөөдөр би аз жаргалтай гэр бүлтэй, бие эрүүл, өөрийн сонгосон мэргэжилдээ дуртай. Ийм амьдралаас минь нэмж асуух зүйл хүмүүст байна гэж үү?

Покерыг мэргэжлийн замнал болгох гэж байгаа хэн нэгэнд та юу гэж зөвлөх вэ? гэсэн асуултад ямар хүн асууж байгаагаас шалтгаална. Хэрэв миний хүүхдүүдийн нэг мэргэжлийн покерчин болохоор шийдээд надаас асуусан бол би түүнд "Энэ бол хялбар амьдрах зам биш, үүний тулд зарчим, зөв оюун санааны хандлага хэрэгтэй" гэнэ. Хамгийн чухал нь

мэргэжлийн покерчин аль ч юмнаас хүчтэй барьж авч зуурч чаддаг байх ёстой гэдэгт итгэдэг. Тэд зайлшгүй амжилтын төлөө тэмүүлж, суралцахын төлөө зүтгэж, тэр бүхний төлөө шургуу ажилладаг байх хэрэгтэй. Мөн покерыг эзэмдэхийг хүссэн хүсэл эрмэлзэл, хичээл зүтгэлтэй байх шаардлагатай. Өгсч уруудах олон тохиолдол гарна. Тэр бүгдийг давж гарах чадварыг бас эзэмших хэрэгтэй.

Мөнгөний сайн удирдлага бас чухал. Түүнгүйгээр покерт амжилт гаргана гэж үгүй. Энэ нь тоглолтын стратеги шиг чухал. Хэрэв покер тоглогч мөнгөний удирдлагын талаар хангалттай чадвар эзэмшээгүй л бол өөрийн цуглуулсан хуримтлалаа амархан алдана. Тухайн тоглолтод тоглох хугацаа нь ч багасдаг. Бүх покер покерчид хир зэрэг сайн нь хамаагүй, тэд бүгдээрээ дараалан алдагдалд орж байсан. Би хэд хэдэн сайн тоглогчдыг мөнгөний буруу удирдлагаасаа болж хамаг байдгаа алдаж архи, хар тамхинд орсныг мэднэ. Шилдэг покерчин болохын тулд мөнгөө сайн удирдаж сурах хэрэгтэй. Хар тамхи, архи, өөр бусад муу зуршлаас хол байх нь чухал. Тэдгээр нь тоглоомд төдийгүй биеийн эрүүл мэндэд эсрэгээр нөлөөлдөг. Би бусад покерчдод ёс зүйтэй, шударга байхыг эрхэмлэх хэрэгтэй гэж сануулдаг. Покерчид маш сайн ой санамжтай байдаг. Хэрэв тэд хэн нэгнийг ямар нэг муу зүйлд холбогдож байхыг харвал түүнийг нь насан туршдаа санах болно.


Төгсгөлд нь, покер тоглохыг хүсч буй хэн нэгэн покерыг үнэхээр мэргэжил болгохоор зорьсон бол эсрэг тоглогчдоо унших чадвараа, тухайлбал, биеийн хөдөлгөөнөөрөө илэрхийлэх хэл яриа, нүүрний хувирал зэргийг ойлгож унших чадвараа дээд зэргээр хөгжүүлэх хэрэгтэй. Чухамдаа энэ чадвар аваргын тэмцээнийг бусад тоглолтоос ялгаж салгах хамгийн чухал ганц зүйл чинь болж мэднэ. Хэрэв чи хүн уншихдаа сайн бол их мөнгө хожих болно. Хэрэв чадахгүй бол мөнгө хожихгүй. Ийм л энгийн зүйл. Чиний тоондоо хир сайн чинь ямар ч хамаагүй, харин заавал чамд хүн унших чадвар байх ёстой.

Сүүлд нь дүгнэж хэлэхэд, покер нь өөрсдийгөө болон эсрэг тоглогчдоо илрүүлэх тоглоом юм. Өөрөөр хэлбэл, өөрсдийгөө болон эсрэг тоглогчдынхоо илэрхийллийг харуулсан тоглоом билээ. Бидний найдвар, айдас, саад бэрхшээлийг хэрхэн давж, амжилтад хэрхэн хүрч байгаагийн илэрхийлэл болж байдаг. Хэн нэгэн надаас та покерчны хувьд хэрхэн дуурсагдахыг хүсч байна вэ? хэмээн асуувал ёс зүйтэй, шударга, тоглоомд хэзээ ч хуурч мэхэлж байгаагүй, ширүүн өрсөлдөгч, хэзээ ч бууж өгдөггүй, байгаа бүх зүйлээ ширээн дээр гаргаж тавьдаг хүн гэж дурсагдах болов уу. Магадгүй хамгийн шилдэг покерчин байсан гэж хэлэгдэх байх.

Түүний тухай мэдээллийг PhilHellmuth.com гэсэн сайт руу орж авч болно. Түүнтэй UltimateBet.net сайтаар орж тоглож болно. Мөн www.pokerbrat.com сайт руу орж түүний хувцасны компанитай худалдаа хийж болно. Түүнд төрөл бүрийн хувцас, малгай, ном, DVD, покерын тухай олон материал бий.

Түүний бичсэн "Покерыг мэргэжлийн түвшинд тоглоцгооё" ('Play Poker Like the Pros') ном нь Нью Йорк таймс сэтгүүлийн шилдэг номоор шалгарч байжээ. Мөн түүний гар утасны тоглоом Фил Хэлмут Техас Холдем тоглоом нь АНУ-д нэг сая гаруй хэрэглэгчидтэй аж. Фил Хэлмутын "Цагаан бүснээс хар бүс хүртэл" нэртэй дөрвөн цагийн курс хичээл нь iAmplify.com-д бий. Түүний намтар "Покер Брат" нэртэйгээр 2010 оны тавдугаар сард гарсан юм.

Амь үрэгдсэн хууль сахиулах байгууллагын ажилтнуудын ТАСЕР нийгэмлэгийн (www.taserfoundation.org) удирдах зөвлөлийн гишүүн тэрбээр энэ байгууллагыг санхүүжүүлэн дэмждэг. Ашгийн төлөө бус уг байгууллага нь АНУ, Канадын муж улс, орон нутагт ажил үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдсэн ажилтнуудын ар гэрийнхэнд дэмжлэг үзүүлдэг байгууллага юм.



Энни Дюк

Тэрбээр Покерын дэлхийн цуврал тоглолтын гурван ч бугуйвчийн эзэн бөгөөд бооцоо өндөртэй покерын хувьд Фил Хэлмут, Фил Айви, Даниел Нигрэну нарын адил алдаршаагүй ч гэсэн удаан хугацаанд бэлэн мөнгөний бооцоо тавьж тоглодог байсан явдал нь түүнд дээрхтэй ижил алдар нэр бүхий хамтрагч нар, ялангуяа покерын ертөнцийн алдартангуудын нэгэн адил ихээхэн хүндлэлийг авчирсан байна.

Гианг нь шүтэн бишрэгчдийн дунд харьцангуй танил бус бөгөөд энэ байдал нь тэмцээнд байнга оролцож байдаг ч оддын хэмжээнд дөхөх нэгэн хандлагаар тайлбарлагдана. Тэмцээнээс тэмцээн рүү аялан тоглосноос онлайнгаар тоглох, мөн Беллажио казиногийн "Big Game"-д тоглохыг тэр илүүд үздэг аж. Гэр бүлсэг хүн болохоор гэртээ аль ойрхон тэмцээнүүдэд оролцдог болохоор Лас Вегаст түүнтэй хамт амьдардаг эхнэр, хүүхдүүдтэйгээ ойр байж чаддаг байна.

Покероос бусад үед тэрбээр даруухан, зөөлөн сэтгэлтэй нэгэн бөгөөд хүүхдүүдийнхээ тухай ярих дуртай. Мөнгөөр покер тоглож эхлэнгүүт тэрбээр дараалан хождог ба түүний хожсон тоо нь одод тэнгэрийн түвшинд хүрсэн ч казинод тоглохдоо олон хүний сэтгэлийг гонсойлгосон алдагдагдалд орж байжээ. Тэр бол үнэхээр амьд үлдэхийн төлөө тэмцсэн, Вьетнамаас АНУ-д цагаачлан ирж оргүй хоосноос баян болсон үнэн түүхийн эзэн юм.

Дайн хоёр жил гаруй үргэлжилсэн агаад коммунистууд зорилгодоо хүрч Сайгоны дэглэмийг нурааж байсан үе. Би 1977 онд Америк руу явах гэж байсан завинд нууцаар суухаар зэхэж байлаа. Завинд суусныхаа дараа Вьетнам эх орноо эргэж нэгэнтээ зэрвэсхэн харсан бөгөөд энэ нь эцсийн удаа гэж найдаж байсан. Нэлээд хугацаа зарцуулан байж завинд суух 7 унци алт цуглуулсан ч гэлээ яг одоо бол би бүрхэг харанхуй нэгэн аялалд бэлэн болсон байлаа. (хүмүүс зөвшөөрөлгүйгээр Вьетнамаас гарах эрхгүй байв, дээр нь зөвшөөрөл хэзээ ч олгогддоггүй байлаа, АНУ руу бол бүр ч ярилтгүй).

•••

Би эх орноосоо одоо л чөлөөтэй боллоо хэмээн бодсон яг тэр агшинд Хойд Вьетнамын эрх баригчид ирэхийг харлаа. Тэр өдөртөө АНУ руу онгоц яваагүй бөгөөд хууль бусаар эх орноо орхихыг оролдсон гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө би дараагийн 5 сарыг Вьетнамын шоронд өнгөрөөх учиртай байв.

•••

АНУ-д байдаг найз маань тэнд байгаа хүмүүст олгогдсон эрх чөлөө, нэр хүнд, эрх дархын талаар ярьсан юм. Хэдийгээр энэ нь бараг мөнгөгүй шахам ганцаархнаа аялалд гарна гэсэн үг байсан ч гэсэн би үүнийг үнэхээр хүсч байлаа. Хэрэв үнэхээр сайн ажиллаж чадвал би өөрөө Америк мөрөөдлөөр амьдарч чадна гэдэгтээ итгэлтэй байсан. Гэтэл одоо л чөлөөтэй боллоо гэж бодсон яг тэр агшинд Хойд Вьетнамын эрх баригчид ирэв. Тэр өдөртөө АНУ руу онгоц яваагүй бөгөөд хууль бусаар эх орноо орхихыг оролдсон гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө би дараачийн 5 сарыг Вьетнамын шоронд өнгөрөөх учиртай байв. Тиймээс дараачийн 5 сарыг Вьетнамын шоронд өнгөрөөсөн юм. Цуглуулсан жаахан алт маань мөн алга болсон байсан агаад шоронгоос гарсны дараа бүгдийг дахин хийх хэрэгтэй боллоо гэдгээ мэдэж байлаа.

Би 1955 онд Вьетнамд төрсөн. Өсвөр наснаасаа л мөрийтэй тоглоомд дуртай байсан. Тэр үед мөрийтэй тоглоом ч нийтлэг зүйл байсан бөгөөд миний тоглодог байсан тоглоомуудын нэг нь хязгааргүй 5-н хөзрийн стад байв. Тэр нь Америкт тоглодог стад тоглоомтой их адилхан боловч хөзрийн багцаас 2-7 хүртэлх хөзрийг хасдагаараа ялгаатай.

Түүнчлэн би бас Хятад покер их тоглодог байсан. Тэрхүү тоглоомд нийт 4 тоглогч стандартын 52 хөзрийг 13-аар тэнцүү хуваан авна. Тиймээс 4-өөс илүү тоглогч байхгүй бөгөөд тоглогч хөзрөө "сэттингс" гэж нэрлэдэг 3 хэсэгт хуваана. Хоёр хэсэг нь 5 хөзрөөс ("байк" ба "мидл" гэнэ), нэг хэсэг нь "фронт" буюу урд дахь хэсэг нь 3 хөзрөөс бүрдэнэ. Арын хэсэгт нь хамгийн сайн хөзрүүдээ хийнэ, урд буюу нүүрний хэсэгт хамгийн муу гэснээ хийнэ (энэ тоглоомд 3 хөзрийн тоглолтод флаш болон стрэйтыг огт тооцдоггүй). Бүх тоглогчид өөрийнхөө урд хөзрүүдээ жагсаан тавина, үүний дараа тоглогч бүр өөрт ирсэн хөзрөөрөө тоглох эсэхээ зарлана.

Аав Сайгонд барилгачин хийж, ээж гудамжинд гоймон зардаг байв. Би айлын гурван хүүхдийн нэг бөгөөд ихэнх хүүхдийн нэгэн адил гудамжны буланд цуглан покер тоглодог байлаа.

Тэр үед хүмүүс Вьетнамын бужигнасан хөл хөдөлгөөн ихтэй гудамжинд покер маш их тоглох бөгөөд тэр нь Америкт тоглодгоос шал өөр боловч би маш их тоглодог байв. Мөн спортын тэмцээн ялангуяа хөл бөмбөгийн тоглолтоор их мөрийцнө. Америк руу явна гэсэн эхний оролдлого бүтэлгүй болсон ч Америкт хүрээд юу хийх талаар ямар ч ойлголтгүй байсан агаад покер тоглоно гэж огтхон ч санаанд ороогүй юм.

Шоронд байх хугацаанд миний сэтгэл санааг юу ч өөрчлөөгүй, би Баруун руу гарна гэсэн бодлоо тээсээр байлаа. Шоронгоос гаруут ажил хийж эхэлсэн ба маш шаргуу ажиллаж олсон бүхнээ хадгалж аяллынхаа бэлтгэлийг хангаж эхлэв. Тэгж зүтгэсний эцэст 7 унци алт цуглуулж чадсан бөгөөд энэ удаа би Вьетнамаас гарч чадав. Гэвч АНУ хүрэх зам тийм ч амар хялбар байгаагүй, бас дуусах ч болоогүй байж.

Завь шууд Америк руу явсангүй, хэд хоногийн дараа эхлээд Тайландад очсон агаад очихоос өмнө маш олон азгүй тохиолдлуудтай учирсан юм. Америкчуудын хэлдгээр "далайн дээрэмчид" таван удаа зогсоож дээрэмдсэн бөгөөд тэд нүдний боолт, сэлэмгүй харин бүгд буутай байлаа. Дээрэмчид онгоцон дээр гарч ирээд бидний алт, мөнгийг дээрэмдсэнээс гадна усан онгоц дээрх хамаг хоол хүнс, усыг бүгдийг авсан. Тэгээд хэдэн өдөр аялсныг би санадаггүй юм. Ямар ч байсан бид хоол хүнс, усгүй олон өдөр хөвсөн бөгөөд энэ нь үнэхээр аймшигтай өдрүүд байлаа.

Тайландад очсон ч байдал бүр хэцүү болсон бөгөөд надад мөнгө, өөр ямар нэг үнэ хүрэх зүйл байсангүй. Тайландад гэр бүлийн болон найз нөхөд гэх ганц хүн ч байхгүй байв. Хамгийн гол нь АНУ-д надад туслах нэг ч ивээн тэтгэгч байгаагүй учраас намайг дүрвэгсдийн хуаранд байрлуулж эрх бүхий ажилтнууд надад ивээн тэтгэгч хайж 4 сар болов.

•••

Завь Тайландад очихоос өмнө маш олон азгүй тохиолдлуудтай учрав. Америкчуудын хэлдгээр "далайн дээрэмчид" таван удаа зогсоож дээрэмдсэн бөгөөд тэд нүдний боолт, сэлэмгүй харин бүгд буутай байлаа.

•••

Эцэст нь Америкаас хэн нэгэн намайг ивээн тэтгэхээр болсон ч надад бас гүйцэтгэх ёстой нэгэн хариуцлага байжээ. Тэр дороо явуулаагүй бөгөөд Тайланд дахь дүрвэгсдийн хуарангаас Филиппин дахь дүрвэгсдийн хуаран руу англи хэл сургах, Америкийн соёлоос зарим нэг зүйлийг мэддэг болгохоор шилжүүлэв. Тэнд дахин 4 сар гаруй хугацаа өнгөрүүлж эцэст нь сургалт дууссан боловч англи хэл харийн хэл хэвээрээ л байлаа.

Эцэст нь Америк явахаар болсон бөгөөд миний ивээн тэтгэгч Колорадо Спрингст амьдардаг байв. Онгоцноос буухдаа би халаасандаа 10 доллартай байсан. Ивээн тэтгэгчтэйгээ уулзахад түүний хэлсэн ганц ч үгийг ойлгосонгүй. Миний мэддэг ганц үг нь "ОК", юу ч хэлсэн хариуд

нь би "ОК, ОК" л гэнэ. Тэр үед Дэнвэрт-5 хэм, хаа сайгүй цастай байлаа. Төсөөлөөд үз дээ, маш халуун чийгтэй Вьетнамаас ирсэн ядуу дүрвэгчид Дэнвэрийн өвөл ямар санагдах билээ.

Би ажилгүй, мөнгөгүй, ямар ч чадваргүй, англиар ч ярьж чадахгүй байсан. Ивээн тэтгэгчийндээ хоёр сар гаруй амьдарсан тэр хугацаанд халамжийн санд хандав. Миний хамгийн анхны ажил 1980 онд Кентаки шарсан тахиа хэмээх хоолны газар байсан бөгөөд тэнд би 6 сар гаруй цагийн 3.35 доллараар ажилласан юм. Хамгийн бэрхшээлтэй зүйл нь гэвэл хүмүүстэй харилцах байлаа. Азаар хажуухандаа нэгэн Хятад ресторан байсныг мэдсэн бөгөөд би Хятад, Вьетнам хоёр хэлээр ярьдаг байсан болохоор тэнд ажиллавал боломжийн санагдав.

Тэрхүү Хятад зоогийн газарт ажилладаг нэгэн зөөгч эмэгтэй покер клубын дилерээр давхар ажилладаг байсан агаад тэрээр нэг удаа "Чи покер тоглодог уу?" гэж асууж билээ. Хариуд нь би "Мэдээж, тоглолгүй яахав" гэж хариулав. Тэгээд сурахаасаа өмнө 7 хөзрийн стад, Холдем, Омаха болон нэрийг нь ч дуудаж чаддаггүй өөр бусад тоглоом тоглож бүх мөнгөө алдав.

Хожим нэг хүнтэй зоогийн газар танилцсан ба тэр хүн надад Флоридад ажил санал болгов. Тэр ажил илүү цалинтай байсан бөгөөд цаг агаар нь бас таалагдаж тийш нүүлээ. Тэнд нэлээд их мөнгө хийсэн боловч миний покер тоглох туршлага сайжраагүй л байлаа. Их мөнгө аваад л байдаг гэвч түүнийгээ бүгдийг алдсаар байв. Жил гаруй хугацаа өнгөрсний дараа Колорадо руу буцахаар шийдэж өөр нэгэн Хятад зоогийн газарт ажиллах болов.

•••

Би ажилгүй, мөнгөгүй, ямар ч чадваргүй, англи хэлээр ярьж чадахгүй байсан. Ивээн тэтгэгчдийндээ хоёр сар гаруй амьдарсан тэр хугацаанд халамжийн санд хандав.

•••

Энэ удаад миний аз шовойж эхлэв. 6 сар гаруй хугацааны дараа би хожиж эхэлсэн бөгөөд бараг тогтмол шахуу хождог болсон учраас покерт илүү гүнзгий орохоор шийдлээ. Тэгээд би ажпаасаа гарч бүхий л өдөржин покер тоглох болов. Энэ бол 1983 он гарах гэж байсан үе бөгөөд би мэргэжлийн покерчин болохоор эргэлт буцалтгүй санаа шулуудав.

Хоёр жилийн дараа Лас Вегас руу нүүхэд миний өөртөө итгэх итгэл болон банкин дахь мөнгө хангалттай болсон байлаа. Голден Наггет казинод 20-40 долларын хязгаартай покерын ширээнд Холдем тоглож эхэлсэн ба эхний жилдээ 100,000 доллар хожив. Тэгээд илүү өндөр хязгаартай тоглож 50-100, дараа нь 100-200 доллар хүртэл өсгөсөн ба түүнээс ч илүү хязгаартайгаар тоглох болов.

1990 он хүртэл тэмцээнд ерөөсөө ороогүй бөгөөд тэр жилээ Покерын дэлхийн цуврал тэмцээнд оролцов. Тэмцээнд орохоосоо өмнө бэлэн мөнгөний тоглолтод хамаг анхаарлаа төвлөрүүлэв. Гурван жилийн хугацаанд хожоогүй боловч 1993 онд эхнийхээ бугуйвчаа 1,500 долларын хязгааргүй Ace to Five Draw тэмцээнд түрүүлж хүртсэн билээ. Удалгүй 2 сарын дараа хоёр дахь түрүү болох Four Queens Casino-д болсон хязгаартай Холдем тэмцээнээс бугуйвч авч байлаа.

Та нар төсөөлж байгаа биз дээ, тэр үед би томоор тоглодог болсон байв. Тэгээд өөртөө "За тэгэхээр тэмцээн гэдэг бол зугаа юм байна, түүгээр би илүү их мөнгө хийж болох юм байна" гэж хэлсэн бөгөөд Лас Вегас, Калифорниор явж аялан тоглолт хийж, тэмцээнүүдэд оролцож эхлэв. Тэгж яваад саяас илүү доллар олсноо мэдээгүй явсан агаад түүнийгээ мэдүүтээ өөртөө ч итгээгүй юм. Би саятан болчихжээ, би Америк мөрөөдлөөр амьдарч байна.

Ингээд би өөрийн чадвараа сорих цаг нь болжээ гэж бодоод надад олдсон өндөр бооцоотой тоглолтуудыг хийж, дэлхийн шилдэг тоглогчидтой тоглож эхлэв. Сая долларын мөнгөтэй хүн чинь Хасаа хочит Рийс, Дойл Брансон, Бобби Болдвин, Лайл Бэрман нартай тоглож болно гэсэн үг. Тэдэнтэй хийсэн тоглолтууд 4,000-8,000 долларын хязгаартай байсан ба хожим нь бид 8,000-16,000 долларын хязгаартай тоглолтууд руу шилжсэн.

Тэгж яваад саяас илүү доллар хожсоноо мэдээгүй явсан бөгөөд түүнийгээ мэдүүт өөртөө ч итгээгүй. Одоо би саятан болчихлоо хэмээн сая л би Америк мөрөөдлөөр амьдарч байгаагаа мэдэв.

Нэг сая доллараа би 20 сая болгосон агаад энэ хугацаа хуруугаа инчдэх хооронд болсон шиг санагдав. Гэвч түүнд хүрэхийн тулд үнэндээ хоёр жил зарцуулсан агаад энэ бүх хугацаа маш хурдан өнгөрч, тийм ч удаан юм шиг санагдаагүй билээ. Энэ бол үнэхээр гайхамшигтай өсөлт байлаа. Брансоны хүү Тод миний хувьцааны 25 хувийг худалдаж авсан хийгээд тэрбээр 2.5 сая долларыг миний хүчин чармайлтын үр дүнд олж авсан юм.

Ингэж томоор тоглох явдал тэмцээнээс намайг хэсэг хугацаанд холдуулсан бөгөөд том дүнгээр тоглосноор илүү их мөнгө хийж байлаа. Мөнгө над руу маш хурдан ирсэн, өнөөдөр ч гэсэн би тийм их олон тэмцээнд оролцдоггүй. Мэдээж, Main Event, Лас Вегас, Калифорнид болдог өөр бусад томоохон тэмцээнүүдэд бол оролцоно. Гэвч Лас Вегаст амьдардаг гэр бүлтэйгээ аль болох ойр байхыг илүү их хүсдэг.

Гадны хүний нүдээр харахад бүх зүйл маш сайхан болсон мэт харагдана. Вьетнамаас ирсэн дүрвэгч Америк мөрөөдлөөр амьдарч, ихээхэн хэмжээний мөнгө буюу хориос илүү сая доллар олсон байна гэдэг үнэхээр гайхалтай, түүнээс илүү зүйл бий гэж үү?

Харамсалтай нь Лас Вегаст 20 сая доллар хожих, тэнд 20 сая доллар хадгална гэдэг хоёр тусдаа зүйл. Би томоохон бооцоот тэмцээнд оролцохдоо сайн, түүнд эргэлзэх зүйлгүй. Харин тийм тоглолт өдөр болгон, эсвэл долоо хоног бүр тийм байдаггүй юм. Бага бооцоотой тэмцээнүүд уйтгартай болсон агаад тэдгээрт би анхаарал тавихаа больсон, харин том бооцоот тэмцээнд илүү татагдах болов. Тэгж байхдаа сэтгэл хөдөлгөмөөр боломжуудыг харж эхэлсэн бөгөөд тэдгээр нь казиногийн тоглоомууд буюу хожиход хүндрэлтэй газар байлаа.

Үүний зэрэгцээ би шоон бакарат тоглож эхэлсэн бөгөөд түүний үр дүн гамшигаар дуусч билээ. Би 20 сая доллараа тэр чигээр нь алдав. Энэ үед би юу хийх ёстой вэ? Бага бооцоот тэмцээнд эргэн орж тоглож эхэлсэн ба тэр үеэс покероос өөр тоглоом ер тоглоогүй юм. Дахиж казино тоглоом тоглохгүй гэж өөртөө амласнаар би бага багаар мөнгөө өсгөсөөр байлаа. Тэндээсээ 200-400 долларын тоглолтууд хийж, дахин бага багаар нь өсгөсөөр эргэн том тоглолт хийх мөнгөө цуглуулж амжив. Үүнд нэлээдгүй хугацаа зарцуулсан ч ямарч байсан хийж чадсан юм.

Өөр нэгэн сургамж авсан нь би бол покерчин тиймээс юу яаж хийдгийг мэддэгтэйгээ л зууралдах хэрэгтэй гэдгээ ухаарсан бөгөөд тэр бол покер байлаа. Тэгээд хожиж чадахгүй казиногийн бусад тоглоомыг тоглохоо болив.

Би маш үнэтэй сургамж авсан, тэр их хэмжээний мөнгө хожно гэдэг бол чамайг дэлхийн орой дээр гарсан мэт болгоно. Тэр нь чамайг ялагдашгүй мэт санагдуулахад итгүүлнэ, гэвч тэр их мөнгийг алдах боломж маш их байдгийг мэдсэн бөгөөд сайн туршлага бол хожсон үеийн сэтгэлийн таашаалаас илүү их үр нөлөөтэй болохыг ухаарч билээ. Түүнчлэн би сүүлийн хэдэн жилд хөрөнгийн зах зээл дээр гурав орчим сая доллар алдсан, тиймээс энэ нь ч гэсэн надад тохирохгүй зүйл байна хэмээн орхисон.

Өөр нэгэн сургамж авсан нь би бол покерчин, тиймээс юу яаж хийдгийг мэддэгтэйгээ хамт байх хэрэгтэй гэдгээ ухаарсан бөгөөд тэр бол покер байлаа.Тэгээд хожиж чадахгүй казингийн бусад тоглоомыг тоглохоо болив. Одоо хүртэл 30 гаруй жил покер тоглосны дараа тоглох бүртээ айдастай байдаг. Энэ бүр миний цусанд шингэсэн юм. Түүнчлэн олон цагаар покер тоглох дуртай хэвэндээ байгаа бөгөөд покер тоглох нь өөр бусад бүх зүйл хийхээс хамаагүй илүү байдаг. Дээрээс нь би Лас Вегаст дуртай, энд гэр бүлтэйгээ хамт байхаас гадна бараг орой бүр хүүхдүүдээ унтахад оронд нь оруулдаг ажилтай.

Түүнээс гадна покер надад зугаатай бусад боломжуудыг ч бас нээж өгсөн юм. Тэр нь "Чи азтай" киноны жижигхэн хэсэгт тоглосон нь хамгийн сонирхолтой зүйлийн нэг болсон доо. Түүнд Эрик Бана, Дрю Барримор, Роберт Дювал нар тоглов. Энэ бүхэн их сонирхолтой байсан, нэгэн томоохон бэлэн мөнгөний бооцоотой тоглолтод Дойл Брансон тоглож байхад түүнтэй хамт кино найруулагч Куртис Хансон хамт сууж байлаа. Тэрбээр Брансоны тоглохыг харж сууснаа покерын тухай кино хийх гэж байгаа, түүндээ жинхэнэ бодит покерын шилдгүүдийг оруулах гэж байгаагаа хэлэв. Тэр даруйд нь би "Хөөе, би тэр кинонд чинь тоглоё, зугаатай байж магад" гэхэд, Куртис "Битгий санаа зов, Чау, чи аль хэдийнэ миний жагсаалтад байгаа" гэж билээ.

Уг кинонд өндөр бооцоот тоглоомын тухай өгүүлдэг. Хак Чийверын дүрд Эрик Бана тоглосон бөгөөд тэрбээр үргэлж хожигддог нэгэн байсан. Гэвч тэрээр 2003 оны Покерын дэлхийн цуврал тоглолтын Main Event /гол тоглолт/-д түрүүлсэн юм. Хамгийн том өрсөлдөгч болох аав Л.С.Чийверын эсрэг тоглоно, тэрбээр мэргэжлийн болон хувийн тал дээр үргэлж эсрэг дүр болдог байсан агаад Хакийн аав ээжээс нь хэдэн жилийн өмнө салсан байдаг. Тэгээд Хак амьдрал болон покерыг ялахын тулд суралцаж эхэлнэ. Тэрбээр амьдралынхаа замналын дагуу хөзөр тоглохыг заавал сурах болдог бөгөөд хөзөр тоглохын тулд тэрхүү амьдралын замыг сонгох ёстой болно. Би кинонд нэгэн покерчны дүрд тоглодог агаад тэр үе нь нэлээд яриа гардаг гоё хэсэг бий. Кинонд тоглосноор бас хэдэн цаас олсон шүү.

Онлайн покер миний анхаарлыг их татаж байгаа бөгөөд тэнд тоглоход байнга сорилтод ордог. Би Full Tilt-д "Ла Ки Юу" (тоглосон киноны нэрний өөр хэлбэрийн дуудлага "Luckum You") гэсэн нэрээр дор тоглож ба 2008 онд 5 сая доллар хожиж билээ. Онлайнд маш олон янзын тоглолт байдаг болохоор би түүнд дуртай байдаг. Бараг л бүх төрлийн тоглоомд дажгүй, тэдгээрийн дотроос холимог тоглоомд бүр ч дуртай. Том бооцоот тэмцээнд, жишээ нь Беллажиод болдог шиг хязгааргүй Холдемыг тэнд тоглоно, тэгээд л болно. Онлайнаар 7 card Stud, Omaha Hi-Lo, Pot Limit, No-Limit, Tournament, Sit & Go гээд олон тоглоом тоглодог

болохоор тархийг хурцалдаг.

• • •

Гэвч Лас Вегаст 20 сая доллар хожих мөн Лас Вегаст 20 сая доллар хадгална гэдэг хоёр тусдаа ойлголт юм. Би том бооцоот тэмцээнд сайн, түүнд эргэлзэх зүйлгүй. Харин тийм тоглолт өдөр болгон, эсвэл долоо хоног бүр тийм байдаггүй.

• • •

Надад покерын тухай дараах үндсэн суурь ойлголт байдаг. Энэ нь чадвар шаардсан аз гэсэн элементтэй тоглоом ба аз шаардаагүй чадвар гэсэн элементтэй тоглоом юм. Би түүнд маш хүчтэй итгэдэг бөгөөд түүнийхээ хүчинд ингэж сайн тоглодог. Жишээ нь, хэн нэгэн хос тугтай байж хос тамгыг хожиж болно, гэхдээ энэ бол байнга тохиолдох зүйл биш. Эсрэг тоглогчоо унших гэдэг маш чухал, энэ бол яаж тоглох вэ гэдгийн их том хэсэг. Би хожно гэдгээ мэдсэн тохиолдолд гарт ирсэн хөзрөөр тоглодог. Хэрэв би хожигдоно гэдгээ мэдвэл хичнээн том хөзөр гартаа барьсан ч түүнийгээ хаядаг. Түүнийг би маш чухал гэж боддог. Ихэнх тоглогчид хос тамгатай үедээ хожно хэмээн боддог гэтэл газарт хөзөр дэлгэхэд эсрэг тал чинь флаш юм уу стрэйт хийн хожих боломжтой болсноор чиний боломж хумигдана. Би эсрэг тоглогчоо сайн мэднэ, хэрэв эсрэг тоглогчид тамга, эсвэл тамга ноён хослолтой байхыг мэдвэл надад байгаа тамга хатан, эсвэл хатан хатан хослол хэдийгээр хүчтэй хослол боловч эсрэг талын хажууд багадаа учраас түүнээс татгалздаг.

Нэгэн тоглоомд аз таараагүй гэж хэлэхгүй. Нэгэн удаагийн Покерын дэлхийн цуврал тоглолт тэмцээнд эсрэг тоглогч "бүгдийг түлхэхэд" түүнийг би дуудаж өөрт байгаа бүх хасаагаа эрсдэлд оруулав. Надад ноён ноён хослол, эсрэг тоглогчид тамга тамга байсан бол газарт мод эргэхэд 7-2-тамга байсан нь миний хувьд байдал бүр бишдэв. Тэрбээр одоо гурван тамгатай болсон бөгөөд би шуудхан бууж өгч түүний гарыг барьж баяртай гэж хэлээд ширээг орхисон юм. Тэгж явсаар машиндаа хүрэх дөхөж байтал нэгэн залуу гүйн ирж сүүлийн хөзөр эргэхэд чиний хоёр ноён дийллээ гэж хэлэв. Тэр үед аз тохиолдсон гэхдээ хугацааны туршид чадвартай тоглогчид үргэлж азтай тоглогчоос илүү байдаг.

Миний хүү бараг 13 настай бөгөөд тэрбээр покер тоглохыг хүсч байна гэдэг, би түүнд чи хэтэрхий жаахан байна, чиний ирээдүйд маш их цаг байна. Яг одоо бол чи хичээлдээ явж хүүхэд насандаа зугаац гэдэг. Хэрэв хүү минь коллеж төгссөний дараа покер тоглохыг хүссэн хэвээр байвал түүнд би зааж өгнө. Тэрбээр их ухаантай, сайн сурагч, түүнийг би юу хүссэнийг нь сонгох боломжийг олгоно гэж боддог.

Би ирээдүйтэй покерчин тул нэр хүнд нэлээд өсөв. Вьетнамд байдаг эгч маань намайг гэртээ нэр алдартай болоод буцаж ирэх нь гэдэг. Хүмүүс намайг ESPN-ээр гардаг WPT тэмцээнээс олж мэдсэн байх. Гэвч нэр хүнд бол надад тийм чухал биш, би түүний хойноос хөөцөлддөггүй, харин хожих боломжтой тоглоомоо л хайдаг. 20 сая доллар хожсон ч алдсан ч би ижилхэн л урд ямар хүн байсан яг хэвээрээ байгаа, оддын зэрэгт хүрлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй.

Надад покерын тухай дараах үндсэн суурь ойлголт байдаг.

Энэ нь чадвар шаардсан аз гэсэн элементтэй тоглоом бөгөөд аз шаардаагүй чадвар гэсэн элементтэй тоглоом.

Ихэнх тоглогчид хэлж ярьж байгаагаараа, зурагтын өмнө хэрхэн жүжиглэж буйгаараа өөрсдийгөө таниулахыг боддог бол харин би яаж тоглосноо харуулахыг ер хүсдэггүй юм. Тэр бол миний загвар биш, тэгээд ч тэдгээр зүйл нь надад ширээний ард суухад саад болдоггүй.

Би өөрийгөө их азтай хүн хэмээн боддог. Эхнэр бид хоёр гайхалтай гэр бүлтэй. 15 жилийн өмнө нэгэн найз маань намайг Америкт байхад Вьетнамд нэг сайн эмэгтэй байна гэж хэлэв. Би Вьетнам руу нисч очин түүнтэй танилцсан бөгөөд хожим нь ихэд дотносч, дахин нисч очиж уулзаж байлаа. Аз болоход тэр надтай гэрлэхийг зөвшөөрч АНУ-руу хамт ирсэн юм. Түүнээс хойш бид хамт амдарч байна, бид 13 настай хүүтэй, хоёр охин маань 11, 8 настай. Манай эгч Вьетнамд байда, нөхөр, 2 хүүхэдтэй. Би түүнтэй байнга харилцаатай байхыг боддог бөгөөд хэзээ ч хамаагүй туслахад бэлэн гэж хэлдэг.

Тэрбээр одоо гурван тамгатай болсон агаад би шуудхан бууж өгч түүний гарыг барьж баяртай гэж хэлээд ширээг орхисон юм. Тэгж явсаар машиндаа хүрэх дөхөж байтал нэгэн залуу гүйн ирж сүүлийн хөзөр эргэхэд чиний хоёр ноён дийллээ гэж хэлэв.


Миний хамгийн дурсамжтай үе бол 2004 онд 2000 долларын Омаха Пот Лимит тэмцээнд түрүүлж 3 дахь бугуйвчаа авсан явдал юм. Түүний эхний байрт өгсөн шагнал нь 187,920 доллар байсан бөгөөд гол нь цэнхэр дэлгэцээр гарсанд байсан. Мөнгө бол түрүүлэхэд тийм чухал байгаагүй агаад алдар нэр, бугуйвч хүртэл миний зорилго байгаагүй юм. Ер нь би оддын нэр хүндээс ичдэг юм. Харин хүүхдүүд намайг зурагтаар харахыг хүсдэг. Тэд байнга "Аав, та эд нар шиг шилдэг покерчин байж яагаад зурагтаар гардаггүй юм бэ?" хэмээн асуудаг байлаа.

Тийм учраас тэмцээнд үнэн зүрхнээсээ хожихын төлөө гэхдээ мөнгө, алдар нэр, бугуйвчны төлөө биш харин хүүхдүүдийнхээ төлөө зурагтаар гарах ганц зорилгын төлөө би тоглосон юм. Манай гэрийнхэн намайг зурагтаар харж байгаа гэдгийг би мэдэж байсан болохоор надад 10 сая доллар хожсонтой ижил хэмжээний сэтгэгдэл төрж байсан.

Ирэх хэдэн жилд покерын шүтэн бишрэгч нар намайг илүү таньж мэдэх байх хэмээн боддог бөгөөд одоо хүртэл англи хэл үзсээр байгаа билээ. Тиймээс яриандаа сайжирч арай итгэлтэй болж байгаа тул зурагтын дуран авай асаад зураг авч эхлүүт бусдыгаа бодвол би харьцангуй бага ярьдаг юм. Тэгээд ч дурангийн өмнө англиар ярихаасаа би бага зэрэг ичдэг талтай. Гэвч зарим хүмүүс ярилцлага авч, гарын үсгээ өгөхийг гуйхад ихэд баярладаг.

Би одоо 53 настай, гэвч покероосоо тэтгэвэрт гарна гэж бодохгүй байгаа. Би покерт маш их хайртай. Хэрэв 80 настай эрүүл саруул байвал би покер тоглосон хэвээр байх болов уу. Би дампуурч байна уу, эсвэл 100 сая доллартай байна уу гэдэг огтхон ч хамаагүй покероо би тоглосоор л байх болно.

Түүний тухай ChauGiangPoker.com-сайтаас мэдэж болно, түүнтэй www.fulltiltpoker.net сайтад орж тоглож болно.



Скотти Нгуен

Энни Дюк бол покерын шилдэг оддын нэг юм. Түүнчлэн дэлхийн хамгийн том бэлэн мөнгөний холимог тоглолтын шилдэг тоглогч, зохиолч, покерын зөвлөгч, дэлхий даяар явагддаг радио болон зурагтын байнгын зочин билээ.

2004 онд анхныхаа Покерын дэлхийн цуврал тэмцээний бугуйвчийг 2000 долларын Омаха найм ба түүнээс дээш тоглоомыг сайн тоглосноор хүртэж байв. Түүний дараа жилийн хойно Аваргуудын тэмцээнээс 2 сая доллар авч Фил Хэлмуттай шувтаргын тоглолтод тунаж үлдэн түрүүлсэн юм. Тэрбээр саяхан өөрийн намтар болох Энни Дюк: Хэрхэн өсгөх, зогсох, хоосон өсгөх, өдөх, шид үзүүлэх болон Покерын дэлхийн цуврал тэмцээнээс саяыг

Тэрээр дөрвөн хүүхдийн ээж, Ховард Ледерерийн дүү юм. Колумбын их сургуулийн англи хэл ба сэтгэл судлалын дипломтой. Эрдмийн мөр хөөх замаа покероор сольсон тэрээр ахынхаа зөвлөснөөр покер тоглож эхэлсэн бөгөөд удалгүй анхныхаа тэмцээнд ахтайгаа туна үлдэн аварга болж байсан түүхтэй аж. 2008 оны байдлаар Покерын дэлхийн цуврал тэмцээнээс эмэгтэйчүүдийн хувьд хамгийн их мөнгө хожсон хүнээр тодорсон ба нийтдээ 3.5 сая доллар хожсон байна. Энни зөвхөн эмэгтэйчүүдийн тэмцээнд оролцохоос татгалздаг бөгөөд покерыг эрэгтэй, эмэгтэй гэж хүйс ялгалгүй оролцуулдаг цөөхөн тэмцээний нэг гэж үздэг.

Би 16 настай байхдаа гэрээ орхин Нью Йорк хотод ирж нэг семестрийн турш Беллевиены эмнэлэгт тархины өвчтэй хүүхдүүдтэй ажиллахаар очжээ. Бие даан суралцах хөтөлбөрийн дагуу ахлах ангидаа байхдаа ийм сонголтыг тэр хийжээ. Ажлын хажуугаар зав гарвал хотын төвд ирж ах Ховард Ледерерийн покер тоглодог байсан Бар Пойнтод очдог байжээ. Тэнд голдуу бага хэмжээтэй 1-3, 3-6 долларын Жакобын шат, Крис Крос мэтийн сонин тоглоомууд тоглодог байсан. Тэнд сууж ахынхаа тоглохыг хэдэн цагаар ч хамаагүй хардаг байсан бөгөөд тэнд байсан бүх хүн намайг хараад бяцхан дүү шигээ ханддаг байлаа. Тэгж л анх покер гэдэг тоглоомтой танилцсан түүхтэй юм.

Манай ах тэнд тоглож байгаа хүмүүс дундаас хамгийн их алдаж байгаа хүмүүсийн нэг байсан бөгөөд тэрбээр тухайн үед 18 настай хүүхэд байсан бөгөөд покерын "боловсролоо" ширээн дээрээс олж авсан юм. Тэр үед техник технологи өнөөдрийнх шиг хөгжингүй биш байсан. Өнөөдөр покерыг интернэтээс үнэгүй суралцаж болно, тэр үед суралцах газар буюу сургалтын төв байгаагүй, DVD, болон покерын тухай унших ном хүртэл ховор байлаа. Тэр үед ерөнхийдөө өөрөө өөртөө эзэн болж хэзрийн учрыг олох гэж өөрөө л зүтгэдэг байв. Ямартаа би ахыг хожигдоод, тэр өрөөндөө унтаж байгаад хүмүүс гарсны дараа өрөөг цэвэрлэн мөнгө хийдэг байсныг мэднэ. Гэвч ах маш хурдан суралцдаг нэгэн бөгөөд намайг эргэн ирж Колумбын их сургуульд суралцахаар ирэхэд Бар Пойнтын тоглолтыг давж гарч Мэйфейр Клубт 50-100 долларын тоглолт хийдэг болсон байлаа. Тэрээр мөнгө олох өөрийн чадварыг хэсэгчлэн найз нөхөд болон хамаатнууддаа борлуулсан бөгөөд түүнээс би хоёр хувийг нь эзэмшдэг байсан шиг санаж байна.

Колумбын их сургуульд байхдаа би ихэд завгүй байдаг байсан бөгөөд үнэндээ Ховардын тоглохыг нь харж чаддаггүй байлаа. Гэвч тэрбээр сар бүр 400 доллар надад шилжүүлдэг байсан нь түүнд дэмжлэг үзүүлсний ногдол ашиг гэж хэлж болно. Намайг сургуулиа төгсөхөд Ховард нэлээн сайн тоглогч болсон байсан бөгөөд Манхэттэнд пентхауст амьдардаг болсон байлаа. Тэр үед хүртэл надад покер тоглох нь тэгтэл их бодогддоггүй байв. Магадгүй "арын өрөөний" тоглолтыг их хардаг байсан болохоор тэр нь надад их сэтгэл хөдөлгөөгүй болохоор ямартаа ч сонирхол татаагүй юм. Тэгээд ч аав маань багш байснаар биднийг сурч боловсроход их дуртай байсан. Бакалаврын сургалтын 4 жилд сайн суралцсан болохоор сургуульд үлдэх нь их боломжийн шийдвэр шиг санагдаж докторын сургалтаа Пенсильванийн их сургуульд сурахаар шийдэв. Пен-д сэтгэл зүй, тархины үйл ажиллагааны талаар хүмүүс хэрхэн бодож, ойлгож, санаж, суралцдаг талаар судалдаг хамгийн шилдэг сургалт байлаа.

Би алдахыг хүсээгүй бөгөөд мөнгөнд их санаа зовж байсан боловч хамгийн гол нь ахынхаа урмыг хугалахыг ер бодоогүй юм.

Хамаг зүйлийг тодорхойлсон мөч докторантурт сурч байхад тохиолдов. Ховардад тоглож байхдаа намайг Лас Вегаст дуудсан бөгөөд тэр үед тэрбээр 21 эсвэл 22 настай л байсан байх. Тийш нисч очиход ах Four Queen Casino-д байдаг Хюгос Вайн Селлард руу дагуулан орж оройн хоол идэхэд тэрхүү тансаг газрыг хараад үнэхээр их гайхав. 13 мянган долларын жилийн цалинтай оюутны хувьд гадуур хооллоно гэдэг тийм олон биш хааяахан байсан агаад Чилисын арай дээр зэрэглэлийн зоогийн газраас өөр зүйл би огт мэддэггүй байв. Голдуу л Салатны гудамж гэдэг зоогийн газар 3 доллараар орж хооллоно. Түүнээс гадна Голден Наггетад бас нэгэн тансаг газар намайг оруулсан бөгөөд тэгж аялснаар сайхан амралт болж хааяахан ганц хоёр цагаар блэкжэк тоглож ихэнхдээ Ховардыг л покер тоглохыг нь хардаг байлаа.

Дараа жил нь дахин Лас Вегаст нисч очсон агаад бид Бинионы кофе хаусанд оройн хоолоо зооглох үедээ ирээдүйн төлөвлөгөөгөө ярилцан сууж байтал Ховард надаас "Чи энэ удаа зүгээр хараад зогсолгүйгээр тоглоод үзэхгүй юм уу" хэмээн асууж билээ. Түүнд би ийм түвшинд тоглож чадахгүй байх гэхэд тэрбээр нүүрний ямар ч хувиралгүйгээр "Чи намайг зөндөө хардаг байсан, битгий санаа зов, чи сайн тоглоно доо" гэв. Тэр ширээн дээрээс ам арчдаг цаас авч надад тоглож болох хослолын жагсаалтыг өгч 1-3 долларын хязгаартай Холдем тоглуулахаар Фрэмонт руу явуулав. Түүний стратеги маш богинохон байсан ба үнэндээ ижил биш бол тамга боолоос дээгүүр ор, хэрэв ижил хослол байвал 6-с дээгүүр ор хэмээн бичсэн байв. Тэгээд юу болж байгааг сайн ойлгоогүй боловч ямартаа ч босч покер тоглохоор казино руу явсан юм. Би хэзэр тоглодог гэр бүлд өссөн бөгөөд 14 настай байхдаа аавтай хамт гүүр тоглодог байв Покер тоглох нь тийм ч аймшигтай зүйл гэж боддоггүй байсан хэдий ч өөрөөсөө хамаагүй илүү туршлагатай тоглогчидтой хамт мөнгөөр мөрийцөн тоглоно гэхээс айж имээж байлаа. Би алдахыг хүсээгүйн зэрэгцээ мөнгөнд их санаа зовж байсан ч хамгийн гол нь ахынхаа урмыг хугална гэж бодоогүй.

•••

Бид Бинионы кофе хауст оройн хоолоо зооглон ирээдүйн төлөвлөгөөгөө ярилцан сууж байтал Ховард надаас "Чи энэ удаа зүгээр хараад зогсолгүй тоглоод үзэхгүй юм уу?" гэж асууж билээ.

•••

Ямартаа ч би анх тоглосон гэхэд ихээхэн аз дайрч 300 доллар хожсон нь надад их мөнгө байлаа. Түүний дараа нэлээд хэдэн удаа тоглосон бөгөөд аяллын хугацаанд баригдаж эргээд харьсан юм. Тэгээд Ховардаас юу хийх ёстой, юу хийж болохгүй талаар олон асуулт асууж байснаа санаж байсан агаад намайг түүнийг тоглоомд илүү татагдах болсныг тэр мэдэж байсан байх. Түүнээс хойш бид Лас Вегас руу жил бүр явдаг болсон хийгээд Ховардыг тэмцээнд оролцож байх хугацаанд би бэлэн мөнгөний тоглоомд тоглож харин түүнийг шувтаргын тоглолтын ширээн дээр тоглох үед түүнийг дэмжин харж зогсдог байв. Хэзээ түүнд чөлөөт цаг гарна бид зоогийн газарт орж хооллохдоо покерын тухай ярилцдаг байлаа.

Би зөвхөн Вегаст покер тоглодог байсан бөгөөд жилийн бусад улиралд яг л жирийн оюутнууд шиг хичээл номондоо анхаарлаа төвлөрүүлдэг байлаа. Цаг ирэх тусам Покерын дэлхийн аваргын тэмцээнээс эргэн ирнэ, сургуульдаа буцаж орно гэдэг хүндрэлтэй болж эхлэв. Миний ирээдүй их сонин харагдаж эхэлсэн агаад нэг талаас Вегаст үлдэж илүү их покер тогломоор байдаг ч нөгөө талаас боловсролтой болно хэмээн хүлээсэн үүрэг байдаг, түүнд намайг дэмжсэн, итгэсэн хүмүүсийн итгэлийг хугална гэдэг хэцүү байсан.

Пенсильванийн их сургуульд сурч асан 5 дахь жилд маш олон өөрчлөлт гарав. Докторын зэргээ хамгаалж дуусгахын тулд их шаргуу ажиллаж эхэлсэн бөгөөд тэр үедээ гэрлэсэн юм. Тухайн үед ажилд орохоор олон сургуулиудад хандаж байсан бөгөөд эхний ярилцлага Нью Йоркийн их сургууль байлаа. Тэр шилдэг сургуулиудын нэг шинэ боловсон хүчиндээ маш их өсөх боломжийг өгөхөөр байсан. Ярилцлагын нэг хэсэг нь тэнхимийн өмнө судалгааны ажлын талаар ярихад оршиж байлаа. Танилцуулга хийх өдрийн урьд орой гэнэт бие муудаж бөөлжиж эхэлмэгц ер зогсохгүй сандаргав. Би тэр ярилцлагад их санаа зовж байсан, тэрхүү ярилцлага намайг үлдсэн бүх амьдралаа дургүй зүйлээ хийхэд хүчээр тулгаж байсан бөгөөд эрдмийн ажлын талаар дахин бодоход хүргэв. Би түүнийг үнэхээр хүсээгүй, харин өөрийгөө тэгж бодохыг зөвшөөрөхгүй байлаа. Мөн надад хөрөнгө оруулалт хийсэн бүх хүмүүс, сургууль, гэр бүл, сургалтын дэмжлэг үзүүлсэн Засгийн газрыг бодож байсан. Тэр үед сургалтын дэмжлэгийг хэн нэгэн хэрэгтэй гэсэн хүндээ өгдөг байх гэтэл тэр хүн нь энд ингээд бөөлжөөд байж байх гэж хэмээн бодож хүсээгүй ажлаа гэнэт авна гэхээс дотор хачин болсон юм.

Түүний эцэст ярилцлагад явахаа хойшлуулаад Филадельфид эргэн ирэв. Улмаар маш их бөөлжсөн тул шингэн дутагдаж эмнэлэгт нийтдээ 14 хоног хэвтэв. Энэ нь мөн сэтгэлийн дарамт байж болох юм, дээрээс нь санаа зовсон байдлаа тайвшруулж чадахгүй байсан нь ихэд хүндрэлтэй байв.

Эмнэлгээс гарсныхаа дараа ярилцлага өгөх байсан бүх сургууль руугаа утасдаж бүгдийг нь цуцалсан бөгөөд судалгааныхаа ажлыг нэг жилээр хойшлуулж нөхрийн хамт Монтана руу нүүв. Тэнд очоод хэсэг хугацаанд амарч, өөрийнхөө юу хүсч байгааг олж мэдэх, бодлоо төвлөрүүлэх шаардлага гарсан юм.

• • •

Өдөр бүр тоглосныхоо дараа гэр рүүгээ машин жолоодон явж байхдаа би ах руугаа утасдаж, ширээн дээр тоглож байхад хүндрэлд оруулж байсан гарт ирсэн моднуудаа нэрлэдэг байлаа.

• • •

Монтанад ирээд удаагүй байтал Ховард биднийг Вегаст урьсан агаад бид тэнд очиж цагийг зугаатай өнгөрөөсөн юм. Бид тоглолтоо ахиулж 4-8 долларын хязгаартай Холдем тоглосон нь нэлээд амжилттай байв. Аяллын үед өөрийнхөө байдлын тухай хэлж би сургуулиа орхисон, одоо мөнгөний төлөө юу хийхээ мэдэхгүй байна, одоогоор байна гэв. Тэрбээр надад хандан, Монтанад покер хуулиар зөвшөөрөгдсөн байдаг юм, тэнд тогло, чамд авьяас бий хэмээн хэлж эхлэл болгон надад 2400 доллар өгсөн юм. Тэр үед би покерыг мэргэжил болгоно хэмээн огт

бодоогүй ч үзээд алдахыг хүсч байлаа.

Монтанад очуут Биллингст байдаг Кристал Лоунж гэдэг газар байдгийг мэдсэн агаад тэнд очихын тулд дунджаар 40 минут зарцуулдаг байлаа. Тэндхийн тоглолт 10-20 доллараас хэтрэхгүй нийт дундын сан нь 300 доллараас илүү гарахгүй байдаг байв. Мөн тэнд хоёр төрлийн хязгаартай Холдем тоглох, 3-6 долларын чек өсгөх тоглоом гэж үгүй, нөгөө нь 10-20 долларын чек өсгөх зөвшөөрөлтэй байлаа.

Эхний сардаа би 2800 доллар хожив, үүнийг долоо хоногт 5 өдөр, өдөрт 5-6 цаг тоглож байж олж авсан юм. Сонирхолтой нь би орой болж хөлчүү хүмүүс нэмэгдээд ирүүт тоглохоо больдог байв. Харин тэр хүмүүс бол хамаг юмаа тавьж мөрийцөхөд бэлэн хүмүүс байдаг. Түүний оронд өдрийн цагаар, орой болж халамцуу хүмүүс орж ирэхээс өмнө тэтгэврийн хөгшчүүлтэй тоглодог байсан юм. Тэд нийгмийн халамжийн мөнгө, тахир дутуучуулын мөнгөөр тоглодог байсан бөгөөд тэднийг арчаад л өнгөрдөг байлаа, надад 300 доллар авахад садаа болох зүйл ер байсангүй. Энэ нь тийм энэрэнгүй бус сонсогдож мэднэ, учир нь настай хүмүүсийн тэтгэврийн мөнгийг булаасантай ижил сонсогдох байх, гэхдээ мөрийтэй тоглосон нь тэдний асуудал шүү дээ.

Өдөр бүр тоглосныхоо дараа гэр рүүгээ машин жолоодон явж байхдаа би ах руугаа утас цохиж, ширээн дээр тоглож байхад хүндрэлд оруулж байсан гарт ирсэн модныхоо тухай хэлдэг байлаа. Цаг хугацаа өнгөрөх бүр миний тоглолт улам бүр сайжирч асуултууд ч бас дээрдэв. Намайг утасдах бүрийд Ховард ямар нэгэн зүйл, жишээ нь зурагт үзэх, сонин унших, эсвэл өөр зүйл хийж байсан бол түүнийгээ хойш тавин миний асуусан асуултад бүх анхаарлаа төвлөрүүлж намайг илүү сайн тоглогч болгохын тулд бүгдийг тодорхой тайлбарладаг байсан гэдгээ хэлж билээ.

Жилийн эцэст би багцаагаар 30 мянган доллар хожсон бөгөөд тэр нь 13 мянган доллар авдаг байсан докторантурын оюутан, 25 мянган долларын цалинтай профессорын туслахын цалингаас хамаагүй илүү байлаа. Тэндээсээ Филадельфи руу явж докторын зэргээ хамгаалахаар хоёр сар гаруй хугацаанд судалгааны ажлын сэдэвтэй ажиллаж байгаад эргэн Монтанад ирж диссертаци бичихээр болов. Гэвч түүнийг хийж чадаагүй учир нь маш их завгүй покер тоглож байсантай холбоотой юм.

1994 оны Покерын дэлхийн аваргын тэмцээн ойртож байтал Ховард над руу утасдан Вегаст болж байгаа дагуул нээлттэй тэмцээнд оролцохгүй юм уу хэмээн асуув. 1500 долларын хязгаартай Холдем тэмцээн нь маш олон хүний анхаарлыг татдаг тул тийм тэмцээнүүдэд оролцож эхлэв. Тэдний дотроос нэлээд олонд нь түрүүлж байлаа. Эхний тэмцээнд 600 гаруй өрсөлдөгч оролцсон агаад би 14-р байрт орж 13 мянган доллараар шагнуулав. Ахын найз нарын нэг Стив Золотов надтай хамт ширээнд сууж байсан бөгөөд миний талаар Ховардад илтгэдэг байсан юм. Тэрбээр намайг сайн, авьяастай тоглогч гэж хэлсэн байна билээ.

Дараа нь 2500 долларын бооцоотой тэмцээнд оролцохоор шийдэн хүлээж байгаад хэд хэдэн тэмцээнд оролцож зарим нэгэнд нь түрүүлэв. Тэр үед эмэгтэй хүмүүс бараг тоглодоггүй байсан нь давуу тал болж байлаа. Нэгэн удаа 2500 долларын бооцоотой тэмцээний сүүлчийн тоглолтод 35 мянган долларын шагнал дээр муу сонголт хийснээ санаж байна. Надад хос 10 ирж, өрсөлдөгчид маань ноён есийн цэцэг ирсэн байлаа. Түүнийг өсгөхөд би бас дагаж

өсгөв, дараа нь би дуудсан бөгөөд газарт гурван жижиг хөзөр эргэхэд нэг нь цэцэг байв. Дараачийн хоёр хөзөр нь хоёулаа цэцэг байсан тул бооцоог би өсгөсөөр байлаа. Эцэст нь нөгөө залуу флаш гаргахад тэр үед нийт мөнгөнийхөө гуравны хоёрыг би алдсан юм. Гэвч удалгүй бүгдийг нь эргүүлж авсан даа.

2500 долларын бооцоотой дагуул тэмцээнд түрүүлсний дараа Ховард намайг Main Event-ын тэмцээнд оролцоод үзээч гэв. Би хязгааргүй тоглолтод ордоггүй байсны сацуу зөвхөн дагуул тэмцээнд оролцож байсан тул түүнд оролцоно гэдэгтээ нэг л итгэхгүй байлаа. Ховард "За тэгвэл, шилдэг дагуул тэмцээнүүдэд оролцоод үз, тэндээсээ Main Event-д түрүүлэх эсэхээ шалгаад үз" гэв.

Тэгээд Ховардын зөвлөгөөг даган шилдэг дагуул тэмцээнд оролцож түүндээ түрүүлсэн юм. Дахин тийм тэмцээнд оролцоод бас л түрүүлэв. Тэндээс нэлээд хэмжээний мөнгөтэй болсон бөгөөд Main Event-д оролцох хангалттай мөнгөтэй болов. Би хязгааргүй Холдем тэмцээний урьдчилсан тэмцээнд оролцохоор болж "Том Тэмцээнд" оролцох бэлтгэлээ базааж эхлэв. Гэвч түүнээс маш эрт цохигдож гарсан агаад тэр бүхэн надад үнэтэй сургамж болсон юм.

Чингээд жинхэнэ тэмцээнд орохдоо би Ховардын ширээнд суухаар сугалаа таарав. Ингээд анх Покерын дэлхийн цуврал тэмцээндээ ахынхаа эсрэг тоглохоор болов. Тэмцээний дунд үед хоёр тамгатайгаар бооцоог 800 доллар болгон өсгөж, харин ах тамга ноёнттой байсан тул бооцоог 6000 доллараар өсгөж, үүний дараа би дуудаж ахыг тэмцээнээс гаргах болсон.

•••

Чингээд жинхэнэ тэмцээнд орохдоо би Ховардын ширээнд суухаар сугалаа таарав. Ингээд анх Покерын дэлхийн цуврал тэмцээндээ ахынхаа эсрэг тоглохоор болов.

•••

Ингэснийхээ дараа би маш их уурлаж нүдэнд нулимс цийлэгнэж эхлэв. Би хуурдаггүй, мөн ахынхаа эсрэг хэзээ ч зөөлөн тоглодоггүй байсан. Бид хоёр байнга хоорондоо тоглодог ч энэ тэмцээн түүний хувьд маш чухал, тэрбээр бараг 10 жилийн турш амжилт олохыг хүсч байсан ч түүнийг би эхний алхамд нь буулган авсан гээд бодохоор өөртөө би ихэд дургүй хүрч байлаа. Тэр өдрөө л хасааны тоогоор тэргүүлэгчдийн нэг болсон бөгөөд хоёр дахь өдрөө мөн л дажгүй тоглосон доо. Харин хоёр ноёнттой байхдаа сохроор түлхэж тамга 3т ялагдаж билээ. Учир нь газарт эхний хөзөр тамга байснаар миний 30 мянган долларыг сэгсэрчихэв. Дараа нь удалгүй хос долоотойгоор Дойл Брансоны тамга боолд даруулав. Эцэст нь тэмцээний 23-р байрт шалгарч 21 мянган доллартай болсон юм. Нийтдээ бусад тэмцээнүүдэд хожсон мөнгөө нийлүүлбэл 70 орчим мянган доллартай Монтана руугаа буцсан даа.

Тэнд би удаагүй, Ховард над руу утасдаж намайг Лас Вегаст нүүж ирэхгүй юм уу хэмээн асуув. Тэрбээр намайг шилдэг тоглогчдын нэг гэдэгт итгэдэг гэдгээ хэлэхэд түүнийг би шоолон инээж байснаа санаж байна. Ховардад үргэлж алсын хараа байдаг бөгөөд надад бол миний урдах л харагдана. Би Вегас явахыг хүсч байсан агаад Ховардын ятгалгаар бид тохиролцоонд хүрч чадав. Бид UNaul-д байр түрээслэж 1995 оны Покерын дэлхийн цуврал тэмцээн эхлэхийн өмнөхөн очихоор төлөвлөв. Аяллын явцад миний бие нэг л эвгүй байсан

бөгөөд энэ нь жирэмсэн болсноос үүдэлтэй байсан агаад энэ нь бидний анхны хүүхэд байлаа. Ховард надад ихэд анхаарал тавьж тусалж байсан болохоор түүнд би энэ тухай хэлэхээс зайлсхийж байв. Жирэмсэн болсноор миний тоглолтод сулрал гарах байх гэж Ховардыг бодох болов уу хэмээн битүүхэндээ би эмээж байлаа. Чингээд баярт мэдээгээ хэлтэл, тэр ихэд баяртай байсан бөгөөд "Энни, чи бусад хүүхдүүдийн ээж байх гээгүй биз дээ, чамд одоо хүртэл хоолой хэрчин тэдний мөнгийг авах хэрэгтэй" гэсэн.

•••

Ховардад үргэлж алсын хараа байдаг бол надад гагцхүү миний урдах л харагдана.

•••

Тэгээд л би анхны хүүхдээ төрүүлж Покерын дэлхийн цуврал тэмцээн эхлэхээс өмнө хүү маань 6 долоо хоногтой болсон байв. Тэмцээн эхлэхэд нөхөр маань хүүхдээ "Horseshoes" казинод авчирсан юм. Эхний дөрвөн тоглолтоос би шалгарсан бөгөөд тоглолтуудын завсарлагаанаар хүүхдээ асарч байлаа.

1995 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний дараа би бэлэн мөнгөний тоглолтуудад өөрийгөө бэлдэж эхэлсэн юм. Би 50-100 долларын хязгаартай өөр бусад тоглолтуудад тоглож эхэлсэн агаад үүнд, стад, разз зэрэг орно (би стад тоглохоороо бүр 5-10 долларын тоглолтууд дээр очдог байсан бөгөөд хүмүүс намайг хамаг мөнгөө алдчихаж хэмээн боддог байсан байх, харин би тэр өөр өөр тоглоомуудад суралцаж байсан юм). Покерын өрөөний ихэнх том тоглолтууд холимог тоглолт байдаг байсан болохоор би холимог тоглолтын мэргэжилтэн болохоор зүтгэсэн юм. Би улам сайжрахын хэрээр надад давуу байдал өдөр ирэх тусам бий болж эхэлсэн агаад хамаг мөнгөө хамаагүй алдчих гээд байдаг шинэ тоглогч бүрийн гэнэн зангаас зайлсхийж эхэлсэн дээ.

Нэгэн удаа покер тоглож алдсан хойно дахин тоглохоо болих уу, яах вэ? гэж бодоход хүргэсэн шүү. 2002 онд би дөрөв дахь хүүхдээ гаргах дөхөж байтал жирэмслэлтийн сүүлийн 30 хоногийн үед алдаа гаргаж 25 мянган доллар алдсан бөгөөд тэр үед маш их ядарч, сэтгэлээр унаад байсан үед тэр нь намайг сэрээсэн юм. Тэгээд л би чинь гэр бүлээ авч явдаг хүн шүү дээ, гэр бүлээ тэжээнэ, гурван хүүхэд дээр дахин нэг нэмэгдэх гэж байхад ийм их хэмжээний алдагдал хүлээж байх гэж дээ хэмээн бодож билээ. Эндээс би дахин тоглох уу, хэсэг хугацаанд амрах уу гэж бодсон. Тэгж амрахыг үнэхээр хүсч байлаа гэвч тоглохоор шийдэж бага бооцоотой тоглолтод оролцох болсон юм. Урд нь 1000-2000 долларын бооцоотой тоглолтод орилдог байсан бол одоо 80-160 долларын Омаха 8 ба түүнээс дээш гэдэг тоглолтод оролцон аажмаар алдсан мөнгөө эргүүлэн авч эхлэв. Удалгүй хэдхэн сарын дотор алдсан бүх мөнгөө олж авсан даа.

Тэгээд л би чинь гэр бүлээ авч явдаг хүн шүү дээ, гэр бүлээ тэжээнэ, гурван хүүхэд дээрээс дахин нэг нэмэгдэх гэж байхад ийм их хэмжээний алдагдал хүлээж байх гэж дээ хэмээн бодож билээ.

Маш олон тоглогчид над шиг шат буурсан хойно эргэж тоглох хэмжээндээ хүртэл тэсдэггүй юм. Харамсалтай нь тэдний бахархал, бардам зан нь тэднийг хүлж тоглож байсан

хэмжээндээ байсаар бүр дампуурахад хүргэдэг билээ. Покер удаан тоглосон хүн бүрт дараалан алдах тохиолдол бий. Түүнээс болж санхүүгийн хямралд орох, бүр эрчимтэй уруудахаас зайлсхийх хэрэгтэй. Бага мөнгөөр тоглох нь алдсан мөнгөө эргүүлж олж авах, түүний хамт өөртөө итгэх итгэлээ дээшлүүлэх боломж зэрэг олгодог.

2002 оны тэр хүнд байдлыг эргэн харахад, санхүүгийн хүндрэл нь покер тоглохоо болих уу гэх шийдвэр гаргахад хүртэл хүрч байсан ч би покерт хайртай сэтгэлээ хэзээ ч алдаагүй. Хөзөр тоглож өссөн гэр бүлээс гаралтай миний сэтгэлийг тайлбарлана гэвэл нэлээд олон цаг хэрэгтэй байх. Монтанад байхдаа тоглоомын ширээн дээр хожиж өөрийгөө бүрэн тэжээж чадна гэдгээ мэдсэн нь миний амьдралд хамгийн том эргэлт болсон юм. Тэндээс би хамгийн дуртай зүйл болох покероо тоглож түүгээр амьдрах болно гэдгээ ойлгосон бөгөөд покерыг мэргэжил болгохоор шийдэж түүний хойноос үхэн хатан зүтгэсэн билээ. Миний хасаа хэдий чинээ бага болсон байлаа ч өнөөдрийг хүртэлх энэ бүх хугацаандаа би хэзээ ч харамсахгүй.

Түүний тухай та www.AnnieDuke.com сайтаас уншиж болно, мөн UltimateBet.net-сайтад орж түүнтэй тоглож болно. Тэрээр [Ante Up For Africa \(www.anteupforafrica.com\)](http://AnteUpForAfrica.com)- байгууллагын үүсгэн байгуулагч, санхүүжүүлэгч бөгөөд уг байгууллага нь Африкт хэрэгцээтэй мөнгө, бусад эд зүйлийг нэмэгдүүлэхэд зориулагдсан ашгийн төлөө бус байгууллага юм. Тэрээр залуусын амьжиргааг дээшлүүлэх байгууллага болох [Decision Education Foundation \(www.decisioneducation.org\)](http://DecisionEducationFoundation.org)-bm удирдах зөвлөлд багтдаг байна.



Лэйн Флэк

Скотти Нгүен бол хамгийн эрч хүчтэй, олонд хүлээн зөвшөөрөгдсөн покерчин юм. Покерын тэмцээн болон холимог тоглолтын хамгийн шилдэг тоглогчдын нэг түүний шагнал эдүгээ 10 сая доллар давж гарчээ. Түүний өвөрмөц төрх, онцгой зан чанар нь Нгүеныг алдаршуулахаас гадна заримдаа бусад талаар сөргөөр нөлөөлөх нь бий.

Түүний амжилтад 1998 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний Main Event-д түрүүлж, сая гаруй доллар хожсон нь яах аргагүй багтана. Хоёр дахь бугуйвчаа тэрээр 2000 долларын бооцоотой Омаха 8 ба түүнээс дээш тэмцээнээс хүртсэн. 1998 оноос хойш гурван ч бугуйвч авсан. Тэрбээр 2500 долларын хязгаартай Омаха, 5000 долларын Омаха 8 ба түүнээс дээш тоглолт, мөн 50 мянган долларын H.O.R.S.E. тоглолтын дэлхийн аварга аварга болсон юм.

Нийтдээ тэрбээр таван бугуйвчтай. Нийтдээ тэр 36 удаагийн Покерын дэлхийн цуврал тэмцээнээс шагнал хүртсэн төдийгүй покерын тэмцээний бүх үеийн тоглогчдоос хожсон мөнгөөрөө тавдугаар байрт бичигддэг.

2006 онд Покерын дэлхийн цуврал тэмцээний Main Event -ын аварга цолыг Gold Strike World Poker Open тэмцээнээс хүртэж шагналд нь 969421 доллар хожсон байна. Тэрбээр МГТ Гурвалсан титмийн цорын ганц эзэн юм. Учир нь тэрбээр Покерын дэлхийн цуврал тэмцээний Main Event, Покерын дэлхийн цуврал тэмцээний 50 мянган долларын бооцоотой Н. О.Р.С. Е. тоглолт, Покерын дэлхийн аялан тоглолтын аварга билээ.

Би Вьетнамын өмнөд хэсэгт орших Хан Хоа мужийн далайн эргийн Нха Транг гэдэг хотод төрсөн. Хот маань байгалийн үзэсгэлэнт далайн эргийн наран шарлагын газраараа алдартай бөгөөд маш олон аялагч, жуулчдын очих дуртай газар билээ. Гэвч намайг бага байхад Нха Транг хот маань Вьетнамын дайны үед хамгийн муу муухайг даван туулсан юм. Би ямар ч хүүхэд хэзээ ч харж байгаагүй аймшигтай зэрлэг балмад явдлын гэрч болж үлдсэн дээ.

Бага байхдаа сургууль, гэр хоёрын хооронд явахдаа олон аймшигт зүйлтэй тулгардаг байлаа. Ангийн маань хүүхэд гэхэд хөл бөмбөг тоглож байгаад минтэй талбайд орж дэлбэрэлтэд өртөж, шөнө бөмбөг дэлбэрэхийг сонсч, өглөө босч харахад хажуу айлын байшин байсан газар үнсэн товрого болсон байхыг олон ч удаа харсан даа. Тэр үед ачааны машинд үхсэн хүмүүсийг хог шиг ачаад явж байхыг харсан. Зарим нэг нь арай үхээгүй байхад хүртэл ачиж аваад явдаг байсан юм. Ийм аймшигтай зүйл олныг харсан болохоор хир баргийн юмыг тоохоо больсон доо.

Би 13 хүүхдийн хамгийн ахмад нь байлаа, найм нь төрсөн, тав нь манай нагац ахын хүүхдүүд байлаа. Тэрбээр хүнд үеийг даалгүй амиа хорлосны улмаас аав ээж хоёр хүүхдүүдийг нь үрчлэн авсан юм. Манай ээж маш онцгой хүн байсны зэрэгцээ биднийг аюулгүй, тав тухтай байр сууцаар хангаж, хоол хүнс, өмсөх зүүхээр дутаагаагүйгээс гадна бүгдийг нь сургууль соёлд явуулж чадсан билээ. Ээж минь надад покер тоглох сонирхлыг төрүүлсэн анхны хүн юм.

Би 7-8 настайгаасаа гудамжинд покер тоглож эхэлсэн. Тэр үед покерыг бараг л гудамж бүрийн буланд тоглодог байсан даа. Бид блэкжэк, таван хөзрийн стадтай төстэй тоглоом бүхий дөрвийг эргүүлээд нэгийг доош харуулж хязгаар тогтоолгүй тоглодог байлаа. Ээж маань покерыг бооцоотой тоглодог байсан тул би түүний ард харж зогсоно. Ихэнх тохиолдолд тэрээр ширээг орхин надад модоо өгөөд өөрийнхөө оронд тоглохыг хүсдэг байв. Харин аав маань покер тоглохыг хатуу хорино. Хэрвээ покер тоглож байгаад баригдвал гэртээ чирж аваачин хуванцар олсоор ороолгодог байлаа. Тэрбээр маш чанга ороолгодог байсан тул цохисон газрын арьс нь язарч цус шүүрч биед олс наалдана.

Вьетнамд эцэг хүн өрхийн тэргүүн гэдэг тэр гэрт амьдарч буй бүх хүнийг бүрэн хяналтдаа байлгадаг жамтай байв. Аавын хэлсэн болгон тушаал түүнийг нь ягштал мөрдөх учиртай. Нөхөр нь эхнэрээ зодох нь байдаг л зүйл төдийгүй өдрийн цагаар ч гэсэн ийм үе таарах нь цөөнгүй. Хажуугаар нь өнгөрөх хүмүүс юу ч хийж чадахгүй зөвхөн харахаас цаашгүй зогсоцгоодог. Ээж маань хүртэл тийм шийтгэлийг олон удаа амсч байсан ч би тоолж мэдэхгүй. Зөвхөн түүнийг өрөвдөн уйлдаг байсан. Ээжийг зодсоныхоо дараа аав гэрээс

гараад явчихна. Түүнийг явангуут ээжийг бид бүгдээрээ бүчин авч ихэд өрөвдөн уйлцгаадаг байлаа. Би одоо хүртэл энэ тухай бодохоор нулимс унагадаг юм.

• • •

Би хашаа давж америк цэргүүд дээр очоод тэднээс тамхи, бохь, шатдаг хий болон бусад хэрэгтэй гэснээ авч хотдоо ирж зардаг байлаа.

• • •

Би 13 хүүхдийн том нь болохоор хариуцлагаа ухамсарлан гэр бүлдээ туслах болов. Аав механик байсан болохоор их мөнгө олдоггүй байлаа. Тиймээс надад мөнгө олох амаргүй үүрэг ноогдов. Түүний тулд янз бүрийн зүйл хийж ихэнхдээ хашаа давж америк цэргүүд дээр очоод тэднээс тамхи, бохь, шатдаг хий болон бусад хэрэгтэй гэснээ авч хотдоо ирж зардаг байлаа. Ерөнхийдөө би тэдэнд таван доллар төлөөд авч явах чинээгээрээ бараа авдаг байсан төдийгүй түүнийгээ хотод ирж 15-20 доллараар борлуулдаг байв. Би маш жижигхэн биетэй байсан учраас америк цэргүүдэд хөөрхөн, өхөөрдөм харагддаг байсан байж магадгүй. Тэд "Хөөе. Скотти танай хотод юу хэрэгтэй байна. Надад зарах юм зөндөө байна. Хэр их юм хэрэгтэй вэ?" гээд л асууна. Арван нэгэн настайдаа би гэр бүлийнхээ хамгийн чухал хүн болсон доо. Тэр үеэс ээж минь заавал ажил хийх шаардлагагүй болж, дүү нар минь санаа амар сургуульдаа явах болсон юм. Тэр цагаас хойш би асар их хариуцлага хүлээж байгаагаа мэдэрсэн төдийгүй өнөөг хүртэл надад хадгалагдсаар ирсэн.

Арван дөрвөн нас хүрч цэрэгт татагдлаа би гурван жилийн туршид ийнхүү тэмцсэн дээ. Арван дөрвөн настай хүүхэд цэрэгт татагдана гэдгийг америкчууд сонсвол лав гайхах байх. Харин Вьетнамд бол энэ жирийн л үзэгдэл. Хамгийн аймшигтай нь тэр олон хүүхдийн хэд нь гэр орондоо эргэж ирдэггүй вэ гэдэг л байлаа. Манай хотын маш олон залуус дайтахаар яваад эргэж ирээгүйг би мэднэ. Миний доод талын дүү надаас нэг насаар дүү учир ээж маань бид хоёрыг бас л тийм хувь заяа хүлээж байгаа гэж боддог байсан.

Ээж минь биднийг ийм аймшигтайгаар алдахгүйн тулд хамаг эд зүйлээ зарж бид хоёрыг Вьетнамаас зугтаалгахаар болсон юм. Боломж гарвал зугтахаар бэлдэв. Харин хаана очихоо мэдэхгүй байлаа. Зарим хүмүүс Тайланд, Сингапур, Филиппин руу зугтаж байв. Бид хоёр Тайван явав. Бид дүрвэгсдийн хуаранд хоёр жил гаруй болсон. Тэнд байсан хүмүүс бидэнд Америкийн Засгийн газраар дамжуулж ивээн тэтгэгч олж өгсөн юм.

Миний юу хийж байгааг мэдвэл маш их асуудал үүснэ гэдгийг мэдэж байсан ч би эрсдэл хийхээр шийдэв. Тэгээд л тэр эмэгтэй дээр очиж асуудлаа хэлсэн дээ.

Дүү бид хоёр тэндээс салж тусдаа хуваарилагдлаа. Тэрбээр Калифорнийн Оранж Каунти руу надаас нэгжилийн өмнө явсан юм. Миний ивээн тэтгэгч Чикагод амьдардаг байсан. Ингэж л би анх Америкт хөл тавьсан даа. Надаас гадна өөр гурван ч вьетнам хүүхэд байсан. Бид бие биенээ таньдаггүй байсан ч Чикагод очмогцоо амьдралдаа анх удаа цас гэдгийг харж гоё санагдсан ч тун удалгүй маш хүйтэн болохыг нь мэдрэв.

Удалгүй бидний ивээн тэтгэгч тийм ч сайн хүн биш байсныг ойлгосон юм. Тэрбээр Вьетнам

хүмүүст туслахын оронд фермийн хямдхан ажилчид хайж байсан юм билээ. Энэ нь удалгүй тодорхой болсон. Бид бүтэн өдрийн турш өглөө зургаан цагаас орой хүртэл ажиллана. Үүний хариуд тэр бидэнд хоол хүнс, хувцас өгдөг байв. Харин нуруу хугалам тийм хүнд ажил хийсний төлөө цалин өгдөггүй, гадагшаа ч гаргадаггүй, сургуульд ч явуулдаггүй байлаа. Бидний амьдардаг фермийн байшин зэргэлдээх хамгийн ойрхон гэх байшингаас нэг бээрийн зайтай байсан бөгөөд бид ч түүний талаар гомдоллох гэхээр нэг ч англи үг мэдэхгүй хэцүүхэн байсан даа.

Нэгэн өдөр манай ивээн тэтгэгч гэртээ хүлээн авалт хийж бөөн хүн цуглаж бид ч үйлчилгээнд гарав. Тэгж явахад нэгэн эмэгтэй вьетнамаар ярьдаг болохыг олж мэдэв. Миний юу хийж байгааг тэрбээр мэдвэл нь маш их асуудал болно гэдгийг мэдэж байсан ч би эрсдэл хийхээр шийдэв. Тэгээд тэр эмэгтэй дээр очиж асуудлаа хэллээ. Өнөөх эмэгтэй байдлыг ойлгож нөхөртэйгээ ярилцах хүртлээ намайг чимээгүй байхыг анхааруулав.

Харин түүний нөхөр америк эмч хүн байсан бөгөөд тэрбээр нэлээд хөөцөлдөж байж биднийг Оранж Каунти руу шилжүүлж, тэнд дүүтэйгээ уулзсан.

Миний Чикагогийн ивээн тэтгэгч болон Оранж Каунти дахь ивээн тэтгэгч хоёр газар тэнгэр шиг ялгаатай байлаа. Өнөөдрийг хүртэл би Калифорнид байдаг ивээн тэтгэгчээ аав ээж гэж дууддаг юм. Мөн тэдний дөрвөн хүүхдийг ах, эгч гэж дууддаг. Тэд бидэнд тусдаа өрөө гарган өгч, сургуульд явуулж, кино үзэх, найзуудтайгаа хамт тоглоход зориулж мөнгө өгдөг байв.

Сургуулийн ахлах ангид байхад Вьетнамд байдаг дүүгээс маань захиа ирж, амьдрал тэнд хүндхэн байгааг бичсэн байв. Тэр үед сургуулиасаа гарч бие даан амьдарч, ажил хийж мөнгө олоод гэр рүүгээ явуулах шаардлага тулгарлаа. Ингээд төгсөхөөс өмнөхөн сургуулиасаа гарч ажилд ороод зургаан найзын хамт байр хөлсөлж суух болсон доо.

Чадвар муутай тул ямар ч ажилд орсон хамгийн доод шатны цалин авна. Тэр нь дөнгөж амьдралаа залгуулахад л зарцуулагдаж гэр рүүгээ мөнгө явуулж чаддаггүй байлаа. Дээрээс нь Вьетнамаас ирсэн цагаач болохоор хамгийн бага цалингаас доогуур цалинжна. Заримдаа цагт нэгээс хоёр доллараар ажилладагбайсан нь ирээдүйдээ итгэх итгэлгүй болоход хүргэв. Тиймээс гутал, хувцас зэрэг бараа хулгайлж эхэлсэн. Энэ нь хэдийгээр хулгай ч гэсэн тийм сүртэй зүйл биш байлаа. Хэрэв баригдвал гарыг минь хүчтэйхэн алгадан, хаалгаараа хөөн гаргаж дахиж битгий ирээрэй гэнэ. Тэгээд олсон би мөнгөө шар айраг, тамхи, хүүхэнд зарцуулдаг байв. Гэтэл ар гэрийнхэн маань надад найдаж тусламж хүлээсээр байсан юм. Хэдийгээр би нас бага байсан ч надад тэр үе маань сайхан санагддаг.

Хэсэг хугацааны дараа "Би юу хийж байна аа, ээж минь хамаг юмаа зарж биднийг хамгаалахын тулд Вьетнамаас гаргасан. Би заавал сайхан амьдрах ёстой. Гэтэл чи ингэж ч явах гэж дээ" хэмээн өөртөө хандаж хэлсэн. Амьдралдаа маш том өөрчлөлт хийхээр шийдэв. Энэ тухайгаа найзууддаа хэлж "Хаана боломж байна тийшээ л явцгаая" гэж тохирцгоов.

Бид Вьетнамд байхдаа Америкийн хоёр хотын тухай бүгд мэддэг байлаа. Тэр нь Лас Вегас, Холливүүд хоёр юм. Тэгээд найзууддаа хандаж, бид энэ хоёр хотын аль нэгэнд очиж шинэ амьдрал, шинэ амжилтыг хайх болно гэж хэлсэн юм. Би Лас Вегасыг сонгож бусад маань ч зөвшөөрсөн. Гэвч зарим нь Холливүүд явах саналтай байлаа. Тэгэхээр нь бид явах хотоо

цаасан дээр бичиж аяганд хийгээд сонголт хийсэн юм. Үр дүнд нь 4:2-ын харьцаагаар бид ялж Лас Вегас явцгаахаар болсон доо.

Тэр үед англиар ярьж байгааг сонсоод ойлгодог болсны зэрэгцээ бага зэрэг ярьдаг байлаа. Тэгээд л ширээ цэвэрлэдэг нэг ажилтанд дөхөж очоод "Надад энд ажил олдох болов уу?" гэж асуусан юм.

Энэ үед би покер тоглоно гэж ерөөсөө бодоогүй. Америкт таван жил болохдоо нэг ч удаа гартаа хөзөр бариагүй. Бид мөнгөө цуглуултал 1500 доллар боллоо. Эндээс л бидний шинэ амьдрал эхэлсэн дээ. Энэ нь тийм их мөнгө биш боловч бид түүнээс ч бага мөнгөөр болгодог л байсан юм. Бидний хэн нь ч 21 нас хүрээгүй мөртлөө тун их зориг гаргацгаасан. Бид Лас Вегас явж байгаа машинд дайгдсан боловч дөнгөж Калифорни Невадагийн зааг дээрээс буцах дөхөв.

Виски Петес гэдэг түр зогсоол дээр зогсох үед бид машинаас бууж мөрийтөй тоглох анхны боломжийг олж харсан юм. Эндээс бидэнд ямар сонголт хийх вэ гэдэг асуулт гарч ирсэн. Тэгээд юу болсон гээч. Бид тоглохоор шийдсэн юм. Бид 777 машинуудыг эгнүүлэн тавьсан байсныг хараад бидний ам ангайж, нүд бүлтийж тэдний мөнгөлөг, гялалзсан байдал, зоосны шарчигнан унаж байгаа чимээнд бүрэн автсан юм. Тэгээд л бүгд эгнэж зогсоод 25 центээр тоглож эхэлсэн дээ. Хэдий хэр удсаныг ч мэдээгүй. Гэнэт хамгаалагч биднээс үнэмлэхээ үзүүлэхийг шаардав. Бидэнд үнэмлэх байхгүй тул тэрбээр бага насны хүүхдүүд байна гээд биднийг хөөж гаргасан даа. Надад ердөө зургаахан доллар, нийтдээ бидэнд 40 доллар л үлдсэн байв. Лас Вегас ортол хагас цагийн зай байлаа. Ингээд шөнө болсон тул их хотын гэрлийг бид бараг л харж байлаа. Гэвч бидэнд 40 доллар үлдсэн болохоор тийшээ хүрэх нь дэлхийн хагасыг туулахтай ижил санагдсан.

Бүгд сүүлээ хавчуулан машинаа эргүүлэн буцаж явахаар болсон. Гэртээ хүрэхэд ердөө 20 минут үлдээд байхад би тэдэнд машинаа зогсоо гээд "Хараач. Бид бараг ирчихсэн байна шүү дээ. Лас Вегас бол бидний мөрөөдөл. Түүнийгээ харалгүйгээр гэртээ харимаагүй байна. Бидэнд бензин авах хангалттай мөнгө байгаа. Бас жаахан хүнс ч авч болно. Ядаж Лас Вегасыг харчихаад буцъя" гэсэн.

Бид Лас Вегаст ирэхэд тэр дороо ангайж хоцорсон. Тэрүүгээр хаа сайгүй хагас нүцгэн, хөөрхөн хүүхнүүд эргэлдэн бидэн рүү даллан инээмсэглэж байсан. Бид тэднийг эхэндээ биеэ үнэлэгчид гэж бодоогүй зүгээр л найрсаг хүмүүс гэж бодсон. Хэсэг жолоодож явтал хямд буфет гэсэн хаяг байхыг хараад маш их өлсч байсан болохоор хооллохоор оров. Энэ бол тэр үеийн "Холидэй Инн казино" байв. Одоо бол "Хара" казино болсон.

Тэр газар дүүрэн хүнтэй байлаа. Хоёр орчим доллараар хүссэн хоолоо идэх боломжтой байв. Биднийг хоолоо идэж байх хооронд ширээ цэвэрлэдэг хоёр хүүхэд хоорондоо ажилчид цөөхөн учир ачаалал ихтэй байгаагаа гомдоллон ярилцахыг сонссон. Тэр үед англиар ярьж байгааг сонсоод ойлгодог болсны зэрэгцээ бага зэрэг ярьдаг байлаа. Тэгээд л ширээ цэвэрлэдэг нэг ажилтанд дөхөж очоод "Надад энд ажил олдох болов уу?" гэж асуусан юм.

Тэрээр хажуугаар өнгөрөх жижигхэн хүүхнийг зааж "Энэ хүн манай захирал. Чи түүнээс асуу" гэв. Би түүнээс асуултаа давтан асуухад хэдэн мөч сонсч байснаа намайг дагаад өрөөнд

хүрээд ороод ир гэлээ. Тэгээд л "Хэрэв чамайг хөлсөлвөл чи хэзээнээс ажиллаж эхэлж чадах вэ?" гэхэд нь "Яг одоо ч ажиллаж чадна" гэж би ам бардам хариулав.

Тэр намайг ажиглаж инээснээ "Уучлаарай, жийнс, теннисний шаахайтай ажиллуулдаггүй юм. Заавал хар өмд, гутал өмсөх хэрэгтэй. Би чамд ажлын хувцас өгнө. Маргааш дөрвөн цагт" гэв. Яг энэ үед айх, гайхах зэрэгцэж байлаа. Би ажилтай болов. Харин хар өмд, гутал надад байсангүй, байх арга ч үгүй юм. Өөртөө байгаа бүх мөнгө болох зургаан долларын нэг доллар 89 центээр дөнгөж сая хоол аваад идчихсэн байлаа.

Найзууддаа би ажилтай болчихлоо гэдгээ хэлсэн. Тэд намайг галзуу амьтан хэмээн даапаалаад хамт буцъя гэлээ. Би шийдсэн байсан болохоор тэдэнд хандан "Та нар яв даа. Би энд үлдлээ" гэсэн. Ингээд л би босс руугаа зааж өгсөн хүүхдэд хоёр долларын шагнал өгөөд өөрөө хоёр доллартай үлдсэн юм. Дараа нь би тэд бүгдээрээ цайны мөнгөөр цалинждаг болохыг мэдэв. Тэнд байхдаа би "Скотти" гэдэг нэртэй болов. "Одоо хэн ч чамайг "Туанн" гэж дуудахгүй" гээд менежер маань надад энэ шинэ нэрийг хайрласан.

Тэр зоогийн газарт бас нэгэн вьетнам хүү ажилладаг болохыг мэдэв. Тэрбээр миний үеийн ойролцоо настай байлаа. Найзуудаа явсны дараа би түүнд хамаг түүхээ яриу. Бас дөнгөж сая ажилд орсон, ердөө хоёрхон доллартай үлдсэн гээд нэгд нэгэнгүй ярьж гарсан. Мөнгө байвал надад туслаач, цалингаа авахаар эргүүлж төлье гэж хэлэв. Тэгэхэд бид хоёр харилцан бие биенээ ойлгосноо тэр дороо л нь мэдэрсэн. Тэрбээр "Ажпын цаг дуустал хүлээж бай. Чи надтай хамт яв.

Хөл дээрээ бостлоо манайд амьдарч болно. Би чамд тусална" гэв. Түүний нэрийг Сан гэдэг. Тэр өдрөөс хойш бид сайн нөхөд болсон төдийгүй тэр үед түүний надад хэрхэн тусалсныг нь би ердөө ч мартдаггүй юм.

Тэр шөнөдөө түүний амьдардаг хоёр өрөө байранд очиход нийт есөн залуу хамтдаа амьдардаг болохыг мэдэв. Хамгийн удаан амьдарсан нь хамгийн аятайхан газар унтдаг бөгөөд хүн бүрт өөрийн хэвтэх, суух газар оногдсон байлаа. Тэнд нэг навсгар, хэмхэрхий, цулхирдаг болсон буйдан байсан юм. Би түүн дээр унтахаар болов. Маргааш нь ажилд гарахдаа Санаас өмд гутал гуйж авав.

•••

Хэдэн өдрийн дотор би түүнээс 1000-2000 доллар хожиж, ширээнээс ширээ рүү нүүх болгонд нь дагаж очин зориуд түүний эсрэг тоглосоор эцэст нь будаа болгосон доо.

•••

Би ширээ цэвэрлэгчээр зургаан сар орчим ажилласан. Өглөө ажилдаа ирэх орой тарах болгондоо покерын ширээний дэргэдүүр өнгөрдөг байлаа. Би сайн ажиллаж байсан учир тушаал дэвшиж ажилчдын ширээг цэвэрлэдэг болов. Тэнд байхдаа Пит захирал болон покерын дилерүүдтэй дотно харилцаатай болсон төдийгүй тэд ч надад бүгд сайн байдаг байлаа.

Нэгэн удаа би боссдоо хандаж "Би бараг 21 хүрч байна. Надад покерын ширээний дилерээр ажиллах боломж бий болов уу?" гэж түүнээс асуусан юм. Түүний найз нь покерын сургуультай байсан тул тэрээр "Би найзаасаа асууж өгье" гэлээ. Харин тэрхүү сургалтын төлбөрийг би бие дааж төлөх ямар ч боломжгүй байсан учир захирал маань "Би чиний сургалтын төлбөрийг өгье. Дараа дилерийн ажилд орохоороо төлөөрэй" гэснээр би өглөө дилерийн сургуульдаа явж өдөр дөрөв хагасаас ажилдаа очдог болов.

Хорин нэгэн нас хүрснийхээ дараахан би "Холидэй Ин казино"-д Техас Холдемын дилерын ажил хийхээр болсон юм. Дилерээр ажиллаж тоглогчдыг ажиглаж байхдаа тэдний өсгөж, хуурч, эргээд, өсгөж байгааг нь хараад "Энэ хүмүүс ямар муу тоглодог юм бэ. Хэрвээ би тогловол бүгдийг нь хожих юм байна" гэж өөртөө хэлдэг байлаа. Удалгүй би зөвхөн дилер хийгээд зогсох биш өөрөө тоглохыг ихэд хүсэх болов. Чингээд л бага багаар мөнгө хадгалж, покер тоглох хуримтлалаа цуглуулж эхэлсэн. Өмнөхөөсөө бүр ч илүү, хэмнэлттэй амьдарч эхлэв. Тэвчээртэйхэн хүлээж мөнгөө хадгалсаар, покер тоглох боломжоо тэсэн ядан хүлээх болов.

Миний покерын алхам нухацтай бодож байж шийдвэр гаргалгүйгээр нэгэн үл бүтэх нөхөр нэлээд өдөөн хатгасны үндсэн дээр гэнэт тэсэрч гарсан юм. Би үргэлж покерын ширээнд дилер хийсээр байсан. Дог Далтоны покерын дилерийн хэсэгт багтдаг байлаа. Мөн хэсэг хугацаанд "Тахой нуур"-т дилер хийдэг болсон тул нэгэн өдөр гэнэт нэг залуу миний ширээн дээр ирж намайг өдөж эхлэв. Тэрбээр өдөр болгон миний ширээн дээр ирж тоглодог болсон бөгөөд намайг хэл амаар доромжилж, өдөөн хатгаж, миний вьетнам гарал, арьсны өнгөөр тохуурхан даажигнадаг болсон. Харин би түүнийг нь огтхон ч тоохыг хүсэхгүй байсан хэдий ч тэрээр байнга ирсээр байлаа.

Нэгэн үдэш энэ бүхэн дээд цэгтээ хүрч, би маш их уурлаж, ширээн дээр байсан бүх хасааг түүний нүүр рүү цацаж талын нэг тараан хаяад "Чамд нэг юм хэлье. Чи дилер бол. Маргааш би чиний үйлчлүүлэгч болж ирье. Тэгээд чиний ширээн дээр тоглохдоо чамд ёстой нэг үзүүлээд өгнө" гэв. Би өөртөө ийнхүү амлаад ажлаасаа гарч одов.

Маргааш өдөр нь амласан ёсоор хүрч ирээд нөгөө залууг хүлээв. Хэсэг хугацааны дараа тэр ирсэн. Амалсан ёсороо би түүний ширээн дээр тоглож түүнийг ёстой хоосруулж өгсөн юм. Хэдэн өдрийн дотор би түүнээс 1000-2000 доллар хожиж, ширээнээс ширээ рүү нүүх болгонд нь дагаж очин зориуд түүний эсрэг тоглосоор эцэст нь будаа болгосон доо. Тэр өдрийг хүртэл би мэргэжлийн покерчин болно гэж өрөөсөө төсөөлж ч байгаагүй. Хэрэв тэр новш хүрч ирж миний уурыг хүргээгүй бол цаашид юу болохыг би мэдэхгүй л байх байлаа. Би покер тоглохдоо тэр залуутай өөр зорилготой тоглодог байлаа. Тэр залууг би зүгээр л нэг хожих гээгүй, түүнийг бүр нам дарахыг хүсч байсан юм. Тэр залуу над дээр ирж надад ингэж их нөлөөлөөгүй бол магадгүй би өнөөдрийг хүртэл дилер хэвээрээ байх байсан болов уу.

Нэмж хэлэхэд тэр залууд баярлалаа гэж хэлэх ёстой байх. Түүний нэрийг би мэдэхгүй ч тэрбээр шууд бусаар миний амжилтад нөлөөлсөн юм.

Хэсэг хугацаанд "Тахой нуур"-т тоглож байгаад Лас Вегаст ирэхдээ би 15 мянган доллартай болсон байлаа. Эргэж ирэхдээ Боб Ступакийн "Вегасын ертөнц" казиногийн талаар сонссон ч урьд өмнө тэмцээнд ер оролцож байгаагүй билээ. Тэгээд л тэмцээний талаар уншиж

сонирхпоо. Тэр үед 1000 долларын бооцоотой хязгаартай Омаха тул дахин худалдан авалт хийж болохоор байв.

Тэмцээнд оролцохгүй байх хоёр шалтгаан байсны нэг дэх нь урьд нь тэмцээнд огт оролцож байгаагүй, хоёр дахь нь би Омаха тоглож үзээгүй байсанд оршино. Байнга шахуу хожиж өөртөө итгэл дүүрэн байсан тул би тоглож үзэхээр шийдэв. Тэмцээний талаар би суралцсаар байлаа. Нийтдээ дөрвөн удаа дахин худалдан авалт хийсэн санагдаж байна. Гэсэн хэдий ч хүмүүсийг буулган авсаар шувтаргын тоглолтод домогт покерчин Сэймүр Либовицтэй тунаж үлдсэн юм. Тэрбээр "Хөөе. Скотти чи бооцоогоо хуваахыг хүсч байна уу?" гэв. Би түүний юу гэж хэлснийг ер ойлгосонгүй. Тэрбээр үргэлжлүүлэн хэлэхдээ "Шагналын мөнгөө 50:50-аар яг одоо хувааж авах уу, тэгээд цомын төлөө ганцхан л тоглоё гэлээ.

Би түүнд хандаж "хуваахаар хэд оногдох юм бэ?" гэхэд тэрээр "85 мянган доллар" гэлээ. Хариуд нь би "Юу. тус бүртээ юу?" гээд түүнд бараг итгэсэнгүй. Тэрбээр "Тийм ээ" гэхэд нь "За тэгвэл хуваацгаая" гэж билээ. Би мөнгөө аваад бэлэн мөнгөний тоглоомд тоглох болсон төдийгүй хожил дараалан ирсээр байлаа. Тэр үед хүн болгон надтай тоглохыг хүсч байв. Би урьд нь ер сонсч байгаагүй тоглоомуудаар тоглож үргэлжлүүлэн хожсоор байлаа. Хөзрөн тоглоомноос салалгүй тоглосоор байгаад арван нэгэн хоногийн дотор 700 мянган доллар хожив. Мөн шоо тоглож нэг оройдоо 30-40 мянган доллар хожсон.

Ийнхүү үргэлжлүүлэн хожсоор миний мөнгө нэг сая илүү долларт хүрэв. Дөнгөж 23 насандаа би ихэнх хүмүүсийн амьдралдаа хийгээд ч барахгүй их мөнгөтэй болсон байсан.

1985 оны үед нэг шөнө л гэхэд 3000 долларын үнэтэй өрөөнд амьдардаг байлаа. Бас ихэнх хүмүүсийн жилдээ олдог мөнгөөр би зөвхөн ширээн дээр нэг удаа л мөрийцдөг болсон доо.

Гурван сарын дараа би байгаа бүхнээ алдав.

Тэр бүгдийг би шооны ширээн дээр алдсан юм. "Цезарь палас"-т зөвхөн дөрвөн цагийн дотор нэг сая доллар алдаж байсан нь маш хүнд сургамж туршлага болсон юм.

Би өөрийнхөө омогшлыг дарж эргээд ажилдаа оров. Хуучин захирал болох "Холидэй Инн казино"-гийн менежер руу залгаж "Би дилерийн ажлаа хийж болох уу" хэмээн асуусан юм. Хүмүүст би 400-500 долларын цайны мөнгө өгдөг байснаа 60-80 долларын цайны мөнгө өгдөг болж сүүлдээ бүр би өөрөө 1-2 долларын цайны мөнгөний төлөө эргээд ажиллахад хүрэв. Тэр бол маш үнэтэй хичээл байсан тул би мөнгөө хадгалж эхлэв.

Хоёр сар дилер хийсний дараа 270 долларын чек авсан бөгөөд түүнээс хойш дахиж дилерийн ажил хийгээгүй юм. Ингээд бага бооцоотой тоглолтуудад оролцох болж төдийгүй нэгээс хоёр, хоёроос дөрвөн долларын ширээн дээр тоглож мөнгөө аажмаар өсгөж эхэлсэн дээ. Ингэхдээ намайг танихгүй жижиг газруудад очдог байлаа. Гэсэн ч олсон хэдийгээ эргүүлж алдсан юм. Тэр бүхний эцэст мөнгөө хамгаалах талаар их зүйл сурч дахин эргэж хараагүй дээ.

Заримдаа нэлээд хүндхэн байдалд орсон үедээ покерын найзуудаасаа мөнгө зээлдэг байв. Гэхдээ зээлээ үргэлж эргүүлэн төлдөг байлаа. Хэн ч миний араас мөнгөө авахаар нэхэж

хөөцөлддөггүй байлаа. Би хүнээс зээлчихээд тэр дороо төлж чадахгүй бол гэрийнх нь үүдэнд очиж өөрт байгаа мөнгөө өгөөд үлдсэнийг нь удахгүй өгөхөө амлаж, тэгээд ч удалгүй төлдөг байв.

Миний амьдралд хамгийн чухал бөгөөд сонин өдөр 1998 оны 5 дугаар сарын 11-нд тохиосон юм. Тэр өдөр хамгийн гайхалтай мөртлөө хамгийн гунигтай өдөр байсан. Энэ өдөр би Покерын дэлхийн цуврал тэмцээний Main Event-д ялж нэг сая долларын шагнал хүртсэн нь түүхэнд байгаагүй аугаа том шагнал байлаа. Тэр үеэс хойш бүх дэлхий даяар Скотти Нгуений талаар мэддэг болсон юм.

Сүүлийн тоглолтод Кэвин Мак Брайдтай тулсан. Надад боол 9 ирж, газарт мод эргэхээс өмнө Кэвин бооцоог өсгөхөд би дуудав. Газарт 9-9-8 эргэсэн. Би гурван ес боллоо хэмээн бодоод чек хийхэд тэрбээр бооцоог 120 мянгаар өсгөж дуудав. Дараачийн хөзөр 8 байсан бөгөөд тэрбээр 240 мянган доллараар мөрийцсэн юм. Би дараачийн нүүдлээ бодож түүнийг жаал хүлээлгээд бооцооны дараа би дахиж дуудав. Сүүлийн хөзөр дахин 8 эргэв. Газарт бүл хаус гарч миний 9 мод газарт байсан бүл хаусаас илүү болсон байв.

Би Мак Брайдын өрсөн хасааг харахад түүнд 470 мянган долларын хасаа байлаа. Би босч хашгирах зуур "Бүгдийг оруулаа" гэхэд Кэвин тун болгоомжтойхон миний бооцоо руу харж хэрхэхээ бодож байх хооронд нь би покерт хамгийн алдарт хэллэг болох "Кэвин, хэрэв чи дуудвал би чамайг зүйл дуусгалаа" хэмээн орилсон юм.

Маш олон сайн покерчид өөрсдийгөө хамгийн шилдэг нь гэж өргөмжилдгийг би мэднэ. Гэвч хэзээ нэгэн цагт би хамгийн шилдэг тоглогчоор дуурсагдах биз ээ.

Мак Брайдыг дуудахад би гараа өргөж, "Гүйцээ. Би яллаа" хэмээн баярласан юм. Тэр үед би хамгийн аз жаргалтай нэгэн байсан төдийгүй хэдэн цагийн дараа миний хамгийн бахархалт орой хамгийн гамшигт үдэш болж хувирав. Би Вьетнам руу залгаж гэрийнхэнтэйгээ энэхүү баяраа хуваалцахад манай хамгийн бага дүү хөөрөн баясч, надаар бахархан хот даяар давхиж миний талаар найз нөхөд, хамаатнуудад мэдээ тараасан юм билээ. Тэгээд эргээд гэртээ харих гэж яваад ачааны машинд мөргүүлж нас барсан юм. Түүнээс хойш миний хувьд тэр тэмцээнд ялсан нь утга учиргүй зүйл болон хувирсан. Хэрэв би ялаагүй бол Данг одоо хүртэл амьд байх байлаа. Ийм учраас би 1998 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний бугуйвчийг зүүдэггүй юм. Тэр цагаас хойш арван нэгэн жил өнгөрсөн ч би одоо ч тэр гамшгийн тухай бодох бүртээ уйлдаг.

Тэр гамшгаас хойш гэр бүлийнхэн гэдэг ямар чухал болох талаар их зүйлийг ойлгож, заримдаа сэрүүн хэвтэж байхдаа хэн нэгэнд маань ямар нэг юм тохиолдоогүй байгаа даа, хэрэв тэдэндээ тусалж амжихгүй бол яана даа хэмээн халаглан бодох болсон доо.

Би өөрийн эхнэр Жүлиятэй дөрвөн жилийн өмнө танилцах үед бидний уулзалт жинхэнэ тохиолдлын аз байсан юм. "Беллажио"-гоос надад боксын дөрвөн тасалбар өгсөн байлаа.

Бүгд л рингийн яг хажуу талд, бараг хувцасан дээр тамирчдын хөлс, цус үсэрч унахаар ойрхон тийм зайнаас үзэх суудал байв. Би тэр тэмцээн рүү очихыг үнэхээр их хүссэн. Яг тулааны өдөр явах гээд тасалбараа хайгаад олоогүй. Дахиж шинэ тасалбар худалдаж авахаар оролдсон

ч олддоогүй юм. Харин тэмцээн дээр очтол манай найз урд талын эгнээнд сууж байхаар нь би түүний хажууд очиж суув.

Тулааны үеэр суудлаа орхиод юм уухаар түр боссон хэрэг. Тэр үед мөрөн дээр тогштол эргэн харвал нэгэн үзэсгэлэнтэй бүсгүй надад хандаж "Та нөгөө мэргэжлийн тоглогчдийн нэг мөн үү?" гэв. Би түүнд тэр дор нь "Тийм байна, хонгор минь" гэтэл тэрээр "Би Окпахомагаас амралтаараа явж байна. Миний найз таны гарын үсгийг авахыг хүссэн юм" гэдэг байгаа. Би түүнд гарын үсгээ зурж өгөөд хэсэг хугацаанд түүнтэй ярилцав. Нэрийг нь Жүлия гэдэг. Үл хөдлөх хөрөнгийн бизнес хийдгийг нь мэдэв. Тэгээд түүнээс явж юм уух уу гэхэд тэр эелдэгхэнээр татгалзаж би уудаггүй гэлээ. Тэгэхээр нь тулааны дараа "Фонтана" уушийн газарт уулзъя гэхэд тэр бас л татгалзсан хариу өгөв. Сүүлд нь би түүнд утасныхаа дугаарыг өгөөч гэхэд нэрийн хуудсаа өгч билээ.

Би эргэн ирж суудалдаа суусан боловч өөртөө сэтгэл их дундуур байлаа. Хэдэн хормын дараа эргэн хартал, тэр яг миний ард сууж байв. Тулааны дундуур хэдэн удаа түүн рүү залгасан ч тэрээр тоглолт үзээд юун утсаа авах манатай байсан байх.

Сүүлд нь Жүлия буудалдаа очоод миний гарын үсгийг найздаа үзүүлтэл гаргац муутай байсан тул найз нь энэ хэний гарын үсэг вэ хэмээн асуухад нь мэдэхгүй ээ нэгэн алдартай ази тоглогч л байсан гэжээ. Хожим сонсоход түүний найз нь "Өө, Бурхан минь, чи Жонни Чантай уулзан юм уу" хэмээн халагласан гэдэг.

Ингээд л миний ирээдүйн эхнэр гэртээ харихдаа намайг Жонни Чан гэж бодсоор явсан юм билээ. Түүний дараахнаас эхлэн би түүний утсыг мессеж болон дуудлагаар ёстой дарсан боловч тэр ердөө хариу өгөөгүй. Харин тэрээр зурагтаар харж байгаад намайг Жонни Чан биш гэдгийг мэдсэн тул миний дуудлагыг авахгүй байсан юм билээ. Учир нь тэрээр интернэтэд орж намайг гэр бүлтэй болохыг олж мэдсэн тул холбогдохыг хүсээгүй ажээ. Гэтэл үнэн хэрэгтээ би аль хэдийнэ салсан байсан юм.

Би түүн рүү зогсоо зайгүй утасдаж, тогтмол мессеж үлдээж байлаа. "Би чамайг утсаа автал чиний мессежний хайрцгийг дүүртэл мессеж үлдээх болно" гэж мессеж бичин явуулдаг байлаа. Нэг өдөр сэтгэл нэлээд дундуурхан байх үедээ түүн рүү залгатал үүнийг тэр тааварласан уу яасан утсаа авлаа. Ингэхийн тулд би түүн рүү 90 өдөр залгасан даа. Түүний дараахан би өмнөх гэр бүлээсээ салсан болохоо хэлж, бидний харилцааны дараачийн шат нээгдсэн юм. Удалгүй бид гэрлэсэн. Би түүнийг эхнэрээ болгож авсандаа туйлын их баярладаг.

•••

Өнөөдрийг хүртэл ээж маань маш шаргуу ажиллаж бусад хүмүүст тусалсаар байгаа. Би ээжээрээ бахархдаг. Жилдээ гурван удаа Вьетнамд байгаа 6000 орчим гэр бүлд би хувийнхаа зүгээс санхүүгийн тусламж үзүүлдэг.

Намайг хөдөлж, амьсгалж, хөзөр тоглож байгаа цагт манай гэр бүлээс хэн нь ч орой дээрх дээвэр, ширээн дээрх хоол, өмсч яваа хувцсандаа санаа зовдоггүй юм. Учир нь өдөр тутмын хэрэгцээт зүйлсээс эхлээд амьдралын бусад асуудлыг шийдвэрлэх санхүүгийн хувьд би илүү

давж гарчихсан хүн. Энэ бүх зүйл намайг бүр бага байхад минь төрж байсан хариуцлагаа бүрэн ухамсарласны үр дүнд бий болсон юм. Би гэр бүл, Вьетнамд байгаа ахан дүүс, эх орон нэгтнүүдийнхээ төлөө байнга санаа тавьдаг. Энэхүү хүсэл мөрөөдөл надад төрсөн өөр нэг шалтгаан нь хүүхэд байхад ээжийн маань бидний амар тайван сайн сайхны төлөө зүтгэж байсан сэтгэлээс бас үүдэлтэй юм. Ээж минь одоо болтол миний мэдэх эмэгтэйчүүдээс илүү их ажилладаг учир би түүний төлөө бүхнийг хийхэд бэлэн байна.

Өнөөдрийг хүртэл ээж маань маш шаргуу ажиллаж бусад хүмүүст тусалсаар байгаа. Би ээжээрээ бахархдаг. Жилдээ гурван удаа Вьетнамд байгаа 6000 орчим гэр бүлд би хувийнхаа зүгээс санхүүгийн тусламж үзүүлдэг. Өнөөдөр Вьетнамын дундаж гэр бүл таван ам бүлтэй гээд үүнийг тооцож үзвэл 30 мянган гаруй хүнд жилд би хэд хэдэн удаа тусалж байгаа гэж бодохоор өөрөөрөө бахархах сэтгэл төрдөг юм. Вьетнамчууд ямар хүнд хэцүү амьдралыг туулж, хэрхэн аж төрж байгааг бас багахан мөнгө тэдэнд ямар их тусламж болдгийг америкчууд мэдэхгүй билээ. Энэ бүх зүйлийг би зөвхөн өөрийнхөө мөнгөөр хийдэг юм. Бусад хүмүүсээс сохор цент ч гуйдаггүй. Үүнийг би өөрийнхөө болон ээжийнхээ төлөө хийдэг. Ээж минь нэлээд хугацааны туршид Вьетнам даяар аялж, хаана ямар тусламж хэрэгцээтэй байгааг судалж, бас бидний тусламж яг эзэддээ хүрч байгаа эсэхэд хяналт тавьдаг юм.

Хобби гэвэл би хоол хийх дуртай. Олон хүн үүнийг сонсоод гайхах байх. Миний хувьд үхрийн махан кобе хоолыг эхнэртээ хийж өгөх хамгийн дуртай. Үүнийгээ би "Шоронгоос суллагдаж эрх чөлөөг мэдрэх шиг боллоо" хэмээн нэрлэж түүнтэй адилтгадаг. Учир нь заримдаа эхнэрээ гомдоосон үед намайг гэртээ ирэхэд хайр минь гал тогооны ширээн дээр кобе хоол хийх махыг ширээн дээр гарган тавьсан байдаг. Энэ бол миний л тавилан, би түүнийг тайвшруулахын тулд нөгөө л хоолоо хийх ёстой болдог. Намайг хоолоо хийсний дараа түүнийг бид хоёр хамтдаа хувааж идэх биш харин эхнэр маань бүгдийг нь ганцаараа идчихдэг юм. Ингээд би эрх чөлөөг мэдэрдэг. Түүнчлэн би гахайн мах болон тахианы махаар хоол хийх дуртай. Гахайн махаар хоол хийхдээ дараа нь идэхэд хутга, сэрээ хэрэглэхгүй байх хэмжээнд хүртэл тийм сайн хийдэг дээ. Гэртээ байх үедээ орой бүр шахуу би хоол хийдэг төдийгүй бас цэцэрлэгт хүрээлэнгээ арчлах дуртай даа.

Миний хувьд олон сайхан жилүүд покерын хувьд хүлээж байгаа гэдэгт итгэдэг. Би өөрийн үзүүлсэн амжилтаараа бахархдаг юм. Түүнчлэн маш сайхан ном бичих ёстой гэдгээ мэдэж байна. Маш олон сайн покерчид өөрсдийгөө хамгийн шилдэг нь хэмээн өргөмжилдөг. Гэвч хэзээ нэгэн цагт би хамгийн шилдэг тоглогчоор дуурсагдах нь дамжиггүй биз ээ. Хэрэв надад хамгийн шилдэг покерчин болно гэсэн зорилго байхгүй бол түүний төлөө тоглох эсэхээ хэлж мэдэхгүй байна. Хэрэв хаа нэгтээ дэлхийн шилдэг тоглогч хэн бэ гэдэгт мөрийцөх хэрэг гарвал би өөрийнхөө төлөө мөрийцөхөд бэлэн төдийгүй үүний төлөө байгаа бүхнээ "түлхэнэ". Тэгээд энэ тухайгаа "Хэрэв чи дуудвал бүх юм дуусаа. Хонгор минь" гэж хэлэх болно.

Түүний тухай мэдээллийг ThePrinceOfPoker.net сайтаас авч болно. Тэрбээр маш олон хандивын байгууллагатай хамтран ажилладаг төдийгүй ээжтэйгээ хамтарч Вьетнам дахь олон олон хүмүүст тусалсаар байгаа юм.



Крис Фергюсон

Лэйн Флэк бол хамгийн авъяаслаг, өвөрмөц төдийгүй өнөө цагийн хамгийн амжилттай тоглогч залуу покерчдын нэг юм. Тэрбээр Покерын дэлхийн цуврал тэмцээн болон Покерын дэлхийн аялан тоглолтод хоёуланд нь түрүүлсэн цөөхөн тоглогчдын нэг. Нийтдээ Покерын дэлхийн цуврал тэмцээний зургаан бугуйвчтай тэрбээр шагналд нь дөрвөн сая гаруй доллар хүртэж байжээ.

Түүний тоглолтын арга барил нь маш хурдан бас зоригтой тоглодог. Ямар ч айдасгүй тоглодог түүний хувьд хасаагаа бооцоонд түлхэхэд түүнд ямар ч асуудал байхгүй. Тэрбээр тоглох арга хэлбэрээ маш богино хугацаанд байнга өөрчилдөг учир өрсөлдөгчид нь түүнийг гартаа ямар модтойг тааварлах ямар ч боломж олдоггүй байна. Түүнчлэн бас нэг сайн

чадвар нь тэрбээр өрсөлдөгчөө маш сайн уншиж чаддаг. Зөвхөн хөзөр эргэсний дараа л сая дөнгөж бүгд түүнийг ойлгодог. Тэрбээр покерт маш аймшигтай тоглогч.

Гол хоёр тэмцээнд дараалж түрүүлсэн нь түүнд "Дахиад эргэж ирсэн Флэк" гэсэн хоч авахад хүрчээ. Тэмцээний тойрогт үргэлжлүүлэн үзүүлж байгаа түүний амжилтууд нь бусад мэргэжлийн покерчдын хувьд "Флэкийг барьж авна" гэдэг маш хэцүү төдийгүй нэлээн хугацаа шаардагдахтай адил болсон юм.

Миний намтар түүх ирээдүйн үеийнхэнд даган дууриах замнал болохгүй л болов уу. Би өөрийн амьдралдаа маш их амжилттай явж ирсэн боловч миний намтар түүхийг сонссон хэн боловч "би энэ л замналаар явна" гэж хэлэх хүн гарахгүй л болов уу. Надад мөнгийг хэдэн арван арван мянгаар нь олдог өдөр байхад түүнийгээ цагийн дотор алдаж байсан үе ч бий. Машинаа хэдэн өдрөөр хонож байсан тохиолдол ч зөндөө. Миний хувьд амьдрал маш хурдтай төдийгүй нэг бол тэнгэрт хүрмээр өндөрт гарч аль эсвэл газар дор ортлоо доош буурсан толгой эргэм явдлаар дүүрэн байсан. Зарим өдөр алдартай хүмүүс, хөөрхөн хүүхнүүдтэй хамт зугаацан цэнгэж байснаа өөр бусад өдөр нь хар тамхи хэтрүүлэн хэрэглэсний уршгаар амьд үхсэн нь мэдэгдэхгүй хэн ч тоохгүй амьтан болж хаягдаж байсан үе олон билээ.

•••

Зарим өдөр алдартай хүмүүс, хөөрхөн хүүхнүүдтэй хамт зугаацан цэнгэж байснаа өөр бусад өдөр нь хар тамхи хэтрүүлэн хэрэглэсний уршгаар амьд үхсэн нь мэдэгдэхгүй хэн ч тоохгүй амьтан болж хаягдаж байсан үе олон билээ.

•••

Гэвч энэ бүлэг сайхнаар төгсдөг. Цөхрөлтгүй чармайлт, өөрийгөө салгаж авах чадвар гэр бүл сайн найз нөхдийн тусламжтайгаар өөрийгөө сүйтгэж байсан хорт зуршил, нөлөөллөөс ангижирч амьдралынхаа удирлага хяналтаа эргүүлэн олж авч чадснаар, мэргэжлийн покерчин болон өсч дэвжсэн юм. Надад Покерын дэлхийн цуврал тэмцээний зургаан бугуйвч, Покерын дэлхийн аялан тоглолтын аварга гээд сайн сайхан дурдатгал миний түүхийг өгүүлэх энэ бүлэгт бий. Миний намтар 1969 оноос Өмнөд Дакотийн Рапид Ситигээс эхлэлтэй. Төсөөлөөд үз дээ. Таван настай жаал хүү өдөржингөө гартаа хөзөр барьж хаа явсан газраа хүмүүстэй тоглохыг хүсдэг байсан. Тэр бол би. Би хөзрөөр дамжуулан хүмүүстэй харилцдаг. Хаана ч явсан миний цүнхэнд хөзөр байна. Хаанаас ч тоглох хүн олдно. Харин тэгж явахыг манай гэрийнхэн, зарим найзууд маань хараад залхдаг байв. Долоон насандаа би покер, зүрх, жин, гил, канастер, пинокль, крибаж гээд олон тоглоомыг тоглож сурсан даа.

Манайх Рапид Ситид нэг жил гаруй амьдрал. Тэндээс Монтана руу нүүж тэнд ахлах сургуульд ортлоо амьдарсан юм. Тэгээд эргээд Өмнөд Дакотад ирж коллежид оров.

Би аавтайгаа дөрвөн настайгаасаа эхлэн тоглосон юм. Манай ах, эгч нар тоглоом тоглож сурахыг хүсдэггүй байсан нь надад их сайхан завшаан болдог байлаа. Би зөвхөн аавтайгаа хамт хоёулхнаа тоглохыг ихэд хүсдэг байсан боловч тийм боломж маш ховор тохиолдоно. Аавгүйгээр өснө гэдэг маш хүнд байв. Тэрбээр ихэвчлэн гэртээ байдаггүй. Тэр үед аав маань

залуухан дөнгөж 26 настай, дөрвөн хүүхэдтэй байлаа. Гэр бүлээ тэжээхийн тулд долоо хоногийн зургаан өдөр заримдаа долоон өдөр ажилладаг байсан. Тийм байхад түүний анхаарлыг татаж хөзөр тоглоно гэдэг нэлээд хүндрэлтэй байлаа. Гэсэн ч би түүнийг дандаа оролддог байв. Хүүхдийн бэйсболын лигт тоглодог байхад хүүхдүүд дандаа аавгайгаа хамт ирнэ. Харин манай аав хэзээ ч ирж байгаагүй. Хэрэв түүнд цаг гарвал түүнтэй хамт хөзөр тоглох нь хэвийн үзэгдэл байсан.

•••

Надад хос туг байлаа. Дөрөв дэх хөзөр бас туг эргэв. Өрсөлдөгчид маань харин хос найм байлаа. Түүнийгээ дээш харуулан дэлгэн тавихад, тэрбээр бооцоогоо өсгөж түүний хариуд би дуудав. Би түүний хос наймыг харж байсан. Миний хийж чадах ганц зүйл нь дуудах гэж үү?

•••

Миний өрсөлдөөнч сэтгэхүй мэрийлт чармайлт аавтай их холбоотой. Тэрбээр их завгүй ихэнхдээ явчихдаг байсан болохоор би түүний анхаарлыг татахын тулд заавал их том зүйл хийх хэрэгтэй гэж боддог байлаа. Ингэснээр түүний анхаарлыг татаж, нэлээд удаан хугацаанд түүнтэй хамт байх боломж олддог байв. Үүний тулд өөрийгөө улам сайн болгохын тулд өөрийгөө маш их шахдаг болов. Нэгэн удаа арван хоёр настайдаа бид боулинг тоглож байхад аав найзуудтайгаа хамт ширээнд сууж байлаа. Би тав дараалан унагаасан юм. Дараа аав дээрээ ирж хэлэхэд тэр бараг эргэж хараагүй. Түүний дараа зургаа бүр долоо дараалан унагаасан. Аавынхаа анхаарлыг татахын тулд ямар ч хэцүү зүйлийг хийхийг би оролддог байлаа.

Бага байхдаа хөзрөөр маш их тоглодог ч мөнгөөр их ховор тоглодог байсан. Хааяа хэсэг хүүхдүүдтэй нийлж тав арван центээр тоглоно. Харин гэртээ болон ахлах ангид байхдаа мөнгөөр биш зугаа болгон тоглодог байсан. Ахлах сургуулиа дүүргэсний бид Монтана руу нүүснээр анх удаагаа мөнгөөр тоглож үзэв. Монтанад хаа сайгүй казино бий. Тэнд мөнгөний машинуудыг эгнүүлэн тавьсан байдаг. Би тэндхийн нэг зоогийн газар казинод ширээ цэвэрлэгчийн ажилд орлоо. Зургаан сарын дараа шөнийн менежер болов. Зоогийн газрын эзэн покерын өрөөтэй болох бодолтой байгаагаа хэлэхэд нь би түүнд нь оролцохыг их хүсэв. Тэгээд "Энэ ажлыг яаж хийх талаар би судлаад ирье" гэв. Судалгааны гол хэсэг нь өөр нэг казинод очиж нэгээс гурван долларын ширээнд покер тоглож тэр бизнесийг яаж хийдгийг мэдрэх хэрэгтэй болов.

Анх удаагаа покерын ширээнд сууж маш их сандарч байлаа. Өрсөлдөгчиддөө үүнийг илт мэдэгдүүлж байлаа. Миний эхний зорилго бол дөнгөж эхэлж байгаа хүн шиг бусдад харагдахгүй, тэвдэж сандарсан байдлаа өөрөөсөө авч хаях хэрэгтэй байсанд оршино. Би тэр бизнесийг сурахыг хүсч байсан болохоор бусад покерчдын асуудгаас өөр сонин асуултууд тавьж байлаа. Тэгээд би зөвхөн тоглох гээгүй ээ, энэ бизнесийг сонирхож байна гэдгээ хэлэв. Хэрэв покерын өрөө шинээр хийвэл юунд анхаарах вэ, яаж тоглодог нь судлах хэрэгтэй байна гэв.

Ингэж хэлэх хэрэггүй байсан боловч эхний туршлага судлал маань тааруухан өндөрлөв. Би

аймаар ичгэвэртэй тоглов. Нэг тоглолтонд надад хос туг байсан. Дөрөв дэх хөзөр бас туг гарав. Өрсөлдөгчид маань харин хос найм байлаа. Түүнийгээ дээш харуулж дэлгэн тавихад тэрээр өсгөсөн түүний хариуд би дуудав. Би түүний хос наймыг харж байсан. Миний хийж чадах ганц зүйл нь дуудах гэж үү?

Тэр залуу надад хандан "Хүү минь. Чи юунд дуудаж байгаа юм бэ, чи бооцоогоо өсгө эсвэл хая" гэхэд нь Тийм ээ. Түүний зөв гэдгийг мэдэж байсан ч "Би хуурч болох талаар л бодож байв. Гэхдээ энэ сайн болсонгүй" гэж хэлсэн нь миний хувьд Покерын дэлхийн цуврал тэмцээнд оролцох яагаа ч үгүй байгааг харуулсан хэрэг болов.

Хэсэг хугацааны дараа покер тоглохдоо өөртөө нэлээд итгэлтэй болж өөр ширээн дээр тоглох болов. Тэнд байх хугацаандаа тоглохын хажуугаар судалгаагаа хийж байлаа. Сүүлд нь өөрөө покерын ширээн дээрээс мөнгө хийж болохыг харсан юм. Удалгүй нэгэн хүн покерын өрөө түрээслэхээ болих гэж байгаа гэсэн мэдээг сонсоод надад тэр боломжийг ашиглах санаа төрөв. Тэр өрөөг түрээсэлж покерын дилер хийж эхэллээ. Би сайн дилер байсан төдийгүй дундын сан 300 доллараас хэтрээгүй бол ямар ч тоглоомд дилер хийдэг байв. Бас үйлчлүүлэгчдийнхээ талаар сайтар мэдэх хэрэгтэйг ч ойлгосон. Тэд яг юу тоглохыг хүсч байна түүнийг нь тоглуулахыг боддог болов. Энэ нь дунд сургуулиас коллежид орох хооронд маш зөв шилжилтийн ажил болсон доо. Өмнөд Дакотийн их сургуульд ортлоо покерын дилер хийв.

Би коллежид сайн оюутан байгаагүй гэдгээ эхлээд хэлье. Эхний хоёр жилийн сургалтын төлбөрөө покер тоглож олсон мөнгөөрөө төлөв. Нэг өрөөнд цуг амьдардаг хүүхдүүдтэйгээ хамт хавар намрын улиралд покер зохион байгуулдаг байлаа. Зуныхаа амралтаар Дийдвүүдэд покерын дилер хийж, түүнийхээ хажуугаар тэндхийн тэмцээнүүдэд оролцон мөнгө олдог байлаа. Эргээд сургуулийнхаа өмнө ирэхэд миний түвшин аймшгийн байв. Энэ бол нэг их гайхамшигтай зүйл биш. Би хэзээ ч хичээлдээ яваагүй. Би түүнийг хэрэгтэй гэж тоогоогүй. "Би бизнесийн удирдлагыг сурахаар сургуульд суралцаж байлаа. Гэвч би сургуульд анх ирэхээсээ л өөр зүйлд суралцаж байсан. Бизнесийн туршлага, их сургуулийн боловсрол хоёрын аль нь илүү вэ?" гэж би дотроо бодов. Ингээд би шийдвэрээ гаргаж, сургуулийн танхимд сууж суралцахаа орхиж покерын дилер хийж бас хажуугаар нь тоглохоор шийдэв. Сургуулиа хаясан тэр үедээ покерын дилер болохоор Дийдвүүдэд дадлага хийж байсан нэгэн охинтой танилцсан байлаа. Түүнийг Энжи гэдэг бөгөөд тэрээр Пеппермил казиногийн тэмцээнд дилер хийж байв. Бид Невада руу хамт явахаар болов. Тэрээр дилер хийж, би тэмцээнд оролцож байлаа. Ингэж аялахын хажуугаар би бас өмнө тоглож байгаагүй том бооцоот тоглоомд, тодруулбал 20-40 долларын тоглолтуудад оролцох болов. Тэмцээн дууссаны дараа бид Ренод хэсэг хугацаанд байв. Тэр хавийн жижиг тэмцээн болон бэлэн мөнгөний тоглоомд гайгүй сайн оролцож 2000-3000 доллартай болов. Хэдий тийм байсан ч бүх мөнгөө алдахад их ойрхон байлаа. Гэсэн хэдий ч покер тоглож эхэлж байх тэр үедээ би мөнгөө ширээний гол руу түлэхэдээ огт айдаггүй байлаа. Ялангуяа зарим нэг сайн сард 10 мянган доллар олдог байв.

Бид Ренод жил гаруй болов. Тэнд байх хугацаанд охин Хали 1995 онд төрөв. Түүний дараагаас бид Монтана руу нүүж гэр бүлийнхэнтэйгээ ойр байхыг бодсон юм. Эргэн очиж дахин нэг өрөө түрээсэлж покер тоглуулж эхлэв. Гурван жилийн дараа бидний харилцаа

тасарч, Энжи охиноо аваад явав. Халияг өгөөд явуулна гэдэг маш хэцүү байсан ч ээжтэйгээ хамт байвал дээр гэж бодов. Надад Монтанад хорогдоод байх зүйлгүй болсон болохоор Лас Вегас явж томоохон тэмцээнүүдэд хүчээ үзэхээр шийдсэн. Тэндхийн "Покерын сонгодог шилдгүүдийн танхим" ("Hall of Fame Poker Classic")-fi болдог 1500 долларын хязгааргүй Холдемийн тэмцээнд нүд унагав.

•••

Манай гэрийнхэн намайг Монтанагаас ирсэн нэгэн хөдөөний жаалыг том хот зажлахгүй залгина. "Чи тийшээ очиж чадахгүй, тэнд чамд ажил ч олдохгүй" гэж хэлж байлаа.

•••

Лас Вегас руу явна гэдэг миний хувьд том асуудал байв. Энэ талаар би гэрийнхэнтэйгээ жил гаруй зөвлөлдөв. Тэд намайг аль болохоор явуулахгүй байх талаар ятгаж байлаа. Тэр үед би Монтанад ширээ ажиллуулдаг байсан ч манай гэрийнхэн намайг Монтанагаас ирсэн нэгэн хөдөөний жаалыг том хот зажлахгүй залгина. "Чи тийшээ очиж чадахгүй, тэнд чамд ажил ч олдохгүй" гэж хэлэв. "Хүү минь, чи юуны тухай бодож байна вэ?" Гэвч эцэст нь би тэдний юу бодож байгааг огт тоолгүйгээр тэндээс явахаар шийдсэн юм.

Тэгээд л явахаар болсон доо. "Юу л болоо аж. Энэ бол амралт" гэж өөртөө хэлээд үлдэх ямар ч сонирхолгүй байсан болохоор тэмцээндээ оролцохоор яарч хэсэг нөхдийн хамт замд гарав. Би хоёр мянга гаруй доллартай байв. Энэ бол Монтанад бол их мөнгө. Лас Вегаст очсоныхоо дараа тэмцээнд орохын тулд нэмж мөнгө олох хэрэгтэй болсон учир дагуул тэмцээнүүдэд оролцож эхлэв. 1500 долларын тэмцээнд оролцсон боловч амжилт олсонгүй. Тэгээд 20-40 долларын тэмцээнд оролцохдоо сүртэй эхлээд нам болов. Амжилт гаргаж чадаагүй тул бүх мөнгөө алдав. Гэрийнхнээсээ 1000 доллар банкаар гуйвуулж авсан. Энэ удаа аз гийж өөр нэг тэмцээнд оролцож 68 мянган доллар хожив. Үүгээр дуусаагүй тэр мөнгөө авангуутаа шууд 300-600 долларын Омаха их бага тэмцээнд Сэм Гризл, Жонни Чан, Чөтгөрийн загас хочит Дэйв Уллиот нартай хамт өрсөлдөн түрүүлж, нэмж 26 мянган доллар хожив.

"Лас Вегасын эргэн тойронд тэд одоо хэрэм босгосон учраас түүнийг би хэзээ ч давж гарч чадахгүй" хэмээн би бодов. Лас Вегасын амьдралын түргэн хэмнэл, их мөнгөний амтыг мэдэрсэн надад эргээд хөдөө очно гэдэг ч бас төсөөлшгүй зүйл мэт байсан. Би Монтана руу богинохон бас маш хурдан аялал хийлээ.

Тэнд очоод зарим өрөө дарж хэсэг найзууддаа санхүүгийн тусламж үзүүлээд таван сарын дараа хамаг юмаа машинд ачиж шинэ гэр рүүгээ нүүв. Тэр бол Лас Вегас аль эсвэл дампуурал байлаа.

Үнэхээр ч тэр бол Лас Вегас аль эсвэл дампуурал байсан. Хотод ирсний дараа бүх юм гайхалтай эхлэв. Дөрвөн сарын хугацаанд гурван тэмцээнд шувтаргын тоглолтод тоглосноос 500 долларын хязгааргүй Холдем Покер багт наадам (Car nival of Poker) тэмцээнээс 64 мянган доллар хожив. Покерын дэлхийн цуврал тэмцээний 2000 долларын хязгааргүй Холдем тэмцээнд хоёрдугаар байрт орж 133 мянган доллар хожив. Мөнгө хийх нь миний хувьд асуудал биш байсан.

Миний асуудал бол Лас Вегаст байхдаа бий болсон дур сонирлоо хянаж чадаагүй явдал байлаа. Тэр хотын хар талруу уруу татагдав. Би яг л Өмнөд Дакотийн жаахан хүүхэд шиг байв. Архи, хар тамхи, хүүхэн, одод бас маш их мөнгөтэй харьцаж мэдэхгүй байлаа. Тэр бүгдэд ямар ч бэлтгэлгүй байснаас хаашаа л бол хаашаа хамаагүй тэднийг дагаж явдаг амьдралын хэвшилтэй болсон байв. Би шаргуу тоглодог хэд хэдэн хүмүүстэй их дотносч, тэдэнтэй нийлж хамтдаа шөнийн цэнгээний газраар зугаалж архи, хүүхэн, хар тамхи хэрэглэх болов. Ингэснээр маш олон удаа байснаа алдаж дампуурч байлаа. Монтанад байсан миний эргэн тойрны хүмүүс иймэрхүү авир гаргадаггүй байв. Хар тамхины тухайд бол огт байхгүй. Би хэдэн хүнийг хүндлэн тэдэнтэй нийлснээр уруу татагдсан. Тэдэнтэй хамт хар тамхи нэлээд хэрэглэх болов. Эхэндээ хааяа хэрэглэдэг байснаа сүүлдээ гүнзгий орж тун удалгүй бүр донтож маш ихээр хэрэглэх болов. Хар тамхи гэдэг чөтгөр бараг намайг бүрмөсөн сүйрүүлэх дөхсөн дөө.

Сүүлдээ маш олон удаа нурж унах шахсан дэн буудалд шөнийг өнгөрүүлж байлаа. Заримдаа хямдхан буудлын мөнгийг төлж чадахгүй болохоор хамгаалагчид намайг хөөн гаргахаар нь машины зогсоол дээр юм уу, эсвэл машин дотроо хонодог байв. Нэгэн удаа томоохон тэмцээний өмнөхөн дүүгээ над руу 40 доллар явуулахыг шаардаад түүгээр хоол авч идэв.

Би покер тоглож хожсон мөнгөө казиногийн бусад тотлоомуудад алддаг байсан. Зарим нь эмгэнэлтэй, зарим нь бүр инээд хүрмээр олон тохиолдол бий. Нэгэн удаа Люксор гэдэг газар би сүүлийн 10 мянган доллараа бакарат тоглож алдав. Бакарат болон бусад тоглоом тоглохын тулд боломжийн хэмжээнд тэдгээр тоглоомын тухай үндсэн мэдлэг ойлголттой байх хэрэгтэй. Гэвч надад ямар ч ойлголт байсангүй. Би зүгээр л мөрий тавин юу болохыг нь хүлээдэг байлаа. Тэгээд л би мөнгөө алдсан. Тийм л юм болсон доо.

•••

Би хэдэн хүнийг хүндлэн тэдэнтэй нийлснээр уруу татагдсан юм. Тэдэнтэй хамт хар тамхи нэлээд хэрэглэх болов. Эхэндээ хааяа хэрэглэдэг байснаа сүүлдээ гүнзгий орж тун удалгүй бүр донтож маш ихээр хэрэглэх болсон доо.

•••

Лас Вегас дахь маш их дур сонирхлоо хяналтад байлгахын тулд би их хугацаа зарцуулав. Одоог хүртэл их болгоомжтой ханддаг. Гэнэн итгэмтгий хүмүүст Лас Вегас бол маш аюултай газар гэдгийг хүмүүс тэр бүр мэддэггүй. Хэрэв хэн нэгэн шинэ тоглогч Лас Вегасын талаар хэлж өгөөч гэвэл "Чи Лас Вегаст очуугаа хамгийн түрүүн "акулууд"-тай мэндэлнэ. Чамайг унтаж байх хооронд чинь тэр аварга махчин загаснууд хотын гадуур тор татах болно. Чи түүнээс гарах юмсан гэж бодохгүй, түүнээс гарсан ч чи чадахгүй. Чи бол далайгаар дүүрэн байгаа аварга махчин загаснуудын дундах нэг цорын ганц далайн нохой юм. Лас Вегаст очуут маш олон махчин загасыг олж харна. Чи тэдэн шиг болохыг хүснэ. Казиногийн гадуур алхах дэгжин хувцасласан, алт мөнгөн гинж, бөгж зүүсэн араатнуудыг хараад чи тэдэн шиг болохыг мөрөөднө. Чи покерын дилер, тэдний эздийг махчин загас гэж бодож байгаа бол эндүүрч байна. Тэнд байгаа хүүхнүүд хүртэл махчин загаснууд. Ер нь маш олон төрлийн махчин загас бий. Тэд бол махчин загаснаас өөр юу ч биш. Тэд чамд яаж ойртох, чамаас юу авахаа бүгд мэднэ. Тэднийг ч чи хүснэ. Чи тэр бүхнийг адал явдал, овсгоотой хэрэг гэж бодно. Тэгээд ч

ихэнх иймэрхүү хүмүүс тэр бөмбөгийг өшиглөхийг л боддог. Чи ч бас тэгнэ. Дараа нь өөрийнхөө тэнэг байдлаас болж чи хэтэрхий даврах бөгөөд эцэст нь мөнгө төлөх болно" гэдэг.

Лас Вегас хүнд их олон хичээл заадаг. Тэр боловсролын үнэ бас их өндөр шүү. Нэгэн Зул сарын баярын орой би 200 мянган доллар бүхий спортын тэмцээний бооцооноос болж алдсан юм. Чи өөрөө өөрийгөө хамгаалах аргыг заавал олох хэрэгтэй. Өөрийгөө хэн бэ гэдгээ мэдэж ав, тэгээд мэдээллийг өөртөө давуу тал болгон ашиглах хэрэгтэй. Хэзээ чи өөрийгөө мэднэ тэр үед чи өөрийн бүх алдаа дутагдал, муу зуршил, сул тал, хүч чадлаа мэдэрч өөрийгөө хамгаалах боломжтой болж, өөрийнхөө амьдралыг урагшлуулахад суралцах болно.

Лас Вегаст амьд үлдэхийн тулд би нэг л зүйлийг их зөв хийсэн. Тэр нь би хэзээ ч дайсантай болж байгаагүй. Би Монтанад өссөн болохоор хүмүүстэй харилцах харилцаагаа бэхжүүлэхийн чухлыг мэдэрч бас бусдыг хүндэлж сурав. Хэрэв ингэж чадвал бүгд чамтай яг тэгж харьцана. Гэхдээ өөр ч байж болно, жишээ нь банкинд байгаа мөнгө шиг байж болно. Чи хүмүүстэй харилцаа тогтоохдоо хэзээ тэд чамд хамгийн хэрэг болно тэр үед уулздаг шиг ижилхэн байх болно. Энэ философи миний тоглоом болон амьдралд их өөрчлөлт хийсэн дээ.

Нэг сонин явдал тохиолдох үед түүнд Жонни Чан оролцсон юм. Тэрбээр миний хүндэлдэг тоглогч билээ. Би түүнийг үргэлж харж байдаг. Нэгэн тэмцээний дараа нэлээд их мөнгө хожчихоод тэндээсээ гарч тэр хавиар өөр тоглолтод оролцов. Харин тэр тоглолтод олсон бараг бүх би мөнгөө алдчихав. Үүнд би их бухимдсан. Яг тэр үед Жонни Чан над руу дөхөж ирээд "Хүү минь битгий санаа зов. Энэ ч бас надад тохиолдож байсан. Одоо гэртээ харьж сайхан унтаж амраад ир. Маргаашийн тоглолтод би чамайг дэмжинэ" гэв. Миний шүтэн биширдэг тоглогч ингэж хэлсэн нь надад маш их итгэл найдварыг төрүүлсэн юм. Түүнээс илүү аугаа хүн болох хүсэл толгойд минь тэсрэв. Тэрбээр хэлсэн үгэндээ хүрч надад мөнгө өгч би тэмцээнд түрүүлж шагналаа бид хоёр хувааж авсан юм. Би түүнд маш их баярласан.

Миний хувьд Жонни Чан бол намайг покерын ертөнцөд зааварчлан дэмжсэн хамгийн хүндтэй хүн. Покерын ертөнцөд бас түүнээс гадна өөр хоёр хүн намайг маш хүнд байдалтай байхад минь тусалсан. Түүний нэг нь Даниел Нигрэану. Тэрбээр намайг 2004 онд түрүүлэхэд тусалсан.

2002, 2003 онд амжилтандаа тайвшраад байлаа. Өнгөрсөн амьдралын маань нэг хэсэг эргэн ирж намайг эзэмдсэнээр 2004 он гарахад би бас л уруудаж эхлэв. Би найз хүүхэн Паулеттайгаа хамт нэг өрөө байранд амьдардаг байлаа. Хар тамхи маш их хэрэглэснээр байрны түрээсээ ч төлж чадахгүй, хоолоо ч авч чадахгүй байдалд оров. Паулет манай гэр рүү хэд хэдэн удаа утасдаж "Та нар энд ирэх хэрэгтэй байна. Тэр асуудалд ороод байна" гэхэд манай гэрийнхэн түүнд нь огт анхаарал тавилгүй зүгээр л намайг өөрсдөөрөө санаа тавиулах гэж байна гэж бодоцгоосон. Энэ бол миний амьдралын хүнд хэсэг байсан. Тэр үед үнэхээр би доошоо орсон байлаа. Би өөрөө үхэж байна уу, амьд байна уу гэдгээ огт хайхрахаа больсон байсан. Баярлууштай нь Паулет дүү рүү минь утасдаж түүнийг над ирэхэд нөлөөлж чадсан юм.

Чи покерын дилер, тэдний эздүүдийг махчин загас гэж бодож байгаа бол эндүүрч байна. Тэнд байгаа хүүхнүүд хүртэл махчин загаснууд. Тэнд маш олон төрлийн махчин загас бий. Тэд бол махчин загаснаас өөр юу ч биш.

•••

Паулет миний дүү хоёрт мөнгө байгаагүй. Тэд намайг Даниелтай ойр байдгийг мэднэ. Би түүнд бас хэдэн жилийн өмнө тусалж байсан юм. Ингээд дүү Даниел руу утасдаж "Даниел. Лэйн одоо маш муу байна. Би ахыгаа алдмааргүй байна. Түүнд тусламж хэрэгтэй байна" гэж хэлэв. Тэрээр дүүгийн маань яриаг тасалж "Би энд байна, чамд юу хэрэгтэй вэ?" гэсэн.

Тэр орой Паулет над дээр ирээд "Лэйн чиний бие их муу байна. Хэрэв би чамайг донтолтын эсрэг хордлого тайлах эмнэлэгт явуулбал чи явах уу?" гэв. Тэр үед би бүр газарт унатлаа муудсан байсан болохоор энэ бол миний сүүлчийн боломж гэж бодоод "Тийм ээ. Би явах болно. Гэвч тийм их хэмжээний мөнгө байхгүй шүү дээ" гэсэн.

"Дүү чинь Даниелтай ярьсан. Тэр бүгдийг төлөх болно гэсэн" гэхэд хэлэх ч үг олдохгүй болсон доо.

•••

Даниел өөрөөсөө 60 мянган доллар гаргаж намайг эмчлүүлсэн юм. Тэр их сэтгэлийн тусламжийг би хэзээ ч мартахгүй. Хэрэв тэр тэнд байгаагүй бол юм яаж дуусах байсныг хэн ч мэдэхгүй.

•••

Тэр эмчилгээ их тусалсан боловч миний бүх асуудлыг шийдвэрлэж чадаагүй юм. Эмчилгээ зөвхөн шархан дээр минь боолт тавьсантай адил байв. Үүний дараа 2004 онд тав дахь бугуйвчаа авах хүртэл хар тамхинаас хол байсан ч тун удалгүй муу зуршил дахин намайг эзэмдэж эргээд л анхны байдалдаа оров. Түүгээр ч барахгүй миний тэрхүү өөрөө өөрийгөө сүйтгэж байгаа байдлыг Паулет тэвчээгүй юм. Бидний харилцаа ч дуусгавар болоход хүрэв.

"Даниел. Лэйн одоо маш муу байна. Би ахыгаа алдмааргүй байна. Түүнд тусламж хэрэгтэй байна" гэж хэлэв. Тэрээр дүүгийн маань яриаг таслаж "Би энд байна, чамд юу хэрэгтэй вэ?" гэв.

Өөр нэг сайн нөхөр бол Фаст Эди Фэлсон намайг хүнд асуудлаас гарахад минь бас их тусалсан. Эди бол биллгардын аугаа тоглогч төдийгүй "Мөнгөний өнгө", "Овжин хүн" зэрэг киноны гол дүрийн үндсэн санааг түүний амьдралаас сэдэвлэн бичсэн юм. Тэрбээр одоо 70 настай. Лас Вегасын төвд амьдардаг. Тэр маш ухаантайгаас гадна Лас Вегас дахь сайн муу бүх зүйлтэй нүүр тулж явсан учир хүмүүст юу гэж зөвлөхөө мэддэг. Тиймээс миний амьдралын зөвлөгч болсон юм. Би зөвхөн түүнд итгэснээр тэр надад өөртөө итгэх итгэлийн тухай хичээл зааж өгөв.

Эдитэй анх уулзахдаа би бүр цөхрөнгөө барсан байдалтай байсан. Усан нүдлэчихээд үхнэ

гэдгээс айж байгаагаа хэлэв. Тэрбээр намайг тайвшруулан "Хүү минь тайван бай. Чи хаагуур явсныгчинь би мэднэ. Чи надад итгэх хэрэгтэй. Бүх зүйл сайхан болно" гэж хэлэв. Түүний зөв байлаа. Тэрээр надад хар тамхи, хүүхэн, өөр бусад муу зуршлын талаар тайлбарлан өгч тэр бүгдтэй хэрхэн харьцах талаар зааж өгөв. Бараг жилийн турш би өөрийнхөө төлөө ажилласан даа. Эдигийн оролцоо маш их байлаа. Тэгээд өөрийгөө хар тамхинаас холдуулж, шөнийн амьдралаас татгалзаж, өөрийгөө дахин шинээр цэнэглэв. Намайг уруу татдаг байсан хүмүүсээс зайгаа авч чадав. Хэдийгээр энэ нь маш хэцүү байсан ч эргэж харалгүйгээр хийж чадсан даа.

Лас Вегаст нүүж ирснээр таван жилийн дотор таван бугуйвч хүртэв. Эхний гурван бугуйвчаа авах үедээ хар тамхи ер хэрэглэдэггүй байлаа. Дөрөв дэх бугуйвчаа авах үеэс хар тамхинд орж эхэлсэн боловч түүнд тэгтлээ гүнзгий ороогүй байсан. 2004 оны бугуйвчийн дараа Даниел эмчилгээнд явуулж аварсан боловч хар тамхинаас бүрэн ангижирч чадаагүй юм. Харин тав дахь удаагийн бугуйвч хүртсэний дараа хар тамхины хэрэглээ хяналтаас гарч, донтолтын хэмжээнд очиж хүнд байдалд оров. Түүндээ ч зовж шаналж эхлэв. Хар тамхи намайг 2008 онд зургаа дахь удаагийн бугуйвчаа авах хүртэл миний амьдралд ямар нэгэн байр эзэлсээр ирсэн юм.

•••

Үүний дараа 2004 онд тав дахь бугуйвчаа авах хүртэл хар тамхинаас хол байсан боловч тун удалгүй муу зуриил намайг дахин эзэмдэж анхны байдалдаа эргэж очив.

•••

Миний покерын ертөнцөд үзүүлсэн эдгээр амжилтын гол үндэс өрсөлдөгчөө "унших" чадвар, айдасгүй тоглолт хоёрт л байдаг. Байгаа бүгдээрээ эрсдэл хийхэд бэлэн байдаг чанар маань бас давхар юу ч үгүй хоосон хоцроход бэлэн байдаг гэдгийг илэрхийлж явдаг. Би өрсөлдөгчийнхөө өмнө хэзээ ч бүх мөнгөө түлхэхэд бэлэн байдаг. Үүнийг өрсөлдөгчид маань ч мэднэ. Тийм учраас тэд над руу эргэж ирж чаддаггүй, хэрэв би алдвал асуудал байхгүй. Тэр үед надад "За, маргааш уулзъя" гэсэн сэтгэл л төрдөг. Хөзөр тоглож байхад надад зургаа дахь мэдрэхүй байдаг гэдэгт би итгэдэг. Бас миний ой санамж маш сайн. Хэнтэй, хэзээ, ямар модоор тоглосноо бүгдийг санадаг. Хурдан уйдаг, зарчимгүй байх нь миний гол хоёр том аюул юм. Хэрэв үнэнхүү сэтгэл зүрхнээсээ анхаарлаа төвлөрүүлэн тогловол би ширээг үргэлж ялагчаар орхиж явна.

Миний амьдралд олон эсрэг тэсрэг зүйл тохиолдож байсан болохоор хүмүүс надаас покерыг мэргэжил болгосон чинь зөв сонголт байсан уу гэж асуудаг. Тэдэнд би "Тийм" гэж хариулдаг. Покер миний өөрийн тухай болон амьдралын тухай маш олон зүйлийг надад заасан. Зарим хичээл нь маш хүндрэлтэй байсан боловч түүний үр дүнд би улам сайн хүн болсон доо. Би покер тоглох дуртай, түүнийг үнэхээр хүсдэг. Покер намайг олон сайн нөхөдтэй болгосон төдийгүй амьдралын мартагдашгүй олон сайхан мөчүүдийг надад үлдээсэн юм.

Тухайлбал, би покер тоглоогүй бол Жэрри Басс гэх мэтийн хүмүүстэй адил олны танил болохгүй байсан. Жонни Чанаар дамжуулан Лос Анжелес Лэйкерсийн эзэн Жерри Басстай танилцаж байлаа. Нэг удаа би түүнтэй 600-1200 долларын тоглолтод тоглож байхад түүнд

мөнгө дутахад би 80 мянган доллар зээлүүлж байв.

Хэдэн жилийн өмнө бид хоёр Покерын дэлхийн аялан тоглолтод аваргын төлөө тоглосон юм. Тэгэхэд нэлээд эвгүй байсан. Жерри надад Лос Анжелес Лэйкерсийн 2001-2002 оны аваргын хүрмийг өгсөн нь үнэхээр түүний өгөөмөр сэтгэлийг харуулсан хэрэг байлаа. Тэр савхин хүрмэн дээр бүх тоглогчид гарын үсэг зурсан байсан төдийгүй аваргуудын цугларалтын тусгай наалт наасан байв. Тэрбээр энэ хүрмийг надад түр зээлээгүй бүр өгсөн юм. Би түүнийг энэ шийдвэртээ харамсч байгаа байх даа гэж бодсон. Тэрбээр өөрийн багтайгаа онгоцонд суух бүртээ Покерын дэлхийн аялан тоглолтод би түүнийг хожсон тэмцээнийг байнга үздэгээ надад хэлэв. Бас тэрбээр би бол хүүхэд, тэр намайг алдартай болгосон гэдэг. Энэ бол Жерригийн аугаа сэтгэл бөгөөд тэр бол "жинхэнэ эр хүн" билээ.

Покер надад олон сайхан дурсгалтай мөчүүдийг бий болгож өгсөн. Тэднээс аль нь ч 2004 оны Арубад болсон "Ultimate Bet Poker Classic" тэмцээнд охиноо авч очсон мөчөөс илүү гарахгүй нь мэдээж. Энэ нь эмнэлгээс дөнгөж гарсны дараахан болсон явдал. Арал дээр бид хоёр бие биенээ анх удаагаа олон жилийн дараа харсан даа. Би түүнийг арал дээр ирэх бүх боломжоор нь хангасан юм. Ганцхан асуудал үүссэн нь тэмцээний дундуур охин маань намайг харах боломжгүй болсонд оршино. Учир нь хүүхэд дотогшоо оруулахгүй гэж байв. Харин шувтаргын тоглолтыг харж болно гэв. Энэ тоглолт гадаа явагдах байсан учраас тэр биз. Ийм учраас би 792 тоглогчоос 786 тоглогчийг ялж гарч ирэх ёстой болов. Гол нь би охиноо сэтгэл дундуур үлдээхгүйн тулд тулалдсаар, тулалдсаар байлаа.

Ингэж тэмцээний эцэст охиныхоо өмнө тоглох эрхтэй болов. Тэр үед тэмцээн эхлэхээс өмнөхөн нэгэн сурвалжлагч надаас ярилцлага авахыг хүсэв. Би түүнд "Би охинтойгоо хамт байж байгаад ярилцлага өгч болох уу?" гэхэд тэрээр "Үгүй" гэж хэлсэн. Би тэр дороо л эргээд явчихсан. Тэр удалгүй бодлоо өөрчилж, ярилцлага өгөх үеэр Халия миний хажууд надтай хамт байсан юм.

"Лэйн чи юу мэдэрч байна, бид чамайг тамхины эмчилгээнээс дөнгөж гарч ирснийг мэдэж байна" гэж асууж байсныг би санаж байна.

Би хариуд нь "Би эргэн ирсэн гэдгээ мэдэрч байна" гэж хэлэхэд охин маань "Дахин ирсэн аав гэж бодож байна" хэмээн нэмж хэлсэн юм.

Ярилцлагын дараа Халия миний ард талд тэмцээн үзэж суув. Бид долоон сая долларын төлөө тоглосон юм. Надад хос ес байлаа. Эсрэг талд хос туг байсан ч тоглоом түүн рүү эргэж би хоёрдугаар байрт оров. Тэр тоглолтоос өөр тоглолтод ингэж их зүтгэж тоглосноо би ер санадаггүй юм. Гол нь охин Халиягийнхаа урмыг хугалахгүйн тулд амлалтаа биелүүлэхийн тулд маш их хүчин чармайлт гаргаж билээ.

Би одоо амьдралын сайхан үедээ байна. Саяхан 2008 онд зургаа дахь бугуйвчаа 1500 долларын хязгаартай Омаха тэмцээнд түрүүлэн авахдаа 577725 доллар хожсон юм. Би бизнесийн шинэ санал хүлээж авав. Өөр бас бусад боломжууд ч надад ирсээр байгаа. Покер үргэлж миний амьдралын гол хэсэг байсан. Би бүхий л хурдаараа тоглох цаг урд маань байна. Магадгүй 50 жилийн дараа миний булшин дээр "Тэр бол өрөөнд гэрэл, ширээн дээр айдас авчирсан хүн" хэмээн бичсэн байх болов уу.

Түүний тухай LayneFlack.com гэсэн сайтаас мэдээлэл авч болно. Тэрбээр Шрайнерс хүүхдийн эмнэлгийг (www.Shriner-sHQ.org) санхүүгийн хувьд дэмждэг. Энэ нь 22 салбартай олон улсын эмнэлэг бөгөөд хүүхдийн амьдралыг сайжруулахад, ялангуяа хүүхдийн өвчний оношлогоо эмчилгээгээр дагнасан эрдэм шинжилгээ судалгаа, сургалтын байгууллага юм.



Аллен Каннинхем

"Есүс" хочит Крис Фергюсон дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн цөөн тооны шилдэг тоглогчдын нэг. Тэрээр покерын олон тэмцээнд гайхамшигтай амжилтуудыг үзүүлсэн юм. К.Фергюсон Покерын дэлхийн цуврал тэмцээний Main Event, NBS National Heads-up, Circuit Championship Title-ын аваргыг оролцуулаад таван удаа түрүүлж, нийтдээ 7.5 сая доллар хожсон байна.

Математик шинжилгээний арга голчлон ашигладаг тэрээр интернэт покерын хувьсгал гарахаас өмнө тоглох өрсөлдөгчдөө интернетээр судалж, стратегийн төлөвлөгөөгөө боловсруулдаг байжээ.

Урт үс, сахал, ковбой малгай нь түүнийг покерийн ертөнцийн хамгийн содон хүмүүсийн нэг болгосон гэдэг. Покерын шилдгүүдийн нэг болох Фергюсоны өөртөө итгэлтэй, төлөв даруу байдал аймшигтай мэт харагдуулдаг. Энэ нь өрсөлдөгчдийг нь чиннээс тусгаарлаж орхидог

гээж хэлж болно. Ямар нэг тэмцээнд оролцоогүй үедээ тэр өөрийн байгуулсан "Full Tilt Poker"-ийн онлайн тоглолтод оролцож, түүнийгээ хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулдаг. Крисийг энэ сайтаас "олж" болно.

Покерчид Крист ойр байдаг хөгжөөн дэмжигчид түүнийг "Есүс" гэж дууддаг, энэ нь насан туршийнх нь хоч болжээ. "Хэрэв та нар намайг харвал яагаад ийм нэр хочтой болсныг төвөггүй ойлгоно, хэн нэгэн намайг ингэж хочлоогүй, зүгээр л ийм хочтой болсон" гэж Крис хэлж байв. "Ер нь энэ хоч нэлээн түгээмэл байдгийг би сүүлд ойлгосон. Гудамжинд явж байхад албаны хувцастай олон хүн надтай таарч "Сайн уу, Крис, намайг урт үс, сахалтай байхад хүмүүс бас Есүс гэж дууддаг байсан" гэгцгээдэг.

Крис бүхий л амьдралынхаа туршид тоглосоор ирсэн. Пэсифик Палисайдэст өссөн түүний хүүхэд нас аж жаргалтай, сургууль соёлын асуудал ч тааламжтай байжээ. Тэр өнөөдрийн ихэнх тоглогчдод түгээмэл байдаг ямар нэг хүнд байдал, сэтгэл санааны дарамтгүйгээр амьдралаа өнгөрүүлэв. Түүний гэр бүлийнхэн их дотно, ихэнх цагаа бүгд нийлж тоглоом тоглодог, покер нь тэр олон тоглоомын нэг байв. Тэрбээр бүр багаасаа покер тоглож сурчээ. Яг хэдэн настайгаасаа эхэлж тоглож сурснаа санахгүй байгаа ч мөнгөний төлөө хэзээ тоглож эхэлснээ тодорхой санадаг. "Дөрөвдүгээр ангид байхдаа ангийнхаа хэдэн хүүхдүүдтэй хамт хичээлийн завсарлага, заримдаа бүр хичээлээ таслан байж, таван хөзрийн покер тоглодог байснаа" дурсдаг.

Нэгэн удаа гурван хатантай байж байгаад флашг хожигдож, 35 цент алдан өдрийн хоолныхоо мөнгийг салхинд хийсгэсэндээ ихэд харамсч байсан гэдэг.

Ахлах ангид сурч байхдаа сургуулийнхаа хэсэг хүүхдүүдтэй хамт тогтмол шахуу тоглож, долоо хонстийн сүүлчээр найзуудынхаа гэрт ээлжпэн очиж, олон төрлөөр, голдуу 50 центээр өсгөх хязгаар тогтоон тоглодог болжээ. Заримдаа өөрсдөө дүрэм зохиож, түнийгээ дилер нь шийдэн шөнийн хоёр гурван цаг хүртэл тоглохдоо 20 доллар алдах эсвэл хождог байв. Ахлах ангид байхдаа зөвхөн зугаа болгон покер тоглож, хожсон үе нь түүнд сайхан санагддаг байжээ. Гол нь тэр энэ тоглоомд дурласан байсан төдийгүй түүнийг нь өдөөж өгөхөд улам ихээр татагджээ. Тоглоом тоглохдоо бүр эхлэхээсээ л Крис Фергюсон учрыг нь олохыг хүсдэг байж. Тоглоомын мөн чанар нь боломжийг зөв тодорхой ойлгох, тоглоомын математик магадлалыг тооцох явдал гэдгийг тэр сайтар мэдэрчээ.

Коллежид байхдаа тэр үргэлжлүүлэн тоглож, интернэтийн эхний хувилбар болох IRC сувгаар покер тоглодог байжээ. Гэхдээ мөнгөөр тоглодоггүй байсан учир Лас Вегас руу үе үе очиж, 1-4 долларын ширээн дээр тоглодог байв. Чингээд хэрэв би хүлээцтэй байж, зөвхөн маш сайн хөзөр ирсэн тохиолдолд орвол нэг цагт дөрвөн доллар хийж болох юм байна гэдгийг ойлгосон ажээ. Покер тоглон мөнгө олж, түүгээрээ амьдарч болох уу? гэсэн асуултыг өөртөө тавьж, цагт дөрвөн доллар олж түүгээрээ амьдарч болно гэж тооцвол, би амжилттай байж болох юм байна гэсэн дүгнэлтэд хүрэв.

•••

*Тоглоом тоглож эхлэхээсээ өмнө Крис Фергюсон тоглоомынхоо учрыг нь олохыг хүсдэг.
Тоглоомын мөн чанар нь боломжийг зөв тодорхой ойлгох, тоглоомын математик*

• • •

1994 оноос эхлэн покерт хандах Крисийн хандлага өөрчлөгдөж эхэлжээ. Тиймээс покерт нухацтай хандаж, тоглоомын мастер болохоор шийдсэн байна. 1994-2000 оны хооронд тэр покер тоглогч л байсан. Тоглох хугацаандаа математикийн онолд тулгуурлан өөрийн авьяас чадварыг хөгжүүлэхэд анхаарч, компьютер загварчлалын тусламжтайгаар хэрхэн амжилттай тоглох тактикаа боловсруулахыг хичээж байв. "Мянга мянган хувилбарыг компьютерээр боловсруулж, хамгийн боломжит стратегийг олохыг" оролдож байснаа ч бас өгүүлжээ. Тэрбээр мэдээллийн технологийн шинжлэх ухааны доктор (Ph.D) цолтой, покерын мастер болохдоо хамгийн шилдэг аргыг компьютер ашиглан боловсруулж байжээ.

• • •

Маш олон хүн покер тоглоход зугаатай байдаг гэдэг ч над шиг нарийн судалж, шинжилж, түүнээсээ таашаал авдаг хүн тун ховор.

• • •

Маш олон хүн покер тоглоход зугаатай байдаг гэдэг ч над шиг нарийн судалж, шинжилж түүнээсээ таашаал авдаг хүн тун ховор. Ер нь ихэнх хүмүүс покер тоглохдоо хүнээр, эсвэл багшаар заалгасан байдаг. Харин Крисийн хувьд тэр өөрөө сурсан. Энэ тохиолдолд өөрөө өөртөө багшилсан, мянга мянган хувилбаруудыг тооцоолон өөрийн аргачлалыг боловсруулжээ. Одоо хүртэл Крис покер тоглодог олон найзтай, тэднээсээ зөвлөгөө авч, тоглоомноосоо өөртөө таашаал авдаг гэдэгтээ итгэдэг. Мөн "покер тоглодог хүн бүр өөрийн дотны зөвлөхтэй байх хэрэгтэй, аливаа асуудлыг харилцан зөвлөж байх нь дээр. Гэхдээ даанч надад тийм хүн байгаагүй, байсан ч болоосой гэж би боддог. Бодоод үз л дээ, найзтайгаа зэрэгцэн суугаад хэзрөө харуулаад яаж ийм болов, юу болчихов, яаж болох байсан бэ гээд хоорондоо зөвлөн ярилцахад их олон зүйлийг хурдан хугацаанд сурна даа" гэж тэр хэлэв.

Фергюсон Лас Вегас, Калифорни орчмоор тэмцээнд оролцож байхдаа ч математик аргачлалаа туршин боловсруулж байв. "1994, 1995 онд томоохон тэмцээнд оролцолгүй, математик загварчлалаа улам боловсронгуй болгож, туршиж үзсэн. Математик шинжилгээ нь байж болох боломжуудаас илүү тодорхой нөхцөлд яаж тоглох ёстойг харуулсан. Олон тоглогч хөзрийн тодорхой хослолуудтай үе дэх боломж, магадлалыг мэддэг ч тэдгээрийн ихэнх нь тэрхүү шинжилгээг дараачийн түвшинд гартал нь судалж чаддаггүй" гэж Крис өгүүлэв.

Дэлхийн шилдэг мэргэжлийн покерчид өөрсдийнхөө хэмжээнд тоглож чаддаггүй гэдгийг Крис анзаарчээ. "Компьютер загварчлалын тусламжтайгаар тухайн нөхцөлд яаж тоглох вэ гэдгийг би аль хэдийнэ боловсруулсан" гэж тэр хэлсэн удаатай. Тэгэхэд тэдгээр шилдэг тоглогчид яг ийм нөхцөлд том алдаа гаргадаг. Энэ нь маш их мөнгө хийдэг хүмүүст хүртэл сайжрах боломж их байгааг хэлсэн хэрэг. Заримдаа Крис шилдэг тоглогчидтой ярилцаж, алдааных нь тухай зөвлөхөд, тэд хүлээж авдаггүйгээр барахгүй өөрсдийн хуучин аргатайгаа тас зууралдан үлддэг байна. "Математик аргаар тайлбарлан батлаад, миний зөв байхад хүртэл үл ойшоодог. Сайн тоглогчид тухайн нөхцөлд яахаа мэдэхгүй байхад дөнгөж эхлэн

суралцаж байгаа хүмүүс миний зөвлөгөөг огт ойлгодоггүй юм" гэжээ.

• • •

Учир нь мөнгөний тоглоомд оролцож болох ч тэнд өндөр чадвартай тоглогчдын өмнөөс тоглох, тэдэнтэй өрсөлдөх боломж байгаагүй, өрсөлдөж ч байгаагүй.

• • •

Покер тоглох чадвараа сайжруулахын тулд та яагаад мөнгөний тоглоомоос тэмцээнийг илүү гэж үзсэн бэ? гэсэн асуултад, "1990-ээд оноос миний гол зорилго бол хамгийн өндөр түвшинд покер тоглож сурах байлаа, үүний хамгийн шилдэг хувилбар нь мөнгө олох зорилгоор биш тэмцээнд оролцох явдал байсан. Учир нь мөнгөний тоглоомд оролцож болох ч тэнд өндөр чадвартай тоглогчдын өмнөөс тоглох, тэдэнтэй өрсөлдөх боломж байгаагүй, өрсөлдөж ч байгаагүй" гэжээ.

Бага хэмжээний шагналтай тоглоомд мэдээж их мөнгө хожихгүй ч тэнд цагийг зугаатай өнгөрөөх гэсэн хүмүүс л байдаг. Тэдний зарим нь покерыг бараг сайн мэдэхгүй, маш олон хөзөр дуудна, худлаа хэтэрхий их хөөргөнө, сонин хослолоор олон удаа азаа үзнэ. Ийм тоглоомноос түүний чадвар сайжрахгүйг тэр ойлгожээ. Тэмцээн бол үүнээс өөр, бүх утга учрын хувьд. Бага хэмжээний шагналтай тэмцээнд хүртэл оролцогчид бүгд ажил хэрэгч, зүгээр нэг цаг өнгөрөөх гэсэн байдалтай биш байдаг. Тэмцээнд оролцогчид нь мөнгөө хаяж азаа үзэгчид биш, тэд бүгдээрээ хожих хүсэлдээ авгсан хүмүүс юм. Хэрэв тэд алдвал маш хүнд тусган авдаг, яг ийм л хүмүүстэй, тэдгээрийн эсрэг тоглох хүсэлтэй байв.

Крис 90-ээд оны дунд үеэс тоглож сурах гэж нэлээд хэдэн бодит алхмыг хийж эхэлжээ. Эрчимтэй өсөлт хэрэгтэй гэж үзсэнээс тухайн үеийн шилдэг тоглогчидтой тоглох ёстойг ухаарав. Гэвч тэдгээр шилдэг тоглогчид бага шагналтай тэмцээнд бараг ордоггүй байж. Том тоглогчид том мөнгөөр, том шагналтай тэмцээнд л оролцоно. Тэр үед Крис том тэмцээнд орох мөнгө байсангүй, тиймээс тэр багахан мөнгөн шагналтай тэмцээнд оролцдог байв. Нэлээн сайн тоглогчид хүртэл тухайн үед тиймэрхүү тэмцээнд оролцдог байжээ.

• • •

Покерын талаар их зүйл сурахын тулд би хамгийн хүнд тоглоомыг, хамгийн шилдэг тоглогчидтой хамт тоглохыг хүсдэг байсан. Энэ нь зардалгүй, үр дүнтэй арга биш байж болох юм, гэхдээ үүнийг дагаарай гэж покер сурч байгаа хүмүүст зөвлөж чадахгүй ч энэ арга миний хувьд их тус болсон юм.

• • •

Крис өөрийн сонголтыг хийж шилдэг тоглогчидтой хамт тоглохоор тэмцээнд орж эхлэв. Тэр үед томоохон мөнгөтэй тэмцээнүүд цөөхөн байлаа. Жилдээ 10 мянган долларын шагналтай тэмцээн хоёр удаа, 5000 долларын тэмцээн хэдхэн удаа болдог, өнөөдрийнх шиг олон тэмцээн байгаагүй юм. Өнөөдрийн покерын ертөнцийн хувьд сайн тоглогчдыг жижиг тэмцээнээс олохгүй, харин 90-ээд оны дундуур том тэмцээн цөөхөн болдог байсан учраас

шилдэг тоглогчдыг жижиг тэмцээнүүдээс амархан олж болдог, тэдэнтэй хамт тоглохыг тэрээр хүсч байв.

Ингэж тоглосноор Крис өөрийн стратегийг шинэ түвшинд гаргаж чадсан байна. Мэргэжлийн гэгдэхТ.Ж.Клаутиэр, Мастер Мен, Фил Хэлмут зэрэг хүмүүстэй тэр тоглож байжээ. Покерын мэргэжилтнүүдийн дүгнэлтээр, ихэнх покерчид амархан тотлолтыг мөрөөддөг, тэд өрсөлдөгчдөөсөө хялбархан аргаар мөнгийг нь салгаж авахыг хүсдэг. Гэвч түүний хувьд энэ аргыг гол болгоогүйгээс гадна хялбар аргаар покер тоглохыг бодолгүй, зөвхөн суралцах зорилготой байлаа. Тоглоомын тухай бүгдийг мэдэхийг хүсч байсан Крисийн энэхүү арга нь зөв логиктой байсан учир шилдэг сургалтыг шилдгүүдээр заалгаж чадсан байна. Тэр үүндээ хамгийн бага мөнгө зарцуулжээ.

2000 оноос Крисийн тоглоомын түвшин шинэ шатанд гарав. Тэр хүртэл тэрбээр өөрийнхөө амьдралын хагасыг UCLA-д таван жил бакалавр, 13 жил дараагийн шатанд сурч өнгөрөөв. 1999 онд Мэдээллийн технологийн шинжлэх ухааны доктор (Ph.D) цол хүртэв. Тухайн үедээ ирээдүйн зорилгоо хөрөнгийн биржийн арилжаалагч болно гэж төсөөлж, компьютер шинжилгээний чадвараа санхүүгийн ертөнцөд ашиглана гэсэн бодолтой байлаа. Арилжаалагч гэсэн ажлаар хэсэгхэн хугацаанд ажилласан нь Крисийн покерын огцом өсөлтөөр дуусгавар болов. Ажлаасаа олсон мөнгөөр тэмцээнд оролцох хураамжийг төлж байжээ.

Ингээд тэрбээр амжилт олж, жилийн дараа Покерын дэлхийн цуврал тэмцээний Main Event-эд түрүүлжээ.

•••

Одоогоос хэсэгхэн хугацааны өмнө интернэтээр тоглодог сайн тоглогчдыг Покерын нийгэмлэгт тийм сайнаар хүлээн авдаггүй байв. Тодруулж хэлбэл, "интернэтээр тоглогч" гэдэг нь "тааруухан" гэсэн далд ойлголтыг төрүүлдэг байжээ.

•••

Түүнийг маш олон хүн, найзууд, гэр бүлийнхэн, багш нар нь өчнөөн жил сурч, мэдээлэл технологийн шинжлэх ухааны доктор зэрэгтэй болчихоод покер тоглоход бүх цагаа зарцуулах болсонд ихэд гайхацгааж байв. Энэ талаараа Крис "яг үнэндээ би өөрөө ч гайхаж, тэднээс түрүүлж үүнийг хүлээн авах гэж нэлээн удаж байсан" тухайгаа дурссан байдаг. Покерын дэлхийн цуврал тэмцээний ялалтын дараа Крис өөрийгөө мэргэжлийн тоглогч гэж хүлээн зөвшөөрөхөд бэлтгэгдээгүй байв. Крисийн хувьд покер нь хобби, өрсөлдөөн, судлах дуртай сэдэв байснаас жинхэнэ мэргэжил нь болсон гэж хэлэгдэх болоогүй байв. Хоёр жилийн дараа дахин томоохон тэмцээнд түрүүлснээр тэр мэргэжлийн тоглогч гэж хүлээн зөвшөөрөгдөв. Найзууд маань намайг мэргэжлийн покер тоглогч гэж танилцуулахад эхэндээ татгалздаг байснаа, сүүлдээ гэнэт өөрөө өөрийгөө мэдэрч, "Би бол мэргэжлийн покерчин" гэж танилцуулах болсон. Үүнийг Крис тэр агшинд л хүлээн зөвшөөрсөн юм. Өнгөрүүлсэн амьдралынхаа туршид мэргэжлийнхээ замналыг хайж байсан ч покер түүний амьдралын нэг хэсэг байсныг тэр байнга хэлдэг юм.

Тэмцээнд оролцохын хажуугаар тэр онлайннар Full Tilt Poker сайтаар байнга тоглоно. Одоогоос хэсэгхэн хугацааны өмнө интернетээр тоглодог сайн тоглогчдыг покерын нийгэмлэгт тийм ч сайнаар хүлээн авдаггүй байв. Тодруулж хэлбэл "интернэтээр тоглогч" гэдэг нь "тааруухан" гэсэн далд ойл голтыг хүмүүст төрүүлдэг байжээ. Одоо бол бүгд өөрчлөгдсөн. Онлайн тоглоом покерт хувьслыг авчирсан төдийгүй Крисийн амжилт энэхүү хувьслын анхдагч болсон. Крис бүр 1989 оноос эхлэн онлайннар тоглож эхэлсэн. Тэр үед өнөөгийнх шиг өнгөт график, тусгай бүрдэл, амьд орчин шиг шийдэл байхгүй, компьютерийн дэлгэц нь зүгээр л үгээр илэрхийлж, тоонд үндэслэсэн энгийн хэлбэртэй, хоорондоо шууд харилцах боломжгүй байлаа.

Гэсэн хэдий ч Крис хязгааргүй Техас Холдемийн талаар нэлээд мэдлэгтэй болсон байв. 1989 оны үед хязгаартгүй тоглолт тийм ч түгээмэл байгаагүй, хэрэв аз таарвал нэг юмуу хоёр л тохиолдол тааралддаг байжээ. Ингэж онлайннар тоглох нь бодит тоглолтын ширээн дээрх хувилбарыг нэгд нэгэнгүй түүнд харуулахаас гадна бусад тоглогчдийг бодвол Крист маш их давуу тал, туршлагыг өгчээ.

• • •

Бодоод үз дээ, математик хэзээ ч худлаа хэлдэггүй л байхгүй юу. Жишээ нь нэг тамга ирсэн гэж бодъё, тэгтэл хоёр тамга эргэлээ, эндээс чи нэг тамга хаа нэгтээ үлдсэн гэдгийг баттай мэднэ, гэхдээ ганцхан үлдсэн гэдгийг. Үйлдэл бол түүнээс огт өөр үргэлж худлаа хэлдэг.

• • •

Покерчид кибер ертөнцөөс орж ирж байгаа залуучуудад чанга хатуу, үл ойшоосон байдалтай ханддаг. Харин Крисийн хувьд онлайн супер одуудыг анхнаасаа л хүлээн зөвшөөрч, тэднийг удалгүй цахиур хагална гэдэгт итгэдэг. Учир нь өөрөө онлайннар их олон зүйлийг сурсан болохоор тэр.

Крис өөрийн туршлагаас интернэт тоглогчид ширээн дээр тоглох тоглогчдоос хамаагүй олон хүмүүстэй хамт тоглодгийг мэднэ. Нэг тохиолдолд Крис бүр гарган байж 300 хүнтэй хамт тогложээ. Энэ нь цагт 300 шинэ аргад суралцах боломж туршлагыг түүнд олгосон байна. Хэрвээ ширээний болон интернэт тоглогчид яг ижил хэмжээний мэдээлэл авдаг гэж тооцвол интернэт тоглогчид ширээн дээр тоглосноос тав дахин хурдан суралцана. Жишээ нь, 22-той интернет тоглогч олон ширээн дээр зэрэг тоглосноор хэдхэн жилийн дотор Дойл Брансоны амьдралынхаа туршид олж авсан туршлагыг эзэмших боломжтой.

Олон тоглогчид өөрт ирсэн хөзөр болон өрсөлдөгчөө унших чадварын аль аль нь тийм ч чухал биш гэж үздэг. Крисийн хувьд покерын үндсэн зорилго амжилтад зайлшгүй хүрэх нь чухал гэдэгт итгэдэг. Зарим тоглогчид үйлдлийг чухалчилдаг бол Крис өөрт ирсэн хөзрөөр үндсэн түвшинд яаж тоглох вэ гэдгийг чухалчилдаг. Энэ нь өөрийн хөзрөө өрсөлдөгчийнхөө үйлдлээс хамаарч, сөргүүлэн тавихаас өөр асуудал юм.

Бодоод үз дээ, математик хэзээ ч худлаа хэлдэггүй л байхгүй юу. Жишээ нь нэг тамга ирсэн гэж бодъё, тэгтэл хоёр тамга эргэлээ, эндээс чи нэг тамга хаа нэгтээ үлдсэн гэдгийг баттай

мэднэ, гэхдээ ганцхан үлдсэн гэдгийг шүү. Үйлдэл бол түүнээс огт өөр, үргэлж худлаа хэлдэг.

Тоглогчид байнга өөрийгөө нуудаг, бас хуурамч үйлдэл зохиодог. Тэд чамайг хуурахыг оролдоно. Харин математикийг бол хуурч чадахгүй. Шинэ тоглогчдод өгөх Крисийн зөвлөгөө нь эхлээд тоо сур гэдэг. Ер нь онлайнаар тоглодог тоглогчид хүчтэй байдгийн нэг үндсэн шалтгаан нь энэ юм.

Олон хүмүүс математик тийм чухал биш, покер бол ердөө л хоёр хөзрийн хослол хоёр хөзрийн нөгөө хослолыг дийлдэг жирийн л хувилбар гэцгээдэг. Нэг талаас харахад үнэхээр тийм чухал зүйл биш гэдэг үнэн ч тоглоомын онол бол математикийн нэг хэсэг юм. Үүнийг ашиглан өөрт ирсэн хөзрөөр яаж тоглохоо зөв шийдэж чадвал энэ нь үндсэн суурь болж өгнө. Математик чухал биш гэж зарим хүмүүс хэлж байгаа нь математикийн тухай ойлголтгүй хүмүүсийн яриа.

Гаднаас нь ажиглаад Крисийг сургуулиа хаясан покерын бусад тоглогчидтой харьцуулахад тун хэцүү. Ахлах сургуулиа бүрэн төгсөөгүй, зарим нь коллежид ч орж үзээгүй тэднийг Фергюсоны мэдээллийн технологийн шинжлэх ухааны зэрэгтэй яаж харьцуулах юм бэ? гэж зарим хүмүүс асууж болох юм. Түүний хариуд тэр нэг л зүйлийг үргэлж хэлдэг. "Шилдэг тоглогчид бол сургуульд сурсан, сураагүй маш ухаантай хүмүүс байдаг. Тэд аваргын төлөө тоглох тоглолтод маш ухаантай байж л оролцоно. Би 18 жил сурсан. Энэ нь хүнийг боловсролтой л болгодог болохоос ухаантай болгодоггүй. Дээд түвшинд тоглож байгаа хүмүүс өндөр боловсролгүй байж болно, гэхдээ тэд бол ямар нэг хэмжээгээр маш ухаантай хүмүүс" гэж тэр хэлдэг.

Крис өөрийн "Full Tilt" сайтаар тэгээс эхлэн 10 мянган доллар хүртэл тоглохдоо покерын тухай маш их зүйлийг суралцсан байна. Жишээ нь, мөнгөө өсгөх, бууруулах зэргээр хэрхэн удирдах. Алдсаныхаа дараа бооцооны мөнгөний хэмжээг багасгах, хожсоны хэрээр бооцоогоо өсгөхгүй байх зэрэг олон зүйл дээр туршлагажсан аж. Алдсаныхаа дараа тоглох мөнгөө багасгаж сурах, үүнд зохицох нь аливаа тоглогчдод маш хэцүү байдаг ч ингэснээрээ өөрт байгаа мөнгөө хадгалж үлдэж чадна.

Маш олон тоглогчид яг үүний эсрэгээр тоглодог. Тэд их мөнгөөр орж эхэлдэг. Тэр нь өөртөө эрдсэн байдал. Үүнээс гадна бас хувь хүний, эсвэл өөр ямар нэгэн хүчин зүйл нөлөөлөөд байдаг юм уу бүү мэд, алдсаныхаа дараа тэд алдсан мөнгөө эргүүлж хурдхан олж авахын тулд бүр ч их мөнгөөр тоглодог. Гэвч хүн болгонд тийм боломж таардаггүй.

Тэгээс 10 мянган доллар хүртэл тоглохдоо бас нэг зүйл сурсан нь тэрбээр мөнгөнийхөө таван хувиас ил үү хэзээ ч гарган тоглодоггүй. Энэхүү стратегийн хүчээр 10 мянган доллараас их мөнгө хийсэн. Цааш бас улам нэмэгдүүлсээр байсан. Хэрэв та нар хүсч байвал өнөөдөр ч гэсэн ChrisFerguson.com гэсэн сайтаар орж тэгээс 10 мянга хүргэдэг түүний арга барилаас суралцаж, бас туршаад үзэж болох юм. "Энэхүү систем намайг алдсан үед бага мөнгөөр тоглоход чиглүүлэн тохируулагдсан" гэж Крис хэлсэн. "Хэрэв би 2000 доллартай бол 100 долларын хэмжээнд л тоглох боломжтой, хэрэв 200 доллартай бол 10 доллараас дээш тоглох боломжгүйгээр тохируулсан" гэжээ.

Өдөрт 14 цаг ширээний ард суун тоглосны дараа ганцхан буруу шийдвэр тэмцээнийг дуусгавар болгодог учир жижиг зүйлүүдийг хүндээр тусган авах хэрэггүй.

• • •

Крисын бас нэг итгэдэг зүйл нь покерыг мэргэжил болгосноор тоглогчид эрх чөлөөтэй болдог. Тэд юу хүсч байгаагаа хэзээ, хаана, хийхээ өөрсдөө л сонгодог. Тэдэнд эзэн гэж байхгүй. Өөрөө өөртөө эзэд нь юм.

Покерын ширээнээс гадна Крис нийтийн бүжгийн үнэнч шүтэн бишрэгч аж. "Ер нь бараг сурвалжлагч бүхэн энэ талаар асуудаг шүү, урд нь долоо хоногт таван удаа бүжиглэдэг байв. Харамсалтай нь Лас Вегаст даанч нийтийн бүжгийн дугуйлан байдаггүй, хэрэв байгуулагдах л юм бол мэдээж би байнгын зочин нь байх болно" хэмээн тэр өгүүлж байсан билээ. Крис жилийн өмнөөс гольф тоглож эхэлсэн боловч түүндээ тийм ч их сонирхол нь татагдаагүй байна. Иймд тэрбээр одоо болтол ямар нэг сонирхолтой зүйл хийхээр эрэлхийлэн хайсаар байгаа юм.

Тэмцээнд оролцохын тулд аяллаар нэлээн явдаг нь түүнд багагүй асуудал үүсгэдэг байна. "Сүүлийн үед покерын тэмцээнүүд дэлхий даяар явагддаг болсон. Тэмцээнд оролцогсод маш сонирхолтой газруудаар явдаг гэж та нар бодож байгаа байх. Үнэндээ бол жуулчдын явдаг газраар явж, сонирхолтой зүйлс үзэхээсээ илүү, онгоцны болон зочид буудал, покерын ширээний ард ихэнх цаг маань өнгөрдөг. Ингэж аялахад би маш их ядардаг, иймд аяллын хуваариа багасгаж, цөөхөн тэмцээнд оролцдог болсон" гэж тэрбээр өгүүлжээ.

Покерын мэргэжил Крист зөвхөн эрх чөлөөт байдлыг авчраагүй, хэцүү зүйлтэй тулгарахад түүнтэй яаж харилцах талаар ч сургасан байна. "Хэдэн жил хязгааргүй Техас Холдем тоглосноор аливаа зүйлсийг хэрэгтэй цагт нь зөв байранд нь тавьдаг болов. Өдөрт 14 цаг ширээний ард суун тоглосны дараа ганцхан буруу шийдвэр тэмцээнийг дуусгавар болгодог учир жижиг зүйлүүдийг хүндээр тусган авах хэрэггүй. Бараг 20-иод жил покерын тэмцээнд тоглосны дараа аливаа нэг жижиг зүйлээс болж, бүх зүйл буруугаар эргэхэд түүнд их санаа зовдоггүй" гэж тэрбээр хэлсэн нь бий. Тэрбээр цааш нь хэлэхдээ "Покер нь хүнд хэцүү байдалтай байнга тулгардаг, иймд покерын ширээн дээрх хүндрэлтэй учирсны дараа түүнийг даван туулж, түүнд "мастер" болж чадвал, өөр хаана ч гэсэн "мастер" болж чадна гэв. Өөрөөр хэлбэл, покерын ширээн дээрх асуудалд "мастер" болж чадахгүй бол амьдралын өөрчлөлтийн бусад нөхцөлд ч "мастер" болж чадахгүй юм" гэжээ.

• • •

Крис цааш хэлэхдээ "Покер нь хүнд хэцүү байдалтай байнга тулгардаг иймд покерын ширээн дээрх хүндрэлтэй учирсны дараа түүнийг даван туулж, түүнд "мастер" болж чадвал өөр хаана ч гэсэн "мастер" болно. Өөрөөр хэлбэл, покерын ширээн дээрх асуудалд "мастер" болж чадахгүй бол амьдралын өөрчлөлтийн бусад нөхцөлд ч "мастер" болж чадахгүй юм гэжээ.

• • •

Крис покероос маш их сэтгэл ханамж, тааламжийг авч байдаг ч бусдад өөрийнхөө мэргэжлийн талаар зөвлөдөггүй. Мэргэжил бүхэнд байдаг шиг хүмүүс зөвхөн тоглоомд дурлах биш, түүнээс илүү олон зүйлийг хийх чадвартай гэдэгт тэр итгэдэг. Хэрэв өндөр түвшинд тогломоор санагдвал ур чадвараа байнга дээшлүүлэх хэрэгтэй.

Хүмүүс Крисээс түүнийг яаж ширээний ард ингэж амжилт олж байгааг олонтаа асуудаг. Тэдгээрийн дотроос түүний намтрыг мэддэг зарим хүмүүс амжилтыг нь "тооны ухааны мэдрэмж"-тэй нь холбож үздэг. Тийм ч байж магадгүй. Учир нь түүний хувьд тооны ухааны торгон мэдрэмж нь илүү их хөгжсөн гэж хэлж болно. Аав, ээж хоёр нь хоёулаа математикийн ухааны докторууд юм. Гэвч эцэг, эхээс улбаатай авьяас гэж бүрэн хүлээн зөвшөөрөхөд итгэлтэй биш байгаагаа Крис хэлдэг. Эцэг нь түүнд покерын математик аргачлалыг заахад их тусалсан хэдий ч тэрбээр өөрийнхөө авьяас чадвараар покерыг тооны ухаан талаас нь илүү эзэмшиж чадсанаараа амжилтад хүрсэн юм. Математик чухал гэж хүлээн зөвшөөрдөг боловч зөвхөн дангаараа юунд ч хүрэхгүй. Магадлалыг ойлгоно гэдэг чухал, мөн аливаа явцын логикийг ойлгох нь чухал. Эдгээрийг сайн эзэмшиж чадвал амжилттай тоглогч болоход эргэлзэх зүйлгүй билээ.

Крисийн бас нэгэн чухал чанар бол хүмүүс түүнийг уншихад маш хэцүү байдаг. Аливаа үйлдэл, зан төлөвөө арилгахын тулд маш шургуу ажилладаг тэрбээр ингэснийхээ хүчинд гартаа ирсэн сайн хөзрүүдээ зүгээр алдчихдаггүй. Ихэнх тоглогчид олон хүмүүсийн дунд, эсвэл зурагтын дурангийн өмнө тоглохоороо жирийн байдлаа алддаг. Крисийн хувьд сүүлийн шатанд тоглож байвал зурагт болон олон үзэгчдийг хайхардаггүй, зөвхөн тоглоомдоо л бүх анхаарлаа төвлөрүүлдэг байна. Түүгээр ч зогсохгүй бусад тоглогчдоо сайн уншиж чаддаг, ялангуяа тэдний худлаа хэлж байгааг тэр даруйд нь мэдэрч, ойлгож чаддаг. Намуухан, сэтгэлийн хөдөлгөөнгүй байдал нь домог болсон төдийгүй түүний тоглолтын чухал бүрэлдэхүүн хэсэг нь болдог. Ихэнх тоглогчид бүр заримдаа шилдэг тоглогчид хүртэл ямар нэг зүйл буруугаар эргэн алдахад маш ихээр уурлацгаадаг, харин Крис Фергюсон хэзээ ч тайван байдлаа алддаггүй.

Магадлалыг ойлгоно гэдэг чухал, мөн аливаа явцын логикийг ойлгох нь чухал. Эдгээрийг сайн эзэмшиж чадвал амжилттай тоглогч болоход эргэлзэх зүйлгүй билээ.

Тэрбээр зөвхөн тэмцээний тоглогч болсны дараагаар заримдаа өөрийгөө покерын ертөнцөөс гадуурх хүн шиг боддог. Ихэнх шилдэг тоглогчид тэмцээний дараа нөхөрлөцгөөн, тэр суусан бүрэлдэхүүнээрээ бүхий л шөнийн турш бэлэн мөнгөөр тоглодог, харин Крис мөнгөөр тоглодоггүй зөвхөн тэмцээнд оролцдог.

Покерын ширээний хувьд энэ нь түүнд чимээгүй, намуухан орчинг бүрдүүлж өгдөг гэж хэлж болно. Гарт ирсэн хөзөртөө тэр анхаарлаа бүрэн чиглүүлж тоглодог. Энэ бүхэн нь покероос тааламж таашаал авдаггүй гэсэн үг огт биш. Харин хурц зантай, хэл амаар их довтолдог хүмүүстэй тэр хамт тоглохдоо дуртай байдагт нь гайхмаар. Бие биендээ бүдүүлэг хандах нь түүний уурыг хүргэдэг цорын ганц зүйл төдийгүй покерт тийм орон зай байх учиргүй гэж тэр үздэг.

Крис Фергюсоны гадаад байдал нь намуухан, тайван ч тэрбээр маш чанга хатуу өрсөлдөгч. Хэзээ ч бууж өгдөггүй, өөрт ирсэн хөзрийн хэмжээнд хамгийн дээд түвшинд тоглодог. Тэр их,

бага хэмжээний шагнал гэж ялгадаггүй. Зарим тоглогчид бага хэмжээний шагналтай тоглолтод оюун ухаан нь аль хэдийнэ буугаад өгчихсөн байдаг. Харин Крис хасаа бариад сууж байвал өөрт байгаа бүх хүч чадлаа дайчлан тоглодог. Тэр бас ингэж тоглохоо ч амладаг. "Хүмүүс өөр өөр зүйлд хөтлөгдөн амжилтад хүрдэг, миний хувьд дуртай зүйлээ маш сайнаар гүйцэлдүүлэх нь чухал гэж үздэг" хэмээн тэрбээр хэлж байв.

Түүний тухай ChrisFerguson.com гэсэн сайтаас мэдээлэл авч болохоос гадна fulltiltpoker.net сайт руу орж түүнтэй тоглож болно.

Эдүгээ Крис хүүхдийн төлөө байгууллагыг дэмжиж Америк болон дэлхий даяар хүүхдэд хэрэгтэй зүйлд нь туслах зорилгоор ажилладаг байна.



Карлос Мортенсен

Аллен Каннингем бусдын л адил жирийн нэгэн хэдий ч покерын хамгийн шилдэг тоглогчдын нэг юм. Мэргэжлийн түвшинд 18 настайгаасаа эхлэн тоглож эхэлсэн тэрбээр 39 тэмцээнд ялалт байгуулснаас Покерын дэлхийн цувралын тэмцээнээс таван удаа бугуйвч авчээ. Калифорнид төрсөн, тайван, бодлогоширонгуй, найрсаг нэгэн бөгөөд 32 нас хүрээгүй байхдаа 2005 онд Покерын дэлхийн цуврал тэмцээний оны тоглогч, 2006 онд 35-аас доош насны хамгийн шилдэг тоглогчоор шалгарч байв.

2006 оны Покерын дэлхийн цуврал тэмцээнд дөрөвдүгээр байрт орсон амжилтаараа тэр 3.5 сая долларын шагнал хүртжээ. 2007 онд 300 мянган долларыг "Оройн Покер" тэмцээнээс, 325 мянган долларыг Вегасын нээлттэй тэмцээнээс, 2008 оны тавдугаар сард Цезарийн Ордонд болсон Покерын дэлхийн цуврал тэмцээнээс 500 мянган долларыг тус тус хожиж

байжээ. Нийтдээ 10 сая доллар хол давсан хожилтой тэрбээр онлайн тоглолтын fulltiltpoker.net-д мөн олны танил болсон юм. Одоогоор Лас Вегаст найз охин, хуучны хамтран тоглогч Мелисса Хэйдэн болон Маффин нохойтойгоо хамт амьдарч байна.

Би 1977 онд Өмнөд Калифорнид төрсөн юм. Аав маань Германд шилжин суурьших хүртэл бид цэргийн баазад дөрвөн жил амьдрал. Хүмүүс надаас Германы юуг нь санаж байна гэж асуухад хэлж чадах ганц зүйл нь "цас" байсан. Сургуульд орох жил буцаж, Оранж Каунтид нүүж ирэв. Дөрөвдүгээр ангид ороход Блүмингтон, Калифорнид шилжсэнээр бидний аялал төгсгөл болж, тэндээ ахлах сургуулиа төгстөл байлаа. Сургуулийн жилүүд нэг их онцлох юмгүй, бусдын адил жирийн л нэгэн шиг өнгөрсөн. Олон найзуудтай, гэхдээ би тэдэн дундаасаа тийм содон хүүхэд байгаагүй. Биднээс сурлагаараа цойлон гарсан хүүхэд цөөхөн, ер нь л дундаж хүүхдүүд. Би ч мөн адил гоц юмгүй, заримдаа ангидаа гайгүй сайнд орчихно, боломжийн дүн ч авчихна, спортоор хичээллэнэ, сургуулийнхаа хөнгөн атлетикийн багт орно, мөн каратегийн бор бүстэй болов.

Покерыг гэр бүлээрээ хамт тоглодог олон тоглоомуудын нэгэн адил сурсан. Бид хэзэр маш их тоглодог байлаа. Ажил хийж байгаа нэг нь шинээр дүрэм, тоглоом зохион тоглодог байсан нь их хөгжилтэй. Арван хоёр орчим настай байхдаа эдгээр тоглоомд би бүр орчихсон байсан. Тэгээд ч би нэлээн сайн тоглодог байснаас голдуу хожно. Энэ үед надад миний дотроос ямар нэг оч гэрэлтэж эхлэв. Арван таван настай байхдаа Лас Вегас ямархуу байдаг бол гэж бодох болов.

Ахлах ангид байхдаа ангийнхаа хэсэг нөхөдтэй хамт анх мөнгөөр тоглож үзэв. Герман сурагчдын амралтын газар бид олуулаа, хаа ч явсан бүгдээрээ хамт явж тоглодог байлаа. Тэнд амарч байх хугацаандаа таван доллараар таван хөзөр гаргаад нэг хөзөр далд хийж покер тоглов. Нэг жаал миний мөнгийг хожсон. Тэр одоо ч хүртэл энэ хавиар байдаг. Дараахан нь Лос Анжелесын коллежид элсэн орж, инженер мэргэжлээр сурч эхэлсэн. Энэ мэргэжил надад тохирсон хамгийн сайн зүйл гэдэгт би хэзээ ч итгээгүй. Уг нь би тоондоо сайн байсан төдийгүй сургуулиа төгсөөд мэргэжлээрээ ажиллана гэж бодож байлаа. Хэн мэдэх билээ, хэрэв би покер тоглож эхлээгүй бол хаа нэгтээ дөрвөн хананы дунд сууж, хэсэг мөнгө хадгалж байгаад, өөрийн бизнесийг эхлүүлнэ дээ гэсэн юм бодоод явж байх байсан болов уу, чөтгөр л мэдэх байх.

Тоглож эхлэх үедээ тоглоомын тухай өөрийн эрхгүй бодож байсан нь гарцаагүй үнэн. Мөрийтэй тоглоно гэдэг нь хүнийг донтуулдаг гэдгийг мэддэг байсан. Гэвч бусад олон хүний адил буцаж очсоор, буцаж очсоор, буцаж очсоор байлаа.

Коллежид сурч байсан жилийн эхний зунаас хэсэг нөхдийн хамт Энэтхэгийн казинод очин покер тоглодог болов. Пицца зөөж байж олсон хэдэн мөнгөө барин очдог байлаа. Тийм ээ, би пицца зөөдөг байсан. Инээдтэй малгай, хачин харагдуулдаг цамц өмсч, хөгийн царайлж ажил хийдэг байв. Казинод Техас Холдем, ер нь голдуу Долоон хөзрийн покер тоглодог байсан. Эхэндээ би тийм сайнгүй байгаагүй. Хэрэв хожихыг хүсч байвал өрсөлдөгчдөөсөө илүү байх хэрэгтэй гэдгийг хамгийн түрүүнд ойлгосон. Ийм тохиолдолд үнэхээр мөнгө хожих боломжтойг олж харсан юм.

Гэхдээ нийт дүнгээр нь авч үзвэл, миний алдсан мөнгө бас миний тоглолт бусад хүмүүсийн

адил хэмжээнд л байв. Харин би үргэлж толгойдоо шинэ стратеги боловсруулахыг бодож тоглоно. Гэхдээ тэр олон аргаас улам сайжирч хөгжсөн нь байхгүй. Заримдаа хожно, заримдаа алдана, нийлбэр дүнгээрээ олсноосоо алдсан нь их байлаа. Гэвч бууж өгөөгүй.

Их сургуулийн хоёрдугаар курст орсон жилээ бараг долоо хоног болгон казинод очиж тоглодог байлаа. Тоглож эхлэх үедээ тоглоомын тухай өөрийн эрхгүй бодож байсан нь гарцаагүй үнэн. Мөрийтэй тоглоно гэдэг нь хүнийг донтуулдаг гэдгийг мэддэг байсан. Гэвч бусад олон хүнийг адил буцаж очсоор, буцаж очсоор, буцаж очсоор байлаа. Тухайн үед мөнгөөр дутмаг байв. Хэрэв зуун доллар алдчих юм бол гэрээс коллежийн зардлын мөнгө иртэл нь хүлээгээд суучихна. Ирсэн мөнгөөр нь хямдхан хоол хүнс аваад, үлдсэнийг нь покерын ширээн дээр тавьж тоглоно.

Анхнаасаа надад покерын багш зааварлагч байгаагүй, хэн ч намайг дагуулж өөрийн далбаан дор авч явж, зөвлөгөө өгч байгаагүй. Би бүгдийг өөрөө хийж эхэлсэн, заримдаа нэлээн сайн тоглогч гэж харагдсан хүмүүсийг дууриан, хасаагаа дээш шидэн, тоо эсвэл толгой гарахыг үздэг байлаа. Бүр өөрөө ч шинээр арга сэдэн, заримыг нь сайн, заримыг нь муухан ашиглаж байсан.

Манай гэрийнхэн намайг покер тоглож байгааг ямар нэг хэмжээгээр мэдэж байсан ч хичээлдээ огт сонирхолгүй болж, покерт хамаг анхаарлаа төвлөрүүлж байсныг мэдээгүй юм. Тэгээд нэг их удалгүй сургууль дээр асуудалтай болж эхлэв.

Долоо хоног бүр тоглодог хэвээрээ л байлаа. Энэ хугацаанд "би ер нь юу хийгээд байна вэ?" гэж өөрөөсөө нухацтайгаар хэд хэдэн удаа асуусан. Алдах бүртээ, гэр рүүгээ буцаж явах үедээ болж өнгөрсөн бүх үйл явцыг толгойдоо бодож явдаг байв. Тэр үедээ юу нь буруу болсон, дараа нь тийм нөхцөлд яаж тоглох хэрэгтэй тухай давхар боддог байв. Гэвч дараачийн долоо хоногт казиногоос бас л алдчихаад гарч явахдаа маш их харамсдаг байсан ч, тэр бүхэн миний тоглохыг зогсоож чадаагүй юм.

Нэгэн удаа гэртээ харих замдаа хэтэрхий бодолд автсанаас болж улаан гэрлээр анзааралгүй орж, нэгэн эмэгтэйн машинтай мөргөлдөв.

Тэр эмэгтэй чичирсээр машинаасаа гарч ирэв. Энэ нь надад маш эвгүй санагдсан. Гэртээ жигнэмэг хийгээд хажуугийн асрамжийн газар хүргэхээр явж байсан тэр эмэгтэйн биед ямар нэгэн гэмтэл учраагүй ч тэрээр чичирхийлсээр л байж билээ. Энэ үед байдлыг харсан хүмүүс бүгд над руу муухай харж байсан. Тэгтэл цагдаа ирээд юу болсныг надаас асуухад, би өөрийнхөө явж байсан чиглэл, бас нөгөө эмэгтэйн чиглэл зэргийг хуруугаараа заан үзүүлж байгаад эргэхдээ хажуу талд хараад зогсч байсан бас нэгэн эмэгтэйн нүд рүү хуруугаараа хатгаж орхив. Удалгүй тэр хүний хараа сайжирсан гэж сонссон. Энэ бол надад тохиолдсон миний хамгийн хэцүү өдөр байсан хэдий ч покер сурах талаар бодож байсан бодлоос маань хэзээ ч хөндийрүүлж чадаагүй юм. Удалгүй энэ байдлаасаа би бүрэн ангижрав. Энэ бүхэн надад зөвхөн покерын ширээн дээр л бодлоо төвлөрүүлэх учиртайг ойлгуулснаас гадна эмэгтэйчүүдээс ч хол байхыг давхар ойлгуулав.

Тэр үед би өөрийн тоглолтын стратеги, тактикаа сайжруулахын тулд покерын номуудыг уншиж эхэлсэн. Тэдгээрээс олж мэдсэнээ жижиг тэмцээнүүдэд туршиж байлаа. Дойл

Брансоны "Супер систем" ном хамгийн түрүүн санаанд орж ирж түүнийг судалсан. Хоёрдугаар курсийнхээ зуны амралтаар тэмцээнд оролцож, хангалттай мөнгө цуглуулав. Гэхдээ дахин үргэлжлүүлэн тоглох мөнгө тийм ч хангалттай байгаагүйгээс алдвал нэлээн эрсдэлд орохоор байлаа. Хэрэв цааш үргэлжлүүлэх хангалттай мөнгөтэй байсан бол хожих магадлал бас нэлээн өндөр байв. Гэвч гайхалтай нь тэр тоглолтод 10:1 хасааны тэргүүлэгч болсон төдийгүй өрсөлдөгчид маань намайг яагаад ч дийлэхээргүй байдалд орцгож билээ. Эцэст нь би тэр тэмцээнд түрүүлж 150 долларын шагнал хүртэв.

Тэр мөнгөө аваад 6-12 долларын ширээнд тоглон, 200-300 доллар, удалгүй ахин 200 доллар нэмж хожоод, дараахан нь 500 доллар хожиж нийтдээ 1000 доллартай болов. Энэ нь урьд өмнө хэзээ ч хожиж байгаагүй мөнгө байв. Одоо эргээд харж байхад, энэ үеэс миний хожих ээлж маань ирсэн шиг санагддаг.

Эндээс юу мэдсэн бэ? гэвэл мөнгөө алдсанаас үүсдэг сэтгэл санааны хямрал, зан төлөвийн өөрчлөлт, донтолтыг зөвхөн хожил л эдгээдэг гэдгийг мэдэрсэн. Хэд хэдэн сайн хожил маань миний нэлээд олон алдаатай тоглолтын шархыг эмчлэх төгс эмчилгээ болсон. Алдсанахаа дараа дотроос шаналгаад, эргэж очиж тогломоор санагдана, ингэхдээ байгаа бүх мөнгөө авч очно. Хэрэв дахин алдчихвал буцаж очмоор санагдаад, эцэстээ энэ нь эрүүл биш үзэгдэл мэт санагдаж, донтолт болж хувирдаг байлаа. Тэгж байгаад нэг сайн хожвол удаан хугацааны хүнд хэцүү ажлын дараах амралт минь болдог байв. Үүнийг та бүхэнд тайлбарлах нь инээдтэй санагдаж магад, гэхдээ би хожиж эхэлснээр байнга тоглох гэсэн хүсэл маань аяндаа замхарч, би өөрөө ч тайвширч, амарч эхэлсэн. Хоёрдугаар курсээ төгсөх үед сургуулиасаа гарч, өдөр бүр покер тоглож эхлэв. Голдуу 6-12, 10-20 долларын ширээн дээр Холдем тоглож, байнга шахуу хождог байлаа. Энэ үеэс би өөртөө итгэлтэй болж, бас мөнгөө ч нэмэгдүүлж эхэлсэн.

Нэгэн удаа гэртээ харих замдаа хэтэрхий бодолд автсанаас болж улаан гэрлээр анзааралгүй орж, нэгэн эмэгтэйн машинтай мөргөлдөв. Тэр эмэгтэй чичирсээр гарч ирэхэд надад маш эвгүй санагдсан.

Манай гэр бүлийнхэн коллежийн шалгалт эхлэхээс өмнө намайг сургуулиасаа гарч байгааг мэдсэн. Тэд миний сургуулийн төлбөрт маш их мөнгө зарсан. Тэр мөнгийг нь би зүгээр л покерт цацсан. Тэд "покерчин гэж мэргэжил байдаг юм уу" гэж эсэргүүцэж байлаа. Манайхан намайг дараа жилээс нь эргээд сургуульдаа орно гэж бодож байсан ч тэдэнд би өөрийнхөө шийдвэрийг шулуухан хэлэв. "Яг одоогоор би мэргэжлийн тоглогч болоогүй ч гэсэн, энэ онгоцыг ингээд живүүлж чадахгүй" гэдгээ эрсхэн хэлж билээ.

Миний дараачийн зогсоол бол Лос Анжелес орчмын казинод том мөнгөний бооцоотой ширээнд тоглох явдал байлаа. Анх тэнд очихдоо 21-ээс дээш насныхныг тоглуулдаг гэдгийг мэдээгүй. Би тэгэхэд 18-тай байсан ч ширээнд суугаад тоглох гэтэл нэгэн тоглогч надаас "чи хэдтэй вэ?" гэж асуув.

"20-той" хэмээн худлаа хэлтэл, мэдээж намайг "ямар худалч гар вэ?" гэж бодсон биз, тэрбээр "21-тэй байж хууль ёсоор тоглох эрхтэй байдаг юм" гэж билээ. Үүнээс хойш хэн ч миний насыг асуугаагүй. Хэрвээ хэн нэгэн асуувал, шинэ найзынхаа зөвлөснөөр төвөггүйхэн "21-тэй" гэж хариулна хэмээн бодсон байлаа.

Удалгүй 20-40 долларын, заримдаа 40-80 долларын ширээнд тоглож 20 мянган долларыг амархан олов. Яг энэ цагаас эхлэн өөртөө илүү их итгэсэн. "Эльсинор нуур" казинстийн тэмцээнээс таван мянган доллар хожсон маань миний хувьд анхны том хожил байлаа. Тэгэхэд би дөнгөж 20-той байсан. Хожпын хувьд том байсан ч би түүхий байгаага мэдэрч байв. Хэрэв Лас Вегаст очиж тогловол илүү их туршлагатай, илүү дээд түвшинд покерыг тоглоно доо гэж бодож байх яг тэр үед 21 насны төрсөн өдөр хаяанд ирсэн байлаа.

Төрсөн өдрөөрөө "Four Queens Casino" буюу "Дөрвөн Хатан Казино"-д сонгодог покер тоглов. Сайн амжилт үзүүлж чадаагүй ч, энэ тоглолт надад маш их туршлага болсон юм. Өмнө нь зөвхөн номноос л уншиж байсан томчуудтай, тухайлбал, Эрик Сайдел, Стив Райдел нартай хамт тоглож үзэв. Хорин хоёртойдоо Лас Вегасын жижиг тэмцээнүүдэд орсон. Үнэндээ энэ тэмцээнүүд бол жижиг гарынхны тэмцээн байсан. Хорин гурван настайдаа Дугуйчдын Холбооны шилдэг тоглогчийн шагналыг хүртэв. Түүний дараа би таван том тэмцээнд түрүүлсэн. Тэр дундаа Покерын дэлхийн цуврал тэмцээний 5000 долларын Омаха 8 ба түүнээс дээш төрөлд Ховард Ледерерийн дараа хоёрдугаар байрт оров. Энэ цагаас л миний бүх амжилт эхэлж, хожил минь шуурганд давал гаалсан юм шиг ар араасаа цуварч эхэлсэн дээ.

Үнэндээ энэ тэмцээнүүд бол жижиг гарынхны тэмцээн байсан юм. Хорин гурван настайдаа Дугуйчдын Холбооны шилдэг тоглогчийн шагналыг хүртэж, дараахан нь таван том тэмцээнд түрүүлж, Покерын дэлхийн цуврал тэмцээний 5000 долларын Омаха 8 ба түүнээс дээш төрөлд Ховард Ледерерийн дараа хоёрдугаар байрт оров. Эндээс амжилтын шуурганд орсон юм шиг хожиж эхэлсэн дээ.

Майк Секстоны аваргын тэмцээнд сүүлийн шатанд тоглохоор казиногийн танхимд орж ирэхэд надад гайхамшигтай мэдрэмж төрсөн. Тэрхэн агшинд Майк Секстон "Покерын ертөнцийн өсч буй шинэ од Аллен Каннингхем орж ирлээ" хэмээн танхимд цугласан олны өмнө чангаар зарлав. Тухайн үед надад үнэхээр "би ороод ирлээ шүү дээ" гэсэн мэдрэмж төрсөн. 2002 онд Покерын дэлхийн цуврал тэмцээнээс анхныхаа бугуйвчийг авсныхаа дараа зүрх сэтгэл нэг л өөрчлөгдөж ирээдүйнхээ тухай бодож эхэлсэн. Тэгээд Санта Моника коллежид орж суралцан, дугуу үлдээсэн кредитээ гүйцээж, Лос Анжелесын коллежид дахин орохоор хичээн, суралцаж эхэлсэн. Энэ үеэр покер тоглохоо нэлээд багасгав. Тэр үед ганцхан анги үлдчихсэн, хэрвээ түүнийгээ төгсчихвөл, дугуу кредитээ дуусгаад Лос Анжелесын коллежид эргэж орох гэж байсан юм. Чухам тэр үед улс орон даяар покерын "тэсрэлт" болсон. Тэр үед Мөнгө хүүлэгч хочит Крис покерын дэлхийн цуврал болон Покерын дэлхийн аялан тоглолтод түрүүлсэн нь покерын ертөнцөд маш том "өдөөлт" болов. Эндээс эхлэн покер хаа сайгүй түгээмэл болж, энд тэндгүй том том шагналтай томоохон тэмцээнүүд зохиогдох болсон юм.

Ягэнэ үед би ахин сургуулиасаа гарч, покерыг дахин тоглох болсон нь тэсрэлтийн өмнөх үе байлаа. Сургуульдаа буцаж орсон нь надад саад болоогүй ч харин оюуны хурц хараа маань улам цэгцэрч, тоглоомны хувьд бүр ч ашигтайгаар эргэсэн. Би эргээд, покерын ширээн дээрээ суух тэр үед, надад өөрийгөө дахин цэнэглэсэн мэт шинэ эрч хүч амтагдаж байлаа.

Эндээс юу мэдсэн бэ? гэвэл мөнгөө алдсанаас үүссэн сэтгэл санааны хямрал, зан төлөвийн өөрчлөлт, донтолтыг зөвхөн хожил л эдгээдэг гэдгийг мэдрэв.

Би покертоо эргэн ирж, тоглохдоо Лас Вегасаас гадна Атлантик Сити, Туника, Миссисипи мөн Австрийн Венад хүртэл өөрийн найз Даниел Нигрэнугийн хамт очиж тоглож байсан. Томчуудын дунд тоглож эхлэх эхний үед тэд бидэнд тун тааламжгүй ханддаг байлаа. Хуучин ахмадуудын хүрээлэлд шинэ залуус орж ирэхийг тэд шууд хүлээн зөвшөөрч чадахгүй байв. Нэгэн удаа 1000 долларын хязгааргүй тэмцээнд Фил Хэлмуттай хамт тоглож байсан. Тэр тэмцээнд би сайн тоглож, Фил ч мөн адил нэлээн ширүүн, үгээр их дайрч байснаа эцэстээ "Томчуудын лигт тавтай морил, хүүхээд..." гэж билээ.

Би ямар ч үед тайван байдгаараа алдартай. Ширээн дээр тоглож байхдаа ямар ч хэцүү байдалд орсон түүнийгээ нууж чаддаг. Намайг элдэв үйлдэл хийж, уурлаж ундууцахыг хүмүүс хэзээ ч хараагүй. Покер тоглогчдын дунд тоглоомын явцдаа бие биенээ дайрах, үгээр довлох, дууны өнгөө өөрчлөх зэргээр эсрэг тоглогчдоо жижигрүүлэх алхам их хийдэг. Үнэндээ бол энэ аргууд мэргэжлийн покерчдод тэгтлээ их сайнаар нөлөөлдөггүй.

Энэ хугацаанд би хэсэг сайн тоглогчидтой сайхан харилцаа тогтоов. Тэдэн дундаас Даниел, Жон Жуанда нартай илүү дотно нөхөрлөсөн юм. Бид бие биенийхээ эсрэг тоглоогүй үедээ харилцан бие биедээ туслахыг боддог. Бүх тоглогчид өөрсдийн өвөрмөц арга барилтай, Даниел гэхэд эсрэг тоглогчдыг ямар хөзөртэй байгааг бараг хэлж чадах гайхалтай чадвартай. Магадлалд гүнзгий мэргэшсэн, түүндээ суурилж тоглодог олон тоглогч бий.

35-аас доош насны ангилалд шилдэг тоглогчоор шалгарсандаа би маш их бахархдаг. Ширээний ард тайван, чимээгүй байдал маань намайг голчлон авч явдаг гэж хэлж болно. Тэр маань ч намайг ийм алдарт хүрэх үндсэн шалтгаан болсон юм.

Покерын тэмцээнүүд зурагтаар гарч эхлэхээс өмнө ширээний ард ширүүн байдал, маш хурц өрсөлдөөн, солиотой гэмээр ч араншин зарим тоглогчдоос их гардаг байсан. Зарим нэг нь иймэрхүү сөрөг төрх байдлаа зурагтын дуран авайд өртөх бас нэг боломж олгон ашигладаг байв. ESPN телевизийнхэн бичлэгтээ засвар хийсний дараа гаргадаг байсан ч чанга ярьдаг, содон хүмүүс дэлгэцэнд гарах нь их.

Миний хувьд намуухан, тайван байдлыг эхнээсээ сонгосон энэ нь ч надад маш сайн тохирсон гэж боддог. Тэгээд ч өөрийгөө сайн хянадаг, ингэснээр сэтгэлийн хөдлөл ихтэй хүмүүс циркт байгаагаас өөрийгөө ялгаж чаддаг юм. Хэдий тийм боловч заримдаа хүндхэн үе тохиолддог, голдуу чалчаа үглээ хүмүүс хажууд суун утга учиргүй бурж эхлэхэд үнэндээ надад байж суух газар олдохгүй хэцүү байдаг.

Гэртээ бол өөр, онлайннар тоглож байхдаа хашгирна, үсэрнэ, дэлгэц рүүгээ чичлэнэ, учир нь намайг хэн ч сонсохгүй. Мөн том хожил авахдаа би баярладаг, бас олон хүнд гэнэтийн бэлэг барьдаг. Хэрэв онлайннар том хожвол үсрэн дэвхцэж, хашгирч яг л хүүхэд шиг аашилна. Гэхдээ сүүлийн үед муухан тогловол бага хашгирч сайн тогловол улам их тэмдэглэж, бусдыг баярлуулдаг.

Харин бодит тоглоомд хэзээ ч сэтгэл хөдлөлөө харуулдаггүй. Сайн тоглогчдын нэг Бобби Хофф нэгэн удаа "Чам шиг сэтгэл хөдлөлөө нууж чаддаг хүмүүсийг хожих хэцүү байдаг" гэж хэлсэн нь одоо хүртэл надад байнга санагддаг.

Харин баярлаж хөөрсөн сэтгэлээ гольф тоглохдоо ихээр гаргаж байгаа. Сайн цохилт хийснийхээ дараа уухайлан баясч, баярлаж хөөрдөг дөө. Энэ нь ямар нэг хэлбэрээр надад нэмэр болдог ч байж магадгүй.

Миний хувьд покерын талаар судалж, нухацтай хандаж эхэлсэн үеэс л өөрийнхөө мэдрэмжид нэлээн итгэдэг болсон. Би ширээний ард тоглож байх үедээ, шинжилгээ дүгнэлт хийхдээ, хувилбар тус бүрийн байж болох нөхцлүүдийг нарийвчлан тооцож гаргадаг. Ингээд энэ бүхэнд үндэслэн өөрийн мэдрэмж, туршлагаа ашиглан тоглолтоо үргэлжлүүлдэг.

Харин одоо би амьдралын өөр шатанд орсон, тоглох гэж үргэлж бодохоо больсон. Яг энэ өдрүүдэд покерын ширээний ард суугаагүй ч гэсэн маш их аз жаргалтай байгаа, үнэндээ бол томоохон, чухал "амьд" тэмцээнүүд л тоглох хүслийг төрүүлдэг болсон. Сүүлийн үед онлайнаар мөнгөөр тоглодог тэмцээнд их оролцож байгаа. Тэгээд ч бодит тэмцээнээс бусад үед казино орохоо ер нь больсон.

Planet Poker, Paradise зэрэг интернэт покер гарч эхлэнгүүт онлайнаар покер тоглож эхэлсэн. Full Tilt Poker нээгдснээр би онлайн тоглоомд бүр их татагдаж орсон. Түүгээр барахгүй би одоо Full Tilt -н багийн гишүүн. Би онлайнаар тоглох маш их дуртай. Онлайн тоглоомд амьд тоглолтоос ч илүү сайн тоглодог юм шиг надад санагддаг. Гэхдээ тэмцээн эхлүүт амьд тоглолтоос илүү их сэтгэл ханамж авдаг.

Онлайнаар тоглохдоо олон ширээн дээр нэгэн зэрэг тоглолт хийх нь илүү амжилт олох боломжтой. Интернэтээр тоглохдоо стратегиэ боловсруулж, эхлээд өсгөх, дахин өсгөх, тэгээд болих гээд ирсэн хөзрүүдэд тохируулан тоглодог боловч нэг ширээн дээрх 6-8 хүний тоглолтын төлөв хандлагатай бүгд таарна гэж байдаггүйг ойлгосон юм. Тэгээд ч түүнээс ч олон ширээ байгаа шүү дээ.

Мэдээж нэг ширээн дээрх тоглоомдоо бүх анхаарлаа төвлөрүүлэн тоглох нь хамгийн шилдэг стратеги юм. Онлайн тоглоомын үйлдэл төлөв бодит тоглоом шиг биш боловч бас адил зүйлс байж л байдаг. Эсрэг тоглогчдынхоо царайг харахгүй байгаа ч хэн няхуур тоглож байна, хэн хамаагүй байнга өсгөж байна, хэн хэзээ ч өсгөхгүй байна, хэн худал хэлж байна, шударга тоглож байгаа эсэхийг мэдэх бүрэн боломжтой.

Би өөрийн амьдралдаа үнэхээр сэтгэл хангалуун байдаг. Хэрэв хүсвэл би тоглоно, заавал бүх том тэмцээнд орно гэж зүтгэдэггүй, надад тийм сонирхол байхгүй, амрах хэрэгтэй бол түүнийг алгасна.

Хэдэн сарын өмнө Европт болсон хэд хэдэн тэмцээнд оролцов. Харин буцах замдаа зүүн эрэгт болсон хоёр том тэмцээнд оролцох боломжтой байсан ч оролцоогүй юм. Хэрэв хүсвэл хаана, хэзээ тоглохоо би өөрөө шийддэг. Хол газар тогловол 10 мянган доллараас бага оролттой тоглоомонд оролидоггүй, харин Лас Вегаст бол 2000 долларын оролттой тэмцээнд ордог. Учир нь заавал аяллаар явах шаардлагагүй байдаг.

Покерчдын дунд тоглоомын явцдаа бие биенээ дайрах, үгээр довтлох, дууны өнгөө өөрчлөх зэргээр эсрэг тоглогчдоо жижигрүүлэх алхмуудыг их хийдэг.

Магадгүй, миний хамгийн сайн тоглодог тоглоом бол хязгааргүй Холдем байх. Түүнийг тоглох бүртээ хожиж чадна гэдэгтээ би итгэдэг. Тэнд хожих мөнгө, бас томчуудтай хамт тоглож, өөрийн чадвараа сорих боломж их бий. Би бас бусад тоглоомыг ч сайн тоглоно. 10 мянган долларын супер холимог тоглолт ч бас миний тоглох дуртай тоглоомын нэг. Тэнд 5 хязгаартай HORSE тоглоом, дундын хязгаартай Омаха, хязгааргүй Холдем багтсан байдаг. Би энэхүү холимог тоглоомд үнэхээр дуртай. Харин Бадугид би муу, ерөөсөө тоглож чаддаггүй юм. Одоогоор түүгээр тоглодог шилдэг тоглогчид надаас хамаагүй илүү, гэхдээ надад бас өсөх боломж байж л байна.

Покероор сайн амжилт олсон хэдий ч бусад залууст үүнийг мэргэжлээ болгоорой гэж би зөвлөхгүй. Маш олон хүн хурдан аргаар мөнгө олохыг хүсдэг, үүнд бас маш олон хувилбар ч мөн бий. Өөрийгөө хэр зэрэг сайн тоглогч вэ? гэдгийг мэдэхийн тулд нэлээд хэдэн жил зарцуулах шаардлагатай. Шинэ тоглогчид маш их мөнгө алддаг, зарим тохиолдолд покер нь тэдний хувьд мөнгө хийх арга биш юм гэдгээ мэдэхээс өмнө бүх юмаа алдаад дуусах нь ч бий. Покер бол "мастер" болох өөр тоглоом гэдгийг ойлгох хэрэгтэй. Дөнгөж тоглож эхлүүт бага зэрэг амжилт олсон хүмүүс байдаг л юм. Гэвч энэ нь үнэхээр чадвар байв уу, эсвэл аз байсан уу гэдгээ тэд мэддэггүй. Би олон ч тоглогчдыг харсан, тэд буруу тоглодог боловч заримдаа азаар хожсон байдаг.


Харин покер тоглож, мөнгө олохоор бодож байгаа хүмүүст зөвхөн хобби төдий л тоглоорой гэж зөвлөх байна. Өдрийнхөө ажлыг хадгалж үлд, покерыг хөнгөнөөр тусгаж ав. Ямар нэг амжилтын түүхийн цаана мянга мянган алдсан хүмүүс байдаг гэдгийг байнга санаарай.

Би покер тоглоогүй үедээ видео тоглоом эсвэл гольф тоглодог, бас далбаат завиараа аялах дуртай. Гольф тоглохдоо ч бас их дуртай. Найз охин Мелисса маань хүртэл покер тоглогч, гэхдээ олон цагаар тоглодоггүй учраас бидэнд хамт байх цаг хугацаа зөндөө байдаг.

Ирээдүйд ямар нэг боломжийг хайж байгаа, гэхдээ түүндээ яарах юм надад алга. Надад цаг хугацаа байна. Покероос хангалттай мөнгө хийсэн, гэхдээ цаг хугацаа өнгөрөх тусам зарцуулах хугацаа багассаар ирсэн. Покер бол миний амьдралын нэг хэсэг, үүнийгээ би зүгээр л орхичихно гэж бодохгүй байна.

Покерын түүхчид намайг юу гэж дурсахыг би мэдэхгүй, гэхдээ дээд зэрэглэлийн тоглогчдын тоонд багтана гэдэгтээ би итгэлтэй байдаг.

Мөн өнөөгийн амжилтандаа сэтгэл хангалуун байдаг ч хамгийн чухал орчин нөхцөл, хамгийн сайн цаг хараахан ирж амжаагүй байгаад итгэдэг. Харин хэзээ, яаж ирэх бол гэдгийг хэлж мэдэхгүй юм. Ямар байдлаар эргэсэн ч хүмүүс намайг сайн хүн, аливаа зүйлийг тийм ч хүндээр тусгаж авдаггүй хүн гэж бодоосой хэмээн чин сэтгэлээсээ би хүсч байна.



Эрик Сайдел

Карлос Мортенсен покерын түүхэнд, 2007 онд Покерын дэлхийн аялан тоглолт болон Покерын дэлхийн цувралын Main Event тэмцээнд хоёуланд нь зэрэг түрүүлсэн анхны тоглогч юм. Тэрбээр анх 1999 онд Покерын дэлхийн цуврал тэмцээнд тоглосныхоо дараа жил нь эцсийн шалгаруулалтын ширээнд хүрч чадсан билээ.

Түрэмгий чанар, цуцашгүй өрсөлдөгч байдлаараа тэр 2001 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний Main Event-д анх удаагаа түрүүлж, 1.5 сая доллар хожсон байна. Хоёр дахь бугуйвчаа 2003 онд Покерын дэлхийн цуврал тэмцээний хязгаартай Холдемын 34 дахь тоглолтод түрүүлж хүртсэн юм. 2006 онд амжилттай тоглож, томоохон гурван тэмцээний сүүлчийн шалгаруулалтын ширээнд сууж чадав. Тэрбээр Покерын дэлхийн цуврал

тэмцээнээс гадна Покерын дэлхийн аялан тоглолтод хамгийн амжилттай оролцож байна. Бүх үеийн хамгийн их хожсон тоглогчдын нэг. Карлос Мортенсен Покерын дэлхийн сүүлчийн цуврал тэмцээнд түрүүлсэн хамгийн шилдэг мэргэжлийн тоглогч төдийгүй өөр олон тэмцээнд оролцож маш их мөнгө хожсоор байгаа юм.

Би Эквадорын Амбато хотод төрж, ферм дээр өссөн. Залуудаа би тийм сайн оюутан байгаагүй, сурахдаа бага зэрэг залхуу байлаа. Сурах нэг их сонирхолгүй байсан гэж хэлж болно. Хүүхэд байхдаа нисэгч болно гэж мөрөөддөг байснаа санадаг юм. Бүр багаасаа л биеэ даасан байдалтай болсон. 12 настайгаасаа сэтгэл зүйн хувьд чөлөөтэй байж, хаа сайгүй аялахыг хүсдэг болов. Дугуйгаа автобусанд ачиж аваад, хаа нэгтээ очиж, хөдөө нутгаар аялна, заримдаа хагас бүтэн сайн өдөр бүтэн аялдаг байлаа. Байнгын шинэ өөрчлөлтийг би хайж байсан төдийгүй аялах хобби маань хожим миний амьдралд сайнаар нөлөөлсөн юм. Манай гэр бүлийнхэн намайг 18-тай байхад Испани руу нүүснээр би тэндхийн иргэн болж шинэ амьдрал эхлэв.

• • •

Байнгын шинэ өөрчлөлтийг би хайж байсан төдийгүй аялах хобби маань хожим миний амьдралд сайнаар нөлөөлсөн юм.

• • •

25 нас хүртлээ долоо найман жил Техас Холдемийг сурахаасаа өмнө би Испанид янз бүрийн ажил хийж амьдрахын төлөө зүтгэж байлаа. Би нэлээн нүүдэлчин маягтай, ойр ойрхон ажлаа сольдог байв. Шатрын клубт байнга очно. Тэнд Гонзало Гарсиа Пелауотой танилцав. Тэрбээр рулет дээр мөрийтэй тоглодгоороо алдартай, төдийгүй Испанид анх Холдемийг дэлгэрүүлсэн юм.

Гонзало Гарсиа Пелауогийн түүх маш сонин. Тэрбээр 1990-ээд оны эхээр хэд хэдэн рулетийн ширээнүүдийг ажиглан судалсны эцэст тэдгээр нь санамсаргүй биш байдлаар, тухайлбал тоо хэмжээ, нүхний том жижгээс хамаарч тодорхой төлөв давтагдан ажиглагдаж, энэ бүхнээс шалтгаалан зарим тоонууд ихэвчлэн гарч ирдгийг олж тогтоосон юм. Тэрбээр өгөгдөл мэдээлэлд статистик судалгаа хийснээр дээд амжилт тогтоон, тоонуудыг тааж байлаа.

Гарсиа Пелауо ийнхүү түгээмэл гарах тоог судалсны үр дүнд, таван хувийн сул талыг 15 хувийн давуу тал болгон Европын казинонуудыг өөрчлөв. Тэрбээр өөрийнхөө энэ системийг ашиглан хэдхэн жилийн дотор хоёр орчим сая евро хожив. Үүний үр дүнд миний очдог байсан шатрын клуб эцэстээ покерын ордон болон хувирсан юм.

Би покерын талаар ямар ч ойлголтгүй байхдаа халаасандаа 100 доллартай явж байгаад нөгөө клубтээ анх очиж тоглов. Ядаж хэдэн цаг тоглох байх гэж бодож байлаа. Тэр өрөөнд Гарсиагаас өөр хэн ч Техас Холдем покер мэдэхгүй бүгд л анхан шатныхан байв. Тэр дунд нь мэдээж би хүртэл байлаа. Анхны өдрөө мөнгөө бүгдийг нь алдав. Чухам тэр өдөр л тоглоомын төлөөх хүслийг минь асааж өгсөн юм.

Мөнгөө алдсаншөнөө би унтаж чадалгүй, тоглоомын тухай дахин дахин бодсоор, ер нь яаж

тоглодог юм бол, ирсэн хөзрөө яаж алдахгүй байж болох байсан бэ, яавал их мөнгө хожиж болох вэ? гэж элдвийг бодсоор маргаашийн тоглоомд очсон юм. Тэгж шөнөжин бодсоны ачаар ч юм уу, маргааш нь 120-130 доллар хожив. Яг хэд вэ? гэдгээ одоо санахгүй байна. Ямартаа ч тэр үед алдсан мөнгөнөөсөө ихийг хожсон нь чухал байлаа.

Маргааш өдөр нь мөн хожиж, улмаар дөрвөн өдөр дараалан хожив. Покер тоглож олсон мөнгөөрөө амьдардаг хүмүүс байдаг талаар ямар ч ойлголт байгаагүй ч "би покерт сайн юм байна" гэсэн мэдрэмж анх удаа тэгэхэд л төрж билээ.

Гэр бүлийнхэндээ покер тоглодог тухайгаа би огтхон ч хэлээгүй. Тухайн үед Испанид покерыг хуулиар хориглоогүй ч тоглохыг зөвшөөрдөггүй байлаа. Бид нэгэн удаа покер тоглож байтал цагдаа нар гэнэт дайрч орж ирж бүгдийг нь баривчилж, нэр ус бүртгэж, зурагтаар гаргасны дараа манай гэрийнхэн намайг покер тоглодгийг мэдсэн юм. Тэрхүү дайралтын бичлэг бүхий сурвалжлага хэсэгтээ л олныг шуугиулсан мэдээлэл болов. Тэр үед хэвлэлийнхэн надаас ярилцлага авч, тэдэнд би мэргэжлийн покерчин болж, Лас Вегаст очиж, Покерын дэлхийн цуврал тэмцээнд оролцоно гэдгээ хэлэв. Гурван жилийн дараа би хүссэн газраа очиж санаснаараа хожиж билээ.

•••

1997 оны покерын дэлхийн аваргын төлөөх цуврал тэмцээний 10 мянган долларын хязгааргүй тэмцээнд түрүүлж, нэг сая долларын шагналыг авсан С.Унгарын зургийг харснаа санаж байна. Тэрбээр өөрийн таних тэмдэг болсон хар шил зүүж, нэг сая доллараа ширээгээр нэг тараасан байдалтай гарсан байв. Түүний тэр зураг надад гүн сэтгэгдэл төрүүлэв.

•••

Покерын дэлхийн цуврал тэмцээнд түрүүлсний дараа авахуулсан Стю Унгарын зураг сонины спортын нүүрэнд гарсан байсныг нэгэн өдөр Гарсиа Пелауо авчирч ханандаа өлгөв. Тэр сонинд С.Унгарын талаар мэдээлэл нийтлэгдсэн байлаа. Тухайн үед түүнийг "Техас Холдемийн тэмцээн дэх хамгийн аугаа хүн" хэмээн магтан ярьцгааж байв. С.Унгар нь Покерын дэлхийн цуврал тэмцээний Main Event-д гурван удаа түрүүлсэн цорын ганц тоглогч юм. Мөн тэрбээр "Amarillo Slim's Super Bowl of Poker" тэмцээнд гурав түрүүлсэн цорын ганц хүн байв. 1997 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний 10 мянган долларын хязгааргүй тэмцээнд түрүүлж, нэг сая долларын шагналыг авсан С.Унгарын зургийг харснаа санаж байна. Тэрбээр өөрийн таних тэмдэг болсон хар шил зүүж, нэг сая долларыг ширээгээр нэг тараасан байдалтай гарсан байв. Түүний тэр зураг надад гүн сэтгэгдэл төрүүлэв.

Тэр сониноос уншаад би нэгэн гайхалтай зүйлийг олж мэдсэн. Америкт покер тоглох нь нууцлаг байдалд бус хуулиар зөвшөөрөгдсөн болохыг ойлгов. Хүмүүс тэнд покероор мөнгө хийж болдог юм байна, С.Унгар мэтийн хүмүүс маш их мөнгө хийж чаддаг юм байна гэдгийг ойлгосон. Гарсиа намайг урамшуулж, "покерыг мэргэжлээ болго, чамд авьяас байна, би түүнд итгэж байна" гэж омогшуулдаг байлаа. Тэрбээр бас надад "чадвараа улам нэмэгдүүлж, боловсронгуй болговол, амжилт чамайг хүлээж байна" хэмээн зөвлөж билээ.

Тэр мөчөөс эхлэн би покерыг мэргэжлээ болгосон. Хязгаартай Техас Холдемийг зогсолтгүй

дөрвөөс аравдугаар сар хүртэл тоглов. Гарсиа Пелауогийн тоглоомд голдуу л хоёроос дөрөв, эсвэл гурваас зургаан доллараар тоглодог, би бараг тоглох болгондоо хождог, тоглолт цөөхөн явагддагаас миний санаанд хүрэхээ больж эхлэв. Гарсиагийн тоглоом тэр хавьд байгаа миний ганц тоглоом байлаа. Тэндхийн 20 орчим хүмүүс түүгээр эргэлдэн тоглоно. Өнөөх л хүмүүс өнөөдөр, маргааш гээд л давтагдана. Эндээс би уйдаж эхэлж, өөр зүйлийг хүсч эхлэв.

Атлантик Ситид очиж авьяасаа сорихоор шийдсэн аялал маань мэдээж хүнд байсан. Миний бүх зүйл нэг үүргэвчинд багтаж, би ганцаараа явав. Дээр нь бас англиар ярьж чадахгүй.

1997 оны 10 дугаар сард надад хоёр сонголт байв. Нэг нь Чирибито. Тэр нь Испанид нэлээн түгсэн покер тоглоом юм. Тоглож байгаа хүмүүсийнхээ тооноос хамаарч 28, эсвэл 32 хөзрөөр тоглоно. Нэг хүнд 7-8 хөзөр очно, газарт хоёр хөзөр доош нь харуулж тавина, Холдемд хоёр хөзрөө гартаа авна, нэлээд өрсөлдөөнтэй тоглоом. Энэ тоглоомд аль нэг нь страйт болвол, дараагийн хүн чинь флаш, түүний дараагийнх нь фүл хаустай байх бүрэн боломжтой. Би түүнийг өмнө нь бараг тоглож байгаагүй. Бас тэр тоглоомоор амьдардаг хүмүүсийн эсрэг тоглоно гэхээс бас эмээж байлаа. Учир нь би Холдем тоглогч байв. Хоёр дахь сонголт маань Америкт очиж Атлантик Ситид тоглох явдал.

Америк бол покерын "эх орон" гэдгийг төвөггүйхэн мэдэв. Ялангуяа Холдем маш түгээмэл байлаа. Атлантик Ситид очиж авьяасаа сорихоор шийдсэн аялал мэдээж хүнд байв. Миний бүх зүйл нэг үүргэвчинд багтаж, би ганцаараа явав. Дээр нь би англи хэлний анхан шатны мэдлэгтэй. Аялал маань өөрөө сорилт болов.

Анх Нью Йоркт буугаад Жон Кеннедийн нисэх онгоцны буудлаас нэгэн үл таних хүнээс Атлантик Сити рүү яаж явах талаар асуухад, Манхэттен ороод тэндээсээ метро, дараа нь автобусаар явахыг зөвлөв. Атлантик Ситид очиход надад гайхамшигтай сэтгэгдэл төрөв. Тэндхийн гудамж, дэлгүүр, наран шарлагын газрууд дээрээс нь мэдээж мөрийтэй тоглоом гээд бүгд тасархай.

Надад ердөө л 2800 доллар байв. Хямдхан амьдарч, покер тоглохдоо бусад мөнгөө зориулна гэж төлөвлөж байсан ч тэрхүү бодол маань талаар болов. Харин тэнд амьдралын өртөг өндөр гэдгийг толгой руугаа цохиулсан юм шиг мэдэж авсан даа. Тэр хавиар хоноглох газар хайтал, хоногт 150-250 доллар гэсэн нь намайг гайхшралд оруулж, амаа ангайхад хүргэв.

•••

Атлантик Ситид тоглосон миний ширээнд маш олон сайн тоглогчид байснаас зарим нь бүр намайг төрөхөөс өмнө тоглож эхэлсэн туршлагатай тоглогчид байв. Би хэтэрхий олон гаруудтай тоглож байгаагаа мэдэхээсээ өмнө өөрт байсан 475 доллараа анхны өдрөө л алдав.

•••

Миний тэнд байж болох хугацаа 15 хоног л байв. Зөвхөн буудалд 200 доллар төлнө гэвэл дангаараа л 3000 доллар давах байлаа. Тиймээс гадуур явж, орчин нөхцөл муутай хороололд өдрийн 22 доллараар байрлахаар болов. Гэвч тэр газар мэдээж Риц Карлтон биш байлаа.

Тэнд байхдаа би үнэхээр дургүй байсан. Гэвч хямд аргаар хэд хонох хэрэгтэйгээ мэдэж байв. Хожихгүй бол Испани руугаа буцахад ч бэлэн байлаа.

Америк дахь миний анхны тоглоом бол 2-4 долларын хязгаартай Холдемийг Тропиканад тоглосон явдал байв. Ширээн дэх тоглогчдын тоо миний анхны бодол байлаа. Испанид бол таван хүнтэй л тоглоно, харин тухайн үед есөн хүн байсан. Миний покерын стратеги бол цөөхөн хүний эсрэг тоглоход үндэслэсэн байсан нь эхний тоглоомоос л шууд надад мэдрэгдэв.

Түүнчлэн "мэргэжлийн" тоглогчдын өмнө тоглож байгаагаар ч бас мэдрэв. Испанид бол Гарсиатай л тоглоно, түүнийг би дандаа л хождог байлаа.

Харин Атлантик Ситид тоглосон миний ширээнд маш олон сайн тоглогчид байснаас зарим нь бүр намайг төрөхөөс өмнө тоглож эхэлсэн туршлагатай тоглогчид байв. Би хэтэрхий олон гаруудтай тоглож байгаагаар мэдэхээсээ өмнө өөрт байсан 475 доллараа анхны өдрөө л алдав.

Нэлээн хүнд байдалд орж, гадагш гарч халуун зайдас авч идэв. Үнэндээ тэр л миний авч чадах зүйл байсан. Ингээд яаж тоглосноо эргэцүүлэн бодож, арай өөрөөр тоглохыг бодов. Мэргэжлийн тоглогчдыг харж суухдаа тэднээс маш их зүйлийг олж мэдсэн. Миний англи хэл тийм сайн биш ч гэсэн тэдэнтэй ярих хэрэг огт гарахгүй, орчуулах ч хэрэггүй байлаа.

• • •

Өрсөлдөгчид маань намайг "маш дайчин, заримдаа галзуу юм шиг тоглож байна" хэмээн боддог байв. Би тэрхүү тоглолтдоо дуртай, тэр бүхэн ч надад давуу талыг өгч байлаа. Тэд сохроор хамаагүй мөнгөө өсгөхийг хүсдэггүй байв. Гэвч би тэднийг хүчээр их хасаа түлхэх шийдвэр гаргахад хүргэдэг байсан.

• • •

Юу сурснаа маргааш нь хэрэглэсээр гэртээ харихынхаа өмнө 15-30 долларын тоглоом тоглодог байлаа. Тэр ч бүү хэл гэртээ харихдаа 10 мянган доллар халаасандаа хийсэн удаа бий. Нутагтаа ирээд Чирибито дахин тоглож эхэлсэн. Чирибито бол хязгааргүй тоглоом. Харин Америкт голдуу хязгаартай Холдем тоглоно.

Гэхдээ хязгааргүй Чирибито тоглоомын туршлага маань хязгааргүй Холдемоор тоглож амжилт гаргахад минь надад ихээхэн тус дэм болсон гэдэгт би одоо ч итгэдэг.

1997 онд би Америк руу хоёр дахь аяллаа хийв. Энэ удаа Лас Вегас руу гурван сар явав. Миний зардал нэлээд өндөр байсан ч алдагдалгүй ирэв. Алдагдал хүлээгээгүй ашиг ч сайн хийгээгүй аялал болсон доо. Ихэнхдээ Миражид хааяа "Horseshoe"-д очиж тоглов. Мөнгөнийхөө хэмжээнээс хамаарч голдуу 15-30 доллар, 30-60 долларын ширээнд бэлэн мөнгөөр тоглож байлаа.

Европт буцаж ирснийхээ дараа олон газраар аялан тоглож эхлэв. Үүнд, Парис, Вена, Амстердам, мөн Испаниар хүртэл явав. Их ч тоглож, тэр хирээрээ туршлагажиж байлаа.

Европын тун чадварлаг олон тоглогчидтой хамт тоглосон. 1998 онд дундын хязгаартай Омаха тоглоомын өндөр шагналтай тэмцээн Испанид анх удаа болов. Тэр тэмцээнд би маш сайн тоглосон.

Өрсөлдөгчид маань намайг "маш дайчин, заримдаа галзуу юм шиг тоглож байна" хэмээн боддогт байв. Би тэрхүү тоглолтдоо дуртай, тэр бүхэн ч надад давуу талыг өгч байлаа. Тэд сохроор ч хамаагүй мөнгөө өсгөхийг хүсдэггүй байв. Гэвч би тэднийг хүчээр олон чипс түлхэх шийдвэр гаргахад хүргэдэг байлаа. Тэдний хувьд гартаа сайн хөзөртэй байсан байж болно, гэхдээ л би тэднийг хүчээр хаяулдаг байсан юм.

Мадридад тоглож байхад олон хүн надад Покерын дэлхийн цуврал тэмцээнд оролцохыг зөвлөв. Тэдний бодлоор би нэлээд итгэл найдвартайд тооцогдож байсан биз ээ. Түүний дараа 1999 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний Main Event-д оролцохоор Лас Вегас руу нисэв. Энэ тэмцээнд дээд түвшний дунд үе хүртэл тоглосон юм. Буцах замдаа Лос Анжелесийн "Коммерс" казинод бэлэн мөнгөөр тоглов.

Покер бол хүмүүсийн хөзрөөр тоглодог тоглоом харин хүмүүсээр тоглодог хөзрөн тоглоом биш гэдэгт би итгэдэг. Тоглогч бүрт өөрийн сул талууд бий, нөхцөл байдал тэднийг ямар нэг байдлаар хэвийн биш болгодог, тийм үед хийгддэг үйлдлүүд заавал байдаг гэдэгт би итгэдэг. Тэр үед нь би тэднийг шалгадаг юм.

2000 оноос эхлэн би олон тэмцээнд оролцох болов. Хаана том тэмцээн болно тэнд л явж байдаг байлаа. Би покерыг ном уншиж судлаагүй. Шууд л ажиллаж байхдаа дадлага хийдэг шиг хар практикаар покерыг судалж, сурсан хүн дээ. Ирсэн хөзөр тухайн тохиолдол болгоныг би санаж тэдгээр мэдээллүүд шинэ нөхцөл байдалд надад маш их тусалдаг. Бас байнга эсрэг тоглогчдынхоо бусдад үл анзаарагдам зүйлсийг анхааралдаа авч эргэцүүлэн бодож, өөрийн тоглолтын өвөрмөц аргыг боловсруулдаг. Миний тоглолтын гол үндэс бусад тоглогчдын арга барилыг судалж шинжлээд тэдний системийг өөрсдийнх нь эсрэг хэрэглэхэд оршдог юм.

•••

Би хэзээ ч хэнийг ч хоосолж чадна, үүнийгээ эргэлзэх зүйлгүйгээр хийдэг. Хэрэв өрсөлдөгчийн ямар нэг сул тал ажиглагдвал би шууд довтолдог. Энэ үед би, эсвэл тэр хоосорно. Заримдаа миний боломж тийм ч сайн биш байж болно, хэрвээ тэр үед би тоглох болвол мэдээж шууд довтолно.

•••

Би хэзээ ч хэнийг ч хоосолж чадна, үүнийгээ би эргэлзэх зүйлгүйгээр хийдэг. Хэрэв өрсөлдөгчийн ямар нэг сул тал ажиглагдвал би шууд довтолдог. Энэ үед би, эсвэл тэр хоосорно. Заримдаа миний боломж тийм ч сайн биш байж болно, хэрвээ тэр үед тоглох болвол мэдээж шууд довтолно. Боломж нэлээн тааруу байж магадгүй үед надад олон хасаа байвал зоос эргүүлэхийн хооронд тэднийг хоосруулна. Заримдаа миний хөзөр тааруу гэдгээ өөрөө хүлээн зөвшөөрдөг ч өрсөлдөгчөөсөө хамаагүй илүү тоглодог. Хэрэв чи үнэхээр ямар нэг зүйл хийхийг хүсч байвал шаргуу оролдоод үз, заавал хийж чадна, ядаж л бүслэгдэхгүй

шүү дээ.

Покер надад эрх чөлөөг олгодогт нь би үнэхээр дуртай. Би өөрийнхөө тухай хэнд ч хариулдаггүй. Покер тоглохоор бол чи өөрийнхөө л мөнгөөр тоглоно, мөн яаж тогломоор байна түүгээрээ тоглож болно. Тэмцээнд оролцохоор бол оролцоно, эсвэл алгасч болно.

Америкчууд надад "Эль Матадор" гэдэг хоч өгсөн. Энэ нь бухын тулаан гэсэн үг. Тэр бол маш дайчин түрэмгий спорт, бас миний тоглох хэлбэр ч түүнтэй адил гэдгээрээ алдартай.

Би онлайнаар тоглох тийм дуртай биш. Хакеруудад үнэндээ итгэдэггүй. Харин тоглолтын арга барил болон тоглогчдын статистик мэдээллийг байнга цуглуулж байдаг. Би бодитоор тоглох дуртай. Энд компьютер хэнд ч туслахгүй, зөвхөн өөрөө өрсөлдөгчтэйгээ нүүр нүүрээрээ тул. Зөвхөн хүн хүнтэйгээ л тоглоно шүү дээ. Миний хувьд ингэж тоглохдоо илүү дуртай.

Тоглогчдын гарт ирсэн хөзрийг хардаг камерт ч дургүй. Өрсөлдөгчид миний тоглолтын бичлэгийг судлаад дараа нь хийх үйлдэл болгоныг маань анхааралтай харна шүү дээ.


Покероос гадна би мотоцикл унах, ялангуяа бартаат замынхыг унах бүр ч илүү дуртай. Тэгээд харайх эрсдэл хийх маш дуртай. Надтай хамт өрсөлддөг хэсэг нөхөд бий. Би тэднээс нэг их дугахгүй. Мөн найз охин Пасторатайгаа хамт ихэнх цагийг өнгөрөөдөг. Тэнгисийн ид давалгаанд самбараар гулгадаг. Ер нь байгальд илүү дуртай.

Покер бол амьдралын маш хүнд зам. Би бусдад үүнийг санал болгохгүй. Бодоод үз л дээ, бүгд покероор амьдардаг гээд, тэгвэл юу болох вэ?

Покер бол хүмүүсийн хөзрөөр тоглодог тоглоом, харин хүмүүсээр тоглодог хөзрөн тоглоом биш гэдэгт би итгэдэг. Тоглогч бүрт өөрсдийн сул талууд бий, нөхцөл байдал тэднийг ямар нэг байдлаар хэвийн биш болгодог, тийм үед хийгддэг үйлдлүүд заавал байдаг гэдэгт итгэдэг. Тэр үед нь би тэднийг шалгадаг юм.

Намайг гаднаас минь хараад тааварлахад маш хэцүү. Миний холимог байдал өрсөлдөгчдийг маань тэнцвэргүй байдалд оруулдаг. Эхлээд намуухнаар боломжоо судалж байснаа дараа нь худлаа ярьж эхэлнэ. Энэ бол миний үндсэн хэлбэр. Би олон янзаар тоглож чадна. Бүхий л хугацааны туршид сайн хөзөртэй байгаад хожсон, муу хөзөртэй байгаад хожсон хожлын маань тоо яг ижил. Ер нь хязгааргүй тоглоомд худлаа хэлсэн нь л хождог юм.

Би Америкт дуртай. Гэхдээ Испанийн найзархаг, нөхөрсөг байдлаа санагалзаж байна. Тэнд жижигхэн газарт хүмүүс гадаа гудамжинд, бааранд би биетэйгээ харилцах бүрэн боломжтой, харин Америкт хүмүүс ихэвчлэн машиндаа л байдаг. Мэдээж нэгэн нартай өдөр Испани руугаа буцна, гэхдээ би одоо Лас Вегаст хамгийн сайн хийж чаддаг зүйл болох покероо л тоглосоор байна.



Дэйв Уллиотт

Эрик Сайдел нь покерын түүхэн дахь шилдгүүдийн нэг юм. Хорин жилийн дотор тэрбээр шувтаргын шилдэг тоглогчдын нэг болж чадав. Э.Сайдел Покерын дэлхийн цуврал тэмцээнд найман удаа түрүүлж, Покерын дэлхийн аялан тоглолтод аварга болж, ойролцоогоор 10 сая доллар хожив. Team Full Tilt-ийн гишүүн түүнийг бусад тэмцээнд тулалдаж ялалт байгуулаагүй үед нь онлайнаас амархан олж болно.

Эрик Сайдел Нью Йоркт төрсөн. Тэрбээр бэкгаммоны (backgammon) мэргэжлийн тоглогч байсан юм. Тэрбээр хөрөнгийн зах зээлд гарахаасаа өмнө нийт найман жил бэкгаммоны тэмцээнд тоглодог байжээ. Ингээд Wall Street-д арилжаа хийж байхтайгаа зэрэгцэн покер тоглодог байсан тэрбээр 1987 оны хямралын үеэр өөрийнхөө амьдралын ирээдүйг дахин үнэлэх болов.

Ерөнхийдөө дуу цөөтэй, таамаглахын аргагүй Эрик Покерын дэлхийн цуврал тэмцээнд анх удаа оролцож хоёрдугаар байрт шалгарч байсан амжилтаа 1999 онд шувтаргын ширээнд тоглохдоо дахин давтаж байсан юм. Харин Покерын дэлхийн цуврал тэмцээнд 1994 онд түрүүлж, анхны бугуйвчаа хүртсэн түүхтэй. Арван гурван жилийн дотор тэр найман бугуйвч авснаараа Жонни Мосстой тэнцэж, бүх үеийн шилдгүүдийн дөрөвт бичигдэх болов.

- Фил Хэлмут түүнтэй ийнхүү хөөрөлджээ. Пак Ман тоглоомоор хангалттай мөнгө олж чаддаггүй байсан учир ахлах сургуульд байхдаа пинбол, бэкгаммон тоглож мөнгө олдог байв. Покер миний амьдралд нэлээд хожуу, есөн жилийн дараа орж ирсэн. Тэр үед арван хэдтэйгээсээ Бродвэйн 75 дугаар гудамжны уулзварт байрладаг "Тоглоомын өрөө"-нд бэкгаммон тоглож эхэлсэн. Манай гэр тэндээс нэг гудамжны цаана, Манхэттены баруун дээд талд байсан юм. Би өөрийнхөө ахлах сургуулийн найз нартайгаа хамт Нью Линкольн, Боулдвины ахлах сургуулиар очиж бэкгаммон тоглоно. Пол Магриэлийн "Бэкгаммон" хэмээх номыг авч уншаад, түүнд автсан цагаас эхлэн бэкгаммоны жинхэнэ тоглогч болсон доо. Би ахлах сургуулийнхаа хамгийн шилдэг тоглогч нь байлаа.

Аав маань киноны бизнест олон мэргэжлээр зэрэг ажилладаг байв. Уран бүтээлийн нэгдлийн менежер, зураглаач, туслах найруулагч, найруулагч гээд бараг л бүгдийг ганцаараа хийнэ. Тэрбээр "Шөлний худалдаа", "Тусгаар хүний өшөө авалт" зэрэг кинонд тоглож байв. Бид ээж, хойд аавтайгаа амьдардаг, тэр хоёр хоёул баримтат кино бүтээгчид юм. Ах, дүү хоёртойгоо би хөлгөн тоглоом их тоглоно. Коллежид орох үед би гэр болон бэкгаммоны төвд ихэвчлэн цагийг өнгөрөөх болов. Ингээд Бруклины коллежид нэг жил, Хантер коллежид хагас жил сурсны дараа би тоглоом тоглож амьдрах болсноо гэрийнхэндээ хэлэхэд бүгд дэмжсэн, бүр ээж маань ч дэмжсэн нь маш гайхалтай байв.

Миний сайн найз Ховард Ледерер Мэйфейр клубээс төрөн гарснаа үргэлж ярьдаг юм. Тэднийг покер тоглох гэтэл клубынхэн эхлээд гүүр, бэкгаммон зэрэг хөлөгт тоглоом тоглохыг шаарддаг байжээ. Иймээс энэ нь нэг талаар надад сайхан санагддаг ч Ховардын хувьд харин жил орчим покер тоглохыг нь хориглосон хэрэг байлаа. Харин дараа нь Мэйфейр клубын покер тоглолтоос, энд покер тоглодог мэргэжлийн тоглогчдоос бүрэн тусгаарлагдсан юм. Учир нь бид зөвхөн гүүр, бэкгаммон тоглодог жаахан хүүхдүүд байсан тул эхлээд покер хэрхэн тоглохыг сурах шаардлагатай байсан юм. Эцэст нь клуб биднийг покер тоглохыг зөвшөөрч, мэргэжлийн тоглогчдыг тэнд авчрах болов. Тэдний тэргүүн эгнээнд мэдээж Ховард байсан. Энэ бүхэн Ховард бид хоёрыг ойртуулсан юм. Бид одоо нөхөрлөөд 20 гаруй жил болж байна.

Нэгэн өдөр "Тоглоомын өрөө"-нд бэкгаммоны дэлхийн хамгийн шилдэг тоглогч, маш энэрэнгүй сайхан сэтгэлт Пол Магриэл орж ирэв. Тэрбээр сүүлд намайг өөртэйгээ тоглохыг урьж, бас бэкгаммон тоглоомын хэтийн төлвийн талаар их зүйлийг зааж сургаж билээ. Тэр бэкгаммон тоглоомд их хайртай, түүнийг зааж сургахдаа их дуртай байсан гэж би боддог. Тэр үед Пол Магриэл "Нью Йорк Таймс" сонинд бэкгаммоны буланг эрхлэн гаргадаг байсан төдийгүй бид бичих нийтлэл, тоглоомынхоо талаар зөвлөдөг байлаа.

•••

Харин дараа нь Мэйфейр клубын покерын мэргэжлийн тоглогчдоос бид тусгаарлагдсан юм.

Учир нь бид зөвхөн гүүр, бекгаммон тоглодог жаахан хүүхдүүд байсан тул эхлээд покер хэрхэн тоглохыг сурах шаардлагатай байсан юм.

• • •

П. Магриелтэй уулзсан явдал миний аугаа их амжилтын эхлэл байлаа. Түүний номыг би дахин дахин уншдаг байсан. Тэр бол үнэндээ бэкгаммоны дэлхийн шилдэг тоглогч юм. Түүнийг телевизийн "60 хором" нэвтрүүлгээр гарахад нь хүртэл шимтэн хардаг байлаа. Миний амьдралд П.Магриэл орж ирээгүй бол би юу хийж байх байсныг мэдэхгүй. Намайг 17-той байхад "Бостоны бөмбөрцөг" сэтгүүлд бэкгаммоны талаар өгүүлэл бичдэг Билл Робертиэс миний хийсэн нүүдлийг магтан бичив. (Э.Сайдел нь бэкгаммоны од байсан. Тэрбээр яагаад ч юм энэ тухайгаа ярих сонирхолгүй байдаг. Энэ сэдвийг хөндөнгүүт клубынхээ тухай, эсвэл өөр бусад хүүхдүүдийн тухай ярьж сэдвээ өөрчилдөг. Ф.Хэлмут.) Манай клубт надаас хоёр насаар ах Жэйсон Лестер, Рожер Лов гэдэг маш сайн тоглодог хоёр хүүхэд байсан. Тэд бол бэкгаммоны жинхэнэ одууд болсон.

Мейфейр клуб шинэчлэгдсэнээр покер тоглуулдаг болов. Үүний хажуугаар бэкгаммоны ертөнцийн төв хэвээр байлаа. Хэсэг сайн тоглодог хүүхдүүд нийлж тоглож, тоглоомынхоо тухай ярилцаж, тэр орчин нэг ёсондоо бэкгаммоны "инкубатор" байв. П.Магриэл тэргүүлж, бусад нь түүнээс суралцаж улам бүр сайжрав. Намайг анх Мэйфейр клубт тоглож эхлэхэд тэднийх 57 дугаар гудамжны хоёр гуравдугаар чөлөөний дунд байснаа дараа нь тэндээсээ нүүж, Грамерси Парк буудлын 21 дүгээр гудамж буюу Лэксингтонд байрлав.

Дараа нь покер тал руугаа илүү давамгай болж, 25 дугаар гудамжны Парк Авеню ба Мэдисон гудамжны дунд байрлах болов. Энэ нь "Раундерс" киноны гол санаа, сэдэл нь болж өгсөн юм.

• • •

Сүүлдээ покер тал руугаа илүү давамгайлах болж 25 дугаар гудамжны Парк Авеню ба Мэдисон гудамжны дунд байрлах болов. Энэ нь "Раундерс" киноны гол санаа, сэдэл нь болж өгсөн юм.

• • •

Мэйфейр клуб нь покерын түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн газар юм. Алдарт покерын одод тухайлбал, Ховард, Микей Эплэман, Ноли Франциско, дэлхийн аварга Дэн Харрингтон, Покерын дэлхийн цуврал тэмцээний зургаан удаагийн аварга Жэй Хэймовиц нар тэндээс төрж гарсантай энэ бас холбоотой. "Раундерс" киноны зохиолыг бичсэн Брайн Коплеман, Дэвид Левиэн нар ч бас тэнд л тоглож байсан төдийгүй тэр бүхэн нь тэдний киноны гол загвар болсон юм.

27 настай байхдаа би покерыг мэргэжлээ болгосон. Түүнээс өмнө маш олон удаа Лас Вегаст очиж бэкгаммоны тэмцээнд оролцож байлаа. Эндхийн талаар ч нэлээн сайн мэдлэгтэй болсон. Яг хэдэн удаа очсоноо сайн санахгүй байгаа ч 1988 онд 22-23 настай байхдаа анх

Бэкгаммоны дэлхийн сонирхогчдын аварга шалгаруулах тэмцээнд оролцож явлаа. Тэр үед уг тэмцээнийг сонирхогчдын гэж нэрлэж байсан ч үнэндээ бүгд л мэргэжлийн тоглогчид өрсөлдсөн юм. Ер нь сонирхогчдын тэмцээнд орж байснаа санахгүй байна.

Тэнд бас мэргэжлийн тэмцээн их болдог байсан ч харамсалтай нь түрүүлж үзээгүй билээ. Тоглож байхад хажуугаар нь мөрийцөх хэлбэр их байсан. Нэг удаа покерийн од Хасаа хочит Дэвид Рийзтэй таармагц, би "энэ хүн чинь покер тоглогч учир тааруухан л байж таарна" гэж бодоод 1000 доллараар мөрий тавьчихав. Тэгэхэд би хожсон хэдий ч эхэндээ түүнийг намайг хожих байх гэж бодож байлаа.

Нэгэн удаа Лас Вегас руу бэкгаммоны тэмцээнд явахдаа покерын тухай Дэвид Скланскийн бичсэн бараг товч тайлбар таницуулга гэмээр номыг гурван доллараар авч уншсаны дараахан нь нэгээс хоёр долларын Холдем тоглож хожсон миний хувьд покерын талаарх анхны өдөөлт болж өгсөн гэж боддог. Би Нью Йорктоо буцаж ирээд Мэйфейр клубт хязгааргүй Холдем тоглож эхлэв. Удалгүй 1987 оны 10 дугаар сард Пайн Вебберт хийж байсан ажлаа хөрөнгийн зах зээлийн хямралаас болж алдав. Тэр үед юу ч үгүй болсон доо. Рожер Лов захирал хүртэл юу ч үгүй үлдсэн дээ. Гэвч хэсэг хугацаанд мөнгө хийсний дүнд Руатай сүй тавьсан ч ажилгүй учир яахаа мэдэхгүй байдалд орж билээ.

Wall Street-д ажиллаж байсан ихэнх хүмүүсийн ертөнц эсрэгээрээ эргэв. Хамт ажиллаж байсан нөхөд маань бүгд л бүсээ чангалцгаасан. Амьдрал үнэхээр хүнд болж, миний хувьд асуудал маань яс маханд тулж ирсэн. Тэр үед эхнэр маань жирэмсэн байсан төдийгүй дээр нь "Манхэттенд амьдардаг гэр бүлээ яаж тэжээнэ дээ?" гэж их санаа зовдог байлаа. Эхнэр Руа минь маш их сэтгэлийн тэнхээ, эрч хүчтэй байсны хүчинд хэдийгээр байдал хүнд байсан ч бие биенийхээ бүрэн дэмжлэг, харилцан ойлголцол, итгэл найдвараар сайхан болно хэмээн бид бат итгэлтэй байв.

Хөрөнгийн зах зээлийн том уналтын дараа, Манхэттенд ажилгүй байхдаа Мэйфейр клубт тогтмол шахуу очиж покер тоглоно. Удалгүй байдал сайжирч, 1988 онд хоёр долоо хоногийн дотор 77 мянган доллартай болов. Энэ нь тухайн үедээ маш их мөнгө байлаа. Тэр үед Ховард, Дэн Харрингтон нар 1987 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний шувтаргын тоглолтын ширээнд хүрцгээсэн байв. Намайгтэд Лас Вегасявж тэмцээнд ор хэмээн ятгаж, 1988 оны Покерын дэлхийн цувралд орж тоглох хүртэл ятгаж чадсан юм. Түүнээс гадна Ховард бидэнд үргэлжид туслалцаа дэмжлэг үзүүлдэг байлаа.

•••

Хөрөнгийн зах зээлийн том уналтын дараа, Манхэттенд ажилгүй байхдаа, Мэйфейр клубт тогтмол шахуу очиж покер тоглодог байв.

•••

Тэр жил Покерын дэлхийн цуврал тэмцээнд оролцохоор анх "Horseshoe" зочид буудлын казинод ороход Тор Хансон нэгэн үзэсгэлэнт, улаан үст бүсгүйн хамт байлаа. Эхлээд энэ залуу хэн бэ? гэж хэсэг гайхсанаа, мэдээж Тор л байна, тэр үргэлж бүсгүйчүүдийн тал дээр сайн байдгийг санав. Энэ бол миний анхны аяллаас надад хамгийн тод үлдсэн дурсамж юм.

Дэлхийн цуврал тэмцээнд би өсөн тусгай ширээнд ганцаарчилсан тоглолт хийж 1000 доллараар тоглосон ч ганц ч хожоогүй юм. Сүүлдээ цаг дуусахын үед өөрийнхөө нийт "Par value"-гийн 80 хувийг, бэкгаммоны домогт тоглогчид болох Майк Свободни, Билли Хоран зэрэг найзууддаа зарж билээ. "Par value" гэдэг нь тэд миний ажиллагааны 80 хувийг санхүүжүүлнэ гэсэн үг. Эндээс би өөрт үлдсэн 20 хувийн чөлөөт мөнгөтэй болов. Хүмүүс өөрсдөө эрсдэл хүлээж, надад хөрөнгө оруулалт хийж байгаад талархаж, бүгдийг нь эргүүлж өгөхийг хүсч байлаа.

Харин Ховард надаас худалдаж аваагүй, үүнд нь би нэлээд гомдсон. Учир нь "Бусад олон тоглогчдоос тэр л надад туслах ёстой" хэмээн бодож байлаа Түүнээс асуусан боловч, тэр "намайг болоогүй байна" гэж бодсон байх. Найзуудаасаа асууж дууссаны дараа хоёр хувийн чөлөөт эргэлтийн мөнгийг хуучны бэкгаммоны найз, дэлхийн шилдэг бэкгаммон тоглогч эмэгтэйчүүдийн нэг Фран Гоулдфарбаас авав. Эцсийн эцэст би найзуудаасаа асуулгүй тэр эмэгтэйгээс л хүссэн юм.

1988 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний эхний хоёр өдрийн тоглолтод нэлээн азтай байлаа. Би ч шулуухан тоглолтууд хийв. Гурав дахь өдрийн дараа зургаан шилдэг тоглогч үлдэв. Ингээд эхнэр Руа, Билли Хоран, Майк Свободни нар руу утасдаж тэднийг дуудав. Тэд маргааш нь Нью Йоркоос нисч ирцгээж намайг дэмжив.

Ингээд шилдэг зургаан тоглогч үлдэхэд, тэдэн дунд дэлхийн аварга Жонни Чан, покерын домог болсон Хумберто Бреннес, Жим Бечтел, Т.Ж.Клаутиер, Рон Грахам тэгээд би байлаа. Тэдэн дунд би туршлагаар хамгийн бага нь байсан. Тэр үед урьд өмнө хэзээ ч хийж байгаагүй алхам олныг би хийсэн. Дөнгөж эхлээд л Т.Ж-тэй тулж тэр тамга арваар өсгөхөд нь би хос таваар бүгдийг оруулж, дараа нь тэр дуудснаар би авч билээ.

Тэр хожил надад маш хэрэгтэй хожил байв. Энэ нь миний өөртөө итгэх итгэлийг улам бүр нэмэгдүүлэв. Дараа нь Рон Грэхэмтэй тулж, эрчтэйхэн үзэлцэв. Түүнийг зогсоно гэдгийг би хүлээж байлаа, яг түүгээр болов. Эцэст нь тэрбээр уул шиг овоолсон хасаагаа бүгдийг нь түлхэж оруулахад, би нэлээн удаан бодож байгаад "тэр намайг хуурч байна даа" гэдгийг өөртөө итгүүлж чадсан юм. Эцэст нь дуудахад надад тамга боол, харин түүний арав дөрөв нь ямар ч хамааралгүй шахам хөзөр байв. Энэ бол миний хожсон бас том хожил байлаа. Үүнийгээ би толгойдоо удаан бодсон, түүнийг зөв уншлаа гэж бодож байсан ч өөртөө бас сайн итгэхгүй байсан юм. Үр дүнд нь би түүнийг зөв таасан төдийгүй уул овоо шиг чипс хожсон доо.

Үүний дараа Чан толгойгоо өндийлгөж, "духныхаа голд нүдтэй буга шиг л юм боллоо" гэж хэлэхэд нь "нээрээ юу болчихвоо, эд бол домог болсон дэлхийн шилдэг тоглогчид, би ямар чөтгөрөө хийсэн юм бол, дөнгөж анхныхаа тэмцээнд оролцож байж" гэж бодоход хүрсэн юм. Энэ бол миний анхны тэмцээн дээр домогт од Жоннийн хэлсэн үг байлаа.

•••

Үүний дараа Чан толгойгоо өргөн, "духныхаа голд нүдтэй буга шиг л юм боллоо" гэж хэлэхэд нь "нээрээ юу болчихвоо, эд бол домог болсон дэлхийн шилдэг тоглогчид, би ямар чөтгөрөө хийсэн юм бол, дөнгөж анхныхаа тэмцээнд оролцож байж" гэж бодоход хүрсэн юм.

Сүүлд нь Чантай тулан аваргын төлөө тоглов. Чан ямар нөхцөлд байсныг би мартжээ.

(Сайделд хатан долоо, Чанд боол ес, хатан арав найм эргэсэн байсан санагдана. Сайдел чек хийхэд Чан 40 мянгаар өсгөсөн, тэгэнгүүт Сайдел 90 мянга болгосон, дараагийн хөзөр нь хамааралгүй болов. Хоёулаа чек хийсний дараа сүүлийн хөзөр нь зургаа болж, Сайдел бүгдийг оруулж, Чан дуудаж дуусгаснаар аварга болж билээ. Филл Хэлмут.)

Сүүлд нь тэр хөзрийн тухай дахин бодохоос ч эвгүйцдэг юм. Тэгээд ч 1988 оны Покерын дэлхийн цуврал тэмцээн миний санаанд хамгийн тод үлдсэн дээ. Хоёрдугаар байрт орж, 280 мянган долларын шагнал авч, түүнийхээ 20 хувь болох 56 мянган доллартай болсон нь намайг нэлээд өдөөж өгөв.

Бас нэг чухал зүйл гэвэл, Мэйфейрээс ирсэн нөхөд минь надад их тус дэмжлэг болж, тэднийхээ хүчээр л амжилттай дуусгасан юм.

Дараа жил нь тэмцээнд бүртгүүлэхээр 10 доллараа барьчихсан зогсч байтал, шилдгийн шилдэг "Пагги" Пийрсон урд зогсч байснаа эргэн харж, "хүү минь, тэр бол миний үзсэн хамгийн тэнэг тоглоом байсан шүү" гэж хэлэв. Түүнийг би бүр бэкгаммоны тэмцээнээс л мэддэг. Ингэж хэлсэн нь нэлээн доромжилсон аястай байсан ч нөгөө талаасаа бас хөгжилтэй байлаа.

Зарчимтай хүмүүсийг харвал тэд өөрсдийн мөнгийг аваад үлдчихсэн байдаг, харин авьяастай хүмүүсээс олон хүн дампуурсныг би мэднэ.

Сүүлийн 20 жилийн хугацаанд би Покерын дэлхийн цувралаас найман бугуйвч, Покерын дэлхийн аялан тоглолтын аварга болж хосгүй амжилт үзүүлэв. Бас хоёр охин, эхнэр маань намайг тоглож байхад дэмждэгт би маш их аз жаргалтай байдаг.

Өнөөгийн залууст өөрийн хэмжээнээс хэтэртэл мөрийтэй бүү тогло, өөрийнхөө мөнгийг зөв удирд, тэгвэл амьдрал чинь амархан болно. Мөнгөө сайн удирдаж чадахгүй бол хүсээгүй, санамсаргүй гарч ирэх олон өвчинд нэрвэгдэнэ.

Зарчим бол авьяасаас ил үү чухал гэдгийг покер тоглогчдод зөвлөх байна. Маш олон авьяаслаг хүмүүс дампуурсныг би мэднэ. Харин зарчимтай хүмүүс дампуурсныг та нар л лав мэдэхгүй байх. Хэрэв зарчимтай хүмүүсийг харвал тэд өөрсдийн мөнгийг аваад үлдчихсэн байдаг, харин авьяастай хүмүүсээс олон хүн дампуурсныг би мэднэ.

Тэр тоглох дуртай хүн байсан гэж бусдад би дурсагдах дуртай. Бас шударга, ёс зүйтэй хүн байсан гэж дурсагдвал сайхан хэрэг.

Дэлхийн бүх тоглоомд би талархаж явдаг хүн. Тэдгээрээс бэкгаммон, покерыг тоглох дуртай, тоглоомноос би их зүйлийг сурч авдаг.

Тоглоом надад ахисан түвшний сургууль мэт санагддаг. Би маш олон хүмүүстэй хамт

тоглосон. Тэднээс зөвхөн тоглоомын тухай биш, хувь хүний, ёс зүйн, нийгмийн олон чанарууд гээд их зүйлийг сурсан даа.

Хэрэв покер тоглоогүй бол одоо хаана байх вэ? гэдгээ төсөөлөөд ч олдоггүй. Дуртай тоглоомтойгоо хамт байгаадаа өдөр бүр би аз жаргалтай байдаг, түүгээрээ бүх төлбөрүүдээ ч гэсэн хийдэг.

Эриктэй www.fulltiltpoker.net-ээр орж тоглож болно.

Тэрбээр бага орлоготой айл өрхийн охидыг боловсрол, сэтгэл зүй, нийгэм соёлын талаар өсч төлөвшихөд тусалдаг Sophia Academy (www.sophia-academy.org) сургуулийг санхүүгийн хувьд дэмждэг юм.



Чад Браун

"Чөтгөрийн загас" хочит Дэйв Уллиотт маш аймшигтай, нөлөөтэй, шулуухан хэлдэг покерчдын нэг. Европын покерчдын дунд түүний нэр алдартай. Европын шилдэг Омаха тоглогчоор хоёр удаа шалгарсан. Нийтдээ 33 удаагийн шагналыг покерийн дэлхийн цуврал тэмцээн болон дэлхийн аялан тоглолтоос хүртсэн. Покерын дэлхийн цуврал болон Покерын дэлхийн аялан тоглолтод хоёуланд нь түрүүлсэн цөөхөн тоглогчдын нэг. Түүний авсан хамгийн том шагнал нь Жак Бинионы нэрэмжит Покерын дэлхийн аялан тоглолтын нээлттэй тэмцээнээс авсан 600 мянган долларын шагнал юм. 2006 онд Их Британийн "хамгийн содон мөрийтэй тоглогч" шагнал хүртсэн тэрбээр түүнийгээ "нэгэн хөгжилтэй нови" гэж хошигнон нэрлэдэг.

Д.Уллиотт 2008 оны Европын "Амьдралдаа хүрсэн шагнал"-ын эзэн. Лас Вегаст бол дэлхийн дээд зэрэглэлийн тоглогч гэсэн алдраа улам бүр өсгөсөөр байгаа. Лас Вегас элдэв янзын

покер тоглогчдоор дүүрэн газар. Энэ номыг бичихээр ярилцаж байхад түрийвчээ уудлан нэгэн үрчийсэн чек гаргаж ирсэн нь 1.4 сая долларын баталгаат чек байв. Түүнийгээ сүүлд нь банкинд тушаахад, теллер охин ухаан алдчих шахсан гэдэг. Тэрбээр энэ явдлын дараа "би юу болоод байгааг сайн ойлгоогүй, тэр охин л өөрөө ухаан алдах шахсан" гэж байсан гэдэг.

Би өөрийн тухай энэ бүлгийг 2008 оны 12 сард нас барсан аав Стенли Уллиоттийн дурсгалд зориулан бичлээ. Тэр надаас илүү хэцүү амьдралыг туулсан хүн. Бас 17хон насандаа сайн дураараа дайнд явж байлаа. Тэрбээр намайг хатуужуулсан, бид байнга ойр дотно байгаагүй ч түүнийг би үргэлж дуурсдаг гэдэгтээ итгэлтэй байна.

Би 1954 онд Английн Кингстон хотод төрсөн юм. Тэр бол хамгийн хэцүү газруудын нэг. Хулл дахь бааранд ороход газраар нэг модны үртэс байж мэднэ, тэр бол урд шөнийн явдлаас болж дахин шинэ тавилга хийхэд гарсан үртэс юм. Покерыг би нэлээд багаасаа эхлэн аав, ээж, эгчийн хамт гал тогооны өрөөний ширээн дээр тоглож эхэлсэн дээ. Өсвөр насандаа Ж.К.Бийулах-д ажиллаж байхдаа хэсэг ажилчдын хамт өдрийн завсарлагаанаар тоглодог байлаа. Тэднээс их зүйл сурч, покерын талаар сайн ойлголттой болов. Тэнд ажилладаг залуус Жак Гарднер ганцаархнаа хотод ганц байдаг "Тавин нэг" клубын гишүүн байв.

18 настай байхдаа би Жакийг нэлээн гуйж байж, казинод ороход туслахыг зөвшөөрүүлэв. Би бас ч гэж өндөр нуруутай, халаасандаа мөнгөтэй байв. Стрип Дек стад 32 хөзрөөр тоглож эхлэв. Бага хэмжээний мөнгөтэй байсан ч эхний өдрөө хамаг байдгаа алдаж нэлээн хэцүү байдалд орлоо. Гэвч ахин дахин очиж, тоглосоор байв. Ямар ч үр дүнгүй мөнгөө алдаад л дуусдаг байлаа. Сүүлдээ энэ нь хэвийн үзэгдэл болов.

Гэвч покер тоглохын сацуу өөр ажил хийдэг байлаа. Өмнө нь 17 настай байхдаа нэлээд ухаалаг хулигаан болох Дэйв, Фрэд нартай танилцан тэдний далбаанд дор орж, тэд ч бас надад юу мэддэгээ зааж сургав. Яг үнэндээ бол би тэднээс илүү байлаа. Фрэд цагдаагийнханд "Чулуун хана" нэрээр бүртгэгдсэн байснаа сүүлдээ ганцаараа ажилладаг болсон юм.

Би 20 орчим настай байхдаа хар хувцас өмсч, байшингийн дээврээр дамжин мөнгөний авдар ухаж эхэлсэн дээ. Бас өөр зүйл ч хийдэг болсон. Гэвч энэ байдлынхаа эсрэг тэмцэвч, үүнээсээ салж чаддаггүй байлаа. Нэг орой нэлээд мөнгө хулгайлаад, маргааш нь бүгдийг нь аваачаад морин тойруулгад алдаж орхив. Тэгээд орой нь нөгөө нөхрийн мөнгөний авдрыг ухаж, алдсан мөнгөө, түүний мөнгөтэй хамт хуу хамсан боловч маргааш нь ахиад л бүгдийг нь алдсан юм даа.

Гэвч казинод тоглосноор миний аз өөрчлөгдсөн, тэнд би хожиж эхэлсэн. Тэндээс бас өөр боломжийг ч олж харав. Энэ бол хувийн тоглолтууд байлаа. Хэсэг нөхдүүд хоорондоо ярьж, хэлэлцэн тохироод тоглоцгоодог. Хэрэв чи тэдэнд таалагдвал, чамд тэднийг хаанаас олж болохыг хэлж өгнө. Тэнд 18 настайгаасаа эхлэн тоглов. Бараг 30 нас хүртлээ тоглосон доо. Эхний тоглолт Луис Стрийтийн доохно Мустафад болж хоромхон зуур тэднийг хожиж билээ.

•••

20 орчим настай байхдаа би хар хувцас өмсч, байшингийн дээврээр дамжин мөнгөний авдар

ухаж эхэлсэн дээ. Тийм ээ, та зөв уншлаа. Би сейф ухдаг байсан. Бас өөр зүйл ч хийдэг байлаа. Гэвч энэ байдлынхаа эсрэг тэмцэвч, үүнээсээ салж чаддаггүй байв.

• • •

Мустафа болон өөр бусад хувийн газруудад тоглодог байхдаа хажуугаар нь илүү аюултай, хууль бус зүйл бас хийнэ. Тэр үед миний амьдарч байсан тэр хороололд бараг л хүн бол гон ямар нэгэн хууль бус зүйл хийцгээнэ. Аюулаас хамгаалагдсан хэн ч байдаггүй, гэмт хэрэгтнүүдэд хүртэл аюултай үе байлаа. Нэг хүн бараа хулгайлж, түүнийгээ ачааны машинд ачин явж байх замдаа морин тойруулгын хажууд түр зогсоод дотогш орж арван минут болчихоод гарч иртэл машиныг нь хоосолчихсон байсныг санаж байна. Тэр эр морин тойруулгаас гарч явах замдаа маш олон хүн гартаа дүүрэн юм барин гүйлдэж байхыг харсан ч түүний хувьд нэгэнт хожимдсон байсан юм.

Төд удалгүй хэсэг нөхөд дэлгүүрийн урд талын хаалгыг хөшиж онгойлгоход түүгээр явж байсан хүн бүр чадах чинээгээрээ эд бараанаас нь авч байлаа. Бид машин дүүрэн тамхи аваад дахин ирж дүүргэж авцгаав. Буцаад ирэхэд маань харин цагдаа нар ирчихсэн байсан ч тэд үзлэг, тэмдэглэл хөтлөлгүй өөрсдөө тэр тамхинаас нь авцгааж байлаа.

Хорин нэгэн насны төрсөн өдөртэй бараг давхцах шахуу би баригдаж Лийдсийн шоронд оров.

Тэндээс ямар ч сургамж авалгүй гарч ирсэн дээ. Дахин мөнгөний авдар ухаж бусад "буруу гар"-ын ажиллагаанд ч оролцсон хэвээр байв. Тэгээд төд удалгүй дахин "аавын хаалга" татав. Гэхдээ энэ удаад хулгайн биш танхайн хэргээр орсон юм. Тэр үед хамгаалалтын компанид ажилладаг байлаа. Мөрийтөй тоглоом биш харин олон удаагийн зодоонд оролцсон хэргээр баригдаж дахин найман сарын ял авч билээ.

Шорон бол зугаалгын газар биш хэцүү хүнд газар. Тэр үед 146 паундын жинтэй хүнд мөртлөө цахилгаан шиг шаламгай хөдөлдөг гартай, түргэн зантай байсан учир хүмүүс надтай сөргөөцөлдөхийг боддоггүй байсан юм.

Нэг удаа хүндийн өргөлт хийж байтал нэгэн том зэвүүн халзан нөхөр над дээр ирээд өдөж эхлэв. Би хэнд ч бууж өгдөггүйн адил түүнтэй ч бас үзэлцэхээр шийдэв. Шанаадаж унагаад дээрээс нь үсрэн очин 10 килограммын жинтэй төмрөөр толгойд нь буулгав. Түүгээр зогсохгүй дахин хүнд төмөр авахаар тийш зүглэн явж байхад хамгаалагч нар орж ирээд миний хүзүү гарнаас барьж зогсоож байлаа. Яг тэр мөчид зогсоогоогүй бол нөгөө бүдүүнийг хүнд төмрөөр дахин цохиж бараг зүйл дуусгах байсан биз. Хэн мэдлээ, өдийд "нарсанд" ч байж мэдэхээр байв.

Ер нь би хурц араншинтай хүн. "Аавынд" орохоосоо өмнө нэг залуутай гар зөрүүлж, түүнийг буулган авсан. Ингэхдээ түүнийг чирж, үүдний дэргэд аваачин хаалгаар 12 удаа толгойг нь хавчин савж билээ.

Бас нэг удаа билльярд тоглож байгаад нэг лагс биетэй эртэй маргалдав. Тэр нөхөр миний улаан нүүрэнд минь буулгасан юм. Би арагш үсрэн хананд цохигдохдоо хүзүүнд нэг өлгүүр

зоогдов. Тэр үед нүднээс гал бутарч, оч үсрэх шиг мэдрэмж төрж байсан. Гэвч би түүнийг барьж авч чихнээс нь хазан зууралдаж дээр нь гарсныхаа дараа бетон шиг том толгойг нь цайны аяганы ирмэгээр цохиж балбаж өгсөн. Нүүрэнд нь 12 удаа дэлсэв. Мэдээж тэр сургамж авсан байх. Би ч тэр үед бас хөгийн новш байсан даа.

Хоёр дахь удаа шоронгоос гарсны дараа хоёр дахь эхнэр Амандатайгаа танилцаж гэрлэв. Тэрээр намайг хулгай хийхээ болиход ихэд тусалсан хүн. Тэгээд ч эргээд харахад хулгай хийлээ гээд ямар ч утга учиргүйг ойлгон дахин тийшээ ойртоогүй одоо бүр бодохыг ч хүсэхгүй байна.

Удалгүй бид бизнесээ эхлэв. Энэ тухайгаа удахгүй өгүүлнэ.

• • •

Шорон бол зугаалгын газар биш хүнд хэцүү газар. Би тэр үед 146 наунд жинтэй цахилгаан шиг хурдан гартай, мөн тийм түргэн зантай байсан.

• • •

Тэр үеэс л покер тоглож эхэлсэн дээ. Хувийн тоглоомны газруудад очиж, тэднийг буулган авсаар сүүлдээ хүмүүс надаас зугтах болов. Тэд надад хэлэлгүйгээр байрлалаа сольдог байв. Гэхдээ би амархан тэднийг олно. Тоглоом ихэвчлэн Марат гэгчийнд явагддаг байлаа. Хүмүүс түүнийг тогооч гэж дуудна. Учир нь тэрбээр урьд нь орон нутгийн нэгэн буудалд хоол хийдэг байсан юм. Голдуу л долоон хөзрийн стад тоглодог байв. Нэлээд хуучирсан барилгын мухрын өрөөнд тамхины битүү утаан дунд тоглоно. Нэгэн удаа тоглолт эхлэхийг хүлээж байтал тэр хэн нэгэнтэй миний мэдэхгүй хэлээр, турк юм уу грекээр утсаар ярьж байснаа над руу ирээд "Дэвид чиний машин гадаа зогсч байхыг харвал хэн ч орж ирж тоглохгүй ээ. Чи одоо зүгээр л яв. Уучлаарай" гэв. Удалгүй миний тухай яриа хотоор нэг тархаж, намайг оруулах тоглоомны газар байхгүй болов.

Дээврийн бизнес хийдэг найз Сеан Эллисон маань надад "Лийдст очоод үзээч, тэндхийн Стакис казинод покерийн өрөө байдаг" гэж хэлэв. Машинаар бол цаг яваад очдог газар. Үнэхээр тэнд покерийн өрөө байлаа. Тоглоом нь урьд өмнө ердөө сонсоогүй Омаха гэдэг нэртэй. Тэр нь дөрөв, тав, зургаан хөзрөөр тоглодог. Товчлуур дээр байгаа тоглогч хичнээн хөзрөөр тоглохоо шийддэг байлаа. Жилийн дараа л миний хамгийн дуртай тоглоом болов. Хэдэн хөзрөөр тоглохоос боломж шууд хамаарч байлаа. Дөрвөн хөзрөөр тоглоход боломжийн байхад тав, зургаан хөзрөөр тоглоход туршлагатай, олон хасаатай тоглогчдод хүртэл халгаатай байв. Шууд хэлэхэд "ихэвчлэн" тийм.

• • •

Тэднийг мөнгөө буцаан авахаар эргэж ирнэ гэдгийг мэдэж ядахад төвөггүй, ойлгомжтой байв. Тэд биднийг зодохоор үүдэнд хүлээж байлаа. Тэр үед буугаа гаргаж, агаарт хий буудахад намуухан орой яг л их буу шиг сонсогдож билээ.

• • •

Зургаан хэзрийн Омаха тоглохоор би юу ч бодолгүй тоглолтоо эхлэв. Хагас цагийн дотор өөрийнхөө мөнгийг гурав дахин өсгөсний дараа "энэ ч амархан тоглоом байна, будаа болгож байна" гэж бодогдож байлаа. Гэвч төд удалгүй давалгаа эсрэг эргэж, хоромхон хугацааны дараа хамаг мөнгөө алдав.

Лийдст байх хугацаандаа нэлээн мөнгө хожив. Түүний хажуугаар нэгэн тоглоом олсон нь мягмар гарагийн орой бүр Дэрби хэмээх газар тоглодог тоглоом байлаа. Түүнд нэлээн галзуу мөрийтэй тоглогчид тоглодог, би тэр дотор дундаж нь байсан. Зарим орой хожно, зарим орой алдана.

Иймэрхүү тоглоомыг бас Ноттинхэмд тоглоно. Тэнд би азтай тоглодог байлаа. Тоглоом бүдүүлэг, бохир хорооллын нэгэн маш том барилгад явагдана. Байшингийн нэг тал нь гимназ, нөгөө талд нь покер тоглодог байв. Тэнд би нэлээд амжилттай тоглож, 40 тоглолтоос 36-д нь хождог байсан. Тэр байшинд орохдоо байнга халаасандаа буу, сугандаа бэйсболын цохиуртай орно.

Лийдст тоглож эхлээд удаагүй байхдаа Хари Витакер гэдэг залуутай танилцан нөхөрлөв. Тэрбээр хаана, ямар тоглоом тоглодогийг, тэр ч байтугай түүний ээжийн ажилладаг Донкастер зоогийн газарт хувийн тоглолт явагддаг болохыг хүртэл бүгдийг нь мэддэг байв. Тэр намайг дагуулан Дэрби, Ноттинхэм зэрэг өөр бусад газруудаар дагуулан явж тоглоно. Заримдаа хэдэн өдрөөр ч явж тоглодог байлаа.

Нэгэн удаа Хари бид хоёр хэд хэдэн хотуудаар явж тоглохдоо гурван газрыг гурван өөр тоглоомоор хоослов. Ноттинхэмаас эхлээд Брэдфорд сүүлд нь Шеффиэлдэд очсон юм. Шеффиэлдэд надад хожигдсон нэг залуу гэртээ очиж тоглохыг санал болгов. Түүний гэрт өглөөний зургаа долоо гэж байхад очлоо.

Хэдхэн цагийн дотор түүнийг дахин хоослон гарч явахад өглөөний 10 цаг болж байв. Тэндээсээ морин тойруулгын газар очин дахиад 70 мянган паунд хожсон. Хэсэг хугацаанд тойруулгаар орох хориотой байсан миний хувьд энэ нь тун сайхан байлаа.

Дээр өгүүлсэнчлэн, "аавынхаас" гараад Амандатай суусныхаа маргааш өглөө есөөс орой таван цагийн хооронд ажил хийх гэж оролдон алт мөнгөний жижиг дэлгүүр нээн ажиллуулав. Түүнийг хоёр жил хэртэй ажиллуулсан. Тэр хооронд эхнэр маань лабораторийн техникчийн ажлаа хийж байлаа. Дэлгүүр ажиллуулахыг сүүлдээ үзэн ядаж эхлэв. Би тэнд яг "нарсанд" байгаа юм шиг санагдана.

Покероос ерөөсөө татгалзаж чадаагүй учир дэлгүүрийнхээ ард өөрийн тоглоомыг тоглуулж эхлэв. Тоглоомоо шөнө эхэлнэ. Заримдаа шөнөжингөө бүр маргааш өглөө нь болтол үргэлжлүүлнэ. Бид дэлгүүрийн ард тоглож байхад эхнэр маань дэлгүүртээ үйлчлүүлэгчдэд үйлчилнэ.

Бид тоглоомоо үргэлжлүүлэхийн тулд, ялангуяа мөнгө хожсоныхоо дараа гарч явах гэдэг хүмүүсийг байлгахын тулд янз бүрийн арга зохиодог байв.

Нэгэн удаа Фил гэдэг залуу нэлээд мөнгө хожсоныхоо дараа явах тухайгаа хэлэв. Хэрэв мөнгө

хожсон нь гарч яваад байвал тоглоом утгагүй болдог учраас "Жаахан суухгүй юм уу, яагаад явах гэж байгаа юм бэ?" гэж асуутал "Уух юм үлдсэнгүй" гэхээр нь дээшээ гүйн гарч хуримнаас үлдсэн хэдэн шил оргилуун дарсаа авчран ууцгааж, Филийг хамаг мөнгөө алдтал нь тоглосон доо. Гайхалтай нь тэр ч бас баяртай байв.

Бас нэг удаа нэгэн нөхөр хожсоныхоо дараа явахаар завдахад нь "Явбал яв. Гэхдээ арын хаалгаар гараарай" гэж билээ.

Амандад урьдчилан хэлээд урд хаалгаа түгжүүлсэн байсан учраас түүнд арын хаалганаас өөр сонголт үлдээгүй юм. Цонхоор гадагш харахад том нохой уруул амаа долоон байхыг тэрбээр хараад эргэн ирж тоглоод бүх мөнгөө алдсанаар тоглоом дуусч байлаа.

Дэлгүүр маань ч гэсэн боломжийн ашигтай ажиллаж байв.

Одоо ч хуучин эхнэр Аманда тэр дэлгүүрийг ажиллуулсаар байгаа.

•••

Т. Чарли гэдэг залуу нэлээн мөнгө хожчихоод сууж байхад дээрэмчид гэнэт дайран орж ирэн түүний толгойг бууны бөгсөөр хага цохиж орхив. Мэдээж тэд над руу шууд дайрах байсан.

•••

Би үргэлж хүнд гаруудтай тоглодог. Бидэн дээр ирж тоглодог байсан мэргэжлийн боксчин Тони Бүүт "Боксын дэвжээ" хэмээх номондоо миний тухай нэгэн хөгжилтэй түүхийг бичсэн юм. Тэр үед намайг нугалчихсан сонин барьж орж ирэхийг тэр хараад "наана чинь юу байгаа юм бэ" гэж асуув. Тэгэхэд нь би сонинд боосон балт сүхээ түүнд үзүүлээд нэг халааснаасаа гар буу, нөгөө халааснаасаа хийн буу гаргатал тэр "чөтгөр гэж, тэгээд бид хаана тоглох юм бэ" хэмээн хэлж байснаа уг номондоо дурссан байлаа.

Бас нэг орой Тони бид хоёр Манчестерт Дэйв Гарднерын тоглуулж байсан тоглолтын үеэр Ливерпүүлээс ирсэн жаахан уудаг бололтой, дажгүй залуутай тоглоход шөнийн турш тэр нэг ч хожоогүй юм. Би толгойгоо дээш өндийлгөж бооцоогоо нэмэхэд тэрбээр цээжээ барин шалан дээр тэрийн унав. Тэгэхэд би энэ нөхөр бооцоог маань авчихлаа гэж бодсон. Өмнө нь тэр залуу дүү рүүгээ дохиж, бооцоогоо нэмж байсан юм. Үнэндээ бол тэгэхэд би юу ч үгүй байж худлаа хэлж байв. Гэтэл тэр мөнгөө хожингуутаа "өнгөрсөн" байлаа.

Түргэн тусламжийн машин ирж түүнийг аваад явсны дараа Тони бид хоёр хаалгаар гарах үедээ "Новш гэж. Би ямар азтай хүн бэ? Би сая үхсэн хүнийг хожчихлоо" гэж намайг хэлэхэд Тони над руу харснаа "тэр өрөвдөлтэй новшийн амьтныг юу гэх гээ вэ, шөнийн турш нэг ч хожоогүй байж, арайхийж хожсон нь түүнийг алчихлаа" гэж билээ.

Миний амьдрал тэр чигээрээ галзуу хулганаар яваа мэт өгсч уруудаж ирснийг та бүхэн харж байгаа байх. Би Лийдс, Брэдфорд, Ноттэнхэм, Бирминхэм, Нортхэмптон гээд олон газар хатуу ширүүн тоглолтуудад оролцож байлаа. Тэдгээр тоглолтод хожсон үедээ мөнгө бөндгөр хоёроо тэндээс авч гарна гэдэг хэцүү. Тиймээс байнга шахуу биедээ буутай явдаг байв.

Заримдаа Дерек Бакстерын тоглоомын газар очиж тоглоно. Тэрбээр Английн алдартай шилдэг покерчдын нэг юм. Тэр намайг тоглолтын үеэр буу авч орохыг хориглов. Тэгэхэд эхэндээ би ихэд уурласан ч дараачийн долоо хоногт цагдаа нар дайран орж ирж баривчилсан юм. Азаар би тэднээс мултарч чадсан. Хэрэв баригдсан бол хууль бусаар галт зэвсэг биедээ авч явж, хууль бус тоглоом тоглосон хэрэгт унах байлаа. Үүний дараа юу болох байсныг би бодохыг ч хүсдэггүй.

Би заримдаа хөгийн газруудад хүртэл тоглодог байсан. Түүний нэг нь Паппас юм. Тэднийх галаас зугтах гарц маягийн хуучны цэвэрсэн нарийн хаалгатай, хаа сайгүй үхсэн хархнуудтай, шээс үнэртсэн заваан газар. Эзэн нь өндөр туранхай пакистан нөхөр. Хоёр сар гаруй эзгүй байгаад ирэхдээ хөлөндөө буудуулчихлаа гэсээр ирж билээ. Эдний ихэнх тоглогчид нь энэтхэг, пакистан хүмүүс. Бид тийм ч их мөнгөөр тоглоогүй. Ойролцоогоор таван зуун паундын сантай тоглов. Тэднийг нэг нэгээр нь хожсоор байлаа. Тэд ч ээлж дараалан суусаар бүгд алдаад дуусахдаа ихэд ууртай байсан даа. Тэр орой би Жон Вэйнээс илүү олон энэтхэгтэй тулалдав. Шөнө дөл өнгөртөл үргэлжилсэн тоглолтын эцэст би тэдний бүх мөнгийг хамж орхисон тул тэд тун их дургүйлхэцгээв.

Хари бид хоёр явахдаа гал тогооны өрөөний гэрлийг унтраагаад хаалгыг сэмхэн онгойлгон харанхуйд чимээ чагнатал нарийн гудамжны үзүүрт тэдний шивнэлдэх дуун сонсогдов. Тэднийг мөнгөө буцааж авахаар эргэж ирнэ гэдгийг бид мэдэж байсан юм. Тэд биднийг зодохоор үүдэнд хүлээж байлаа. Өглөөний зургаан цаг орчим болж байсан ч гадаа чимээ аниргүй, харанхуй байв. Би буугаа гаргаж агаарт хий буудахад нам гүмхэн орчинд буун дуу яг л их буу шиг сонсогдож билээ. Хари надад буу байгааг мэдээгүй учир хүчтэй буун дуунаар ухаан алдах дөхөв. Пакистанчууд ч бүгд айж, харанхуйд бүдчин сандралдаж яг л живж байгаа онгоцноос зугтаж ядах хархнууд шиг тал тал тийш зугтацгаасан юм.

Бид машин дээрээ ирэхэд Харигийн нүүр цаас шиг цагаан болчихсон, нүд нь байдгаараа бүлтийчихсэн, зүрх нь хаагдах шахсан байлаа. Тэгснээ тэр "Окей. Одоо яах вэ" гэхээр нь би "Залуу минь дахиад нэг газар очиж тоглоё" гээд тэндээс хөдөлцгөөсөн дөө.

Бирминхэмд би "Рэйнбоу Казино" нэртэй өндөр бооцоотой тоглодог, нэлээн аюултай газарт тоглож их мөнгө хожчихоод байтал намайг "чөтгөрийн загас" хэмээн хочилсон, хувийн тоглоомын газартай Стив Ау Еунг гэгч залуу өөрийн тоглоомын газар очиж хувийн тоглолт хийхийг надад санал болгов. Би ч зөвшөөрч хамтдаа тийш явцгаасан юм. Тэнд очиход ердөө хорьхон яард орчим газар үлдээд байхад би гэнэт бодлоо өөрчилж "Ер нь тийшээ очих ямар хэрэгтэй юм бэ?. Би бүх мөнгийг нь хожсон, тийшээ орохоор тэд бүгдээрээ надаас зээлж, миний хожсон мөнгөнөөс сан үүсгэн тоглох болно" гэж бодоод шууд буцаж эргээд, зочид буудлынхаа өрөөнд орж унтав. Энэ нь миний хувьд маш их аз болсон.

Хорин минутын дараа зэвсэглэсэн дөрвөн залуу тэнд очиж нэлээд их мөнгө хожсон Т.Чарли гэгч залуугийн толгойг бууны бөгсөөр зад цохиж дээрэмдсэн байлаа. Тэр үеэр хүмүүс хашгиралдан тал тал тийш зугтаж байсан гэсэн. Ер нь их мөнгө хожсон хүмүүсийг харж байгаад дээрэмчдэд утсаар мэдэгддэг. Тэр хүмүүс намайг тэнд байгаа гэж бодсон байх.

Стив хамт тоглодог хүмүүстээ хоч өгдгөөрөө бас алдартай. Нэг орой зальжингуй харцаар над руу ихэд хүйтнээр харж байснаа "чи яг чөтгөрийн загас шиг харагдаж байна" гэж хэлэв. Ямар

амьтан байдгийг нь би мэдэхгүй учир акул юм уу, тиймэрхүү төрлийн амьтан байх гэж бодоод өнгөрөв. Дараа нь зургийг нь олж үзвэл хачин муухай царайтай амьтан байхаар нь түүнийг би намайг доромжилжээ гэж бодсон. Гэтэл тэр миний дүр төрхийг бус харин довголгоо маань маш аюултай гэдгийг мэдээд тоглолтын арга барилыг минь тийнхүү хочилсныг би ойлгосон.

Миний тоглолт бол Майк Тайсоны зодоонтой төстэй. Тайсон өрсөлдөгчөө зүгээр цохиж унагахыг боддоггүй, бүр алахыг бодож тулалдаг. Би өөрт ирсэн хөзрөөр яг тэгж тоглодог байсан юм.

•••

Намайг буруутгах хэрэггүй, надад зодооны хэрэгсэл одоо нэг их удаан хэрэггүй болсон. Ер нь би асуудалд байнга ороохоо больсон. Долоо хоногтоо ердөө дөрвөн өдөр л.

•••

"Чөтгөрийн загас" гэдэг хоч намайг Америкт нэрд гарах хүртэл нэг их тархаагүй байсан. Үнэндээ тэр хочийг би Стивийн байрнаас гарахдаа л бараг мартсан даа.

1997 оны нэгдүгээр сард азаа үзэхээр Лас Вегаст ирж, Фор Күинс Казинод анхныхаа тэмцээнд оролцож байхдаа "мастер" Мэн Нгуентай Омаха тоглож билээ. Түүний дэмжигчид босч "мастер" хэмээн хашгиралдаж байхад харин миний цор ганц дэмжигч Хари босч ирээд "Үзүүлээд өг. Чөтгөрийн загас минь" хэмээн хашгирч байлаа. Тэр орой би Мэнийг хожиж, "Чөтгөрийг загас мастериЙг залгилаа" гэж маргаашийн сонины тэргүүн нүүрэнд гарч билээ.

Гурван сарын дараа Бинионст тоглож байхад миний аз эсрэгээрээ эргэв. Үнэндээ тэр үед би өөрийнхөө хэмжээнд маш их мөнгө хожчихсон байсан. Ингээд тайвширч, довлолгүйгээр бас нэг их идэлгүйгээр тоглосноор алдаж эхэлсэн. Эхлээд 200 мянган доллар алдаж, нэмж 70 мянган доллар зээлж аваад бүгдийг нь алдсан. Тэр үед тэнгэрийн авралаар Техасаас ирсэн цагаан үст Бобби Лорестой таарч, тэр намайг ойлгож, 2000 доллар зээлүүлэв. Ингэж л би тоглолтоо үргэлжлүүлсэн дээ.

Тэгээд 1997 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний хязгаартай Холдемийн тэмцээнд оролцов. Тэр тэмцээнээс би 180 мянган доллар хожсон төдийгүй миний алтан бугуйвч авсан ганц тэмцээн байлаа.

Тэмцээний сүүлчийн тоглолтод надад бундын тамга, дөрөв, эргэсэн мод нь гурав, тав, долоо байснаас түүний хоёр нь бунд байв. Өрсөлдөгч маань хоёр долоотой байсан. Тэрбээр нийт гурван долоотой болж давуу байдалтай болов. Миний хувьд хоёр, эсвэл зургаа гарч страйт хийх, аль эсвэл ямар нэгэн бунд гарч флашдах болох зорилготой байлаа. Тэрбээр бүгдийг түлхэж "оолин" (all in) хийж намайг үхлийн цохилтод орууллаа хэмээн бодсон байх. Хөзөр эргэхэд үнэхээр гайхамшигтай тоглолт болов. Миний "туг" гарч ирсэн. Маргааш өдрийн сонины эхний нүүрэнд "Гайхамшигт туг" гэсэн гарчигтай нийтлэл гарав. Хүмүүс бусад хөзрүүдийг мартсан байх. Надад зургаа, эсвэл нэг бунд эргэхэд хожих байсан боловч хэвлэлийнхэн зөвхөн "туг"-ийг л бичсэн.

•••

100 мянган доллар гэдэг тухайн үед миний нэр оролцсон мөнгөн дүнгийн бараг тал нь байсан. Тэр үед үнэхээрийн галзуу хүн л иймэрхүү зүйл хийх тухай бодох байсан байх. Би тэдэнд болж байна. Тоглоё" гэсэн.

•••

Би бугуйвч дээрээ "Devilfish" гэж сийлсэн. Бас үүнээсээ санаа авч "чөтгөр" ба "загас" гэж сийлсэн хоёр том бөгж зүүдэг болов. Урьд нь би үргэлж зодолдохдоо хэрэглэх зорилгоор гартаа атгадаг бөгжин цагираг байнга авч явдаг байлаа. Хэрвээ Англид ийм хэрэгсэлтэй явж байгаад баригдвал шууд л шоронд орох хангалттай үндэслэл болно. Харин Америкт иймэрхүү зодооны хэрэгсэл, том бөгжөө ил гарган зүүж явахад хуулиар бүрэн зөвшөөрөгдсөн байдаг. Үгүй ээ, зөвшөөрөгдсөн ч гэж дээ. Тэглээ гээд шоронд орох үндэслэл болохгүй л байхгүй юу. Энэ тухай ярилаа гээд одоо намайг буруугаар бүү ойлгоорой. Одоо бол эдгээрийг байнга авч явж, зодолдохдоо хэрэглэхээ больсон. Ер нь сүүлийн үед асуудалд бараг орооцолдохоо байсан гэж ойлгож болно.

Дэлхийн цуврал тэмцээнээс 180 мянган доллар хожсоныхоо дараа би маш их хэмжээний өр барагдуулав. Ингээд л бэлэн мөнгөний томоохон тэмцээнүүдэд түрүүлж эхэлсэн дээ. Дараа нь 1990-ээд оны үед хүчтэй байсан Мансур Матлоби гэгч иран тоглогчтой таарав. Тэрбээр 1990 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний Main Event-д түрүүлсэн америк бус гаралтай тоглогч юм. Тэр намайг Лайл Бермантай хязгаартай Омаха тоглохыг зөвлөв. Л.Берман тэр үедээ Лас Вегаст Омаха тоглолтоор толгой цохидог байлаа. Тэрбээр надтай тоглохыг зөвшөөрсөн хэдий ч ширээн дээр ирэхдээ 100 мянган доллартай ирэхийг санал болгов.

Маш их өр дарсны дараахан тэр үед, миний хувьд 100 мянган доллар гэдэг миний нэр оролцсон мөнгөн дүнгийн бараг тал нь байв. Ийм үед үнэхээрийн галзуу хүн л үүнийг хийх тухай бодох байсан байх.

Би түүнд, "Болж байна. Тоглоё" гэж хэлсэн. Ингээд бид тоглоход түүний ард Т.Ж. Клаутер сууж байлаа. Өөрөө тэр зогсоохоор шийдвэрлэх хүртэл би 168 мянган доллар Л.Берманаас хожсон юм.

Л.Берманыг хожсоны дараа би 300 мянган долларт ойртсон гэж хэлж болно. Миний өмнө Пагги Пийрсон орж байлаа. Тэр 1970-аад оны үеийн Покерын дэлхийн цуврал тэмцээний дөрвөн бугуйвчтай. Харамсалтай нь, 2006 онд нас барсан билээ. П. Пийрсон хувийнхаа "Мөрийтэй тоглогч аялагч" нэртэй автобусаар аялан тоглодог байв. Автобусныхаа гадна мөн "Би хэзээ ч, хаана ч, хэнтэй ч хүссэн тоглоомоор нь, хүссэн мөнгөөр нь тоглох болно" гэсэн бичиг наагаастай аж.

Түүний тухай сонсч байснаас өмнө нь огт хараагүй учир би түүнд "Хөөе, Пагги. Одоо чиний ээлж, хүрээд ир, хамт тоглоё" гэхэд тэрбээр өмнөдийн аялгаар "Чөтгөрийн загас минь. Чамд би нэг юм үзүүлье, хүрээд ир" гэв. Харрид мөнгөө үлдээчихээд П.Пийрсоныг дагаж автобусных нь дэргэд очиход тэр маш жижгээр бичсэн "надад таалагдсан тохиолдолд тоглоно" гэсэн бичгийг надад харуулав. Тэгснээ над руу эргэн харж, "Devilfish. Чи надад

таалагдахгүй байна" гэв.

Түүнээс хойш би өндөр бооцоотой Омаха тэмцээнүүдэд 20 гаруй удаа оролцов. Нэг удаа Самми Фархатай гурвын эсрэг нэг тоглоом тоглож байхдаа мөнгөө алдсан. Самми бол мөрийтэй тоглогч, би түүнтэй тоглох дуртай. Түүнээс мөнгийг нь салгана гэдэг тун хэцүү.

Миний өнгөрсөн үеийн хүндхэн амьдрал, покерын ертөнц дахь нэр хүнд маань ширээний ард дахь амжилтын бараг тал хувь болж надад тусалж байсныг хэлэх хэрэгтэй. Шинэ залуу тоглогчид, сонирхогчдыг би "сармагчингууд" гэж дууддаг. Надаас тэд үнхэлцэгээ хагартал айна. Тэд үргэлж намайг хожихийг хүсч, байнга намайг бай болгон онилж байдаг. Гэхдээ тэд гартаа хөгийн мод барьчихаад бооцоогоо өсгөж байгаа нь хүртэл жул харагддаг юм. Ихэнх нь намайг бас бусад том гаруудыг ангуучлахаар зэхдэг. Аливаа тэмцээнд таван мянган хүн оролцлоо гэхэд дөрвөн мянга таван зуун нь сармагчингууд байдаг. Тэр дундаас нэг азтай нь чамайг буулгаж авч болно. Энэ нь яг тэсрэх бөмбөгтэй талбайд сүлжиж яваад хальтираад гишгэчихтэй адил. Тэмцээнд орохдоо би эхлээд том гарын тоглогчдод хандаж "эхлээд моднуудыг тайрцгаая, тэгвэл сармагчингууд орж чадахгүй" гэж хэлдэг.

Сармагчингуудаас гадна тэнд бас эмэгтэй тоглогчид бий. Миний бодлоор эмэгтэйчүүд эрчүүдтэй адил тоглож чадахгүй. Мэдээж тэдний дунд ганц нэг онцгой тохиолдол байж болох юм. Англид Люси Рокач гэдэг эмэгтэй бий. Тэр бараг л зэрлэг нохой гэсэн үг. Өглөөнийхөө цайндаа түүхий мах иддэг гээд бод доо. Хэрэв түүнийг хожоод мөнгийг нь авчихвал тэр чиний араас муу санаалан салахгүй дагана. Мэдээж сайн бүсгүйчүүд олон байгаа ч эмэгтэй хүн эрэгтэй хүн шиг дайчин биш, том гарын тоглогчид бол бүгд маш дайчин байдаг.

Покерын дэлхийн цуврал тэмцээнд оролцож байхад тэнд гурван эмэгтэй байгааг хараад тэдэн дээр очиж "Хэн тэгээд хоол хийж, хувцас индүүдэж, аяга таваг угааж, цэвэрлэгээ хийх болж байна" гэж асуув. Тэд жуумалзаагүй болохоор нь би "эмэгтэйчүүд жижигхэн хөлтэй болохоор гал тогооны угаалтууртай ойр дөхөм байдаг, тэгээд ч тэд үргэлж цагаан өнгөтэй нийлэн гал тогооны өрөөндөө уусдаг" юм гэж дахин хэлэв.

Би тоглоомноос тэнгэрийн умдаг атгахын тулд чадах бүхнээ хийдэг. Эхний шатанд сармагчингуудаас хол байхыг хичээдэг, дараагийн үеэс аз хийморь тоглолттой холилдон ирдэг. Ер нь аз хийморь хэзээ ч хэрэгтэй. Тоглоомын дундуур элдэв хувилбар хийх хэсэг хасаа танд хэрэгтэй, дээр нь бас түүнийгээ ашиглах чадвар хэрэгтэй. Зарим үед сайн модгүй байсан ч санг хулгайлж болно. Хожихын тулд заавал хасаагаа нэмэгдүүл, хасаатай байвал заавал сайн модтой байх шаардлагагүй.

Хүмүүс заримдаа надаас "чи хэзээ тайвшрах юм бэ" гэж асуудаг. Гэвч би байгаараа л байж, нийлдэг хэдтэйгээ шоудсан хэвээрээ л байгаа. Миний найз охин одоо хорин нэгэн настай, бид хоёр хамтдаа жил гаруй болж байна. Элдэв сониуч зан маань хэвээрээ, тайвширна гэж ер бодохгүй байна. Зарим нэг нь "далайн эрэг дээр байр худалдан аваад тэтгэвэртээ гарахгүй юм уу" гэдэг. Яахав үл хөдлөх хөрөнгө худалдан авч болох л юм, харин тэтгэвэртээ гарах талаар бодох болоогүй байгаа. Хэзээ тогломоор санагдана тэр үедээ тоглох л болно, одоогоор тоглоход хүндрэлтэй хэцүү мэдрэмж надад төрөөгүй байна.

Магадгүй үхсэн загастай холбоотой ямар нэг зүйл байдаг юм уу бүү мэд. Би одоо хүртэл хүнд

гарын аваргуудтай нөхөрлөдөг. Тэд маш өөнтөгч, хатуу ширүүн хүмүүс. Бид нүцгэн гараараа зодолддог зодоон очиж үздэг. Миний амьдрал тэр чигээрээ галзуу юм шиг. Дээр нь би уух дуртай, шоудах дуртай, өөр юу гэж хэлэх вэ, энэ бол би.

Би гитар, төгөлдөр хуур тоглох дуртай. AC/DC, Rolling Stones-ийг сонсч, Эрик Клэптоныг тоглох дуртай, ойлгож байгаа биз дээ. Яг Эрик Клэптон шиг биш шүү, зүгээр л түүний дуунуудыг тоглох дуртай.

Одоо би зургаан хүү, нэг охин, гурван ачтай. Тэд миний амьдралын нэг хэсэг болсонд би баярлаж явдаг юм. Маш сайхан байшин, бас "Феррари" машин бий, олон хүний мөрөөдөж байдгаас ч илүү тансаг, үнэндээ бол би их ерөөлтэй хүн.

Чөтгөрийн загас буюу www.devilfishpoker.com бол намайг покер тоглоогүй үед аливаа асуудлаас хол байлгадаг зүйл маань юм. Бид Америкийн тоглогчдыг оруулахгүй байгаа ч гэсэн боломжийн байгаа.

Амьдралдаа би маш энгийн философи баримталдаг. Амьдрал бол тэсрэлт, тийм удаан үргэлжлэхгүй. Тиймээс аль болох удаан бас дээрээс нь хурдан амьдар."

Тийм ээ энэ бол загас, хүүхэд минь.



Даниел Нигрэану

Киноны дүрийн шалгаруулалтад орох, бейсболлын бөмбөгийг хүчтэй цохигчийн шидэхээс өгсүүлээд покерын дэлхийн цуврал тэмцээний шувтаргын тоглолтын ширээн дээр тоглож байхдаа хүртэл Чад Браун зорилгодоо хүрэхийн тулд байнга өөрийгөө төвлөрүүлдөг. Тэрбээр амжилт олж болох жүжигчин, загвар өмсөгч, бейсболлын тамирчнаас илүүтэй покерыг дээгүүрт тавьсан юм. Мааш чадварлаг, бэлэн мөнгөөр голдуу тоглодог Чад Браун 2006 онд гялалзсан амжилт үзүүлж, тэр жилдээ Блэф сэтгүүлийн "Оны тоглогчоор" шалгарч байлаа.

2007 онд амжилтаа үргэлжлүүлэн тоглож, мянга таван зуун долларын хязгаартай Омаха найм болон түүнээс дээшхи тэмцээнд тавдугаар байрт орж байв. Мөн хязгаарлалтгүй тоглоомын дэлхийн аваргын тэмцээний хоёроос долоон төрөлд Эрик Зайделийн араас нэхэж

хоёрдугаар байрт оров. Ч.Браун өөрийн жүжиглэх авьяасаа харуулан зурагтын хэд хэдэн нэвтрүүлгийг тэдгээрийн дотроос "Покерын шилдэг сорилт" шоууг хөтөлсөн удаатай юм.

Булчинлаг бадриун биетэй тэрбээр покерын тоглолтод эрүүл чийрэг бие бялдар ихээхэн чухал болох талаар Блэф сэтгүүлд хэд хэдэн өгүүлэл бичсэн байна.

Би 15-16 настай байхдаа найзуудынхаа хамт Итали кафены арын өрөөнд покер тоглож эхэлсэн. Үнэхээр санамсаргүйгээр би тогтмол хождог байв. Миний хүүхэд насны хүсэл мөрөөдөл покертой огт холбоогүй. Мэргэжлийн тоглогч болоход минь хүүхэд насны үеийн ямар ч холбоо байхгүй. Гэвч би покер тоглож хожсоноо тооцож эхэлснээр миний орлогоор нэмэгдсэн.

Эцэг маань Нью Йоркийн Бронкс хот дахь байшингийнхаа ард покер тоглуулдаг байлаа. Би тэр үед арван хоёр настай байсан. Тэрбээр надад покерын анхан шатны мэдлэг олгосон юм. Өрсөлдөгчөө ажиглах, үнэлэх, арга барилыг нь судлах гээд үнэтэй сургаал зөвлөгөө өгч байв. Хэдий сайн тоглогч байлаа ч гэсэн уурлах юм бол тоглолтын арга барил алдагддаг гэдгийг маш сайн ойлгуулсан. Уурлаж бухимдсан үедээ ихэнх хүмүүс голдуу муу тоглож эхэлдэг. Тиймээс тоглож байхдаа болгоомжтой бай, хэрэв өрсөлдөгчид чинь хүнд байдалд орвол хасааг нь хурааж ав гэдэгсэн.

Хамгийн шилдэг тоглогчид ч хожигдох үе гардаг. Гагцхүү сайн, муу тоглогчын ялгарах ганц зүйл гэвэл тэд ялагдлаа хэрхэн хүлээж авч байгаараа мэдэгддэг. Аав минь тоглож байгаад хожигдохоороо уурлаж, босоод яваад өгдөг байв. Тэгээд надад заахдаа, амжилтад хүрье гэж бодож байвал чи өөрийн арга барилыг сонго, байнга түүгээрээ бай гэж хэлсэн. Өнөөдрийг хүртэл миний баримталж ирсэн зарчим бол тайван байдал юм. Энэ нь намайг илэрхийлдэг.

Кафед ихэвчлэн долоон хэзрийн стад тоглодог байлаа. Заримдаа дилерийн сонголтоор Омаха, Крис Крос болон өөр олон тоглоом тоглоно. Надад олон тоглоомын боломж, магадлалыг тооцох унаган авьяас байгааг би мэдэрсэн. Тэр чадвар маань өнөөдрийн компьютер тооцооллыг хийх арга гарахаас өмнө надад их тус болсон юм. Тоглогч бүр өөрсдийн чадварт найддаг. Бусад хүмүүсийн хувьд илүү боломж байхад би бооцоогоо дахин дахин өсгөдөг. Тэгээд сангаа хурааж байхад хүмүүс намайг азтай гэж боддог ч үнэндээ би мэдрэмжээрээ бүх зүйл миний талд байгааг мэддэг юм. Энэ нь эсрэг тоглогчдод маань тэгж харагдахгүй байсан ч би өөртөө итгэдэг.

•••

Намайг азтай байлаа гэж хүмүүс бодохыг би зөвшөөрдөг. Анх тоглож эхэлж байхдаа яагаад тэгж тоглосноо их тайлбарладаг байсан. Одоо бол зүгээр л зөвшөөрч, энэ удаа би азтай байлаа, та ч гэсэн дараагийн удаа азтай байх болно гэдэг болсон.

•••

Намайг азтай байлаа гэж хүмүүс бодохыг нь би зөвшөөрдөг. Анх тоглож эхэлж байхдаа яагаад тэгж тоглосноо их тайлбарладаг байсан. Одоо зүгээр л зөвшөөрч би энэ удаа азтай байлаа, та ч гэсэн дараагийн удаа азтай байх болно гэдэг болсон. Орчин үеийн покерын тэмцээнд

тоглогчид бие биенээ шүүмжилж, хожигдвол уурлаж хүмүүсийн анхаарлыг татдаг. Жишээ нь "баахан 4 гарсан байхад чи гартаа тамга, хатан, боол барьчихаад өсгөөд байдаг, яадаг тэнэг вэ" гэх мэтээр тоглогч хэлж байхыг та нар сонссон байх.

Энэ бол солиотой явдал. Харин миний хувьд хасааг нь авах гэж байгаа хүндээ хэзээ ч заадаггүй.

Кафед тоглож байхдаа оройдоо 300-400 доллар хождог үе байсан. Тэр үедээ мэргэжлийн тоглогч болно гэж огт бодож байгаагүй. Загвар өмсөгч юм уу бейсболын тамирчин болохыг хүсдэг, хоёулаа боломжийн санагдаж байлаа.

Сэтгүүл, сонин, сурталчилгааны хуудсанд хувцас сурталчлан зургаа даруулж эхлэхийн хажуугаар жүжигчний сургалтад явж эхлэв. Учир нь зурагтын сурталчилгаагаар бас амжилт олж магадгүй гэж бодсоны үүднээс ийм алхам хийсэн юм. Анхны зурагтын сурталчилгаа "Жордаче" жинснийх байлаа. Тэгээд ганц хоёр сурталчилгаанд тоглосон. Удалгүй загварын ертөнцийн ид шид нь загвар өмсөгчдөө бус гэрэл зурагчинд байдгийг ойлгож, загвараас уйдаж эхэлсэн. Харин жүжиглэх нь хавьгүй бүтээлч болохыг ойлгов.

Би бас бэйсбол тоглож эхлэв. Энэ бол жинхэнэ бэйсбол байлаа. Тоглогчид нь урилгаар очно. Миний дасгалжуулагч Сид Пак лигийн шилдэгүүдийн нэг Род Кареуг эхнээс нь дасгалжуулан бэлтгэсэн юм. Сид Пак намайг талбайн болон бөмбөг шидэгч тоглогчоор бэлтгэж гарав.

Түүнээс өмнө Нью Йоркийн хамгийн сайн сургалттай Колумбус ахлах сургуульд сурч байхдаа би бэйсбол тоглодог байлаа. Хотын аваргын тэмцээнд ч оролцсон. Төгсөх жилээ амжилттай тоглосон ч хагас шигшээ тоглолтод харамсалтайгаар хожигдож хасагдсан юм.

• • •

Кино найруулагч Витней Бурнетийн киноны дүрийн шалгаруулалтад ороход тэрбээр "Чад чи энэ дүрд тохирох хүнээс их ялгаатай байна, чамд гэж хэлэхэд, чи энэ дүрийг авч чадахгүй" гэв.

• • •

Тэр өдөр би бөмбөг шидэж байсан бөгөөд дөрөвдүгээр үе гэхэд бид 5:2-оор хожиж явсан юм. Үүр дүүрсэн гаралттай явж байгаад алдаа гарган тэд талбай давуулан цохиж оноог 5:6 болгосон. Учир нь түүний цаана олон үе байгаа тул үүнд бид санаа зовохгүй байлаа. Дараагийн үе эхлүүт бороо цутган орсноос тоглох ямар ч боломжгүй болж шүүгчдийн саналаар тоглоомыг дуусгаж билээ. Ингэж биднийг хожсон баг дараа нь хотын аварга болсон юм.

Бөмбөг шидэх нь покертой тун төстэй, тэрбээр өөрийн бодлогоор цохигчийг удирдана. Цохигчийг гарч ирүүт түүнийг ажиглаж, юу хүлээж байгааг олж мэдэхийг бодно. Хэрэв цохигч хурдтай бөмбөг хүлээж байвал эргүүлнэ, эргүүлэг хүлээж байвал эсрэг зүг нь эргүүлнэ, мөн өндөр нам, дотуур гадуур гээд ямар бөмбөг хүлээж байна вэ? гэдгийг бүгдийг тооцоолохыг хичээнэ. Тэгээд бодсоноос нь тэс өөрөөр шидэж түүнийг гайхшруулна. Покер

үүнтэй яг ижил, үргэлж өрсөлдөгчийн толгойд юу болж байгааг таамаглахыг хичээнэ, тэгээд түүндээ үндэслэн дараагийн үйлдлээ хийнэ.

Арван жилээ төгссөний дараа Майамигийн их сургуулийн бэйсболын багт тоглохоор очоод эхний жилдээ нөөц суудалд сууж өнжив. Манай багш хэлэхдээ, "чи очингуутаа гарааны тоглогч болно" гэсэн. Би сургуульдаа "од" байсан учраас ингэж нөөцөнд суух нь надад цоо шинэ зүйл байлаа. Байдал энэ хэвээр үргэлжилж, хоёр жилийг үдэв. Дараа нь Нью Йорктоо эргэн ирж, хагас мэргэжлийн Вестчестер Бэйсболын Нийгэмлэгт орсон юм.

Тоглож байх хугацаандаа жүжигчний сургууль, загварын ажлаа дахин хийж эхлэв. Бэйсболын сайн тоглогч байсан учир надад доод лигийн Нью Йорк Мэтс багт тоглох гэрээний санал ирлээ. Бараг үүнтэй зэрэгцэн зурагтын цуврал "Шөнийн хязгаар" савангийн дуурийн дүрд бас уригдав. Энэ нэвтрүүлэг цагтаа хүмүүсийн үзэх дуртай нэвтрүүлэг байсан ч нэг их удаан дэлгэцэнд гараагүй юм. Миний хувьд бэйсбол эсвэл жүжигчин гэсэн сонголтоос нэгийг сонгох хэрэгтэй болсон.

Кино найруулагч Витней Бурнетийн киноны дүрийн шалгаруулалтад ороход тэрбээр "Чад чи энэ дүрд тохирох хүнээс нэлээн их ялгаатай байна, чамд гэж хэлэхэд, чи үүнийг авч чадахгүй" гэв. Тэрбээр цааш хэлэхдээ "хэрэв уран сайхны кино байсан бол асуудал алга, харин чи дөнгөж эхэлж байна, тэгээд ч энэ чинь савангийн дуурь шүү дээ" гэлээ.

Би юмны учрыг гадарлана. Цаад санаа нь ойлгомжтой байв. Тодорхойгүй байсан олон зүйл илэрхий болж ирсэн. Савангийн дуурь хүнд ажил, дараачийн өдрийн зураг авалтад бэлтгэхийн тулд үнэндээ 24 цаг бэлтгэл хийх хэрэгтэй. Өдөр болгон ийм хуваариар бэлтгэл хийнэ. Шинэ жүжигчид энэ ачааллыг дааж гарахад хэцүү. Найруулагч надад сайн жүжигчин болох ирээдүй байгааг хэлсэн юм. Бэйсболын хувьд А зэрэглэлийн түвшинд гэрээ хийгдэв. Сайн тогловол АА, дараа нь ААА түүнээс илүү давж гарвал мэргэжлийн лигт тоглоно. ААА-гаас мэргэжлийн лигт гарна гэдэг аугаа алхам. Ердөө хуруу дарам цөөхөн хүн тэр үсрэлтийг хийсэн дээ.

Тэрбээр шууд хэлээгүй боловч эм хэрэглэн бие махбодио хөгжүүлж, хүлээх цагаа наашлуулахыг бишүү утгаар ойлгуулав. Түүнийг хэрэглэхгүйгээр дараачийн шатанд орно гэдэг боломжгүй зүйл гэдгийг тайлбарлав.

Би нэг дасгалжуулагчаасаа миний боломж хэр байгааг асуухад "ирэх хоёр жилд одоогийнхоос 20-25 паундаар булчинг нэмбэл нэлээн сайжирна. Түүний дараа магадгүй, зөвхөн магадгүй шүү, чи үзээд алдаж болох юм" гэлээ. Би энэ орчинд хангалттай удаан хугацаанд байсан болохоор байдал ерөнхийдөө ямар байдгийг мэднэ. Иймээс асуудал бараг яаж төгсөхийг тааварлаж байсан. Тэрбээр шууд хэлээгүй боловч эм хэрэглэн бие махбодио хөгжүүлж, хүлээх цагийг богиносгохыг ойлгуулав. Түүнийг хэрэглэхгүйгээр дараагийн шатанд орно гэдэг боломжгүй зүйл гэдгийг бас тайлбарлав.

Нухацтай удаан бодсоны эцэст мэргэжлийн бэйсболлын тамирчин болно гэхэд найман жилийн хугацаа байна, тэгээд бас тийм ч баталгаатай биш. Дээрээс нь мэргэжлийн дээд лигт ороход хол байна. Орж чадах эсэх нь ч тодорхойгүй. Тэгээд ч одоогийн доод лиг маш бага цалинтай. Эндээс үзэхэд боломжууд миний эсрэг гарч ирээд байв. Гуч хүрээд тэр бүгдийг

дуусгасны дараа амьдралаа дахин эхлэх зам дээр зогсч байгаагаа ойлгож билээ.

Бэйсболын чадварлаг мэргэжлийн тоглогчдын хүрээ хязгаарлагдмал. Жүжигчид амьдралынхаа бүхий л хугацааг бэлтгэлдээ зориулна. Энэ бүхнээс би эцсийн шийдвэр гарган бэйсболлоо орхин, покероо үргэлжлүүлэн тоглож, хажуугаар нь жүжигчин бэлтгэх багшийн удирдлага дор ажиллаж эхлэв. Тэрбээр надад их зүйлийг заасан даа. "Өөр ертөнц" гэдэг савангийн дуурьт гоё дүр авсан. Зөвхөн тайзан дээр тоглоод байх надад сонирхолгүй байлаа. Удахгүй Баруун эрэг рүү нүүнэ гэж бодож байсан. 1990 онд Лос Анжелест очихдоо жүжигчин болтлоо наана нь бармэн юм уу зөөгч хийж амьдарна гэсэн хүлээлттэй очсон юм.

Лос Анжелест ирсэн даруйдаа миний хамгийн их гайхсан зүйл бол казино. Атлантик Сити, Лас Вегаст казино байдаг гэдгийг мэддэг ч харин Лос Анжелест казино байдаг, дээр нь энд покер тоглох зөвшөөрөлтэй гэж бодохоор юу болоод байгааг ойлгохгүй шахам гайхаж байлаа. Эхлээд сонирхогчидтой хамт арын ширээнүүдэд тоглож эхэлсэн. Хуучны архаг тоглогчидтой тоглоход миний чадвар ямар түвшинд байгааг мэдэхгүй байсан.

Эхний удаа "Коммерс" казинод 30-60 долларын бэлэн мөнгөний ширээнд тоглоод хожсон, одоо яг хэдийг хожсоноо санадаггүй юм, 2000 ам.доллар байж магад, гэхдээ гол нь хожсон. Үүнээс эхлэн тоглож эхэлсэн дээ. Голдуу л хождог болсон. Хүмүүс илэрхий алдаа их гаргаж байгааг мэдэж, түүн дээр нь тоглолт хийж, хожиж эхэлсэн юм.

Энэ үед жүжигчний ажил бас амжилттай явагдаж эхлэв. Вүүди Аплений хуучин эхнэр Люис Лесертэй хамт "Цусан зам" киноны дүрд тоглох болов. Мөн Биюу Брижийн зурагтын шоуны "Максимум Боб"-ын дүрийг авав. Ахмад Рашидийн шоу "Цезарийн сорилт" шоуд Ромын цэрэг, түүнээс гадна "Майамигийн үймээн", "Хулсан сав 2" зэрэг кинонд уригдав.

•••

Үйл ажиллагаа сайн явж байсан ч гүйцэтгэх захирал буруу хүн байснаас манай компани гурван жилийн дараа нам унав.

•••

Хэдийгээр би зорилгодоо хөтлөгдөн явдаг ч бодит байдал дээр гарч ирж байгаа боломжуудыг жүжигчний ажлынхаа хажуугаар сонирхдог байлаа. Сайн найз маань 1995 онд надад нэгэн хувьцаат компанид борлуулалт хариуцсан дэд ерөнхийлөгчөөр ажиллах санал тавьсан юм. Компани ашигтай ажиллавал сая саяар мөнгө хийх сайхан боломж байсан ч гол нь Флорида руу нүүх нөхцөлтэй байлаа.

Яахаа мэдэхгүй хэсэг эргэлзсэнээ, компанийн ажил надад таалагддаггүй, би мөнгөний хойноос биш харин өөрийн юу хүссэн, дуртай зүйлээ хийнэ гээд тэрхүү боломжийг түр орхихоор шийдсэн юм. Тэр үед жүжигчний ажил маань ч нэлээд амжилттай явж байсан төдийгүй цаг хугацаа өнгөрөх тусам би өөрөө өөртөө итгэлтэй болж байлаа. Тиймээс уг ажлаас татгалзахаар шийдэв.

Найз маань намайг ятган "зөвхөн гуравхан жил ажиллахад л бид саятнууд болно, түүний

дараа ч юу дуртайгаа хийхэд хангалттай мөнгөтэй болно, түүгээр уран бүтээлийн компаниа ч байгуулж болно шүү дээ" гэж хэлж билээ.

• • •

Сүүлчийн тоглолтод оролцоод ялалт ойрхон ирлээ хэмээн бодож байв. Түүний дараа ажилдаа иртэл найруулагч намайг дуудаж "Чад, намайг уучлаарай, би алдаа хийжээ, одоо бүх зүйл утгагүй болсон" гэв.

• • •

Тэр саналаас шууд татгалзаж чадахгүй ч бас шуудхан хүлээн авч чадахгүй байсны эцэст зургаан сар гэхэд гол дүр олж авч чадахгүй бол компанийн ажилд оролцоно гэсэн амлалтыг өөртөө болон найздаа өгөв. Хугацааны туршид ямар нэг өөрчлөлтгүй явж ирснээ амлалтын хугацаа дуусахаас долоо хоногийн өмнөөс олон зүйлс зэрэг давхцаж ирэв.

Инээдмийн шинэ шоуны гол дүрд миний нэр дэвшлээ. Утсаар гурван удаа ярилцсаны дараа найруулагч миний тухай судалж эхэлсэн нь тодорхой болов. Найруулагч намайг цаг агаар танилцуулагчийн дүрд оруулахаа хэлэв. Энэ дүр нь "Мэри Тайлер Мүүр шоу"-ны Тэд Бакстериин дүртэй ижил жаахан тэнэгдүү, сайн залуугийн дүр байв. Түүнчлэн Кэвин Поллак түүнд тоглохоор болсон нь нэр хүндийн хэрэг байлаа. Эцэст нь энэ дүрд надаас гадна өөр нэг хүн, бид хоёр л тунав. Шалгаруулалтад орсон тэр долоо хоногтоо Роб Рэйнерийн кинонд Бетти Мидлертэй хамт тоглохоор урьдчилсан уулзалтад оров. Тэр хоёр хоёулаа том сорилт байсан боловч би ялж чадаагүй. Энэ бүхэн надад маш гайхалтай сэтгэгдэл төрүүлсэн юм. Тэнцээгүй гээд сэтгэлээр унаагүй, элдэв сөрөг бодолгүй үлдэв. Ялалтад би маш ойрхон очсоноо мэдсэн төдийгүй зөвхөн цаг хугацааны асуудал гэж бодоод өнгөрсөн. Энэ зуур найздаа амласан амлалтаа биелүүлж, Флорида явав.

Флоридад очоод би покер ерөөсөө тоглоогүй. Жүжигчин болох бодлоо ч орхив. Компани маань эмнэлгийн тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг хувьцаат компани байлаа. Гол бүтээгдэхүүн нь үений зөөлөн эдийг мэс заслын бус аргаар эмчлэх тоног төхөөрөмж. Бүтээгдэхүүн, үйл ажиллагаа сайн явж байсан ч гэсэн гүйцэтгэх захирал буруу хүн байснаас манай компани гурван жилийн дараа нам унав. Ингээд өөрийн компанитай болно гэсэн санаа биелэгдэхгүй нь тодорхой болов.

Калифорнид буцаж ирээд урьд нь хамт ажилладаг байсан түнштэйгээ холбогдоход тэрбээр нэлээн нэртэй том компанид ажилладаг болсон байсан. Бид хуучин андууд шиг уулзалдлаа. Түүний харилцаа холбоо бас компани нь надад туслах байх гэж найдан сураг ажиг тавин хүлээсээр гурваас дөрвөн сар өнгөрөв. Тэр үед 38 хүрч, өөрийгөө хөгширсөнд тооцогдох мэт санагдаж эхлэв. Найруулагч нар дүрийн сонголт хийхдээ ихэвчлэн залуу бас нэрд гарсан хүмүүсийг сонгож байлаа. Би хэд хэдэн хэсэгт тоглосон ч жүжигчний амьдралаар өөдөө гарахгүй юм байна гэдгээ хожим ойлгосон доо.

Ганцаараа бага зэрэг покер тоглож явсаар, 2002 онд "Беллажио" казинод болсон Омаха том, жижиг тэмцээн болон долоон хөзрийн стад покер төрөлд оролцон түрүүлж, 80 мянган доллартай гэртээ харив. Тэр үеэс покер өргөн дэлгэрч эхэлсэн төдийгүй 2003 онд "мөнгө

хүүлэгч" хочит Крис "Main Event"- д түрүүлэн орон даяар шуугиан тарьж, олны анхааралд орсон юм. Ийнхүү покер "хууль ёсны" спорт болж, зурагтын маш олон үзэгчидтэй болов. Жүжиглэх авьяас, покерын чамгүй туршлага дээрээ тулгуурлан энэхүү түрэн гарч ирж байгаа давалгаанд өөрийн байр суурийг эзлэх боломж байгааг би олж харав.

Покер тоглохоор бүрэн шийдэн 2004 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний Долоон хөзрийн стад аваргын төлөө Тэд Форресттой тоглож, хоёрдугаар байрт орсон ч, энэ тоглолтын бичлэг зурагтаар гарч олон хүн жүжиглэх болон загварын талаар ярьсныг маань сонссоноор барахгүй, Холливудын нэгэн найруулагч үүнийг үзсэнийхээ дараа миний хуучин түнш рүү утасдаж, покерын шоу хийх бодолтой байна, түүндээ намайг хөтлөгчөөр тоглуулах тухайгаа дурдсан байлаа.

Шоуг "Покерын шилдэг сорилт" буюу "The Ultimate Poker Challenge" гэж нэрлэсэн юм. Түүнд нь би хөтлөгч мөн тоглогчоор оролцов. Тун удалгүй тэрхүү нэвтрүүлэг зурагтын хамгийн шилдэг, хамгийн олон үзэгчтэй шоу болсон төдийгүй араасаа дахин хоёр шоу хөтөлбөрийг дагуулсан юм. Түүнчлэн "Покерын өрөө", "Покерын мөнгө" гэсэн өөр хоёр шоу ч бас хөтлөв. Ингэснээр би өөрийн давуу талаа улам баталгаажуулж, давалгаалан орж ирж байгаа мөнгөн дээрээ нэмж илүү их мөнгө олж байлаа. Зурагтын хөтлөгчийн мэргэжил эзэмшихэд покер тоглож байсан маань ихээхэн тус болж, зурагтын жүжигчний мэргэжлийг маань улам баталгаажуулж өгөв.

Энэ үед би дэлхийн түвшний тоглоомд мэргэшсэн байлаа. Тэмцээний тоглолтод өөрийн арга барилаа тохируулаххэрэгтэй болов. Хязгааргүй Холдем тоглоомд сайжрах хэрэгтэй байв. 2005 онд амжилттай тоглож, хэд хэдэн удаа шувтаргын ширээнд тоглосон юм. Дараа жил нь Блэф сэтгүүлийн "Оны тоглогчоор" шалгарсан нь хамгийн нэр хүндтэй шагнал байлаа.

Оны тоглогч болсон нь миний хувьд зорилгодоо хүрч чаддагийг маань харуулсан тод жишээ болов. Шагнал авахын өвчтэй болж ирэх жилийн шагналыг ч мөн авна даа гэж сүйт бүсгүй Ванессадаа амлав. Тэрээр өөрийнхөө хэмжээнд покер сайн тоглодог мэргэжлийн тоглогч юм. Ингээд тэр жилийг бүхэлдээ шагнал авахын төлөө зориулав. Амлалтаа баталгаажуулахын тулд том гэсэн бүхий л тэмцээнд оролцлоо. Лондонд болсон нэг тэмцээн надад их юм сургасан даа.

•••

Тэр үед жүжигчний ажил маань амжилттай явж, хугацаа өнгөрөх тусам би өөртөө итгэлтэй болж байсан ч энэ ажлаас сүүлд татгалзахаар шийдлээ. Найз маань намайг ятган "зөвхөн гурван жил ажиллахад л бид саятнууд болно, надад итгэ" гэж хэлсэн.

•••

Сэтгүүлийн эрхлэгч рүү утасдаж "10 мянган долларын тэмцээн байна, тэр тэмцээн шагнал авах шалгаруулалтад орох уу" гэж асуухад, болно гэхээр нь тухайн үед хийж байсан бүх зүйлээ орхиж Лондон руу нисэв. Тэмцээний шувтаргын тоглолтод оролцчихоод, шагнал авах эрхээ баталгаажуулчихлаа хэмэн бодсоор ирэв. Буцаж ирсний дараахан сонины эрхлэгч над руу ярьж, "Чад, намайг уучлаарай, тэр тооцогдохгүй юм байна" гэв. Үүнийг сонсоод хэсэгтээ

хачин болсон ч энэ тэмцээнээс 150 мянган ам.доллар хожоод ирсэн учраас сэтгэлээр ер унасангүй.

Төдөлгүй оны тоглогч болох шалгуураа бүрэн баталгаажуулж чадалгүй байсаар Атлантик Ситид болох 5000 долларын оролттой стад тэмцээн шагналд тооцогдоно гэхээр нь очлоо.

Гэвч хамгийн багаар зуун тоглогч оролцох ёстой байснаас дөнгөж гучин хүн л бүртгүүлсэн байсан юм.

• • •

Лондонгоос Атлантик Сити рүү нисэн тоглож байхдаа зочид буудлынхаа өрөөнд бараг бүх цагаа онлайнаар покер тоглоход зориулж байсан ба нийтдээ 225 мянган доллар хийсэн байлаа.

• • •

Очсон өдрөө л тэмцээнд оролцохоос дургүй хүрч, онлайнаар тоглож эхлэв. Сэтгүүлийн шагналт байрыг баталгаажуулж чадаагүй байсан ч интернетээр тоглож их мөнгө хийж болохыг олж мэдэв. Лондонгоос Атлантик Сити рүү нисэн тоглож байхдаа зочид буудлынхаа өрөөнд бараг бүх цагаа онлайнаар покер тоглоход зориулав. Нийтдээ 225 мянган доллар хийсэн байлаа. Нөгөө шагналт байрт орох нөхцлөө баталгаажуулж амжаагүй л байв.

Атлантик Ситигээс Лас Вегас руу нисч, тэндээ 5000,10000 долларын хоёр тэмцээнд оролцов. Эд хоёулаа сэтгүүлийн шалгаруулалтад орохоор байлаа. Ингэснээр 5000 долларын тэмцээнд шалгарч, шагналаа баталгаажуулснаар зорилго маань биелэв.

Амьдралынхаа туршид олон сайхан боломжуудтай тулгарч байсандаа би их баяртай байдаг. Яг одоогоор би покероор амьдарч байгаа ч жүжигчний ажлаа бүр хаяагүй ээ. Миний найз Жэймс Вүүдс гэхэд жүжигчин төдийгүй сайн покерчин. Тэр өөрийн найруулах гэж байгаа киноны хэсэгт намайг тоглуулах талаар саяхан надад хэлэв. Өөр нэг найруулагч покерын тухай өгүүлэх кинонд тоглохыг бас санал болгов.

Надад покерын ширээнээс өөр бизнес удирдах ямар ч сонирхол байдаггүй. Покертоо гол анхаарлаа төвлөрүүлэхийн сацуу би аливаа зугаа цэнгэлтэй боломжуудад өөрийгөө нээлттэй байлгадаг юм. Түүнээс гадна сүйт бүсгүйтэйгээ хамт хандивын ажил нэлээдгүй хийнэ. Ванесса саяхан тэмцээнд түрүүлж дахин хандивын шинэ төрөл нээв. Олон покер тоглогчид хандив өргөдөг, бид хоёр үүнийг голлон зохион байгуулдаг юм.

Покер байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг. Тэмцээний тоглолтод онлайнаар тоглодог залуус тэмцээний стратегийг маш хурдан өөрчилдөг. Өнөөдөр нэг хүн л зөвхөн тэмцээний жинхэнэ мастер гэж хэлэгдэх үе өнгөрсөн. Харин ч Фил Айви хэлэхдээ, хүн бүрт муу тоглолт, ялагдал байдаг гэв. Мэдээж хэрэг покер нь спорт болохоор аз бас хамаатай. Сонирхогчид болон эхлэн тоглогчид гольф тоглохоор Тайгер Вүүдстэй хамт талбайд гараад хожих нь юу л бол, харин покер тоглоход сонирхогчид сайн хөзөртэй л бол бугуйвчтай тоглогчдыг хожих бүрэн боломжтой.

Ширээний ард сууж тоглосон тоглолтоороо Фил Хел мут, Фил Айви хоёр л хамгийн шилдэг тоглогчид болох байх. Мэргэжлийн гэдгийн хувьд тэд л амжилтаараа хүртэх боломжтой. Миний хувьд ирээдүйд юу болох нь хамаагүй. 2006 онд хэдэн арван мянган хүмүүсийн дундаас покерын ертөнцийн оройд гарсан гэдгийг хэн ч надаас булаан авч чадахгүй билээ.

Чад Браунтай www.pokerstars.net-сайтад хамт тоглож болох ба тэрбээр ядуурлыг бууруулах www.nolimitnofit.org санг дэмждэг ажээ.



Фил Айви

Дэлхийн өндөр зэрэглэлийн тоглогчдоос хамгийн дээд амжилттай бас зугаатай тоглогчдын нэг нь Даниел Нигрэну юм. Канадад төрсөн тэрбээр нөхөрсөг, хөгжилтэй, ам нь хуурай байдаггүйгээс гадна гайхалтай мэдрэмж, бусдыг гайхируулсан амжилтууд нь түүнийг бүх үеийн тоглогчдоос хамгийн хүндтэй тоглогчдын нэг болгосон билээ.

Покерын дэлхийн цуврал тэмцээний дөрвөн бугуйвчтай, покерын дэлхийн аялан тоглолтуудын бүх үеийн "мөнгөний" тэргүүлэгч гэхэд тэрбээр дөнгөж 35 нас шүргэж байгаа хүн.

Өрсөлдөгчөө "унишж" чаддаг нууцнаг арга нь түүнийг бусдаас ялгаруулдаг. Даниел 2006 оны хамгийн дур татам покер тоглогчоор шалгарч байв. Одоо тэрбээр Лас Вегаст

амьдардаг покер тоглогч гэдгээрээ олонд танигдсан. Зурагтаар байнга шахуу гарна. Тухайлбал ESPN, Үдшийн покер, Харанхуйн покер, Өндөр бооцоот покер мөн EPT, APPT-д тайлбарлагч гээд зурагтын олон нэвтрүүлэгт оролцдог.

Даниел pokerstars.net -д тоглодог.

Покер тоглон амьдралаа залгуулдаг үеэ яг тодорхой хэлэхэд хэцүү боловч эргээд харж байхад хүүхэд насны зарим тод дурсамжууд энэ зам руу хөтлөхөд тусалсан байдаг юм. Таван настай байхдаа би гэр бүлийнхэнтэйгээ хамт худалдааны төвд явж байхдаа хүмүүсийг их анхааралтай харж эхэлснээ хамгийн сайн санадаг. Ер нь бол хүүхэд бүр л хүмүүсийг гайхшран хардаг. Харин миний хувьд бүр ондоо байсан. Дөнгөж таван настай байсан ч хүмүүсийг таньж мэдэхийг ихэд хүсдэг байлаа. Тэр үеэс, тэр өдрөөс л би хүмүүсийг нэвт харагч болсон юм.

Тэр үед нэгэн хосууд хоол идэж байлаа. Залуу нь мөнгөтэй, бас хөөрхөн бүсгүй дагуулсан байв. Тэр залуу бүсгүйгээ хайрлаж, халамжилж байгаа нь илт мэдэгдэнэ, байсхийгээд түүнийгээ нална, гарыг нь атгана, тэрбээр түүнд маш хайртай нь илэрхий байлаа. Бүсгүйн хувьд харин огт өөр, залуудаа ямар ч хайргүй төдийгүй залууг халамжлахын хэрээр харцаа бууруулан хөндийрч, залхсан янзтай байв. Хэсэг хугацааны дараа хэдэн найз нь ирж, тэдэнтэй нийлэхэд тэр бүсгүйн нүд сэргээд ирэх нь тэр. Бүсгүй өөртэй нь зэрэгцэн хамт суусан нэгэн залуу руу хөлөө чиглүүлэв.

Таван настай байхдаа би "тэр бүсгүй эхний залууг мөнгөтэй болохоор нь хамт явж байгаа юм байна, гэвч түүнд дургүй, харин сүүлд ирсэн залууд сайн юм байна" гэж бодсоноо санадаг юм.

Одоо бол тэр байдлыг уншихад маш амархан, харин таван настай хүүхдэд бол үнэхээр хэцүү. Тэр үеэс хойш хаа яваа газраа хүмүүсийг харж эхэлсэн төдийгүй өөрийгөө зогсоож чадахгүй бүр үүндээ орчихсон явлаа. Яагаад ийм болсон тухайгаа их боддог. Энэ чанар маань покер тоглоход их туршлага болсон. Покер тоглож байхдаа ч ингэнэ. Миний зорилго бол өрсөлдөгчийнхөө толгой дотор юу болж байгааг мэдэх явдал юм.

Би Торонтод ердийн л европ маягийн гэр бүлд өссөн, аав цахилгаанчин, ээж румын гаралтай, гэртээ хүүхдүүдээ асардаг нэгэн байлаа. Ахаасаа би таван насаар дүү, бид хоёр бүх зүйлд эсрэг тэсрэг ханддаг байсан. Тэр өндөр, хүчтэй, бүхнийг засч чаддаг, харин би байнга тусламж эрнэ.

Хүмүүсийг ажихаас гадна миний бас нэг сонирхол тоо байв. Бусад хүүхдүүд шиг компьютер тоглоом нэг их тоглодоггүй, харин бэйсбол тоглодог байв. Тэр үед өнөөдрийнх шиг статистик мэдээллийг тэр бүр гаргадаггүй байсан. Би тэр бүх үзүүлэлтийг өөртөө гаргаж тоонуудыг санадаг байв. Хэрэв тухайн тоглогч арван нэгээс дөрөв бол түүний цохих дундаж нь 364 гээд л тогтоочихно, мөн шидэх, цохих, өөр юу байж болох бүгдийг л ой тойндоо тогтооно. Өрөөгөөр дүүрэн тоотой цааснуудыг ээж хараад, энэ их цаасаар юугаа хийдэг юм бэ хэмээн гайхдаг байлаа.

Видео тоглоомноос гадна мэргэжлийн бөхийн жижиг дэвжээ байгуулж, түүнд оролцох

"Аварга хүн" Рэнди Саваж, Халк Хоган, Рики Стиймбоат, "Могой" Жайк, англи Бульдог гээд 64 бөхөөс бүрдсэн мини тэмцээн зохиож, зоос шидэн хэн хожсоныг тодруулаад бүгдийг бүртгэн, аварга тодортол бүртгэлээ хөтөлдөг байлаа.

• • •

Миний анхны покер тоглож амтанд нь орсон тоглолт бол снукерийн тэмцээний дараа найзындаа уригдаж тоглосон тэр өдөр байсан юм. Тэнд 10 доллар, зургаан шил шар айрагтай очсон.

• • •

Ямар бөх барилдаж байгааг нэг их анхаарал тавьдаггүй, харин үүнийхээ оронд оноолтоор тохируулсан тэмцээн зохиож, түүний үр дүнг харах сонирхолтой байв. Ингэхдээ би өөрийн онооны систем зохиож, тэмцээний үнэлгээг тогтоон явуулдаг байлаа. Дэвтэр дүүрэн тамирчдын үзүүлэлт, оноолт, оны тоглогч, шилдэг нь гээд байж болох бүхий л жагсаалтыг гарган дүгнэдэг байсан юм.

Дунд ангид орсныхоо дараа снукер билльярд их тоглож, бүр тэмцээнд хүртэл оролцох нь надад их сонирхолтой санагдсан. Мягмар гараг бүр зохиогддог тэмцээнд би тогтмол оролцож, хамгийн шилдэг тоглогч нь байгаагүй ч хамгийн хүчтэй өрсөлдөгч нь байлаа. Мөн даваа гарагт өөр газарт болдог тэмцээнд бас оролцоно, лхагва гарагт бүр өөр хотод очиж тэмцээнд оролцох дуртай байлаа.

Миний хүмүүс, тоо, тэмцэлдэх дуртай байдал гурав маань покер тоглох гол түлхүүр болж өгсөн дөө. Хүүхэд байхдаа би покер тоглож үзээгүй. Миний анхны покер тоглож амтанд нь орсон тоглолт бол тэмцээний дараа найзындаа уригдаж тоглосон тэр өдөр байсан. Тэнд 10 доллар, зургаан шил шар айрагтай очсон. Ноён ба бусад, Хатанг дагах, Дунд нь, 7/27 зэрэг тоглоомыг тэнд тоглож сурав. Хуулиар согтууруулах ундаа хэрэглэх насандаа хүрээгүй байсан ч харин үүнийг тоох хүн тэнд нэг ч байгаагүй юм. Гэхдээ шар айраг уух нь надад тийм ч их сонирхолтой байгаагүй, учир нь би гэртээ хааяахан оройн хоолон дээр, эсвэл аавтайгаа усан сангийн хажууд байхдаа ганц нэгийг уудаг байлаа.

Мөнгөө алдахад тийм ч урт хугацаа шаардагдсангүй. Тэгээд тэр хавиар сэлгүүцэж, юу хийж байгаагаа ойлголгүй нэг хэсэг эргэлдэв.

Түүний дараа покер тоглож эхлэв. Миний өрсөлдөх чанар үүнд их нөлөөлснийг мэдэж ядах юмгүй байв. Жон Сэто гэх ази хүүхэд бүхэл шөнөжингөө дөрвөөс таван хүнтэй тоглож, тоглолт бүртээ хождог байлаа. Ингээд би өөрөө өөрөөсөө "чи тоглоогүй байж яаж хожих юм бэ?" гэж асуув. Жоныг ажиглаж байхад, түүнд хэзээ сайн мод ирнэ, тэр үед л тоглодог, зөвхөн сайн модтой үедээ л бол орно, түүний тэр байдлыг бусад тоглогчид ер анзаарахгүй, өөрсдийнхөө л асуудалд орооцолдон түүнээсээ гарч чадахгүй байгааг олж харав. Уг нь Жон санд орж ирвэл тэд уул руу зугтах ёстой байсан юм.

Сэтогоос би маш их сургамж авсан, хүлээцтэй байж, хамгийн сайн хөзрийг хүлээдэг болсхэн. Цөөхөн хүн тоглох үед улам сайжирсаар байлаа. Нэгэн орой бүгдийг гайхшруулсан юм болов.

Тарган, үнэртэн цацсан, элдэв үнэт эдлэл зүүсэн, урт үст итали найз Бэнни ирж тоглоод, тоглоомыг бүхэлд нь гартаа авч билээ. Тэрбээр үргэлж том тавьж, байнга өсгөж, хүмүүсийг хүчлэн түлхэж тоглосноор 600 ам.доллар хожоод явсан юм. Ийм их мөнгө хожсон тоглоомыг анх удаагаа тэгэхэд харж билээ. Бэнни галзуу юм шиг дайчин тоглоно, эсрэг талд Сэто хад чулуу шиг зогсоно. Энэ хоёр туйлыг ихэд ажигласан даа.

Миний хувьд покерт нэлээд авгаж эхлэв. Сургууль дээрээ 11 цаг гэж очно, тэр үед цайны цаг болно, надад хөзөр, покер, хасаа байнга байна, тэгээд бид кафед орж покер тоглодог байлаа.

Сэто болон Бэннигийн тоглолтыг харж суухдаа би өөрийн стратегийг боловсруулсан юм. Би Сэто шиг сайн хөзөр ирэхэд тоглоно, ингэхдээ харин Бэнни шиг байнга өсгөж тоглоно. Үүнийг бодож олоход сар гаруйн хугацаа зарцуулав. Удалгүй тэр залуусыг хожиж эхэлсэн. Тэр үед би арван долоотой, харин тэд хорь аль хэдийнэ гараад гуч дөхөж байв.

Миний амьдрал покероор амьсгалж эхлэв. Сургууль дээрээ арван нэгэн цаг гээд очно, тэр үед цайны цаг болно, надад хөзөр, покер, хасаа байнга байна, тэгээд бид кафед орж покер тоглоцгооно. Цайны цаг дууссаны дараа үргэлжлүүлэн хоосон ангид орон тоглоно. Багш нар ч нэг их асуудал болгоод, хичээлдээ суухыг шаардахгүй.

Удалгүй сургуулиасаа хөөгдөв. Нэг хүүхэд надад төлөх өрөө ээжийнхээ чекнээс хулгайлж өгснийг мэдэлгүй түүнийг нь би бэлэн мөнгө болгосноос энэ хэрэг үүдэв. Тэрбээр надад 300 долларын өртэй байсан юм. Энэ нь надад тийм ч шударга санагдаагүй. Гэвч би үүнд нэг их санаа зовоогүй, харин ч нэлээд чөлөөт цагтай болж, покерт илүү татагдаж, энэ чиглэлийн ном судлан, маш нухацтай оролдож эхэлсэн дээ.

Гэрийн покерын сургуулиа төгссөний дараа покер тоглодог хувийн клубүүдэд тоглож эхлэв. Тэнд Ховард Голдфарбтай танилцсан юм. Тэрбээр Лас Вегаст болсон Покерын дэлхийн цуврал тэмцээнд Дан Харрингтоны дараа хоёрт орсон нь бидний хувьд том од байлаа. Түүний Лас Вегас явж тэмцээнд оролцсон нь надад их сайхан санагдаж, би ч бас тэнд очихыг хүсч, тун удахгүй очих ёстой гэж дотроо бодов.

"Торонтстийн гүүр", "Голын өрөө", "Үзэмний өрөө" зэрэг хувийн клубүүдэд очиж тоглодог байлаа. Би хамгийн залуу нь байсан учир тэнд намайг "хүүхэд" хэмээн хочлон дуудна. Ингэж хууль бус нууц газруудад очиж тоглоход надад ердөө аюултай санагдаагүй. Хоёр ч удаа дээрэмдүүлж байснаас өөр сүйдтэй юм болоогүй. Нэгэн удаа "Гүүр" клубт тоглож байхад бүлэг залуус нүүр амаа далдлан орж ирээд "Бүгд доошоо, халаасан дахь бүх мөнгөө гарга" хэмээн хашгирав. Ер нь би клубт мөнгөтэй очдоггүй, үргэлж данс хөтлөн бичүүлж, долоо хоногийн сүүлээр тооцоогоо хийж, хожсоноо авч алдсанаа өгдөг байлаа. Доошоо харан хэвгэж байхдаа надад мөнгө байхгүй учраас тэдгээр дээрэмчид ямар миний дансыг авах биш гэж бодоод, хажууд байсан Ник хэмээх залуугийн урд дахь 5000-ын хасаанаас хэсгийг авч болох уу хэмээн дохиход тэр зөвшөөрч, би 1000-ын хасаа авч мөнгөтэй мэт харагдахаар болов. Тэд арван минутын дотор авах юмаа аваад гарч, тун удалгүй бид үргэлжлүүлэн тоглож эхэлсэн бөгөөд маргааш орой нь ч гэсэн тоглов.

Торонтогийн Чимо буудалд зөвшөөрөгдсөн хандивын тоглолт болж түүнд би оролцов. Тэнд 60 ширээ байснаас 10-20 доллар, 5-10 долларын ширээн дээр хязгаартай Холдем тоглоцгоов.

Тэнд байсан ихэнх хүмүүс юу хийж байгаагаа бараг мэдэхгүй шахуу байсан учир тэднийг би хоосолж өгөв. Эхэндээ тэд намайг "Ха ха, чи харалгүйгээр яаж түлхэж байнаа" хэмээн шоолж байсан ч тоглоом дуусахад би ганцхан инээмсэглээд 1000 доллартай гарсан юм. Тэр үед Дэтройтоос ирсэн хэсэг хүнд гарууд миний тухай сонссон байлаа.

•••

"Торонтогийн Гуур", "Голын өрөө", "Үзэмний өрөө" зэрэг хувийн клубүүдэд очдог тоглогчдын хамгийн залуу нь би байсан учраас тэнд намайг "хүүхэд" хэмээн хочлон дууддаг байв.

•••

Хүмүүс заримдаа покер тоглож байгаад хууртагддаг, би ч гэсэн нэг удаа хууртагдсан. Дэтройтын хүмүүс дунд Дэтройт Дон, Блаки Блэкбун, Тэкс хэмээх хүмүүс байсан. Тэд намайг тоглохыг урьж, сангийн хязгаарлалттай Холдем тоглож, 13 мянган доллар алдав. Өмнөхөөсөө илүү том тоглосон энэ тоглоомд өрсөлдөх чадварынхаа хэрээр тоглосон хэдий ч өнхөрчихөв. Зовж байж олсон мөнгөө нэг орой л бүгдийг нь алдсандаа их харамссан. Гэхдээ голдуу хууртагдаж алдсан даа. Энэ нь надад том сургамж болж, үүнээс хойш дахин хувийн тоглоомд оролцохоо болив.

Эхэндээ арван хэдэн настай байхад ээж минь румын аялгаар "наад покероо март, хичээлээ хий" гэж хэлдэг байсан ч би покерт хэр гүнзгий орсноо хэлж, судалж байгаа номоо хүртэл үзүүлэхэд тэрээр арай жаахан тайвширч байлаа. Сүүлдээ тэмцээнд амжилттай оролцоод ирсний дараа ээж минь надаар бахархах болов. Аав маань намайг Лас Вегаст тоглож эхлэхээс өмнө нас барсан юм .

Хорин нэгэн нас хүрч байхдаа Лас Вегаст л байхыг үнэхээр их хүсч, 1996 оны Покерын дэлхийн цуврал тэмцээний хамгийн залуу аварга болохоор санаа шулуудав. Хамгийн эхний хэцүү асуудал нь бол надад тэр үед 10 мянган доллар байгаагүй. Ингээд супер сателайт тоглож эхлэв. Арван нэгэн хүн үлдэхээс арван гурван тоглогч үлдсэн байлаа. Тэдэн дундаас би бас боломжийнх нь байсан юм. Нэг тоглогч хоёр боолтой бүгдийг түлхэхэд, би бас хоёр тамгатай бүгдийг түлхэв, өөр нэгэн тоглогч тамга ноёнттой бас бүгдийг түлхэв. Тэр дунд би бүжиглэж эхэлж байтал хамгийн эхний хөзөр боол эргэв. Эндээс хүнд байдалд орж, Покерын дэлхийн цувралд орно гэдэг үлгэр болсон доо. Тэр жил Хак Сийд аваргалав. Тэмцээнийг би харж чадаагүй, учир нь би тэр дунд байх ёстой байлаа. Гэхдээ үзэгчдийн хувьд бус. 10-25 долларын сангийн хязгаартай Холдем тэмцээнд 13 мянган доллар нэг орой алдсандаа ихэд харамссан.

1997 онд Покерын дэлхийн цуврал тэмцээнд оролцохоор очсон боловч урьдчилсан тоглолтуудад амжилт олж чадалгүй мултарсан юм. Тэмцээнд оролгүй 20-40 долларын ширээн дээр ихэнх цагийг өнгөрөөдөг байсан ч үргэлж алдана. Тэгээд буцаж Торонтодоо сүүлээ хавчин очно, дахин буцаж ирнэ, ингэсээр байгаад сүүлдээ учрыг нь олсны үндсэн дээр Лас Вегасын тоглолтуудад голдуу ялдаг болов. Хэд хэдэн тэмцээнд түрүүлсний дараа Фоксвүүдийн тоглогчоор шалгарч, тэр үедээ урьд өмнө хэзээ ч хожиж байгаагүй их мөнгө буюу 60 мянган доллар хожив.

Тэр мөнгө их удаан хадгалагдаагүй. Покерын Рио Карнавал тэмцээнд 75-150 долларын хязгаартай Холдем тэмцээнд оролцон байдгаа алдав. Их хэмжээгээр муу зээл тавьсан учир 1998 оны Покерын дэлхийн цуврал тэмцээнд хөнгөхөн орох ёстой байсан ч хүнд байдалд орж эхэлсэн юм. Гол гурван тэмцээнд түрүүлсэн ч буруу хүмүүстэй тоглож, мөнгөө удирдах чадвар муу байснаас нэлээдийг алдав.

Энэ үеэс эхлэн тэндхийн хүмүүсийг мэддэг болж эхлэв. Дилер хийж байгаад саяхан тоглогч болсон Майк Матусов гэдэг нөхөрсөг эр дээр очиж 200 долларын худалдан авалттай 2000 долларын дундын сангийн хязгаартай тоглоомд тоглов. Тэндээс Майк, Тод Брансон бид гурав үлдсэн юм. Надад 2800 доллар байсан, дээрээс нь бага зэрэг мөнгө нэмэхэд л тэмцээнд оролцоход хангалттай байв. Тэгээд Тодын ноён хатанг миний ноён боол дийлснээр Тод надад 500-гаа өгч "За, энэ маргаашийн тэмцээнд чиний хэсэг болсон шүү" гэв. Тухайн үед надад тэмцээнд оролцох бодол байхгүй байсан ч огт танихгүй хүн надад итгэж байхад яагаад оролцож болохгүй гэж бодсон.

Энэ бол миний анхны Покерын дэлхийн цуврал тэмцээн байлаа. Эхэндээ энэ бол зөвхөн мөнгөний асуудал гэж бодож байсан бол дараа нь өөр бас олон зүйл байдгийг мэдсэн. Тэгэхэд Крис Фэргюсон гэгчтэй нэг ширээн дээр хамт тоглож, түүнийг их сайн тоглогч байсныг сүүлд нь мэдэв. Тэмцээний төгсгөлд англи эр Доминик Бүркетэй тунаж үлдэв. Би урьд нь сангийн хязгаартай Холдем тоглож байгаагүй бөгөөд юу хийж байгаагаа ч мэдэхгүй үе их гарч байлаа. Харин өрсөлдөгч маань сайн мэдлэгтэй. Бид бараг тэнцүүхэн, би улаан тамга хатантай, өрсөлдөгч хар боол-аравтай байтал голын хөзөр хар хатан, улаан боол, хар гурав гарсан, тэгэхэд Доминик бүгдийг түлхэхэд нь би ч адил бүгдийг нь түлхсэн юм. Дараа нь хар зургаа эргэсэнд гол харлаад явчихав. Сүүлийн хөзөр хар гарвал алдах байлаа.

Тэгээд ямар хөзөр гарч ирэхийг харалгүй дээшээ харж байтал үзэгчид гараа өргөн баяр хүргэж эхлэхэд би сая л хожсоноо мэдсэн юм. Ингэж би анхны бугуйвчаа авлаа. Хамгийн чухал тэмцээн биш байсан ч гэсэн өөрөөрөө их бахархсан шүү.

Тэмцээний дараа Тод Брансоны найз охин Женнифер Хармантай хамт бааранд шар айраг шимэн ярилцаж, түүнээс хойш бид сайн найзууд болцгоов. Тэрээр сүүлийн тоглолтыг харж байсан нэлээн сайн тоглогч юм. Урьд нь Рио Карнавалд миний алдсан мөнгөнийн нэлээн хэсгийг ч тэр авсан байлаа.

Энэ үеэс эхлэн тэндхийн хүмүүсийг мэддэг болж эхэлсэн дээ. Дилер хийж байгаад саяхан тоглогч болсон Майк Матусов гэдэг нөхөрсөг эр дээр очив...

Энэ үеэс покерын ертөнцөд би танигдаж эхэлсэн юм. Тэгээд тэр хавиар тоглохоор сул ширээ хүлээн сууж байтал хажууханд Ховард Ледерер. Хак Сийд нар дараачийн тэмцээний тоглогчдын нэрсийн жагсаалтыг гаргаж байснаа Хак над руу харж "Энэ жаалыг авбал яасан юм бэ" гэхэд Ховард намайг хараад гайхснаа "Энэ чинь хэн бэ?" гэв.

"Энэ хүүхэд саяын 2000 долларын хязгаартай Холд'емд түрүүлсэн, дөнгөж 23-тай гэсэн, дажгүй байж магад" гэхэд би өөрийнхөө чихэнд итгээгүй юм. Дэлхийн аварга Хак Сийд намайг дажгүй гэсэнд дотроо "би хийж чадлаа" хэмээн бодов. Гэвч би тэр тэмцээнд сайн тоглож чадаагүй, тэд надаас туршлагаар хамаагүй илүү байлаа. Майк Мак Жий миний хамаг

мөнгийг эхний өдөр хамж авав, газарт тамга тамга зургаа, надад хоёр найм байсан мөртлөө л би алдсан.

Тэр үеэс Лас Вегаст байнга тоглож эхэлсэн ч миний хувьд талх, цөцгийн тос болсон хязгаартай Холдемийг нэг их тоглохоо болив. Харин түүний оронд аялан тоглолтууд бас мөнгөний тоглолтод оролцох болов. Гол төлөв 200-400 доллар, 400-800 долларын хязгаартай тоглоом голчлон тоглоно. Покерын тэсрэлт хараахан гараагүй байсан болохоор тэмцээнүүд хүндхэн болдог, очиход л ихэвчлэн мэргэжлийнхэн сууж байдаг байлаа. Үе үе хүнд том алдагдалд ордог ч эргэж олж чадна гэсэн найдвар надад байнга байдаг байв.

2000 онд олон тэмцээнд аялан тоглоод эцэстээ тэдгээрээс үнэндээ залхаж эхэлсэн юм. Түүнээс хойш нэг их аялахаа больж Лас Вегаст голдуу тоглох болов. Тэр жил миний хувьд хамгийн муужил байлаа. Голдуу л согтуу тоглодог байлаа. 1999 оны 12 дугаар сард Америкийн Покерын аварга шалгаруулах тэмцээнд найм болон түүнээс дээш тоглоомд Фил Хэлмут, Жон Хенниган нартай ана мана тоглож түрүүлэв. Тэнд мөнгөтэй болсноос хойш мөнгөний хойноос тэгтлээ улайран гүйхээ ч болив.

Беллажио руу очиж тоглохдоо голдуу л 20-30 мянгыг алддаг байсан ч түүндээ нэг их санаа зовдоггүй байлаа. Удалгүй мөнгө дуусч, 2001 онд Тэд Форест дээр очиж, мөнгөний тэмцээнд даагаач гэж гуйв. Хүний мөнгөөр тоглож байсан болохоор хөнгөн хандалгүй нэлээд хариуцлагатай тоглов. Тэд надад Лос Анжелес явахад 2000 доллар зээлсэн юм. Сарын сүүлчээр 60 мянган доллартай ирж билээ. Тэгээд буцаж Беллажиод тоглон 400-800 долларын тоглоомонд тоглож, Тэдийн мөнгийг ч эргүүлж өгч, хүний мөнгөөр ер тоглохоо болив. Цааш дараагийн түвшинд шилжиж, 2003 оноос 4000-8000 долларын тоглоом тоглон хождог болов. Гэхдээ л нэг их сайн байгаагүй болохоор 2000-4000 долларын тоглоомыг голчлон тоглосон доо.

2003 оны сүүлээр бас л өөрийн тоглолтын системээ алдаж тоглосноос дампуурлын ирмэг дээр ирэв. Залуу байсан болохоор ямар ч анхааралгүй, тэнэг байлаа. Тэгээд зорилго маань зөвхөн их мөнгөтэй байхад биш гэдгийг ойлгож, өөрийн зорилтуудыг хамгийн чухлаас эхлэн эрэмбэлж эхлэв. Үүнээс хойш хамаагүй тоглохоо болив.

Цагийн байдал эерэгээр эргэж, 2004 оноос гол гол тэмцээнд түрүүлж эхэлсэн нь дахин давтагдахааргүй амжилт байлаа. Гурав дахь удаагийн Покерын дэлхийн цуврал тэмцээний бугуйвчаа авсаны дараа 10 мянган долларын оролттой Сэндс-т түрүүлэв. Миний оролцсон тэмцээнүүдээс хамгийн хүнд нь тэр байв. Оны сүүлээр Покерын дэлхийн аялан тоглолтын Боргатад болсон 10 мянга, дараа нь Беллажиод болсон 15 мянган долларын тэмцээнд түрүүлснээр бүх хугацааны туршид Покерын дэлхийн аялан тоглолтын мөнгөний лидер, оны тоглогч, мөн "Card Player's" -ийн оны тоглогчоор тодров.

Миний хувьд 2004 он хамгийн амжилттай жил байлаа. Тэр үе шигээ дотоод төвлөрөлтэй, анхааралтай тоглохыг түүнээс хойш хичээдэг болов. Байдал өнөөдөр улам их чангарч, маш олон залуу сайн тоглогчид гарч ирж байгаа ч тэд намайг үзээд алдахаас зогсоож чадахгүй юм.

Хэрхэн хамгийн шилдэг тоглогч болох вэ? гэх асуултад хариулахад өнөөдөр хэцүү болсон байна. Намайг тоглож эхэлж байх үеийг өнөөдрийнхтэй харьцуулахын аргагүй. Тэр үед

интернетээр сургалтын сайтад бүртгүүлсний дараа онлайнаар дадлага хийж тоглож болдог байсан. Харин өнөөдөр өөрт хэрэгтэй мэдээллээ олж авчихаад ашиглаж чадахгүй бол түүн шиг тэнэг зүйл үгүй болжээ.

Би тэмцээн болон мөнгөний тоглоомд хоёуланд нь амжилттай тоглосон гэдгээрээ дурсагдахыг хүсдэг. Мөн хувийн сонирхлоосоо илүү бүхий л хүсэл мөрөөдлөө покерт зориулсан гэдгээрээ дурсагдахыг хүсч байна. Бас покерын ширээн дээр тоглогчдоос хамгийн хөгжилтэй залуу гэдгээрээ олны сэтгэлд үлдэхийг хүсч байна.

Даниел Нигрэануг pokerstars.net сайтаас олж болох бөгөөд тэрбээр Лили Клэйрийн тархины гэмтэлтэй хүмүүст туслах санг санхүүгийн хувьд дэмждэг.



Фил Айви

Фил Айви Покерын дэлхийн цуврал тэмцээнд гучаас илүү удаа түрүүлсэн билээ. Тэрбээр гуч гаруйхан настай гэхэд гайхамшигтай тоглогч юм. Фил Хэлмут, Амарило Слим нарыг 23 настайдаа хожиж Покерын дэлхийн цуврал тэмцээнд анхудаа түрүүлжээ. Хоёр жилийн дараа буюу 2002 онд Покерын дэлхийн цувралын гурван удаагийн тэмцээнд түрүүлж (нэг жилийн дотор гурван бугуйвч авч Тэд Форест, Фил Хэлмут нартай тэнцсэн), Беллажиогийн тэмцээнд хоёр удаа, Покерын дэлхийн нээлттэй тэмцээнд нэг удаа, "Коммерс" тэмцээнд хоёр удаа түрүүлсэн.

2005 онд "Монте Карло саятан" тэмцээнээс сая доллар, маргаааш нь нэмж 600 мянган долларыг "FullTiltPoker.Net" Монте Карлогийн олон улсын шууд тэмцээнээс хожиж байсан юм.

2006 онд "All In" болон "Bluff" сэтгүүлүүдийн "Оны тоглогч"-оор шалгарч, 2008 оны Покерын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, Лос Анжелес Покер Классик-т түрүүлсэн амжилтын эзэн юм. Энэ бүхнээрээ Фил Покерын дэлхийн аваргын тэмцээний амжилтуудыг найман удаа эвдсэн шилдэг тоглогч төдийгүй бүх үеийн туршид хамгийн их мөнгө хожсон тоглогчоор тодорсон юм. Одоогоор гэр бүлтэйгээ Лас Вегас амьдарч байна.

Би 1976 онд Калифорнийн Риверсайдад төрсөн билээ. Намайг гурван сартай байхад манай гэр бүлийхэн Нью Жерси, Розелл руу нүүсэн юм. Бид их олуулаа өссөн, миний эргэн тойронд үргэлж л бөөн хүмүүс байдаг байв. Байрандаа ах эгч, хамаатнууд гээд 14, 15-уулаа бужигналдан амьдарч, би эмээгийнхээ тус дэмийг их авдаг байлаа.

•••

Намайг найман настай байхад өвөө минь анх покертой танилцуулж байв. Тэрбээр ширээ, хөзөр гаргаж ирээд, таван хөзрийн покер тоглоомыг тэвчээртэйгээр заасан юм.

•••

Ээж даатгалын, аав барилгын компанид ажиллана. Аав ажилтай үедээ зургаан сараар яваад өгдөг байсан. Манай гэр бүлийнхэн маш их тоглоом тоглоно. Монополь, Парчийс гээд олон тоглоом тоглоцгооно. Бас сагсан бөмбөг их тоглодог байлаа. Охин дүү маань найман насны зөрөөтэй ч сүүлдээ бид хоёр их ойр дотно найзууд болсон юм.

Намайг найман настай байхад өвөө минь анх покертой танилцуулж байлаа. Тэрбээр ширээ, хөзөр гаргаж ирээд таван хөзрийн покер тоглоомыг тэвчээртэйгээр заасан юм. Бид мөнгө цуглуулдаг гахайнаас нэгтийн мөнгөнүүдийг гаргаж тоглоно. Тэр надад яаж бооцоо тавих талаар зааж өгсөн. Түүнд би бүрэн татагдсан байсан.

Шөнө болсон хойно би өвөө дээрээ очоод "хоёулаа дахин тоглох уу?" гэхэд тэрбээр хэзээд тоглоход бэлэн байдаг. Өвөө маань үргэлж л "Чи ахиад л хожигдмоор байна уу?" гэнэ. Түүнийг хэзээ ч "хожиж" байгаагүй ч өвөө намайг голдуу зальддаг байсныг сүүлд мэдсэн юм. Учир нь тэр надад мөрийтэй тоглоомын нарийн учрыг ойлгуулах гэж оролдож байсантай холбоотой. Гэхдээ тэр покерыг зөвхөн зугаа цэнгээнээс цааш хэтрүүлэхгүй байхыг хүсч байлаа. Ээж маань хүртэл покер тоглож амьдралаа залгуулна гэдэгт дургүй байсан. Хэдийгээр дургүй байсан ч сүүлд намайг мэргэжлийн покерчин болоход тэрээр ихэд дэмжсэн дээ. Өвөө бас дургүйцсэн ч эцэстээ бас дэмжив. Учир нь покер аль хэдийнэ миний хүсэл мөрөөдөл болчихсон байлаа. Өвөө маань харин "За яахав, би түүнийг зогсоож чадахгүй нь. Яагаад гэвэл тэр маш их хүсч байна" гэж хэлэх байсан биз.

Би хар багаасаа л бүх төрлийн өрсөлдөөнтэй сорилтуудад дурлаж өссөн юм. Хөзөр, спорт, видео тоглоом гээд алинд нь ч ялгаагүй, бүгдэд нь өрсөлдөнө. Гадаа ил талбайд тоглодог тоглоомд ч дуртай байлаа. Тухайлбал, цагираг шидэх, гэхдээ тэдгээрт тэгтлээ их гүнзгий татагдаагүй юм. Учир нь тэр бүгд цаг хугацаа их шаарддаг байв. Би аль эртнээс ямар хүн болохоо мэддэг болов. Дунд сургуульд байхад найзууд, гэр бүлийнхэн, багш нар ямар мэргэжилтэй болох талаар асуухад "би мэргэжлийн покерчин болно" гэдэг байлаа. Энэ нь хүмүүст янз бүрийн сэтгэгдэл төрүүлдэг байсан биз ээ.

Арван зургаан насандаа аавын найзынд покер тоглохоор ирдэг хүмүүсийн дунд анх танигдсан юм. Бас надад хуурамч үнэмлэх байлаа. Түүнийг Атлантик Сити орохдоо ашигладаг байв. Ахлах сургуульд байхдаа покерт илүү дуртай болж, бүх анхаарлаа түүнд чиглүүлэх болов. Нью Жерси хавиар тоглодог хувийн тоглоомын газруудаар их очно. Надад мөрийтэй тоглох онцгой чадвар, авьяас билиг байгалиас заяасан нь илэрхий байсан юм. Би 21 нас хүрэхийг тэсэн ядан хүлээв. Тэр үед Атлантик Сити, Лас Вегас руу чөлөөтэй очих болно гэж боддог байлаа.

•••

Дунд сургуульд байхад найзууд, гэр бүлийнхэн, багш нар ямар мэргэжилтэй болох талаар асуухад "би мэргэжлийн покерчин болно" гэдэг байлаа. Энэ нь хүмүүст янз бүрийн сэтгэгдэл төрүүлдэг байсан биз ээ.

•••

Сургуулиа төгссөний дараа би маш их яарч байв. Учир нь хууль ёсоор казинод орж тоглоход дахиад гурван жил хүлээх шаардлагатай байлаа. Үнэндээ би хүлээсээр залхаж гүйцэв. Утсаар залгаж, борлуулалт хийдэг ажилд орсон ч хүмүүсийн гэр рүү утасдах нь залхуутай байлаа. Гэсэн ч энэ ажлаа сайн хийсэн шүү. Олсон ашгийнхаа тодорхой хувийг цагдаагийн байгууллагад хандивлана. Эндээс олсон мөнгөө хадгалж байгаад Атлантик Ситид очив. Тэнд өнөө хуурамч үнэмлэхээ ашиглаж Тропикана казинод оров. Миний хуурамч нэрийг "Жероми Грэхэм" гэдэг байлаа. Дилер намайг 21 нас хүрээгүй гэдгийг мэддэг байсан байх, гэхдээ намайг мөнгөтэй байсан болохоор олон зүйл асуудаггүй байв.

Сургуулиасаа гарсан байсан болохоор өглөө, өдөр, оройд бага зэргийн завсарлага авч тоглоно. Би эрч хүчтэй тоглох зарчим баримталж байлаа. Өдөрт 14-15 цаг тоглоно. Тэр хавиар байнга шахуу байдаг болохоор хүмүүс намайг амьдрах газаргүй юм болов уу гэж ихэд гайхна. Бүр надад орон "гэргүй Жероми" гэдэг хоч өгсөн нь яг таарсан нэр байлаа.

Тропиканад покер тоглохын хажуугаар Таж Махал, Шоубөат зэрэг казинод тоглодог байв. Хорин насандаа 10-20 долларын тоглоом тоглож байхдаа нэгэн мэргэжлийн тстлогчтой танилцсан юм. Тэр мөрийтэй тоглоомноос жилдээ 100 мянган доллар олдог гэж хэлсэн нь намайг гайхшралд оруулав. Тэр цааш нь яг ажил хийж байгаа юм шиг өдөрт 10 цаг, долоо хоногт таван өдөр, 10-15 жил үүнийг хийж байна гэж хэлэв. Энэ нь покерт үнэнээсээ дуртай надад яг миний явах зам шиг санагдав. Тэрхүү мэргэжлийн тоглогч миний өмнө ирээдүйн замыг минь дэлгэн өгч, би ч түүнийг дагахаар шийдсэн билээ.

Тэр үед тоглоомын тухай бүх л зүйлийг анхааралтай ажигладаг байлаа. Ирсэн хөзөр, өрсөлдөгчид, тухайн нөхцөл байдал бүрийг ямар ч жижиг зүйлийг жижиг хэмээн үлдээлгүй тунгаан боддог байв. Би покерын тоглолтын стратегийн тухай маш их боддог байсан учраас заримдаа унтаж ч чаддаггүй байлаа. Өнөөдөр надад ирсэн хөзөр болгоноороо маш сайн тоглож чадсан уу?, юу нь болоод, юу нь болсонгүй вэ?, бусад тоглогчид яг юуны төлөө тоглосон бэ?, яагаад тэд заавал тэгж тоглосон бэ? гэх зэргээр зуу зуун тэмдэглэл хийсэн дээ. Жижиг дэвтэрт бичсэн бодол, ажиглалтаа одоо болтол хадгалсаар байна. Энэ бүхний эцэст бусад тоглогчид яаж тоглосон бэ? Тэр тохиолдолд би яаж тоглох ёстой байсан бэ? гэсэн

асуулт тавигддаг байв. Тэмдэглэлүүд маань надад хэрхэн сайн тоглох, хүнд үед өөрийгөө яаж авч гарах талаар их зүйлийг ойлгуулсан юм. Тэр тэмдэглэлүүд маань сүүлд юу болох талаар надад ямар ч ойлголт байсангүй.

•••

Сургуулиасаа гарсан болохоор өглөө, өдөр, оройд бага зэргийн завсарлага авч тоглодог байсан. Би эрч хүчтэй тоглох зарчим баримталж байлаа. Өдөрт 14-15 цаг тоглоно.

•••

Гэртээ сайн тоглодог байсан ч Атлантик Ситид ирээд шуудхан хожиж эхэлсэнгүй. Эхэндээ олсноосоо ихийг алдсан. Алдсаныхаа дараа утасны борлуулалтын ажлаа очиж хийгээд дахин тоглох хангалттай мөнгө хийснийхээ дараа буцаж ирж тоглоно. Миний дотоод сэтгэлд "хэзээ нэгэн цагт мэргэжлийн тоглогч болно" гэсэн бодол байсаар байлаа. Покер, утасны борлуулалтын ажлын хооронд хоёр жил гүйв. Хэрэв хожоод л байвал буцаж очиж борлуулагчаар ажиллах ямар ч шаардлагагүй, ер нь ажил хийхгүйгээр амьдрах бүрэн боломжтой. Харин хожигдсоныхоо дараа эсрэг тоглогчдоосоо би хамаагүй илүү байсан гэж өөрийгөө хэзээ ч дөвийлгөж байсангүй. Учир нь тэд намайг бодвол туршлагатай, зарчимтай байв. Би шилдэг тоглогчдыг анхааралтай ажигладаг байлаа. Би өөрийн тоглолт болон алдаагаа эргэж үнэлэн цэгнэж, түүнээсээ суралцдаг байсан юм. Өөртөө итгэлтэй, зорилготой, хүлээцтэй байхыг эрхэмлэнэ. Энэ бүгд зөвхөн цаг хугацааны асуудал, хожлын давалгаа ирэхэд хожиж эхэлнэ гэдэгтээ би бүрэн итгэлтэй байв.

Өөрийн тоглолт болон алдаанаасаа суралцдаг гэснийг төсөөлж байна уу? Алдагдлын дараа маш хүнд байдаг ч тоглоомын тухай ихийг зааж өгдөг. Өөр нэг зүйл бол мөнгөний менежментийг зөв зохицуулах нь чухал. Би бага мөнгөтэй тоглоом руу бууж тоглохдоо хэзээ ч санаа зовж ичдэггүй, бас бардам зан огт гаргадаггүй. Хэрэв надад 30 мянган доллар байвал 15 мянгыг нь авч 75-150 долларын тоглоом тоглоно, хэрэв алдвал доошилж 30-60 долларын тоглоом 10 мянган доллар олтоо тоглоно, тэр мөнгөө олж чадвал буцаад тоглоомоо дээшлүүлнэ. Ахин алдвал ахин доошилж тоглоно.

Өнөөдрийн зарим залуу тоглогчид үүнийг ердөө анхаардаггүй, энэ нь тэдэнд урт хугацаанд хүндээр тусдаг. Тэдгээр залуус хожвол овоолтол нь хожно, алдвал хамаг мөнгөө дуустал нь тоглож бүгдийг алддаг. Тэгээд тэд ажил хийж мөнгө олохын оронд найзуудаасаа зээлдэг. Би хэзээ ч мөнгө зээлж байгаагүй. Зээлэх хүсэл байсан ч зээлээгүй, надад зээлэх хүн ч байгаагүй. Надад мөнгө хэрэгтэй болвол эргээд ажил хийдэг байсан.

Хорин настай байхдаа би хожиж эхэлсэн. Атлантик Сити руу нүүсэн нь надад амар болов. Ирж очихдоо их хугацаа зарцуулна, замд аялахдаа ядарна. Бага аялна гэдэг олон цагаар покер тоглоно гэсэн үг. Хорин нэг хүрсэн өдрөө Тропикана казинод очиж тэр өдрийн менежерт намайг Фил Айви гэдэг Жероми биш шүү гэж хэлэв. Тэр өдрийн менежер нь Кате байсан. Тэрээр "Тийм ээ, би чамайг 21 хүрээгүй гэдгийг мэднэ, чи балчир харагддаг байсан, гэхдээ чиний хуурамч үнэмлэх чинь жинхэнэ юм шиг л харагдсан, гэлээ гээд одоо би юу ч хийх билээ дээ, одоо чи хорин нэгтэй юм шиг харагдахгүй байна, гэхдээ би чамд итгэж байна" гэв. Ийнхүү "орон гэргүй Жероми" гэнэт чимээгүйхэн алга болж, мэргэжлийн покерчин Фил

Айви төрсөн түүхтэй юм.

Би Лас Вегас руу хийсэн анхны аяллаар Нью Орлеаны зочид буудлын казинод тоглов. Тэнд Майк Секстоны "Аваргын Тоглолтод" оролцов. Хэдийгээр удаан тоглож чадаагүй ч хоёр долоо хоногийн турш казиногийн гадна талыг хараагүй л байлаа. Удалгүй ойр ойрхон Лас Вегас явдаг болж, тэмцээнүүдийг даган явж, оролцдог болсон. Анх Покерын дэлхийн цуврал тэмцээний шагналыг 2000 онд 2500 долларын сангийн хязгаартай Омаха тоглож хүртэхдээ 23 настай байлаа. Тэндээс 195 мянган доллар хожиж, эхний байрт ороход Фил Хэлмут дөрөвдүгээр байрт орсон юм. Түүнтэй хамт миний хамгийн хүндэлдэг хүний нэг Амарило Слим Престоны аваргын төлөө тоглож байсан юм. Хоёр жилийн дараа буюу 2002 оны Покерын дэлхийн цуврал тэмцээнээс гурван шагнал хүртэв. Түүнээс хойш 27 нас хүрч, багын найз Лусиаттатайгаа гэрлэв. Түүхэнд тэмдэглэгдэхээр үйл явдал болсны дараа Атлантик Сити дахь гэртээ ирэхдээ 400 мянган доллартай харив. 400-800 долларын тоглоом тоглож эхэлсэн чинь тоглоом арай л таарахгүй байснаас ихэнх мөнгөө алдаж, 40-50 мянгатай л үлдсэн байлаа. Ингээд 75-150 долларын тоглоом тоглож, мөнгөө 200 мянгад хүргээд 400-800 долларын тоглоом буцаж тоглон хожиж, 600 мянган доллартай болж билээ.

Өөр нэг зүйл бол мөнгөний менжментийг зөв зохицуулах нь явдал юм. Би бага мөнгөтэй тоглоом руу бууж тоглохдоо хэзээ ч санаа зовж ичдэггүй, бас бардам зан огт гаргадаггүй.

Би өөр шилжилт хийхээр шийдэв. Лос Анжелест өндөр бооцоот покерын тоглоомын газар ажиллуулдаг Ларри Флинт гэгчтэй уулзлаа. 1500-3000 долларын хязгаартай долоон хөзрийн стад тоглоом тоглуулдаг түүнтэй уулзсанахаа дараа шинэ шатанд шилжих шийдвэр гаргав. Бас Баруун эрэг руу нүүхээр шийдлээ. Урьд нь би хэзээ ч ийм өндөр бооцоотой тоглоом тоглож байгаагүй, хамгийн дээд тал нь 600-1200 долларын бооцоот тоглоом тоглож байсан. Ойролцоогоор 600 мянган доллартай очоод эхний өдрөө л бараг бүгдийг нь алдчихав.

Ингээд еөрийн зарчмын дагуу бага бооцоотой тоглоом руу бууж тоглон, Коммерсе казинод 80-160 долларын тоглоом хэдэн сарын туршид амжилттай тоглосны эцэст 600 мянган доллартай болж дахин Ларри дээр очин 550 мянган доллар алдсан юм. Тэндээсээ ахин эргэж 80-160 долларын тоглоом тоглов. Иймэрхүү байдлаар хэсэг хугацаа өнгөрсний дараа Ларригийн тоглоомд хожиж эхэлсэн юм. Энэ нь маш том үр дүнд хүргэв.

•••

Лос Анжелест өндөр бооцоот покерын тоглоомын газар ажиллуулдаг Ларри Флинт гэгчтэй уулзлаа. 1500-3000 долларын хязгаартай долоон хөзрийн стад тоглоом тоглуулдаг түүнтэй уулзсанахаа дараа шинэ шатанд шилжих шийдвэр гаргав.

•••

Покерын дэлхийн цуврал тэмцээний гурван удаагийн бугуйвчтай Барри Грийнстэйн гэх мэтийн хүмүүстэй нэлээн ойртов. Тэр надад хожим Лас Вегасын "Их гарын тоглолт"-ыг танилцуулсан юм.

Би Барригийн амьдралын хэв маягт үнэхээр их татагдав. Түүний жишгээр амьдрахыг хүсч

байлаа. Би хэдэн жилийн туршид тэмцээн болон мөнгөний тоглоомд оролцож, өөрийн гэсэн намтартай болсон байв. Барри нэгэн удаа надад хандаж "би бол дэлхий дээрх хамгийн шилдэг тэмцээний тоглогч" гэж хэлсэн юм. Тэр ганцаараа тэмцээний тоглогчоос их гарын тоглолтод амжилттай шилжсэн тоглогч байсан юм. Тэр үед их гарын тоглолтууд Беллажиод "Боббигийн өрөө"-нд олон төрлийн тоглоомын холимог хэлбэрээр явагддаг байлаа. Холимог хэлбэр гэдэг нь хязгаартай Холд'ем, долоон хэзрийн стад бага, долоон хэзрийн стад их/бага, сангийн хязгаартай Омаха, хязгаартай Омаха найм ба түүнээс дээш гээд өөр бусад олон тоглоомыг хослуулан тоглохыг хэлдэг байлаа. Харин би болохоор зөвхөн долоон хэзрийн стад тоглодог, бусдыг нь яаж тоглодгийг мэддэггүй байсан. Эцэст нь тэдгээрийг хүчээр сурах шаардлага тулгарсан шүү.

Ларригийн тоглолт зөвхөн бямба, нямд гарагт болно. Долоо хоногийн дундуур Лас Вегас руу явж их гарын тоглолтод оролцож эхлэв. Дэлхий даяар алдаршсан шилдэг тоглогчидтой зэрэгцэн тоглох болсноор миний амьдралд нэгэн шинэ хуудас нээгдсэн билээ. Беллажиогийн "Боббигийн өрөө"-нд тоглохоор очиход "Хасаа" хочит Дэвид Рийс, "Техасын хүүхэлдэй" Дойл Брансон гээд их гарын тоглолтод гаршсан залуус гараа сунган хүлээж авсан юм. Боббигийн өрөөнд тоглож байхдаа мөнгөө алдалгүй харин ч байнга өсгөж байлаа. Долоо хоногийн сүүлээр бүр чангарч, тэднийг бүгдийг нь хождог болов. Удалгүй холимог тоглоомын учрыг олж, байнга хождог болсон чинь сүүлдээ тэнд тоглодог хүмүүс намайг харахаас дургүй нь хүрч эхэлсэн юм.

Би үнэхээр байгалиас заяагдсан авьяастай байснаар миний амжилт тодорхойлогдоно. Гэхдээ би авьяастай байсан ч зөвхөн түүнд л бүх амжилтын гавьяа оногдохгүй. Удаан хугацааны туршид өгсөж уруудаж, бас уйгагүй хөдөлмөрлөсний үр дүнд энэ амжилтууд бий болсон гэж боддог. Ширээний ард айдасгүй, өөртөө итгэлтэй байдаг гэж намайг тодорхойлсонд би сэтгэл тэнэгэр байдаг. Үнэндээ тэр нь надад үнэхээр сайнаар нөлөөлсөн. Их мөнгөөр тоглож байгаа үедээ гурваас таван offsuit тоглож байхдаа тамгатай байсан ч би дайчин тоглодог. Үүнийг өрсөлдөгчид маань мэддэг ч гэсэн тэд бүх хасаагаа түлхэхэд түүнээс нь огт айдаггүйд л хамаг нууц оршино.

Хүмүүс надаас хэр их мөнгөөр эрсдэл хийхдээ сандардаг вэ? хэмээн асуудаг, хариулт нь ямар ч мөнгөний дүн миний хөлсийг гаргадаггүй, та нар үүнийг санаж яв, би мөнгөний төлөө тоглоогүй, миний хувьд мөрийтэй тоглож байгаа бол би үүнийг хийнэ, энэ бол би өөрөө гэж хэлдэг юм. Их мөнгөөр бооцоо тавихад би огт сандардаггүй, харин түүний оронд зөв шийдвэр гаргахыг л хүсдэг. Тэгээд хэдийг ч алдсан байхдаагүй, түүнийгээ дахин олж авч чадна гэдэгтээ итгэлтэй байдаг. Үүний тулд тоглох хэмжээгээ багасгана, хэсэг хугацааны дараа эргэн ирнэ гэдгээ би үргэлж мэддэг. Би бүх л амьралынхаа туршид ийнхүү бодож санаж ирсэн дээ. Боломжтой бол хэнтэй ч мөрийцнө, түүндээ ч бэлэн байна.

Атлантик Ситид 400-800 долларын тоглоом тоглож эхлэхэд "тоглоомон хүн" Хенри Оренстэйн намайг үргэлж хождог байсан. Тэрбээр намайг зургаан сарын туршид хүнд байдалд оруулсан. Түүнд хожигдсоныхоо дараа доод түвшинд орж тоглон, хэсэг мөнгө хийгээд буцаж ирж тоглоод, дахин хожигдоно. Иймэрхүү байдлаар хэсэг хугацаа өнгөрсөн. Ингэж хожигдож байгаа маань ихэд гайхалтай санагдав. Гэхдээ би түүнд хэзээ ч бууж өгөөгүй. Дахин дахин ирсээр байлаа. Түүнийг би ялна гэдгээ мэдэж байсан.

Дэлхийн шилдэг покерчдын нэг болохын тулд мөрийтэй тоглохдоо бүх зүйлийг дарааллаар нь авч үзэх хэрэгтэй. Хэрэв үнэхээр сайн тоглогч болъё гэж хүсч байгаа бол хэтэрхий хатуу, эсвэл мөнгөндөө хэт их анхаарал тавих хэрэггүй. Хамаагүй тоглохыг хэн ч зөвлөдөггүй, учир нь хамаг мөнгөө алдаад дуусна шүү дээ. Хэт их болгоомжтой тоглоно гэдэг хамаагүй тоглохтой яг ижил, болгоомжтой тоглосноор мөнгөө арай л удаан хугацаанд алдана. Үргэлж их мөнгөөр мөрийцөж байдаг болохоор заримдаа мөнгийг санаанаасаа авч хаях хэрэгтэй, харин алдвал эргэж олж чадна гэдэгтээ итгэлтэй байх хэрэгтэй.

Би ихэнх гол гол тэмцээнүүдэд гаргасан амжилтаараа бахархдаг. Тэмцээнийг үзүүлж байгаа зурагтын нэвтрүүлгээр хүмүүс миний тухай ойлголттой болдог. Покерын дэлхийн цуврал тэмцээн болон покерын дэлхийн аялан тоглолт зэрэг томоохон тэмцээнүүдийн дараа миний очих дуртай газар бол их мөнгөөр тоглодог бэлэн мөнгөний тоглоомууд. Тэмцээнүүд бол зурагтаар гаргахад л хамгийн тохиромжтой. Хэрэв чи үнэхээр дэлхийн шилдэг покерчидтой хамт тоглохыг хүсч байвал 4000-8000 долларын Беллажиод тоглодог тоглоом мэтийн газруудыг олох хэрэгтэй.

Хүмүүс намайг "чиний ширтэх чинь ер бусын юм аа" гэдэг.

Мэдээж, тоглож байхдаа өрсөлдөгчөө ямар байдалтай байгааг харахын тулд анхаарлаа төвлөрүүлнэ. Би нарны шил зүүдэггүй. Хүмүүсийг ингэж их ажиглан харахад, тийм их эвгүй байдаг бол тэд ингэж их мөнгө дундаа тавьчихаад өөрсдийгөө нууж чадахгүйгээр тэнд суугаад хэрэггүй, тэгээд ч энэ бүгд тэдний л хариуцлагын асуудал. Ядаж л сэтгэл хөдлөлөө нууж сурах хэрэгтэй. Олон шилдэг тоглогчид нарны шил огт зүүдэггүй. Нэг удаа би Покерын дэлхийн цуврал тэмцээнд нарны шил зүүсэн чинь хөзрөө буруу харж, түүнээс хойш тэр шилээ хогийн саванд хаяж дахиж зүүгээгүй.

Би хүмүүсийн дунд нэг их ил гараад байхыг боддоггүй. Ихэнх цагаа покер тоглон өнгөрөөдөг. Покер тоглож байхад хэн нэгэн саад хийхэд тун дургүй. Миний гэр бүл, найз нөхөд гээд надад зайлшгүй чухал зүйлээс бусад өөр юу ч байсан покер тоглох цагаас минь хорооход би дургүй байдаг юм.

Миний эхнэр Лусиатта үнэхээр гайхамшигтай хүн, тэрээр надад бүх зүйл дээр тусалдаг. Би бараг үргэлж покер тоглож байдаг учир миний амжуулж чадахгүй олон ажлыг тэр гүйцэлдүүлж, намайг алдахад хажууд минь байж дэмждэг. Хэрэв эхнэр минь байгаагүй бол би ийм амжилтад хүрэхгүй байсан. Тэрээр харин надад ийм үнэтэй чухал гэдгээ өөрөө хэзээ ч бодож байгаагүй байх.


Хүмүүс заримдаа чи хүүхдээ покерын мэргэжилтэй болохыг зөвшөөрөх үү? Гэж асуудаг. Тэгэхэд нь би "үгүй" гэдэг. Ийм замаар битгий яваасай гэж боддог. Энэ бол хүнд бизнес, бид зөвхөн амжилтын түүхийг л мэднэ, энэ мэргэжлээр явж байсан олон хүн дампуурсныг би бас мэднэ. Лас Вегас покерын хувьд гайхамшигтай мэт санагдавч болгоомжтой байхгүй бол тэнд чиний амьдрал үндсээрээ өөрчлөгдөж болно. Покерыг хоббигоо болгоход сайхан, харин мэргэжлийн тоглогч болно гэдэгтусдаа асуудал. Гэвч хүмүүс нэгэнт мэргэжлийн покерчин болохоор шийдэж сонгосон бол би юу ч гэж хэлэх вэ дээ.

Хэрэв би покер тоглож эхэлбэл хэдэн цагаар тоглодог. Урт хугацаанд би хожно гэдгээ мэддэг.

Энэ бол зөвхөн цаг хугацааны асуудал. Энэ бол ажил. Хэрэв би алдвал эргэн ирж ажиллана, мэдээж үүнд мөрийцсөн ч бэлэн байна.

Түүний тухай Phillvey.com-оос мэдээлэл авч болох бөгөөд www.fulltiltpoker.net-ээр хамт тоглож болно. Эрүүл мэнд, боловсрол, хүүхдийн санд хандив өгдөг ажээ.

Цахиур хагалах залуус



Том Дван

Том "Дурр" Дван онлайн хувьсгалаас төрсөн олон тоглогчдын нэг. Дөнгөж 22 настай тэрбээр тэмцээн болон онлайнгаар амжилттай тоглон их хэмжээний мөнгө хожсон тоглогч төдийгүй хамгийн хурц одын нэгээр тодорсон юм. Хэдийгээр тэр энэ шагналыг хүртсэн ч оддын түвшинд үүнийг хүлээн зөвшөөрөөгүй билээ. Түүний хожсон мөнгө нь гайхалтай боловч 2006, 2007 оны Покерын дэлхийн цуврал тэмцээнд 21 насхүрээгүй гэдэг шалтгаанаар оролцоогүй аж. 21 нас хүрүүт 2007 оны Покерын дэлхийн аялан тоглолтын Фоксвүүдэд болсон тэмцээнд ялагчаар тодрон 325 мянган долларын шагнал хүртсэн байна.

Нью Жерсигээс ирсэн тэрбээр зургаан хүнтэй хамт онлайнгаар тоглох болон үндсэн тэмцээнд ширээний ард тоглохдоо зурагтын олон дурангын өмнө шулуухан ярьдаг. Түүний хувьд покер

амьдралын гол зорилго биш харин түүний олон сонирхлыг санхүүжүүлэх гол хэрэгсэл болдог байна.

Би Нью Жерсигийн жижигхэн хот Эдисонд төрсөн, жирийн дундаж гэр бүлээс гаралтай. Ахлах сургуульд жирийн л нэг хүүхэд байлаа. Гэхдээ сурлагадаа сайн, нэлээд хэдэн спортын төрлөөр хичээллэнэ. Коллежид орсны дараа амьдралаа зохионог эж төлөвлөж байлаа. Миний хувьд мэргэжлийн покерчин болно гэсэн бодол ер байгаагүй.

Бүр бага байхаасаа л ахлах сургуулийн сургалтын системийн дутагдлыг олж харан шүүмжилж, ихээхэн ундууцдаг байв. Тухайн сэдвийн маш бага хэсгийг багш нар заана, тэр нь ирээдүйд юунд ч хэрэг болохгүй зүйл байсан тул сүүлдээ хичээлдээ нэг их анхаарахаа болив. Гэсэн хэдий ч өөр олон сонголт байхгүй учраас сургуулиа дундаас нь орхилгүй үргэлжлүүлэн суралцав.

Арван долоон настай байхдаа би анх покер тоглож үзсэн юм. Тэр өдөр манай гэр бүлийнхэн болон миний найз гээд хэдэн хүмүүсийн хамт 5-10 долларын оролттой энгийн тоглоом тоглов. Тийм ч сүртэй тоглолт болоогүй зөвхөн зугаацах хэлбэрээр тоглосон хэдий ч бүхэл оройн туршид манай аав Томас Дван, авга ах Энтони Коделла нар надад покер тоглоомын үндсэн ойлголтуудыг зааж өгсөн юм.

Анхны таван минутыг эс тооцвол би бараг хэнээр ч заалгаагүй гэж хэлж болно. Манай гэрийнхэн анх надад покер заасан, тэд үүнийг зөвхөн цагийг зугаатай өнгөрөөхөд зориулдаг байлаа. Ингэж гэртээ сурсныхаа дараа үе үе найзуудынхаа гэрт очин 5-10 долларын тоглоом тоглож эхлэв.

Санамсаргүй байдлаар онлайн тоглоом байдгийг олж мэдэв. Тэр өдөр найзуудтайгаа кино үзэхээр төлөвлөсөн байсан ч цасан шуурганаас болоод хойшлуулав. Хийх юмаа олж ядахдаа Эмпайр Покер тоглоомын тэмцээнд оролцож өдрийг өнгөрүүлэв. Хэсэг өдрийн турш нэлээн тоглосны дараа амжилт олж болмоор санагдахаар нь 50 доллар оруулж анхны онлайн тоглолтоо хийв.

Энэ үед дөнгөж анхан шатны түвшинд байлаа. Удалгүй гайгүй мөнгө олж эхэлсэн хэдий ч бусад тоглогчдоос болж буруу шийдвэр их гаргадаг байсан. Эхэндээ бараг амархан мэт санагдсан ч сүүлдээ онлайн покерт эргэлзээ төрөх болов. Ингээд сургуулиа төгсөхдөө анхаарлаа хандуулж, сагсан бөмбөг болон найз нөхөдтэйгээ ихэнх цагийг өнгөрөөдөг болов. Тэр үед покертой ингэж зууралдана, их мөнгөөр тоглоно гэж зүүдлээ ч үгүй явсан.

•••

Бусад тоглогчдоос болж буруу шийдвэр их гаргадаг байлаа. Эхэндээ бараг амархан мэт санагдсан ч сүүлдээ онлайн покерт эргэлзээ төрж эхлэв.

•••

Сургууль төгсөх жил байсан болохоор манай гэр бүлийнхэн намайг ингэж онлайнаар тоглож байгаад дургүй байлаа. Үүний оронд ажилд орохыг зөвлөнө. Гэтэл би өдөр ирэх тусам улам

их тоглодог болов. Эхлээд 25-50 центээр тоглож байснаа удалгүй үүгээр мөнгө хийж болох юм байна гэдгийг үнэн голоосоо ойлгов. Зун гэхэд 15 мянган доллартай болж, ажил хийх хэрэггүй болсноо гэрийнхэндээ ойлгуулж, найзуудтайгаа далайн эрэг дээр байр түрээслэн амьдрах болов.

•••

Миний онлайнаар тоглодог нэр бол "Дурр". Энэ нэрийг үнэндээ 90 секундэд бодож олсон. Энэ нэр хүмүүсийн толгойд үргэлж бодогдоно, тэгээд ч энэ нэрнээс айх хүн байхгүй, ийм нэртэй хүнд мөнгөө алдах сонирхол хэнд ч байхгүй гэж бодсон. Энэ нэр бүр эхнээсээ л тохирсон нэр байсан.

•••

Коллежид орохын өмнөхзун 18 настайдаа би найзуудтайгаа Нью Жерсийн эрэг дээр тансаглаж, юу дуртайгаа, юу хүссэнээ, ямар ч санаа зовох зүйлгүйгээр авч байлаа.

Бостоны их сургуульд орсноор покер тоглох боломж маань улам нэмэгдсэн. Харин онлайн тоглолт маань сургуулийн болон амьдралын бусад асуудлаас шалтгаалан бага зэрэг багассан ч ахиад 40-50 мянган доллар хийж чадсан. Энэ үед хамт сурдаг оюутнууд маань өөрсдийн багахан хэмжээний мөнгөндөө бүхнээ тааруулах гэж хуруу хумсаа хугалж байхад, миний хувьд юу хүссэнээ л хийж явсан. Оюутны байранд байхад сонирхолтой байсан. Гадуур байнга гарч, покер маань ч улам сайжирсаар байлаа. Сурлагаас бусад амьдрал минь сайхан байсан. Гэвч амьдралын тэр хэв маяг сурлагад маань сөргөөр нөлөөлж эхлэв. Гол буруутан нь покер гэж би хэлэхгүй. Тэгээд ч хичээл таслах, даалгавраа хожимдуулах зэргээр сурлагадаа тавих анхаарал маань суларсаар байв. Харин дуртай хичээлдээ бол суудаг байсан. Сүүлдээ хичээлдээ ямар ч сонирхолгүй болж, кино үзэх, мөн өөр юу дуртайгаа л хийхийг хүсдэг болов.

Миний онлайнаар тоглодог нэр бол "Дурр", тэгээд ч энэ нэрнээс айх хүн байхгүй, ийм нэртэй хүнд мөнгөө алдах сонирхол хэнд ч байхгүй.

Их сургуулийн хоёрдугаар курсэд байхдаа миний орлого нэмэгдэж 150 мянган долларт хүрэв. Гэвч сургуулиасаа гарах сонирхолгүй байлаа. Түүнийхээ хажуугаар мөнгө хийх том боломж байгааг би олж харав. Энэ үед гэрийнхэн маань намайг сургуульдаа дургүй болсонд санаа зовж эхлэв. Тэд миний хамгийн сонирхолтой зүйл суралцах явдал хэмээн бодож байсан юм.

Гэвч мөнгө хийх асар том боломж байсаар байтал яагаад мөрийтэй тоглоомоор амьдарч болохгүй вэ гэж би бодлоо. Гэр бүлийнхэн маань ч сүүлдээ сургуульдаа сур хэмээн шахахаа больж, миний шинээр сонгосон энэ мэргэжлийг дэмжив. Тэгээд ч ойрын үед сургуулиа төгсөнө гэж бодохоо больж, эцэст нь ер хэрэггүй юм байна гэж шийдсэн. Ямар ч утгагүй зүйл үзэж, хамаг цагаа барах нь надад харамсалтай байсан. Үүний оронд харин мөнгө олох боломжийг ашиглан их мөнгө хийгээд түүгээрээ бизнес эрхлэх, эсвэл өөрийн дуртай зүйлээ санхүүжүүлэх нь надад илүү сонирхолтой байлаа.

Коллежоо хөзрөн тоглоомоор сольсон надад бусад хүмүүс шиг өндөр бооцоотой тоглоомоор

тоглох сонирхол тэгтлээ их байгаагүй. Мэдээж покер нь миний амьдралын салшгүй хэсэг хэдий ч өнгөрсөн хэдэн жил шиг амьдралын маань эн тэргүүний эгнээнд байхаа больсон юм. Долоо хоногт дунджаар 40 цаг тоглодог байлаа. 2007 оны сүүлээс 2009 оны эхэн хүртэл жил хагасын хугацаа дуусашгүй мэт санагдаж байсан. Энэ хугацаанд алдаа, оноо маань ч гэсэн тэр хэрээр нэмэгдэв.

Энэ бүхний эцэст ийм их төвлөрөлтэйгээр удаан байж чадахгүй гэдгээ мэдэрч, цаашдаа долоо хоногт ердөө 15 цаг тоглоход л болно гэж бодох болов. Покерын томоохон тэмцээнүүдэд оролцдог боловч покер бол миний амьдралын хамгийн гол зорилго биш, амьдралд покер тоглохоос илүү маш олон чухал зүйл байдгийг би туулж өнгөрүүлсэн амьдралаасаа мэдэрч байв. Би долоо хоногт 5 цаг покер тогломоор байсан ч бодит амьдрал дээр 10-15 цаг тоглодог байсан гэвэл илүү үнэнд ойртоно.

Их мөнгөөр мөрийцөн тоглодог тоглогчдыг харахаар надад ойлгомжгүй санагддаг. Покерт хожиход өрсөлдөгч их чухал гэж олон хүн боддог, миний хувьд ижил нөхцөлд хуваарилагдсан хөзрөөр хийх үйлдэл, үйл явцыг ерөнхийд нь үнэлэх үнэлэмж, тухайн үеийн ухааны хэмжээс л чухал гэж үздэг.

Бодит тоглоомд бусдыг уншдаг чадвар үнэхээр чухал, зарим тоглогчид үнэхээр гайхмаар зүйлийг тэр тусмаа дохио зангаа, үйлдэл зэргийг нарийн ажиглаж, зөв ашигладаг. Гэхдээ тэр нь тоглолтын цагийн ердөө 10-аас 15 хувьд шүү дээ. Үйл хөдлөл үнэхээр чухал зүйл, гэвч миний хувьд тийм биш. Покерт үйл хөдлөл судлах, бусдыг унших, тэд хэр мөрийцөж байна, бооцооны дүн зэргээс илүү чухал зүйл бий.

Покерт дан ганц мэдрэмжээрээ үргэлж хожно гэж байхгүй. Би тоглолтынхоо арга барилдаа математик магадлалыг их ашигладаг хүмүүстэй байнга тоглож байсан. Покер тоглогчид маш нарийн цогц асуудлуудыг үл тоомсорлон, ухаалаг биш хандвал ихэнх цагтаа алдах болно гэдгийг ойлгосон. Математик магадлал покерт зайлшгүй байх ёстой зүйл. Бас өрсөлдөгчдийн тухайн үеийн нөхцөл байдал, сэтгэл санаанаас ихээхэн хамаардаг юм.

Өндөр чадвартай олон хүн тоглож байхад ялангуяа тэд их мөнгөний бооцоотой тоглож байгаа бол хүмүүсийг уншиж шийдвэр гаргана гэдэг найдвар багатай. Покер сайн тоглодог хүмүүс тоглоомын бүх л талбарт сайн тоглогч байдаг. Тэд бүгдээрээ математикийг ойлгодог, өрсөлдөгчдийнхөө нөхцөл байдлыг зөв үнэлж чаддаг, үүн дээр өөрийн туршлага, давуу талаа ашиглан тоглоцгоодог юм.

Өөр нэг шилдэг арга бол хамгийн шилдэг хүмүүсийн тоглохыг харах явдал. Дээр дурдсан шиг онлайн тоглолтоос харж байхад олон хүн илэрхий алдаа гаргадаг, түүнийг нь сайн тогтоож аваад тухайн нөхцөл байдал давтагдахад анхаарч байх хэрэгтэй. Хүмүүсийн амжилтыг бодитоор болон онлайнаар харах нь хоёулаа хэрэгтэй. Ингэж болдгийг зөвхөн би л ганцаараа мэдсэн юм биш, өөр олон тоглогчид ийм аргаар амжилт олсон байдаг юм. Үүнд Фил Айви, Патрик Антониус зэрэг шилдэг тоглогчид хүртэл орно.

Цаг хугацааны зарцуулалт покер тоглогчдод бас л гарцаагүй байх хэрэгтэй зүйлийн нэг мөн. Покер тоглож сурахад маш их цаг хугацаа, тоолж баршгүй хувьсагч хөзрийн хослол, өрсөлдөгчийн эсрэг тоглох төрөл бүрийн чадварууд орно. Хамгийн гол нь 50 настай тоглогч

хүртэл өнөөдөр тоглоомдоо тохиргоо хийж явдгаараа покер нь бусад казингийн тоглоомноос эрс ялгаатай.

Хэдийгээр би арваад жил покер тоглож байгаа ч гэсэн нас залуу гэдэг шалтгаан хэзээ ч миний хувьд сул тал болж байгаагүй. Покерын ертөнцөд бүх л насны хүмүүс байдаг. Бас хөзөр байдгаараа л байна, түүнд өөрчлөлт гэж байхгүй, тэд наснаас хамаарч өөрчлөгдөнө гэж үгүй. Хамгийн гол нь өөрт ирсэн хөзрөөрөө яаж тоглох вэ? гэдэг нь чухал болохыг бүх тоглогчид сайн мэднэ.

Ингэж болдгийг зөвхөн би л ганцаараа мэдсэн юм биш, өөр олон тоглогчид ийм аргаар амжилт олсон байдаг юм. Үүнд Фил Айви, Патрик Антониус зэрэг шилдэг тоглогчид хүртэл орно.

Бие биенээ өдсөн яриа хамгийн залхмаар зүйлийн нэг. Сайн тоглогчид үүнийг зохицуулж хэрэглэдэг. Үүнд хэд хэдэн хүндэтгэх шалтгаан байж болно. Шилдэг тоглогчдын хувьд энэ бол гол арга биш. Ингэж ярьдаг хүмүүс бусдын толгойд орох гэж ихэнх цагаа үрдэг. Иймэрхүү арга нь зурагтын нэвтрүүлгийн үнэлгээг л өсгөхөөс цаашгүй юм. Үнэхээрийн авьяастай тоглогчид өөрийн нөхцөл байдал дундуур хэн нэгэн орж ирэхийг хориглон хааж чаддаг, тэгснээрээ тэд амжилтад хүрдэг. Ийм тоглогчид олон үзэгчтэй танхим, зурагтын дурангаас өөрсдийгөө бүрэн тусгаарлаж чаддаг.

Лас Вегасын казиногоос гадуурх ертөнцөд намайг хэн бэ? гэдгийг олон хүн мэддэггүй. Хөзөр тоглож байхдаа авсан тааруухан үнэлэмжүүд маань надад одоо болтол сонин санагддаг. Гэхдээ тэр бүхэн аажмаар багасч байгаа ч покер тоглосноороо би олонд танигдаагүй, танигдана ч гэж бодохгүй байна. Покер дахь нэр алдар бол холимог асуудал, сайн гэгдсэн тоглогчдын хувьд маш том хариуцлага нуруун дээр нь буудаг, тэд бас асар их ачааллын дор байдаг. Тэд заавал сайн, улам илүү сайн тоглох хэрэгтэй болдог гэтэл тоглоом өөрөө уналт босолттой гэдэг нь тодорхой.

Бас нэгэн сонин үзэгдэл бол өндөр бооцоот тоглоомын дараа хэдий хэмжээний мөнгө алдсаныг покер тоглогчид найз чинь хүртэл тухайн тохиолдол болоод дөнгөж өнгөрсний дараа мэдсэн байдаг нь заримдаа ичмээр санагддаг. Зарим тохиолдолд туршлагагүй тоглогчид миний эсрэг тоглож байхдаа ямар нэг хэмжээгээр айдаг, тэр нь тэдний цаашдын үйлдэлд нөлөөлдөг. Надтай урьд өмнө тоглож байгаагүй хүмүүс их мөнгөний бооцоотой тоглож байхад төдийгүй тэмцээний үед ч илэрхий их алдаа гаргадаг юм.

Бие биенээ өдсөн яриа хамгийн залхмаар зүйлийн нэг. Сайн тоглогчид үүнийг зохицуулж хэрэглэдэг. Ингэж ярьдаг хүмүүс бусдын толгойд орох ихэнх цагаа үрдэг.

Хамгийн энгийн, ойлгомжтой зүйл бол хэн ч хэзээ ч үргэлж хожоод байдаггүй. Хэнбугай ч бай өөр хэн нэгэнтэй тоглохдоо үргэлж түүнийг байнга хождоггүй. Миний ойлголтоор сайн тоглогчид гэж алдсаныхаа дараа алдсанаа хурдан нөхөж авч чаддаг хүмүүсийг хэлдэг байх гэж боддог. Харин алдсандаа харамсч түүнээсээ гарч чадахгүй байгаа бол сайн тоглогч гэж хэлэхийн аргагүй. Би "хэрхэн яаж" алдсанаа л чухалчилдаг. Хэдийг алдсанаа бодож үзээд, тэр мөнгөний дүн нь миний нийт мөнгөний мэдэгдэхүйц хэмжээтэй тэнцэж байсан ч би тэгтлээ их анхаарал тавьдаггүй.

Ойролцоогоор арваад удаа нийт мөнгөнийхөө гуравны нэгийг алдаж байлаа. Үүний хоёр удаагийнх нь 5000 доллараас бага мөнгөтэй байхад тохиолдсон юм. Тэгэхэд би өөрийгөө супер алдагч гэж байсан, харин 2007 оны дөрөвдүгээр сард гурван сая гаруй доллартай байснаа 11 дүгээр сард нь хоёр саяыг алдсантайгаа харьцуулахын аргагүй дээ. Энэ нь хорин настай хүүхдийн хувьд өөрийн чадварыг бүрэн үнэлээгүйгээс болсон хэрэг. Миний найзууд, гэр бүлийнхэн юу гэж бодсоныг асуугаад ч хэрэггүй. Тийм байдалд орсондоо би дүгнэлт хийж, бага бооцоогоор тоглодог тоглоомд маш олон тоглолтыг зэрэг хийж байсныхаа хүчинд алдсан мөнгөө эргүүлж олж авч чадсан даа. Ийм алдагдалтай нүүр тулгарсан үедээ түүнээс гарахын тулд олон долоо хоног, олон сараар тоглолт хийх хэрэгтэй байдгийг их хэмжээний мөрийтэй тоглодог бүх хүмүүс мэднэ.

Шинэ тоглогчдын хувьд тоглоомоо бүрэн ойлгохоосоо өмнө маш их илэрхий алдаанууд гаргадаг. Тийм хүмүүс хожлоо гэдэг нь тэд сайн тоглосны дүнд биш, тэд бас алдаж болох байсан. Надад ч мөн адил зөв гэж бодсон тохиолдолд алдсан, буруу гэж бодсон тохиолдолд хожиж байсан тоглолт зөндөө бий. Олон тоглогчид буруу тоглосныхоо дараа хожиж болдог. Тэд хожсоныхоо дараа хасаагаа хураан авч, хожсондоо ихэд баярладаг. Муу тоглосны дараа хожиж, мөнгө хураан авч байхдаа яаж ингэж авснаа бүрэн ойлгодог байх хэрэгтэй. Тэгж байж л энэ нь иж бүрэн покерын тоглолт болно.

Покерт маш олон дурсамжтай үе байдаг. Хамгийн их дурсамжтай нь сайн тоглодог тоглогчийг олон удаа буулгаж авах шиг гайхалтай зүйл үгүй. Мөн сайн, мууг хамтатган үзэж сурах хэрэгтэй. Зөвхөн сайн тоглогчид л алдагдлаа даруухан хүлээн зөвшөөрч чаддаг, харин шинэ тоглогчдын хувьд алдагдал хүндээр тусдаг, гэвч мөнгө олохын хэрээр алдагдал нь арай хүндрэлгүй болдог.

•••

Харин 2007 оны дөрөвдүгээр сард гурван сая гаруй доллартай байснаа 11 дүгээр сард нь хоёр саяыг алдсантайгаа харьцуулахын аргагүй дээ. Энэ нь хорин настай хүүхдийн хувьд өөрийн чадварыг бүрэн үнэлээгүйгээс болсон хэрэг.

•••

Покер тоглоход надад үргэлж тааламжтай байдаг. Хожигдож байсан ч ялгаагүй ижилхэн. Учир нь түүндээ их цаг зарж, туршлага сууж, ойлгоход гол нь оршдог. Хамгийн өрсөлдөөнтэй энэ тоглоомыг сайн тамирчин, сайн нөхөр, сайн хөзөр тоглогчийн нийлбэр цогц гэж үзэж болно. Миний хувьд покерыг ингэж тоглох ёстой гэж үздэг.

Таван жилийн өмнөх цасан шуурганаар онлайн покер тоглож эхлээгүй бол өнөөдөр би хаана байгаа бол гэж бодоход үнэхээр хэцүү. Магадгүй Бостоны их сургуулиа 2008 онд төгсчихөөд хаа нэгтээ магистрт сурч, эсвэл өөрийн бизнесийг эхлэхээр оролдож байх байсан болов уу. Миний үүсгэн байгуулсан хоёр компанийг покер маань ямар нэг хүндрэлгүй эхлүүлж өгсөнд талархаж явдаг юм. Компанийн гарааны хөрөнгө олох эсвэл хөрөнгө оруулагчийн ямар нэгэн зөвлөгөөг дагаж хийх гэж хүсч байсан зүйлээсээ өөр зүйлийг би хийх гэж оролдоогүй. Надад ийм их эрх чөлөөг олгож байдагт нь дурлаж, анх би покер тоглож эхэлсэн. Ширээн дээр гаргасан амжилт маань амьдралын бусад олон талбарт амжилт олоход минь тусалсан. Би

одоо ч ийм шийдвэр гаргасандаа баярладаг.

Покерыг миний амьдралын цорын ганц боломж гэж боддоггүй. Тэр надад өөр бусад олон боломжийг нээн харуулсан, олон чухал хүмүүстэй танилцуулсан, мөн миний ирээдүйг тодорхой болгож өгсөн. Хүүхэд насны минь маш холын мөрөөдлүүд эдүгээ бодитой болж ирсэн. Дөрвөөс таван жилийн өмнө энэ бүгд надад бараг боломжгүй зүүд мэт санагддаг байлаа.

Харин покер миний хувьд үргэлж сайнаар нөлөөлж ирсэн юм. Үүнийг огт үгүйсгэхийн аргагүй. Ширээн дээр үзүүлсэн амжилтаар минь намайг хувь хүн талаас нь дүгнэх нь учир дутагдалтай хэрэг болно. Ирээдүйн покерын ертөнцөд миний нэр дурсагдах эсэх нь надад тийм ч чухал санагддаггүй. Магадгүй миний үзүүлсэн амжилт үүнийг илэрхийлэх байх. Бугуйвч, ивээн тэтгэгч, сэтгүүлийн хавтсан дээр гарах талаар нэг их бодохыг хүсдэггүй юм шүү.

Зөвхөн тэмцээнд оролцож өндөр мөрийтэй тоглох нь миний гол зорилго биш, харин хангалттай мөнгө хийж, амьдралд тохиолдох бусад сонирхлуудаа санхүүжүүлэхэд покер надад хэрэг болно гэж би үздэг.

Мэдээж таван жилийн өмнөөс үр өгөөжөө өгч, сэтгэл ханамжтай амьдралыг надад авчирсан, тийм замыг зааж өгсөн покертоо би цаг үргэлж талархаж явах болно.



Аннетте Обрестаг

Шинээр төрөн гарч ирж буй оддын нэг. А.Обрестаг хорин нэгэн нас хүрээгүй, тоглох эрхгүй байх үедээ 2009 оны есдүгээр сард Лас Вегасын казинод слот машинаар тоглож 2,5 сая доллар хожсон байна.

Түүний покерын амжилт онлайнаар эхэлж, 2006, 2007 онд Покер Старсаас 500 мянга, Алтимэйт Бетээс 200 мянга, Фүл Тайтл Покероос 136 мянган доллар хожсон ажээ. Покерын дэлхийн цувралын Европын тэмцээнд түрүүлж, бугуйвч авсан хамгийн залуу тоглогчоор тодорсон.

Покерын дэлхийн цувралын Европын тэмцээнд олон шилдэг тоглогчдоос илт давамгайлсан гарч ирж түрүүлсэн эзэн тэрээр дайчин тоглодгоороо алдартай. Арван хэдэн настай хүүхэд байхдаа нэг удаа Жон Табатабайтай аваргын төлөө тулж, гурван долоогоор түрүүлэн

шуугиан дэгдээжээ. Дөнгөж арван есөн нас хүрснийхээ хэдхэн цагийн дараа Покерын дэлхийн цувралын Европын тэмцээнээс хоёр сая доллар бэлнээр нь авч байжээ.

Би Норвегид төрсөн. Хүүхэд нас маань бусдын л адил жирийн өнгөрсөн. Ээжтэйгээ хамт өсч, сургуульдаа явна, найзуудтайгаа нийлнэ, бусад охидын адил тэдний хийдгийг л хийнэ. Арван нэгтэйгээсээ эхлэн боулинг тоглож, түүндээ дуртай болсон. Удалгүй клубт хамрагдаж хэдэн жил тоглосон. Миний авдаг дундаж оноо 160 байсан нь үеийн охидынхаа дунд нэлээн сайнд тооцогдоно. Зурагтаар боулинг үзэх их дуртай. Нэг удаа тэмцээн үзэж суутал дэлгэцийн доогуур зурвас сурталчилгаанууд гарч эхэлсэн. Бусдын л адил тэрхүү сурталчилгаанд нэг их анхаарал тавиагүй.

•••

Хүснэгт бөглөхдөө 18 нас хүрснийг баталгаажуулсан жижиг цонхыг бөглөв. Тэгэхэд би дөнгөж 15 настай байсан юм. Гэрээний нөхцлийг хүлээн зөвшөөрч байна гэсэн цонхон дээр чагт тэмдэг тавив.

•••

Нэгэн сурталчилгаа Мультипокер онлайн покерын тухай байв. Яагаад ч юм мэдэхгүй, тэр зар миний анхаарлыг татсан. Зарласан хаягийн дагуу орж данс нээв. Тэр нь маш амархан байлаа. Хүснэгтийг бөглөхдөө 18 нас хүрснийг баталгаажуулсан жижиг цонхыг бөглөв. Тэгэхэд би дөнгөж 15 настай байсан юм. Гэрээний нөхцлийг хүлээн зөвшөөрч байна гэсэн цонхон дээр чагт тэмдэг тавьснаар миний онлайн покер тоглоом анх эхэлсэн түүхтэй.

Долоон хөзрийн стад тоглоомыг мөнгөөр тоглож эхлэв. Миний насны хүүхдүүдийн адил би компьютер тоглох дуртай, ихэнх цагаа компьютерын ард өнгөрөөнө. Би анх онлайн покер тоглож эхлэхэд ээж нэг их санаа зовоогүй. Тэрээр эхэндээ компьютерын олон тоглоомуудын нэгийг тоглож байна гэж бодсон ч сүүлдээ намайг покер тоглож байгааг мэдсэн. Би бага зэрэг мөнгө хожиж эхлэв. Удалгүй нэлээн хэмжээний мөнгө, тэр ч байтугай ээжийн ажиллаж олдгоос хавьгүй их мөнгө олж буйг ээж мэдээд, надад их уурласан. Мэдээж энэ нь түүнд хэцүү байсан биз ээ.

Би Норвегийн Ставангер гэдэг хотод төрсөн. Одоогийн амьдардаг Санднес хотоос 14 км-ийн зайтай оршдог. Энэ хоёр хот бараг зэрэгцээ оршдог, хоорондоо их хамааралтай, Норвегийн гурав дахь том төвлөрөл болдог. Ставангер хот шатахууны нийслэл гэдгээрээ алдартай.

Ахлах ангид ортлоо сайн сурлагатан байсан ч сүүлдээ хичээлээсээ уйдаж эхэлснээр миний дүн буурч, дундчуудын эгнээнд оров. Намайг дөрвөн настай байхад аав ээж хоёр салж, би ээжтэйгээ хамт өссөн. Миний ах надаас 12 насаар ахмад. Тэр мөн Аннетте гэдэг бүсгүйтэй гэрлэв. Ижил нэртэй болохоор баяр ёслолын өдрүүдээр заримдаа сонин байдалд ордог байлаа. Тэдний хүүхэд намайг хамгийн сайн нагац эгчээ болгосон юм.

Онлайн сайтад данс нээлгэснийхээ дараа би Холдемийн талаар сонсов. Удалгүй үнэгүй тоглоомоор тоглож эхэлсэн. Нэг өдөр онлайн тэмцээнд түрүүлж, есөн доллараар шагнуулав. Тэр бол миний оруулсан анхны бодит мөнгө байсан бөгөөд түүний дараа нэг цент ч нэмж

хийгээгүй.

• • •

Нэг өдөр онлайн тэмцээнд орж түрүүлэн есөн доллараар шагнуулав. Тэр бол миний оруулсан анхны бодит мөнгө байсан бөгөөд түүний дараа нэг цент ч нэмж хийгээгүй.

• • •

Сургуулиа төгсөхөөс зургаан сарын өмнө би сургуулиасаа гарав. Би өөрийнхөө хийж байгаа зүйлдээ сэтгэл хангалуун байснаас надад сургууль огт хэрэггүй мэт санагдсан. Норвегийн сургалтын тогтолцоо Америкийнхаас огт өөр. Би барилгын дотоод засал чимэглэлийн чиглэлээр сурч байлаа. Сургууль төгсөхөд зургаан сар дутуу байсан ч дотоод засал чимэглэлчин болоход хэдэн жил дутуу байсан. Харин тэр үед би бараг л мэргэжлийн покерчин болсон байлаа. Ээж намайг дэмжиж байв. Түүний хоёр жил ажиллаж байж олохтой тэнцэх хэмжээний мөнгийг би хийсэн ч ийм шийдвэр гаргахад ээжид хэцүү л байсан байх.

Тоглож эхлэхдээ би маш хянуур тоглодог байлаа. Том бооцоо тавьдаггүй, хэзээ ч худлаа түлхдэггүй, дандаа л үндсэн ABC хэмжээнд тоглодог байсан. Үүгээрээ би анхны бодит байдлыг ойлгож, бага мөрийтэй тоглоомуудад хожиж чадна гэдгээ мэдсэн. Энэ нь надад хэсэг хугацаанд гацаанд орсон мэт санагдаж, арай илүү бооцоотой тэмцээнд оролцож, томоор тоглодог хүмүүстэй хамт тогломоор санагдаж, тоглоомоо өөрчилсөн. Тэгээд хэсэг хугацаанд хэрэггүй газар өсгөх, хаяхгүй газар хаях зэргээр хачин гэмээр маш олон инээдтэй үйлдэл, алдаануудыг хийснийхээ дараа тэдгээрийн учрыг олж эхлэв. Энэ үеэс би үнэхээр хожиж эхэлсэн дээ.

• • •

Би мянга мянган хүнээс илүү тоглож, мөнгөний хэмжээ маань 20 мянган доллараас давж эхлэхэд "Пөөх, би үнэхээр сайн юм байна, би үүнийг хийж чадах юм байна" гэж бодсоноо санаж байна.

• • •

Арван зургаан настай байхдаа өөрийгөө бодитойгоор мэдрэв. Тэгэхэд онлайннар нэлээд удаан тоглосон, хожил, зэрэглэлээ хамт өсгөж эхлэв. Би мянга мянган хүнээс илүү тоглож, мөнгөний хэмжээ маань 20 мянган доллараас давж эхлэхэд "Пөөх, би үнэхээр сайн юм байна, би үүнийг хийж чадах юм байна" гэж бодсоноо санаж байна.

Халаасны тавд шалгарсны дараа би хүмүүст танигдаж эхлэв. Үзэгчдээс авсан санал асуулгаар би өөрийн дэмжигчидтэй юм байна гэдгээ мэдсэн. Олон хүн үүнд анхаарлаа хандуулж байгааг мэдээд би үнэхээр их гайхсан. Энэ тоглоомын араас олон хүн сонирхож үргэлж дагадаг юм билээ.

Нэгэн тохиолдлын тухай бодит тоглолтод оролцохдоо нэлээн удаан асуугдсан шүү.

Тийм ээ, тэр тоглолтуудад би бараг бүх модоо нэгийг нь ч хараагүй тоглосон. Юу болсон бэ гэвэл, тэр ням гарагт яагаад ч юм надад сонин санагдаад байсан юм. Тэгээд би тоглоомоо хөгжилтэй болгох зорилгоор гарт ирсэн модоо харахгүй тогловол хэр удаан тоглохоо үзэхээр шийдэв. Би ухаан гарган төвлөрч тогловол бусдад ирсэн мод, надад ирсэн мод ямар ч утгагүй болно гэдэгт итгэдэг.

Тэгээд энэ онолыг туршихаар шийдэн онлайн тэмцээнд орохдоо, дэлгэцэн дээрх өөрийнхөө мод харагдах хэсгийг өөр зүйлээр халхлан харах боломжгүй болгоод тоглож эхэлсэн. Тоглож эхэлснийхээ дараа өрсөлдөгчдийнхөө сул талуудыг ажиглаж гарав. Ингээд л тэрхүү онлайн тэмцээний ялагчаар тодров. Үүнийг гайхалтай зүйл хэмээн интернетийн покер форумд гаргахад тэр нь түймрийн гал шиг хурдан тархсан төдийгүй надаас хамгийн их асуугдсан асуулт болсон.

Энэ үнэхээр сонирхолтой тоглолт болсон юм. Надад маш бага мэдээлэл байлаа. Би өөрийнхөө модыг мэдэхгүй мөртлөө өрсөлдөгчөө маш сайн ажиглаж тоглосон. Тэд зогсохын өмнө яаж тоглож байна вэ? Хэр нээлттэй байна вэ? Үндсэндээ тэдний сул тал, тодорхойгүй байдлыг мэдсэний дараа би мөрийг нэмж, нэмж, нэмсээр ирсэн. Тэднийг удалгүй хаяна гэдэгт итгэж байлаа, яг түүгээр л болсон. Гэвч энэ бүхнийг зөв мэдэрснээс болсон уу, тэгж дайчин өсгөн тоглноос болсон уу, ямар ч байсан би хожсон.

Бодит тэмцээнд орохдоо хэнд ч өөрийнхөө тухай хэлээгүй. Магадгүй олон хүн миний онлайн нэр "Аннетте-15" гэдгээр мэдэх тул энэ чигээрээ байхаар шийдсэнийх биз. Насанд хүрсэн хүмүүстэй жижигхэн охин хамт сууж покер тоглоно гэхээр тэдэнд их хачирхалтай санагдсан байж магадгүй. Тэд намайг үнэхээр муу гэж бодсон байх. Ядаж л эхлээд тэд миний талаар бодож үзсэн болов уу? Миний тэдэнд харагдах анхны төсөөлөл бол өхөөрдөм хөөрхөн юу ч мэдэхгүй охины дүр байлаа. Ийм байдал нь надад давуу тал олгох болов уу гэж бодсон. Тэмцээн эхлээд удаагүй байхад тэд цөм намайг хэн байсныг мэдсэн.

Эхлээд тэд энэ жижиг охины мөнгийг хурдхан аваад явуулья гэж бодож байсан бол ийм зүйл болохгүй гэдгийг удалгүй ойлгоцгоов. Би үүнээс өмнө хэзээ ч ингэж олны өмнө ил гарч тоглож байгаагүй.

2007 оны Покерын дэлхийн цувралын Европын тэмцээнд ялсныхаа дараа би байшин авсан. Одоог хүртэл ээж бид хоёр амьдарч байгаа. Ээж зарим тэмцээнд надтай хамт явахдаа ажлаасаа чөлөө авдаг. Тэрээр намайг тоглож байх хооронд слот машин дээр тоглодог. Тэмцээнд яваагүй үед ээж ажлаа хийдэг. Тэр өөрийн ажлаас их мөнгө олдоггүй ч ажилдаа маш дуртай. Аавыгаа би бараг мэдэхгүй. Багадаа л харснаас өөр зүйлгүй. Намайг онлайн покертоглоон мөнгө хийж байгаа гэдгийг мэдэх боловч тэмцээний тухай юу ч мэддэггүй байлаа. Хожим нь тэмцээнд орж, тэгээд бүр хожсоныг маань олж мэдээд над руу утасдан "Хөөе, юу болоод байнаа" хэмээн хэлж билээ.

•••

Тийм ээ, тэр тоглолтуудад би бараг бүх модоо нэгийг нь ч хараагүй тоглосон.

•••

Тэмцээнд ялсаны дараа миний утас тасралтгүй арван хоёр цаг дуугарсан. Тэд бүгдээрээ сэтгүүлчид байсан. Надаас ярилцлага авахыг тэд хүсэв. Гэвч би түүнд бэлэн биш, юу хэлэхээ мэдэхгүй байснаас олон хүнийг эвгүй байдалд оруулсан байх. Тэр үед 18 настай байлаа. Сэтгүүлчид хэзээ ч миний амьдралын нэг хэсэг байгаагүй, би яаж тэдэнтэй нүүр тулна даа хэмээн гайхдаг байсан.

Бэтфэйртай байгуулсан гэрээнд ярилцлага өгөхөөр тусгагдсан байлаа. Эндээс л эхэлж би сэтгүүлчидтэй харьцаж эхэлсэн. Бэтфэйр бол дэлхийд хамгийн томд орох бооцооны интернет солилцоо. Тэр компани Английн Вест Лондонд байрладаг. Тэднийхтэй гэрээ хийсэн нь том үйл хэрэг болсон юм. Тэдэнтэй гэрээ хийсэн хүмүүс голдуу хэд хэдэн бугуйвчтай байдаг.

Хорин нэгэн насныхаа төрсөн өдрийг Лас Вегаст өнгөрөөхөөр төлөвлөж байсан ч Лондонд тэмцээнд оролцож байгаад тийшээ явж чадаагүй. Олон хүн намайг Лас Вегаст хэр тоглох бол хэмээн боддог байв. Би өөрөө ч тэр хүмүүсийн дунд орчихсон байсан. Покерын дэлхийн цуврал тэмцээний "Main Event" буюу үндсэн тоглолтын эзэн Фил Хэлмутын амжилтыг эвдсэн хамгийн залуу покерчин Пэтер Ийстгэйтийн амжилтыг намайг эвдэж чадах эсэх талаар зарим хүн асуудаг. Үнэндээ би энэ тухай хэзээ ч бодож байгаагүй. Анхны оролдлогоороо тэр тэмцээнд түрүүлэх магадлал бага гэж маш олон хүн хэлдэг. Би голдуу магадлалаар тоглодог. Заримдаа тэдгээр магадлал маш бага байдаг.

Мэдээж би Main Event-д тоглолгүй яахав. Түүнд чадах хэрээрээ тоглоно. Харин учир утгагүй хүлээлттэйгээр тийшээ явахгүй. Би залуу байна. Маш олон тэмцээн миний емне бий. Магадгүй хэзээ нэгэн цагт би Лас Вегаст амьдарч магадгүй. Тэнд амьдарна гэсэн бодол маань их дажгүй боловч ойрын ирээдүйд бүтэхгүй. Надад Бэтфэйртэй хийсэн гэрээний хоёр жилийн хугацаа үлдсэн, бас Европын олон тэмцээн намайг хүлээж байгаа.

•••


Тэр үед би 18 настай байлаа. Сэтгүүлчид хэзээ ч миний амьдралын нэг хэсэг байгаагүй, би яаж тэдэнтэй нүүр тулна даа хэмээн гайхдаг байсан.

•••

Лас Вегас бол миний ажиллах, тэнд болж байгаа тэмцээнүүдэд оролцох, дэлхийн шилдэгүүдтэй өрсөлдөх, өөрийн чадварыг сорихыг хүсдэг газар. Би голдуу тэмцээнд оролцдог. Үүндээ ч нэлээн гаршсан. Харин бэлэн мөнгөөр тоглодог тоглоомоор нэг их тоглодоггүй. Хааяа Омаха тоглодог. Тэмцээнээс л үндсэн таашаалаа авдаг. Хязгаартай тоглоомд дургүй, уйтгартай байдаг.

Зарим хүмүүс намайг казинод крэп юм уу блэкжек тотлохгүй юу гэж асуудаг. Тэр асуултад би "Хэзээ ч үгүй" хэмээн хариул на. Яагаад тэгж тоглоно гэж? Урт хугацаанд хаусыг хэзээ ч дийлэхгүй, чи хичнээн ч удаа шургуу оролдсон ч бүтэхгүй. Зарим хүн ширээн дээрээс нэлээд мөнгө хожсоныхоо дараа бүгдийг нь казинод алдаж байхыг би харсан. Тэгээд тийм ухаантай хүмүүс яагаад ийм тэнэг зүйл хийдэг байна гэж гайхдаг. Тэгж мөрийцөж байхын оронд мөнгөө зүгээр шатаасан нь дээр.

Би покерт дуртай, одоогоор залуу байна, тав, арав, хорин жилийн дараа хаана юу хийгээд явж байгаа мэдэхгүй. Гэхдээ би үргэлж, үхтлээ покер тоглогч байна гэдгээ мэднэ.



Петер Ийстгэйт

2008 онд тэрбээр Покерын дэлхийн цуврал тэмцээний Main Event-ын хамгийн залуу аваргаар тодорсон юм. Энэ нь түүний 10 дахь удаагийн бодит тэмцээн нь байлаа. Тэрбээр тэр өдөр 22 нас, 10 сар, 28 өдөртэй байсан. Өмнөх залуу аварга болох ФилХэлмут харин 24 нас, 10 сар, 5 өдөртэйгээр 1989 онд түрүүлж байсан юм.

Данид төрсөн, Данийн иргэн тэрбээр одоо Лондонд амьдардаг. Тэрбээр интернет покероос төрж гарсан залуучуудын нэг төдийгүй онлайн тэмцээнээс бодит тэмцээнд амжилттай ишлжсэн тоглогчдын нэг юм. Хэдийгээр тэр онлайнаар хязгааргүй Холд'ем болон өндөр бооцоот бэлэн мөнгөний тоглоомоор мэргэшсэн ч бодит тэмцээнд бас их амжилт үзүүлсэн. Хэд хэдэн томоохон тэмцээнд түрүүлснээс Европын нэлээн олон тэмцээн, тухайлбал, Айриш Опен, Скандинавын Опен зэрэг тэмцээнд түрүүлсэн юм.

Дунд сургуульд байхдаа бусад хүүхдийн адил юу хийх дуртайгаа мэддэггүй нэгэн байв. Би

Данийн Оденсе хотын дагуул хот Далумд сайхан гэр бүл дунд хэвийн амьдралаар өссөн. Сургуулиа төгссөний дараа хэсэг хугацаанд аялж, мөн ажиллаж байж ирээдүйгээ тодорхойлох боломж гарав. Ажлын хувьд голдуу цалин багатай байлаа. Нэг удаа бага ангийн багшийн оронд хүртэл ажиллаж үзсэн дээ.

• • •

Онлайнаар олон ширээн дээр зэрэг тоглож, хоёр ширээн дээр л тоглохгүй хаяхад бусад дээр нь хангалттай өрнөл явагдана.

• • •

Коллежид би хагас жил л явсан. Данийн Аархус их сургуульд эдийн засаг судалж байсан. Суралцаж байхдаа найзуудтайгаа хамт бодит тоглоомоор тоглож эхэлсэн юм. Нэг найзаасаа онлайнаар тоглодог болохыг мэдэж түүндээ ихэд татагдав. Тэр үед 18 настай байлаа. Нэг бус хэд хэдэн сайтад тоглоно. Надад тоглоомын олон хоч байсан хэдий ч "намайг ахиж харахгүй" (see me no more) нэр маань нэлээд алдартай.

Тэр үед покер судалж ном уншаагүй зөвхөн зугаа болгон нэг ширээнд тоглодог байсан. Тоглох тусам суралцаж онлайн тоглоомд итгэлтэй болж ирэв.

Олон ширээн дээр зэрэг тоглох нь хамгийн сонирхолтой. Нэг тоглоомд тоглоод хаясны дараа бусад тоглогчид яаж тоглохыг харан хүлээж суух уйтгартай байсан учраас онлайнаар олон ширээн дээр зэрэг тоглож, хоёр ширээн дээр л тоглохгүй хаяхад бусад дээр нь хангалттай өрнөл явагдана. Заримдаа зургаагаас долоон ширээн дээр зэрэг тоглодог. Ер нь ихэвчлэн дөрвөөс таван ширээнд тоглоно. Олон ширээн дээр зэрэг тоглосноор покерт хурдан суралцана. Учир нь олон хөзрийн хослол, тохиолдлуудтай богино хугацаанд танилцах болно.

Мөн тав тух байна. Хэрэв тоглохыг хүсэхгүй байвал битгий тогло. Харин тоглоход бэлэн байвал тэнд үргэлж бэлэн мөнгөний тоглоом зөндөө бий.

• • •

Манай гэр бүлийнхэн намайг онлайнаар тоглож эхлэхэд тун их шүүмжлэлтэй хандаж байлаа. Сүүлд намайг нэлээн итгэлтэй болсны дараа хүртэл тэд миний юу хийхийг заахыг оролддог байв. Гэвч ихэнх гэр бүлийн адил тэд намайг аз жаргалтай байхыг хүснэ.

• • •

Хэрэв би жаргалтай байвал тэд жаргалтай байна. Покер намайг аз жаргалтай болгож байгааг мэдэхэд удаан хугацаа зарцуулаагүй. Ер нь би мэдэж байсан.

Зурагтаар гарч байгаа алдартнуудыг харж, тэднээс эрч хүч авдаг байлаа. Гэхдээ миний хувьд тэд надад олигтой нөлөөлөөгүй. Харин онлайн покерын хажуу талд байдаг блогт тавигдсан нийтлэлүүд надад их нөлөөлсөн. Тэнд ухаалгаар тайлбарлаж шинжилсэн маш олон блогууд байдаг.

Тэдгээрийн онол стратегийг уншиж бас туршиж үзэх нь их сонирхолтой байсан. Тэр дундаас өөрийн тоглох зарчим, арга барилыг олж авсан билээ.

Манай гэр бүлийнхэн намайг онлайнаар тоглож эхэлэд тун их шүүмжлэлтэй хандаж байлаа. Сүүлд намайг нэлээн итгэлтэй болсны дараа хүртэл тэд миний юу хийхийг заахыг оролддог байв.

2006 оны зун гэхэд би покерыг мэргэжил болгох хэмжээнд хүртэл хангалттай мөнгө хийсэн байв Үүнээс өмнө нь тоглоомд дуртай хүүхэд байсан бол тэр үеэс эхлэн бага бооцоотой тоглоомоос илүү дээгүүр бооцоотой тоглоомд тоглодог болсон юм. Дундаж бооцоотой тоглолтуудад ч оролцдог байлаа. Оны сүүл гэхэд 300 мянган доллартай болов. Эргээд 2005 онтой харьцуулахад алдагдал, хожил маань тэнцүү жил болсон мэт санагдсан.

2005 ба 2006 оны ялгаа нь илүү туршлагатай болж басолон зуун мянгаар тоологдох хүмүүстэй хамт тоглох болсонд оршино. Тэр бүхэнд өөрийн алдаанаас суралцаж дахин давтахгүй байхыг хичээнэ. Данийн олон сайн тоглогчидтой нөхөрлөж, бид өөрсдийн туршлага тохиолдлуудыг өөр хоорондоо ярьж зөвлөлддөг болов. Тэгээд ч Данийн мэргэжлийн болон тэмцээний тоглогчид хоорондоо их эвтэй байдаг.

2008 оны Покерын дэлхийн цувралын Main Event-д оролцох эрхийг Ладброкес Покер веб сайтаар дамжуулан авч билээ. Лас Вегаст тэдний баг болж очив. Эхний шатанд маш олон эхлэн тоглогчид тэмцээнд оролцож байгааг харсан. Тэдний хувьд тэрхүү нэр хүндтэй том тэмцээнд оролцох нь л хамгийн чухал байсан байх. Тэд тийм сайн тоглогчид биш.

Хожихгүй гэдгээ ч мэддэг мөртлөө маш олноороо оролцоно. Европт иймэрхүү том тэмцээнд голдуу нэлээн сайн тоглогчид орилдог.

•••

2005 ба 2006 оны ялгаа нь илүү туршлагатай болж бас олон зуун мянгаар тоологдох хүмүүстэй хамт тоглох болсонд оршино. Тэр бүхэнд өөрийн алдаанаас суралцан дахин давтахгүй байхыг хичээнэ.

•••

Лас Вегасын Main Event-д орохын өмнө надад тэмцээний туршлага гэхээр юм бараг байхгүй байсан. Хамгийн томд тооцогдох нь 2007 оны "Irish Poker Open" тэмцээн байлаа. Түүнд есдүгээр байранд орсон юм. Энэ нь би амжилтад дургүйдээ биш онлайнаар ихэвчлэн тоглож, тэндээс их мөнгө цуглуулж банкаа өсгөж байсантай шууд холбоотой.

Маш олон хүн надаас онлайнаар тоглодог хүн яаж бодит тэмцээнд амжилт гаргасан бэ? гэж эсвэл эсрэгээр нь асуудаг байлаа. Онлайнаар тоглоход ил харагдах үйлдэл байхгүй, бодит тоглолтын эхний даваануудад бол үйлдэл их харагдана. Шаг ахих тусам үйлдлүүд багасч, хоорондох зай нь уртасч эхэлдэг. Мэргэжлийн бүх тоглогчид тэр бүхнээ маш сайн нууж чаддаг. Хэрэв сайн тоглогчоос тийм үйлдэл гарвал их гайхдаг. Үнэхээр тийм байдалд орсон уу эсвэл тийм байдалд орлоо гэж надад харагдахын тулд ингэв үү гэдгийг ялгах хэрэгтэй.

Миний тоглолтод тэдгээр нь тийм чухал биш, эцсийн тоглолтод "үйлдэл"-ийг хэзээ ч хардаггүй. Үүнийхээ оронд онлайн-аар яаж тоглодог яг түүн шигээ тоглохыг би хичээдэг. Түлхэх хандлага, бооцооны хэмжээ болон сул талыг нь олж харахыг боддог.

Миний өөр нэгэн давуу тал бол Лас Вегаст удаан тоглож хүмүүст танигдаагүй болохоор покерчид намайг дутуу үнэлж байгаа мэт санагддаг. Тэд үл хүндэтгэсэн тоомжиргүй байдлаар хандаж намайг аюултай амьтан гэж ер боддоггүй нь тодорхой байдаг.

Том тэмцээн болох Покерын дэлхийн цуврал тэмцээний Main Event-д орохдоо би түрүүлнэ ер гэж мөрөөдөөгүй. Дөнгөж 22 настай надад нэр хүндтэй том тэмцээнд орох нь мэдээж нэр хүндийн асуудал байсан. Мэдээж бас тэндээс туршлага олж авах аль болох удаан тоглохыг хичээж оролцсон. Тоглох тусам хожсоор байв. Түрүүлнэ гэж төлөвлөөгүй байлаа. Шувтрагын тоглолтод үлдсэний дараа ялалт байгуулж болох юм байна шүү хэмээн санагдаж билээ.

•••

Тэмцээнд түрүүлснээр аваргын титэмтэй хамт маш их хариуцлага дагаж ирдэг. Би покерын сайн төлөөлөгч байхыг хүсдэг.

•••

Покер тоглож байх үедээ би их намуухан бодогширонгүй байдаг. Энэ бол зөвхөн өнгөцхөн талаасаа. Дотроос минь харин өөр мэдрэмж төрж байсан. Эхний гурваас дөрвөн өдөр өөрийн тоглодог дунджаас доогуур тоглосон. Хоёр удаа бүгдийг түлхэснээс хойш миний банк дахин тэгж хүнд байдалд орохооргүй болов. Тэр үеэс эхлэн намайг нам цохиж унагаах "нүүдэл" удахгүй ирнэ гэдэгт өөрийн сэтгэл зүйгээ сайтар бэлдсэн юм.

Төгсгөлийн тоглолтод орохдоо мөнгө нийтдээ хэр их болох бол, тоглолт хир удаан үргэлжлэх бол гэдэгт өөрийгөө бэлдсэн нь хамгийн чухал зүйл болсон. Тэрнээс биш би огт айж сандраагүй. Есдүгээр байранд орсон "Irish Poker Open" тэмцээнд хүртэл тийм бодолтой байсан.

Аваргын төлөө Иван Демидовтой тоглосон. Урьд нь түүнтэй хэзээ ч тоглож байгаагүй. Тэмцээний тав дахь, долоо дахь өдрүүдэд түүний яаж тоглож байгааг харсан. Тэрбээр хуурамч нүүдэл их хийдэг болохыг нь ажигласан. Намайг зальдахыг хүртэл оролдсон. Гэвч надад хэд хэдэн удаа маш сайн мод ирсэн болохоор хаях ямар ч шаардлага, боломжгүй байсан.

Тэмцээн дууссаны дараа бүх юм дууслаа хэмээн бодож бага зэрэг амсхийсэн. Тэгээд ч Покерын дэлхийн цуврал тэмцээний тухай бодол аль эрт замхарсан байлаа. Үнэндээ тэмцээнд оролцоно гээд бие сэтгэлийн хувьд их ядарсан байсан. Энэ бүхний эцэст одоо л нэг амарч баярлан цэнгэх цаг боллоо хэмээн бодсон.

Тэмцээний дараа миний утас зогсолтгүй дуугарсан. Зарим хүмүүс намайг галзуу юм шиг шоудна гэж бодсон байх. Гэвч би тэгээгүй. Хоёр өдрийн турш маш их хүч гарган тоглосон болохоор ядаргаанд орсон байлаа. Эхний өдөр тэмцээн өглөөний 10 цагт эхлээд 15 цаг

үргэлжилсэн. Дараачийн өдөр нь оройн 10 цагаас тэмцээн эхэлсэн. Энэ нь миний хувьд өдрийн хэмнэл алдагдуулж байсан.

Хүмүүс надаас гарын үсгээ өгөхийг хүсдэг. Гэвч надад энэ тал дээр ажиллах шаардлага байгаа. Учир нь миний зурсан гарын үсэг яг гарын үсэг шиг харагддаггүй. Мөн надаас байнга асуудаг асуулт бол алдар нэрийг яаж авч явах вэ? гэдэг. Үүнд өгөх миний хариулт үргэлж ижилхэн байдаг. Би урьд нь ямар хүн байсан тэр хэвээрээ л үлдэнэ. Зан төлөвт маань ямар ч өөрчлөлт ороогүй. Тэмцээний өмнөх болон тэмцээний дараах Петер Ийстгэйт хэвээрээ байгаа. Би жирийн байгаагаараа үргэлж бахархдаг. Бас ийм амжилтад хүрсэндээ баярладаг.

Есөн сая долларын шагналын мөнгө гэдэг их тоо гэдгийг мэдэж байна. Гэвч тэр мөнгө намайг тодорхойлохгүй гэдгийг хэлмээр байна. Мэдээж түрүүлснээрээ бахархалгүй яахав. Ганцхан түүгээр амьдралыг хэмжиж болохгүй. Мөнгөний тухай миний бодол бусад тоглогчдынхоос арай өөр. Маш их мөнгө онлайн тоглоомоос хожиж, бас алдаж байсан. Хоёуланд нь ямар байдгийг би сайн мэднэ. Мөн олон тоглогчид гарт ирсэн модоороо шийдвэр гаргахаасаа өмнө олох мөнгөө түрүүлж боддог.

Миний найзууд одоо хүртэл надтай найзууд хэвээрээ. Урьдын л адил сайхан харьцаатай. Хэдэн өдрийн дараа тэмцээнээс буцаж, Лондонд очиход бүх юм байдгаараа хэвийн. Ихэнх хүмүүс урьд нь намайг хэн байсан, одоо хэн болсныг мэдэхгүй. Гэвч энэ нь надад чухал биш.

Эргэлзээтэй олон асуудлууд бас намайг тойрон эргэлддэг. Жишээ нь их азтай гэнэ. Бас үнэхээрийн тийм сайн тоглогч юмуу?, дээд түвшинд үргэлжлүүлэн сайн тоглож чадах болов уу? гэх зэргээр. Гэвч би өөрийн тоглолтондоо бүрэн итгэлтэй байдаг. Би дараачийн удаа дахин нэг том тоог өөрийн нэрийн ард нэмэх гэж яараагүй байгаа. Одоо хүртэл өөрийгөө бэлэн мөнгөний тоглогч гэж бодсон хэвээрээ. Үүнийгээ ч үргэлжлүүлэн тоглоно гэж бодож байгаа.

Тэмцээнд түрүүлснээр аваргын титэмтэй хамт маш их хариуцлага дагаж ирдэг. Би покерын сайн төлөөлөгч байхыг хүсдэг. Чиний хэлснийг сая сая хөгжөөн дэмжигч хүмүүс сонсдог. Тиймээс юу хэлэхээ маш сайн тунгаан бодож бай. Би хүмүүст үргэлж сайн мэдээлэл өгөхийг хүсдэг. Түүнийгээ бас хамгийн сайхнаар хийхийг оролддог.

Би покерт үнэхээр их татагдсан. Покерын мэргэжлийн талаар хүмүүс надаас зөвлөгөө авахаар бол, хэрэв тэд покерт үнэхээр дуртай бол, оролдоод үз хэмээн урам өгдөг. Гэхдээ ажлаа шууд орхин тоглох хэрэггүй. Покер бол өгсөж уруудсан маш хатуу тоглоом гэдгийг санаж яваарай.

Покер надад их орлого, бас их олон боломжийг нээж өгсөн. Шинэ хотууд урьд өмнө үзээгүй соёл иргэншилтэй танилцах гайхалтай сайхан байдаг. Дэлхийгээр хөндлөн аялж урьд хийж байгаагүй олон зүйлээ хийдэг болсон.

Одоогоос зургаан сарын дараа яг юу хийж байхаа мэдэхгүй л байна. Зургаан жил биш шүү. Одоохондоо би залуу байна. Одоогоор ямар нэгэн дарамтанд орж цаг хугацаанд баригдаж шахагдсан юм алга. Тийм болохоор тоглоомноосоо ташаал авч, амьдралаа улам бүр тэлж баяжуулах болно. Хамгийн шилдэг покерын төлөөлөгч болохын төлөө хамаг бүхнээ дайчилна даа.

Тайлбар

Блайнд (Blind)- Энэ нь сохор буюу харанхуй бооцоо гэх утгатай агаад тоглогчдын хэн нэг нь хэзэр хуваахаас өмнө, аль эсвэл хэзэр хуваасны дараа авсан модоо үзэлгүй тавьдаг урьдчилсан бооцоо аж. Блайнд нь тухайн тоглоомыг нээж буй анхны бооцоо юм.

Блаф (Bluff)- Муу модтой мөртлөө сайн модтой хэмээн өөрийгөө бусдад итгүүлэхийг чиглэсэн арга залийн хэлбэр.

Блэкжек (Black Jack)- Блэкжекийг тусгай хэлбэр бүхий ширээний ард тоглодог бөгөөд тоглолтод гол төлөв долоон хүн оролцоно. Тэд ширээний нэг талд суух бөгөөд тэдний эсрэг талд дилер зогсоно.

7 хэзрийн стад (Seven poker stad) - Тоглогч бүрт хоёр модыг доош харуулж гурвыг нь дээш харуулж тавиад дээш харсан мод бүрийн дараа наймааны тойрог эргэнэ. Дараа нь тоглоомд үлдсэн тоглогчид өөрсдийн модноос нэгийг тавьж өөрийг авах боломжтой байдаг.

Дроп (Drop)- Казиногийн шимтгэл хураахыг хэлнэ. Үүнээс гадна тухайн тоглогч тоглоомноос гарах эсвэл хожигдохыг мөн ийнхүү нэрлэнэ.

Омаха 8 ба түүнээс дээш төрөл - (Omaha 8 or Better event) - Сүүлийн үед Омаха улам бүр олны тоглох дуртай тоглоом болж Долоон хэзрийн стад, Техас Холдемын эн зэрэгцээ нэгэн түвшинд очоод байна. Тэрээр харьцангуй сүүлд бий болсон ч 1980 он хүртэл хэвлэгдэж байсан нэр бүхий эх сурвалжаас та энэхүү тоглоомын талаар нэг ч үг олж харахгүй байж мэднэ.

Оллин - (All in)- Хэзэр хуваасны дараа тоглогч нэмэлт хасаа авах эрхгүй байдаг. Тоглолтын үеэр хэн нэгэнд нь тэрхүү бооцоонд хариу бооцоо тавих хасаа хүрэхгүй бол энэхүү нөхцөл байдлыг Оллин гэж нэрлэнэ.

Страдл- (Stradl) - Покерын зарим төрөлд хоёр дахь ба сүүлчийн бооцоог харанхуй (блайнд) тавихыг хэлнэ.

Стрэйт флаш (Straight flush) - Нэг өнгийн дараалсан таван модны хослол.

5 хэзрийн стад (Five poker stad) - Хамгийн алдартай стад покерын төрөл. Хэдийгээр бүх моднууд нээлттэй байдлаар хураагддаг ч тоглогчид өрсөлдөгчдийнхөө хэзрийн тухай хавьгүй их мэдээлэлтэй байдаг бөгөөд энэ нь улам илүү хүнд төлөвлөгөө боловсруулах боломжийг нээж өгдөг юм.

Техас Холдем - (Texas Holdem) - Техас Холдемыг гол төлөв Холдем хэмээн энгийнээр нэрлэдэг агаад энэхүү тоглоом нь өнөөдрийн байдлаар покерчдын дунд хамгийн өргөн тархсан тоглоомын төрөл ажээ.

Флаш-(Flush) - Нэг өнгийн таван мод.

Флоп (Flop)- Холдем болон Омаха покерт эхний гурван дундын мод ба бооцооны хоёрдугаар шат.

Фүл хаус- (Full house) - Бүтэн гэр. Адил тоотой гурван мод ба адил тоотой өөр хоёр модны хослол.

Чек - (Check) - Бооцоо тавихаас татгалзан тоглоомд үлдэхийг хэлнэ. Заримдаа энэ тухайгаа ширээ цохиж мэдэгдэнэ. (Үнэндээ үүнийг эртнээс тохирох учиртай). Чек гэж хэлсэн тоглогч хожим нь бооцоо тавих юм уу, өөр тоглогчийн бооцоонд хариу барьж болно.

Table of Contents

Өмнөтгөл-Жак МакКлелланд 3

Их гарын тоглогчид

Дойл Брансон

Жонни Чан

Женнифер Харман

Ховард Ледерер

Фил Хэлмут

Чау Гианг

Энни Дюк

Скотти Нгүен

Лэйн флэк

Крис Фергюсон

Аллен Каннинхем

Карлос Мортенсен

Эрик Сайдел

Дэйв Уллиотт

Чад Браун

Даниел Нигрэану

Фил Айви

Цахиур хагалах залуус

Том Дван

Аннетте Обрестад

Петер Ийстгэйт

Тайлбар